Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2020 оны 04 сарын 29-ний өдрийн №20/17 тоот тогтоолоор Компанийн зээлийн үйл ажиллагаа санхүүжүүлэх зорилгоор нийт 5 тэрбум төгрөгийн үнийн бүхий 17%-ийн хүүтэй 1 жилийн хугацаатай компанийн өрийн бичгийг нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн юм.

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 06 сарын 10-ны өдрийн 482 дугаар тогтоолоор “ЛэндМН ББСБ” ХК-ийн нийтэд санал болгон гаргах 12 сарын хугацаатай, жилийн 17%-ийн хүүтэй, нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 50,000 (тавин мянга) ширхэг “Лэнд бонд” өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэлд бүртгэх болон “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв”-д бүртгэж нийтэд санал болгохыг зөвшөөрсөн юм.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5099754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК
ХХК
5163255
9021031195 СТС2420

СЗХ 2021.06.23 БҮРТГЭВ №01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2021-06-18 БҮРТГЭВ-03

Энэхүү нээлттэй бонд гаргах үйл ажиллагаанд Андеррайтераар "Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК" болон "Ард Капитал ҮЦК" ХХК, Аудитын компаниар "Эрнст энд Янг Монголия Аудит" ХХК, Хуулийн зөвлөх компаниар "Эм Ди Эс энд Хаанлекс" хуулийн фирм, Синдикат компаниар "Райнос Инвестмент ҮЦК" ХХК, Үнэлгээний компаниар "Итгэлт-Эстимэйт" ХХК нар хамтран ажилласан юм.

"Лэнд Бонд"-ын арилжааг хүн бүрт хүртээмжтэй байлгах зорилгоор ухаалаг гар утастай хүн бүр бондын анхдагч зах зээлийн арилжаанд оролцох боломжийг бүрдүүлж, андеррайтер болон үнэт цаасны компаниудаас гадна SuperUp аппликейшнээр дамжуулан бондын захиалгыг хүлээн авч, бага үнийн дүнтэй захиалгыг тэргүүн ээлжинд хуваарилахаар зохицуулалт хийснээрээ онцлогтой.




Ийнхүү Монголын хөрөнгийн зах зээл дээр финтек компанийн анхны нээлттэй бондын анхдагч зах зээлийн арилжаа 2020 оны 06 сарын 15-ны өдрөөс эхлэн 2020 оны 06 сарын 19-ний өдрийн хооронд буюу 5 хоногийн турш үргэлжилсэн бөгөөд нийт 541 хөрөнгө оруулагчдаас 6,742,400,000 төгрөгийн захиалга хүлээн авснаар татан төвлөрүүлэхээр зорьсон үнийн дүн 34.8% -иар давж биелсэн нь Монголын хөрөнгийн зах зээлд хамгийн олон захиалагчтай компанийн бонд болсон юм.

Монголын Хөрөнгийн бирж дээр хийгдсэн анхдагч зах зээлийн хуваарилалтаар 28.8 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй захиалгыг 100% биелүүлж, түүнээс дээш давсан дүнтэй захиалгыг 58.8%-иар хувь тэнцүүлэн хуваарилсан бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооноос анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсон шийдвэр гармагц хөрөнгө оруулагч нарт үлдсэн мөнгөн хөрөнгийг захиалга өгсөн үнэт цаасны компаниудаар дамжуулан буцаан олгосон билээ.

*Хүснэгт 3: Гаргасан бондын нөхцөл*

| ***БОНД ГАРГАГЧ*** | **"ЛЭНДМН ББСБ" ХК** |
|---|---|
| *Үнэт цаасны төрөл* | **Компанийн өрийн хэрэгсэл** |
| *Бондын нэрлэсэн үнэ* | **100,000 төгрөг** |
| *Биржид бүртгүүлэх бондын нийт тоо* | **50,000 ширхэг** |
| *Татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ* | **5,000,000,000 төгрөг** |
| *Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт* | **Компанийн зээлийн үйл ажиллагаа санхүүжүүлэх** |

ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ... КАПИТАЛ ҮЦК ХХК

2021.05.23
МОНГОЛЫН ХӨРЕНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

*График 4: "Лэнд хувьцаа" болон "Лэнд Бонд"-ын хаалтын ханш*




*Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж*

## ХАЛААСНЫ ХУВЬЦААНЫ ТУХАЙ

Үнэт цаас гаргагчаас 2019, 2020 болон 2021 онуудад нийт 3 удаа хувьцаа халааслах шийдвэр гаргаж амжилттай хэрэгжүүлж байна.

*Хүснэгт 4: Халаасны хувьцаа*

| ***Халаасны хувьцаа*** | **2019 он** | **2020 он** | **2021 он** |
|---|---|---|---|
| ***Үнэт цаасны төрөл*** | Халаасны хувьцаа | Халаасны хувьцаа | Халаасны хувьцаа |
| ***Хувьцаа халааслах тухай шийдвэр*** | ТУЗ-ийн 2019 оны 03 сарын 23-ны өдрийн №05 тогтоол | ТУЗ-ийн 2020 оны 12 сарын 23-ны өдрийн №20/37 тогтоол | ТУЗ-ийн 2021 оны 04 сарын 23-ны өдрийн №21/17 тогтоол |
| ***Халаасны хувьцааны хувь хэмжээ*** | Компанийн нийт гаргасан хувьцааны 0.5 хувьтай тэнцэх хувьцаа | Компанийн нийт гаргасан хувьцааны 5 хувиас ихгүй хувьцаа | Компанийн нийт гаргасан хувьцааны 5 хувиас хэтрэхгүй хувьцаа |
| ***Халааслсан хувьцааны нийт тоо*** | 4 сая ширхэг энгийн хувьцаа | 40 сая ширхэг энгийн хувьцаанаас хэтрэхгүй | 40 сая ширхэг энгийн хувьцаанаас хэтрэхгүй |
| ***Хувьцаа халааслах зорилго*** | - “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх удирдлага болон ажилтнуудын дунд хугацааны урамшууллын бодлогыг хэрэгжүүлэх<br>- Хувьцааг хүний нөөцийн бодлогын хүрээнд зөвхөн | - Хувьцааны хөрвөх чадварыг сайжруулах<br>- Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийг хамгаалах<br>- Хөрөнгийн зах зээлийн идэвхжлийг нэмэгдүүлэх<br>- Хувьцааны ханшийг тогтворжуулах | - Хувьцааны хөрвөх чадварыг сайжруулах<br>- Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийг хамгаалах<br>- Хөрөнгийн зах зээлийн идэвхжлийг нэмэгдүүлэх<br>- Хувьцааны ханшийг тогтворжуулах |

ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

2021/05/24

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

| | | | |
|---|---|---|---|
| | Гүйцэтгэх удирдлага болон үндсэн ажилтанд эзэмшүүлэх нөхцөлтэй | | |

## 1.5. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БАЙГУУЛСАН ГЭРЭЭ, ХЭЛЦЭЛ

Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3-н жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа бол хуульд заасан журмын дагуу байгуулсан эсэх талаарх хуулийн зөвлөх компанийн хураангуй дүгнэлтийг дор дурдаж байна.

*Хүснэгт 5: Их хэмжээний болон Сонирхлын зөрчилтэй хэлцэл*

| | Их хэмжээний хэлцэл | Сонирхлын зөрчилтэй хэлцэл |
|---|---|---|
| Нийт хийгдсэн хэлцлийн тоо | 0 | 37 |
| Хэрэгжиж дууссан хэлцэл | 0 | 29 |
| Одоо хэрэгжиж буй хэлцэл | 0 | 8 |

### 1.5.1 ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

**Сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар:**

Бидэнд ирүүлсэн мэдээллээр Компани сүүлийн 3 жилд сонирхлын зөрчилтэй хэлцэл 37-г хийсэн бөгөөд 29 нь бүрэн хэрэгжсэн, Дүгнэлт гаргах өдрийн байдлаар ямар нэгэн зөрчил маргаан гараагүй байна. Сүүлийн 3 жилийн дотор хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулахын өмнө Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан журмын дагуу ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж, зөвшөөрөл олгосон байна. Эдгээр 37 хэлцлээс Дүгнэлт гаргах өдрийн байдлаар 8 хэлцэл нь хэвийн хэрэгжиж байгаа болохыг Компанийн Гүйцэтгэх захирал мэдэгдсэн болно.

**Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ:**

Компани нь сүүлийн 3 жилийн хугацаанд Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн (Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 8,000,000,000 төгрөг бөгөөд үүний 5 хувь нь 400,000,000 төгрөг) бүхий үүрэг хүлээсэн нийт 47 гэрээ байгуулсан. Тэдгээрээс их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлээс гадна 2018 оны 1 гэрээ, 2019 оны 1 гэрээ, 2020 оны 5 гэрээ тус тус хэвийн хэрэгжиж байна. Бусад гэрээ нь бүрэн хэрэгжиж дууссан.

**Их хэмжээний хэлцлийн талаар:**

Бидэнд ирүүлсэн мэдээллээр компани сүүлийн 3 жилийн дотор их хэмжээний хэлцэл байгуулаагүй болохыг Компанийн Гүйцэтгэх захирал мэдэгдсэн болно.

**Илүү дэлгэрэнгүй мэдээллийг Хуулийн зөвлөх компаниас гаргасан "Хууль зүйн дүгнэлт"-ээс уншиж танилцана уу.**

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
1118267206

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙТ ЭНД ЭН ХО
ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18
БҮРТГЭВ-03

## 1.6. НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 сарын 07-ны өдрийн хурлаар баталсан "Ногдол ашгийн бодлого"-ын баримт бичигт дараах агуулгыг тусгасан байна.

### Ногдол ашиг хуваарилах нөхцөл

- Нэг төрлийн нэгж хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна;
- Компанийн тухайн жилийн цэвэр ашгийг тухай жилийн дундаж өөрийн хөрөнгөнд харьцуулсан харьцаа 20 хувиас багагүй байх;
- Шийдвэр гаргах өдрийн байдлаарх зээлийн багцын чанар сайн байх;
- Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;
- Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үед төлөх дүн, компанийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх;
- Компани хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаагаа эргүүлэн авах нөхцөл байдал үүссэн, өөрийн бичгээ эргүүлэн худалдан авах хугацаа болсон бол эдгээр үнэт цаасыг бүрэн эргүүлэн авсан, эсвэл бүрэн худалдан авахад шаардагдах хөрөнгөтэй байх;

### Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр

- Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг тухайн жилийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулснаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана. ТУЗ шийдвэртээ нэг хувьцаанд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг олгох хэлбэр, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан мэдээлэлтэй хамт мэдээлэл хүргүүлнэ.
- Ногдол ашгийг бэлэн мөнгө, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.
- Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг нийтэд мэдээлж, хувийг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржийн мэдээллийн нэгдсэн санд хүргүүлнэ.
- Жилийн тайланд тусгах мэдээлэлд ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэл, төлөх журмын талаар бүрэн тусгасан байх бөгөөд ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсэн бол түүний үндэслэлийг энэ журмын дагуу тайлбарласан байна.
- Компани ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал тайлагнах бөгөөд тайлбартаа ногдол ашиг хуваарилах боломжгүй байдалд хүрсэн шалтгаан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тайлбар зэргийг тусгасан байна.

### Ногдол ашиг хуваарилах, тайлагнах

- Ногдол ашиг төлөх хэлбэр, олгох хугацаа, журам нь хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна.
- Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ногдол ашгийг ТУЗ-өөс тогтоосон хугацаанд төлөөгүйгээс компанид учирсан хохирлыг гүйцэтгэх захирал болон холбогдох бусад албан тушаалтнууд хариуцна.

lendmn
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

2021/05/24

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

- Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан бол төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгах бөгөөд ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр тусгайлан өглөгийн бүртгэл хөтөлнө. Ногдол ашгийг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК дахь хувьцаа эзэмшигчийн дансанд шилжүүлэх бодлого баримтална.
- Ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын санхүүгийн тайлан гаргах үед "Ногдол ашгийн хуваарилалтын тайлан"-г гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит хуралд өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.

## НОГДОЛ АШИГ ХУВААРИЛСАН ТУХАЙ

Үнэт цаас гаргагч нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан "Ногдол ашгийн бодлого"-ын хүрээнд 2018, 2019 болон 2020 оны жилийн эцсийн цэвэр ашгаас дараах байдлаар ногдол ашиг хуваарилж, хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэн ажиллаж байна.

*Хүснэгт 6: Хуваарилсан ногдол ашиг*

| Ногдол ашиг | 2019 он | 2020 он | 2021 он |
|---|---|---|---|
| **Ногдол ашиг хуваарилсан нийт дүн** | 800,000,000 төгрөг | 1,200,000,000 төгрөг | 447,843,215 төгрөг |
| **Ногдол ашгийн эзлэх хувь хэмжээ** | 31.24% /2018 оны цэвэр ашгаас/ | 24.44% /2019 оны цэвэр ашгаас/ | 20% /2020 оны цэвэр ашгаас/ |
| **Нэгж хувьцаанд ногдох ногдол ашиг /төгрөг/** | 1.00 | 1.50 | 0.58 |
| **Суутгал** | Хувь хүн бол ХХОАТ , хуулийн этгээд бол ААНОАТ | | |
| **Олгогдох хэлбэр** | Мөнгөн хэлбэрээр | Мөнгөн хэлбэрээр | Мөнгөн хэлбэрээр |
| **Олгогдсон огноо** | 2019.04.30 | 2020.04.30 | 2021.04.30 |

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

2021/05/24

# II. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

## 2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

### 2.1 ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА

### САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДЭЛХИЙН ЧИГ ХАНДЛАГА

**А. Технологийн жил**

2020 он технологийн салбар, тэр дундаа санхүү, боловсрол, цахим худалдаа зэрэг салбарын дэвшилтэт технологи хэрхэн хөгжсөн, түүний үүрэг ямар чухал салбар болохыг хүн төрөлхтөнд ойлгуулсан жил байлаа. Өмнө нь байсан уламжлалт олон бизнесүүд үүдээ барьж, харин цоо шинэ технологид суурилсан бизнесүүд түрэн гарч ирсэн байна. Хүмүүс хичээл, ажил, албан уулзалт, худалдаа үйлчилгээ, эмчийн үзлэг зөвлөгөө гээд өдөр тутам хийдэг бүхий л үйл хэргээ цахимаар хийж сурсан жил байв. Хэдийгээр Ковид-19 цар тахал хүн төрөлхтний эдийн засгийн үйл ажиллагааг олон талаас хязгаарласан ч, хүмүүс технологийн тусламжтайгаар шийдлийг олсоор байна.

*Зураг 11: Ковид-19 цар тахлын өмнө ба дараах амьдралын хэв маяг*




*Эх сурвалж: LEK consulting, Civis consumer survey (2020)*

2019 оноос хойш дэлхий нийтийг тэр чигээр нь хамраад буй КОВИД-19 цар тахлын үед дэлхий даяараа хөл хорионд амьдарч, гэрээсээ ажиллаж амьдрах, суралцах, бүгдийг зайнаас хийх шаардлага гарч, хэрэглэгчид интернет, гар утас, зөөврийн хэрэгсэл ашиглан аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээг авах явдал нь 40-60 хувиар нэмэгдсэн байна. Мөн хэрэглэгчид бэлэн мөнгөнөөс татгалзаж, цахим төлбөр тооцоог илүүд үзэх болсон байна. Энэ нь цаашид санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад найдвартай, хялбар, түргэн шуурхай, цаг хэмнэсэн төлбөр тооцооны шийдэлд орон зай буйг илтгэж байна.

2021/05/24

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

**Б. Финтекийн чиг хандлага**

Ковид-19 цар тахал олон салбарт тодорхойгүй байдал үүсгэсэн ч финтекийн салбарт илүү олон боломжийг нээж өгсөн байна. Цахим худалдаа, үйлчилгээ, сургалт, энтэртайнментын салбар хөгжихийн хэрээр түүнийг дагасан цахим төлбөр тооцоо, зээл, санхүүгийн үйлчилгээ өсөн нэмэгдэх болно. Финтекийн салбар цаашид өсч хөгжих өргөн боломж буйг тус салбарын трендийг харуулсан дараах инфо зургаас харж болно.

*Зураг 12: Финтекийн салбар, тоогоор*




*Эх сурвалж: Main Trends and Challenges in the Fintech Industry By Simon Pearson*

Технологийн компаниуд цар тахлаас үүдсэн хямралыг даван туулах болон ирээдүйн чиг хандлагад суурилсан ганхашгүй, хүчирхэг байр суурь олж авахын тулд 3 чухал стратегийн боломжуудыг бий болгох хэрэгтэй гэж 2021 оны Делоиттоос гаргасан "Технологийн салбарын хэтийн төлөв" тайланд зөвлөжээ. Энэхүү тайланд **дижиталчлалыг түргэсгэх,** ажиллах хүч болон боловсон хүчнийг өнөөгийн нөхцөл байдалд уялдуулан сургах, мэргэшүүлэх, хэрэглэгчдийн хурдацтай өсөж буй эрэлтийг хангах үйлдвэрлэлийн боломжийг нэмэгдүүлэх гэсэн 3 чухал стратегийг дурдсан байна. **"ЛэндМН ББСБ" ХК**-ийн хувьд анх үүсгэн байгуулагдсан цагаасаа технологийн шилжилтийг урьдчилан нэвтрүүлж, өмнө нь огт байгаагүй барьцаагүй зээл, цахим хэтэвч, төлбөр тооцоо, хиймэл оюун ухаанд суурилсан зээлжих зэрэглэл тодорхойлох систем зэрэг платформын бизнесийг нэвтрүүлсэн билээ. Цар тахал ихэнх аж үйлдвэрийн салбар, тэр дундаа уламжлалт хэв маягаар үйл ажиллагаа явуулж байсан Монголын бизнесүүдэд том өөрчлөлтийг авчирсан.

ЛэндМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ул.1111267206
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

*График 5: Дэлхийн финтекийн салбарт хийгдсэн хөрөнгө оруулалт*




*Эх сурвалж: KPMG, Финтек салбарын импульс*

Хэдийгээр цар тахлаас үүдэн 2020 оны 1-р хагаст олон бизнес уналтанд орж олон хэлцлүүд зогссон ч 2020 оны 2-р хагаст финтек компаниуд дэлхийн "шинэ нормал" буюу "new normal"-д дасан зохицож 1-р хагаст татсан хөрөнгө оруулалтаас ойролцоогоор 45% илүү хөрөнгө оруулалтыг финтекийн салбарт татан төвлөрүүлсэн болохыг KPMG-ээс эрхлэн гаргадаг "Финтек салбарын импульс" тайланд дурджээ. 2020 онд финтек салбарт нийт 2,861 хэлэлцээр хийгдэж, 105.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

## B. Цахим төлбөр тооцооны зах зээл ба финтек

Цахим бизнес болон худалдааг дагасан цахим төлбөр тооцооны зах зээл улам хурдтай тэлж байгааг BCG research судалгааны тайлангаас харж болохоор байна. Тус тайланд дурдсанаар 2025 онд бэлэн мөнгөний төлбөр тооцоог цахим төлбөр тооцоо давна гэж дурджээ. Мөн BIS Research тайланд дурдсанаар 2025 онд дэлхийн мобайл төлбөр тооцооны нийт орлого 4.6 их наяд ам.долларт хүрнэ гэсэн байна. Энэ нь "ЛэндМН ББСБ" ХК-ийн цахим хэтэвчний үйлчилгээг нэвтрүүлсэн СуперАп аппликейшны зах зээлийн боломжийг харуулж байна.

*График 7: Төлбөр тооцооны чиг хандлага*




*Эх сурвалж: BCG research*

*График 6: Глобал мобайл төлбөр тооцооны салбарын нийт орлого /тэрбум ам.доллар/*




*Эх сурвалж: BIS Research, Statista*

lendmn
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

2021.06.23

## МОНГОЛ УЛСЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2020 оныг дэлхийн эдийн засагт тодорхойгүй байдал үүсгэсэн Ковид-19 цар тахлын нөлөөг дурдахгүй өнгөрч болохгүй ба улс орнууд хөл хорио тогтоож, хилээ хаан, үйлдвэрлэл зогссоноос болж эдийн засгийн өсөлт саармагжиж эхэлсэн билээ.

Монгол Улсын хувьд ДНБ-ийн өсөлт -5.3% хүрч хямралтай жилийг үдлээ. Монгол Банк мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлж энэхүү уналтын үед зээлийн өсөлтийн тогтвортой байдлыг хангахын тулд бодлогын хүүг тухайн онд 4 нэгж хувиар бууруулсан ч 2020 оны 3 дугаар улирлын байдлаар нийт зээлийн үлдэгдэл 17.18 их наяд төгрөг болж 2019 оноос 750 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Харин банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын нийт зээлийн үлдэгдэл 1.327 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 7.6%-иар өссөн байна. Финтек шийдэл ашиглаж зээлийн үйлчилгээ үзүүлж буй ББСБ-ын зээлийн үлдэгдэл 197.2 тэрбум төгрөг хүрч 11.6% буурсан нь цар тахалтай холбоотой хөл хорио болон бусад арга хэмжээнүүд нь өрхийн хоёрдогч хэрэглээний зардал, худалдан авалтад сөргөөр нөлөөлсөнтэй холбоотой.

*График 8: ДНБ, нийт зээлийн өсөлт, нийт зээлд эзлэх хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн хувь /Нэгж: хувь %/*




*Эх сурвалж: Монгол Банк*

2008 оноос 2020 он хүртэл ББСБ-ын тоо, актив болон зээлийн хэмжээ тасралтгүй өссөнөөр 2020 онд 2 их наяд төгрөгийн нийт активтай болоод байна. Уг үзүүлэлт хэдийгээр Монгол улсын санхүүгийн зах зээлд банкны эзлэх хувь болон өрсөлдөөн өндөр хэдий ч санхүүгийн үйлчилгээ хүрдэггүй том орон зай байсаар буйг харуулж байна.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
2021.06.23 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

*График 9: ББСБ-ын салбарын хэмжээнд нийт олгосон зээлийн хэмжээ, нийт активын хэмжээ, тэрбум ₮*




*Эх сурвалж: СЗХ*

**А. ББСБ-ын актив болон зээлийн өсөлт банкны өсөлтийг давж байна.**

2020 онд үйлдвэрлэл буурч, бизнесийн үйл ажиллагаа хэсэг хугацаанд зогсонги байдалд орсон тул зээл гаргалт үүнийг даган буурсан ба арилжааны банкны зээл 4.18% буурч 17.2 их наяд төгрөгт хүрсэн бол ББСБ-ын зээлийн үлдэгдэл 1.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 7.6% өссөн байна. Банкны нийт актив энэ онд 13%-иар өссөн бол ББСБ-ын хувьд 16% өсөлттэй байна. Сүүлийн 10 жилийн дунджаас харахад ББСБ-ын зээлийн өсөлт болон нийт активын өсөлт харгалзан 32.5%, 31.4% байгаа нь банкны зээл, активын өсөлтийг давсан үр дүнг бий болгоод байна.

*График 10: Банк болон ББСБ-ын салбарын нийт актив, олгосон зээлийн өсөлт*




*Эх сурвалж: МБ, СЗХ*




*Эх сурвалж: МБ, СЗХ*

Өнгөрсөн оны байдлаар ББСБ-ын салбарын нийт олгосон зээлийн хэмжээ нь банкны нийт зээлийн үлдэгдлийн 7.5 хувьтай тэнцэж байгаа ба нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 47%-г тус тус эзэлж байна. Энэ нь өмнөх оны тухайн үзүүлэлтээс харгалзан 0.8 %, 5.4% дээшилсэн үзүүлэлт юм.

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

ББСБ-ын үйл ажиллагааны төрөлжилтийн тоо, үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын статистикийн хувьд факторингийн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо 17.2%-иар, гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-ын тоо 5.77%-иар буурч бусад төрлийн үйл ажиллагаа явуулдаг ББСБ-ын тоо өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс итгэлцлийн үйлчилгээ 26.5%, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээ эрхэлдэг ББСБ-ын тоо 8.8%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь ББСБ-ын салбарын үйл ажиллагаа тэлж буйг илэрхийлнэ.

**Б. Финтек зээлдэгчийн тоо ББСБ-ын нийт зээлдэгчийн 73%-ийг эзэлж байна.**

ББСБ-ын салбарын нийт олгосон зээлийн хэмжээ 2008 – 2020 оны хооронд 46 тэрбумаас 1.32 их наяд төгрөг болж өссөн бол нийт ББСБ-ын тоо 131-ээс 532 болж өссөн байна. 2018 оноос эхлэн ЛэндМН ББСБ ХК тэргүүтэй финтек, техник технологийн дэвшилт ашиглаж хэрэглээний зээл олгож буй компаниуд харилцагчийн тоо огцом өсөхөд нөлөөлж байна. Монгол улсын хэмжээнд ББСБ-ын нийт харилцагчдын тоо давхардсан байдлаар 2,844,782, зээлдэгчдийн тоо 788,058 хүрсэн байна. Энэхүү үзүүлэлтийн 88.4% буюу 2,515,149 харилцагч, 72.6% буюу 572,668 зээлдэгч нар финтек шийдэл бүхий ББСБ-аар дамжуулан санхүүгийн үйлчилгээ аваад байна. Үүнээс "ЛэндМН ББСБ" ХК нь нийт зээлдэгчдийн 22.2%, финтек зээлдэгчдийн 30.6%-д санхүүгийн үйлчилгээ үзүүлээд байна.

*График 11: ББСБ-ын зээлийн үлдэгдэл /Нэгж %/*




*Эх сурвалж: СЗХ, ЛэндМН тайлан*

*График 12: ББСБ-ын харилцагчид*




*Эх сурвалж: СЗХ, ЛэндМН тайлан*

ББСБ-ын нийт зээлийн үлдэгдэлд эзлэх финтек ББСБ-ын зээлийн дүн өмнөх онтой харьцуулахад 3 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна. Харин "ЛэндМН ББСБ" ХК-ийн хувьд барьцаагүй, мобайл хэлбэрээр нийт 210 тэрбум төгрөгийн зээлийг 175,271 зээлдэгчдэд олгосон байна. Энэхүү үзүүлэлтийг нь өмнөх онтой харьцуулахад даруй 2 дахин буурсан харагдаж байгаа нь 2020 онд нийгэм эдийн засгийн ихээхэн эрсдэл дагуулсан Ковид-19 цар тахалтай холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, цар

2021/05/24

СЗХ
2021.06.23
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

тахлын эрсдэлийг үнэлж чанаргүй зээлийн түвшинг тогтвортой байлгах зорилгоор хэрэгжүүлсэн шийдвэрүүдтэй холбоотой.

| Финтек ББСБ | App |
|---|---|
| Ард Кредит | Ard app |
| Ашид капитал | Simple |
| Говь финанс | Cash One |
| Жи Эс Би Капитал | GSB capital |
| Зээл Эм Эн Платформ | Zeel.mn |
| Инвескор хэтэвч | Pocket.mn |
| ЛэндМН | LendMN |
| Мобифинанс | Monpay |
| Монголиа импакт финанс | Qmoni |
| Нөмөр кредит | Numur |
| Смарткапитал фанд | Mycredit.mn |
| Соно финтек | Sono mongolia |
| Ти финанс | T-finance |
| Хатан суудал инвест | Zeely |
| Централ капитал | Kmobi |

Монгол улсад финтек хэлбэрээр хэрэглээний зээл олгох үйл ажиллагаа явуулж буй голлох дараах 15 ББСБ байна. Үнээс зах зээлд тэргүүлэгчийн байр суурьтай "ЛэндМН ББСБ" ХК, "Ард кредит ББСБ" ХК, "Инвескор ББСБ" ХК-ийн зээлийн үлдэгдэл 143.7 тэрбум төгрөг буюу нийт зээлийн үлдэгдэл болох 197 тэрбумын 72.8%-г эзэлж байна. Бусад финтек ББСБ-ын хувьд сүүлийн үед хүч түрэн орж ирж байна. "ЛэндМН ББСБ" ХК-с ялгаатай нь дээр дурдсан ББСБ нь уламжлалт болон финтек үйлчилгээг хослуулан эрхэлж байгаа ба өөрийн гэсэн онцлог бүхий зээлийн үнэлгээ, бүртгэлийн арга хэрэгслийг ашиглаж байна. "ЛэндМН ББСБ" ХК-ийн хувьд зээлийн үйлчилгээнээс гадна төлбөр тооцоо, цахим худалдаа зэрэг цахим эко орчинг хөгжүүлэхэд түлхүү анхаарч байна.

**В. Хэрэглээний бичил зээлийн чанаргүйжилт бусад төрлийн зээлээс бага байна.**

Монгол улсын хэмжээнд иргэдийн дунд хамгийн түгээмэл зээлийн бүтээгдэхүүнүүд буюу банкны хэрэглээний зээл, цалингийн зээл, кредит карт, ББСБ-ын уламжлалт зээл, финтек ББСБ-ын бичил хэрэглээний зээл зэргийг харьцуулан судалж үзэхэд чанарын хувьд 2020 оны байдлаар банкны өрхийн хэрэглээний зээл хамгийн өндөр буюу 18.3% нь чанаргүй байгаа бол цалингийн зээл, банкны кредит карт зэрэг зээлийн бүтээгдэхүүнүүд өрхийн хэрэглээний зээлтэй харьцуулахад харьцангуй бага буюу харгалзан 5.6%, 12.1% нь чанаргүйжсэн байна.

ББСБ-ын салбарын хувьд уламжлалт болон финтек хэлбэрээр ангилан дээрх үзүүлэлтээр харьцуулахад уламжлалт ББСБ-ын чанаргүй зээлийн түвшин 10.9%, финтек ББСБ дунджаар 6.4% байна. Харин ЛэндМН ББСБ-ын чанаргүй зээлийн түвшин 2020 оны эцсийн байдлаар 9.1%-тай байгаа нь бусад үзүүлэлттэй харьцуулахад харьцангуй бага байна.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118207208



УЛААНБААТАР ХОТ
ЭЙ ЭНД ЭЙ КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

2021 .06. 23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18
БҮРТГЭВ-03

*График 13: Банк санхүүгийн салбарын чанаргүй зээл /тэрбум төгрөг/*




*Эх сурвалж: МБ,СЗХ, ЛэндМН тайлан*

**Г. Хэрэглээний зээлийн хүү буурч байна**

Монгол Банкны мөнгөний бодлогын гол хэрэгсэл болох бодлогын хүүгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс даруй 4 нэгж хувиар буурч одоогоор 6%-тай байна. Энэ нь санхүүгийн зах зээл дэх суурь хүү учраас банк болон ББСБ-ын зээлийн хүү буурахад нөлөөлж буй үндсэн бодлогын хүчин зүйлс ба нөгөө талаас Ковид-19 цар тахалтай холбоотой зээлийн бүтээгдэхүүн зогсох, санхүүгийн үйлчилгээний хүртээмж муудах зэрэг эрсдэлээс зайлсхийж буй мөчлөг сөрсөн бодлогын үр дүн юм.

*График 14: Банк болон ББСБ-ын иргэдэд олгосон хэрэглээний зээлийн сарын дундаж хүү*




*Эх сурвалж: МБ,СЗХ, ЛэндМН тайлан*

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

## ЦАХИМ САНХҮҮ, ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮЗҮҮЛЭЛТ

Ухаалаг утасны хэрэглээ болон дата хэрэглээ нь финтек зах зээлийн үндсэн дэд бүтцийг бүрдүүлэгч чухал хүчин зүйл болохын хувьд зайлшгүй авч үзэх шаардлагатай үзүүлэлтийн нэг юм. Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны /ХХЗХ/ тайланд дурдсанаар 2016-2020 оны хооронд дата хэрэглэгчийн тоо жилийн өсөлтийн хувиар /CAGR/ 1%, смарт утасны хэрэглэгчийн тоо 7% буюу жилийн өсөлтөөр 2021 онд 3.8 сая болж өсөхөөр байна.

*График 15: МУ-ын смарт утас болон дата хэрэглэгчийн тоо /Нэгж: мянган хүн/*




*Эх сурвалж: Харилцаа Холбооны Зохицуулагч Агентлаг*

Монгол улсын хэмжээнд 2015-2020 оны хооронд идэвхтэй ашиглаж буй картын тоо болон нийт картын тоо харьцангүй хэлбэлзэлтэй буюу буурах хандлагатай байна. Харин интернет болон мобайл банкны хэрэглэгчдийн тоо тасралтгүй өссөн үзүүлэлттэй байна. Төлбөр тооцоо түүнийг дагасан эдгээр өөрчлөлтүүд нь финтек шийдлийн тусламжтайгаар тус зах зээлийг илүү боловсронгуй болгоход нөлөөлж байна.

*Хүснэгт 7: Интернет болон мобайл банкны идэвхтэй хэрэглэгчийн тоо /мян.хүн/*

| | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020Q3 |
|---|---|---|---|---|---|---|
| Картын тоо | 4,058.9 | 3,953.9 | 3,844.6 | 4,291.1 | 3,748.0 | 3,688.1 |
| Идэвхтэй ашиглаж буй картын тоо | 2,289.8 | 1,468.4 | 1,716.2 | 1,585.9 | 1,899.5 | 1,867.1 |
| Интернэт банкны хэрэглэгч | 874.9 | 1,054.2 | 1,388.7 | 1,804.6 | 2,133.3 | 2,635.4 |
| Мобайл банкны идэвхтэй хэрэглэгч | 875.7 | 1,348.0 | 1,637.6 | 2,012.3 | 470.1 | 546.0 |

*Эх сурвалж: Монгол Банкны Хөдөлгөөнт банкны тайлан*

Төлбөрийн уламжлалт ойлголтыг өөрчилж илүү хялбар хүртээмжтэй болгохоор олон төрлийн цахим үйлчилгээнүүд нэвтрээд байгаа ба Монгол Банкнаас гаргадаг Хөдөлгөөнт банкны тайланд дурдсанаар 2019 оны байдлаар 156 сая ширхэг гүйлгээгээр 74 тэрбум төгрөгийн төлбөр тооцоо хөдөлгөөнт банкаар хийгдсэн байна.

2021.06.23 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

*Хүснэгт 8: Санхүүгийн аппликейшн татсан тоо*

| | Андройд /мянган татaлт/ | IOS МУ-ын топ таталттай аппликейшн /Жагсаалт/ |
|---|---|---|
| И-баримт | 1000 | 8 |
| Хаан банк | 1000 | 2 |
| ЛэндМН | 500 | 50 |
| Төрийн банк | 500 | - |
| Голомт банк | 500 | 17 |
| Ard | 500 | 42 |
| Mon pay | 500 | 23 |
| Xac bank | 100 | - |
| U point | 100 | - |
| TDB | 100 | - |
| Social pay | 100 | 1 |
| Most money | 100 | - |
| Pocket | 100 | 22 |

Санхүүгийн аппликейшн татан авалтын дүнгээс харахад андройд утсанд татаж авсан тоогоор И-баримт болон Хаан банкны аппликейшн тус тус 1 сая байсан бол ЛэндМН болон Төрийн банкны аппликейшн тус тус 500 мянган татан аваалттай байна. Үргэлжлүүлээд Голомт банкны Сошиал Пэй болон Хас банк, Кэнди Пэй зэрэг апп-ууд тус тус 100 мянган татан авалттай байгааг харж болохоор байна. Эпл /Apple/ утасны Ай О Эс /IOS/ дээр татагдсан топ апп-уудын жагсаалтыг мөн Хүснэгт 8 дээрээс харж болно.

*Эх сурвалж: Play Store, Similar Web*

## ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД /бичил зээл, төлбөр тооцоо/

### A. Бичил зээлийн оролцогчид

*График 16: Бичил зээлийн оролцогчид, Олгосон зээлийн дүнгээр*




*Эх сурвалж: СЗХ, Хувьцаат Компаниудын 2020 оны тайлан*

ББСБ-ын нийт зээлийн үлдэгдлийн задаргаанаас харахад 85%-ыг нь уламжлалт ББСБ, финтек ББСБ 15%, үүнээс 2%-ийг "ЛэндМН ББСБ" ХК-ын зээлийн үлдэгдэл эзэлж байна. Хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын нийт зээлийн үлдэгдлийг судалж үзэхэд "ЛэндМН ББСБ" ХК нь зээлийн үлдэгдлийн 17%-ийг эзэлж байна.

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
2021.06.23 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРЕНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

### Б. Цахим төлбөр тооцооны зах зээлд оролцогчдын төлөөлөл

*Хүснэгт 9: Цахим төлбөр тооцооны оролцогчид*

| | SuperUp | Social Pay | TDB Pay | Candy Pay | U Point | Store Pay |
|---|---|---|---|---|---|---|
| **Нэвтэрсэн он** | 2020.02 | 2017.04 | 2019.05 | 2015.04 | 2018.12 | 2019.09 |
| **Үүсгэн байгуулагч** | ЛэндМН | Голомт банк | ХХБ | Мобиком | Юнивишн | Сторпэй |
| **Систем хөгжүүлэгч** | АНД Системс тех | Банкны IT | Банкны IT | Мобиком | Юнивишн | Сторпэй |
| **Харилцагчийн тоо /апп татаж авсан тоо/** | 100,000 | 100,000 | 50,000 | 100,000 | 100,000 | 10,000 |
| **Төлбөр тооцооны онцлог** | Өөрийн эко орчинтой | Банкны үйлчилгээ | Банкны үйлчилгээ | Өөрийн эко орчин | Бонус оноо цуглуулдаг | Төлбөрөө 4 хуваах төлдөг |

*Эх сурвалж: Play store*

Санхүүгийн үйлчилгээ, цахим төлбөр тооцоо, мөнгөн шилжүүлгийн шийдэл санал болгож буй үйлчилгээнүүдийн дунд өрсөлдөөн нэмэгдэж байна. Ялангуяа энэ салбарт арилжааны банкнууд болон технологи, харилцаа холбооны компаниуд өрсөлдөж байгаагаас гадна, технологийн компаниуд хоорондоо өрсөлдөж эхлээд байна.

| **Үйлчилгээ** | **SuperUp** | **Simple** | **Ard** | **Pocket** | **Monpay** |
|---|---|---|---|---|---|
| Барьцаагүй зээл | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| Шилжүүлэг | ✓ | ✗ | ✓ | ✓ | ✓ |
| Төлбөр тооцоо | ✓ | ✗ | ✓ | ✓ | ✓ |
| Цахим худалдаа | ✓ | ✗ | ✓ | ✗ | ✓ |
| Эко орчин | ✓ | ✗ | ✓ | ✗ | ✓ |
| Купон урамшуулал | ✓ | ✗ | ✓ | ✓ | ✓ |
| Цахим итгэлцлийн үйлчилгээ | ✓ | ✗ | ✓ | ✗ | ✗ |

*Эх сурвалж: Компаниудын бүтээгдэхүүний мэдээлэл*

## ЗАХ ЗЭЭЛИЙН БАГТААМЖ

### А. "ЛэндМН ББСБ" ХК-ийн хэрэглэгчдийн өнөөгийн байдал

"ЛэндМН ББСБ" ХК-ийн санал болгож буй бичил хэрэглээний зээлийн зах зээлийн зорилтот хэрэглэгчид нь дундаж орлоготой мобайл болон интернет банк ашигладаг, технологийн дэвшилд иддэвхтэй 20-39 насны интервалд хамаарах хэрэглэгчид байна.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5030754 1118267606

УЛААНБААТАР ХОТ
...ЗЭНИТ ЭНЭЙВО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СӨХ
2021.06.23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

Эдгээр хэрэглэгчид нийт харилцагчдын 65%-ийг ээлдэг ба нийт харилцагчдын 60 гаруй хувь нь ямар нэгэн зээлтэй бол үлдсэн хэсэг зээлгүй байна.

Зээлийн гэрээ байгуулсан идэвхтэй харилцагч нар 2017 онд ойролцоогоор 19 мянга гаруй харилцагч байсан бол 2020 оны эцэс гэхэд 175,271 болж нийтдээ 9.2 дахин өссөн байна. ЛэндМН-ийн харилцагчдыг насны бүлгээр задалж харвал 39-өөс дээш насны харилцагч нар нийт зээлдэгч нарын 26%-ийг эзэлж байгаа нь анхны зорилтот насны түвшин болох 24-34 насны хэрэглэгчдээс тэлж байгаа нь зах зээлийн хэмжээ бизнесийн цар хүрээнд эерэгээр нөлөөлж байна.

Цаашид хугацаа өнгөрөх тусам карт ашиглан төлбөр тооцоо хийдэг үеэс интернет болон мобайл банк ашиглан үйлчилгээ авах сонирхолтой хэрэглэгч өсөх хандлагатай ба финтек шийдэл хүн амын дунд нас харгалзахгүйгээр тархаж эрэлт хэрэгцээ нэмэгдэхээр байна.

**ЛэндМН ББСБ ХК-ийн харилцагчийн хүрээ хэрэглээний зээлийн эрэлт өндөртэй дунд болон дундаас дээш орлоготой дундаж насныхнаар хүрээгээ тэлсэн байна.**

### Б. Нас, орлогын түвшинд суурилсан хэрэглэгчид

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооны тооцоогоор 20-39 насны хүн амын тоо нийт хүн амын 30% болох 989,059 иргэн буюу ойролцоогоор 1 сая хүн уг насны интервалд хамаарч байна. Уг насны хүмүүсийн онцлог гэвэл бусад насны хүн амыг бодоход хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хэрэглээний түвшин харьцангуй өндөр бүлэг юм.

*График 17: Цалингийн бүлгийн задаргаа*




*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

2020 оны эцсийн байдлаар ажил эрхэлж буй 500,000 төгрөгөөс 1,500,000 төгрөг хүртэл цалингийн орлоготой хүн амын тоо 442,709 болж байна. Энэ нь нийт ажил эрхлэгчдийн 72%-ийг эзлэх ба ЛэндМН ББСБ ХК-ийн хэрэглэгчдийн зээл олголтын тоон үзүүлэлтээс харахад 2020 оны 1-р улирлын байдлаар нэг хүнд олгосон сарын дундаж зээлийн хэмжээ 232,000 төгрөг байгаагаас үзэхэд зорилтот зах зээлд багтах хүн амын тоогоор харгалзуулан тооцсон зах зээлийн багтаамж сард дунджаар 102.7 тэрбум төгрөг буюу жилийн 1.2 их наяд төгрөг байхаар байна. Энэ нь ЛэндМН ББСБ ХК-ийн нийт хэрэглэгчдийн 65%-тай дүйцэж буйгаас харвал (2021 оны 1-р улирлын байдлаар) нийт зах зээлийн багтаамж ойролцоогоор 1.9 их наяд төгрөг байхаар таамаглагдаж байна.

ЛэндМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ХХК

СЗХ
2021.06.23 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

*График 18: Монгол Улсын иргэд насны бүлгээр*

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*




* *"ЛэндМН ББСБ" ХК-ийн 26% нь бусад буюу 20-39 насны ангилалд ороогүй зээлдэгчид байгаагаас харахад 39-с дээш насны тогтмол цалингийн орлоготой харилцагчид тус компанийн бүтээгдэхүүнийг хэрэглэж эхэлсэн нь сонирхол татаж байна. Энэ нь 40-өөд насныхан нь энэ салбарын нэмэлт сегмент болж буйг харуулах ба 15-19 насныхан нь санхүүгийн бүтээгдэхүүний ирээдүйн хэрэглэгчид байх болно.*

**2021 оны 1-р улирлын байдлаар нэг хүнд олгосон дундаж зээлийн хэмжээ болон ажил эрхэлж буй 500 мянгаас дээш цалингийн орлоготой хүн амын тоо 442,709 байна. Үүн дээр тулгуурлан авч үзэхэд зах зээлийн багтаамж ойролцоогоор 1.9 их наяд төгрөг байхаар таамаглагдаж байна.**

### В.Технологийн хэрэглээгээр тодорхойлсон хэрэглэгч

2017 онд "ЛэндМН ББСБ" ХК-ийн олон нийтэд хувьцаагаа санал болгох үед смарт гар утас хэрэглэгчийн тоо 2.4 сая байсан бол 2020 онд 3.3 сая болж өссөн байна. Түүнчлэн ЛэндМН аппликейшн татаж авсан тоо 2017 онд 100 мянга гаруй байсан бол 2020 оны байдлаар даруй 8 дахин өсч 890 мянга хол давсан байна. Үүнээс зээлийн гэрээ байгуулсан хэрэглэгчийн тоо 2020 оны байдлаар 175,271 болж өссөн байна. Банк санхүүгийн аппликейшн ашиглаж буй хэрэглэгчийн тоог хамгийн багадаа 200,000, ихдээ 500,000 гэж үзэх юм бол зах зээлийн багтаамж сард дунджаар 46-116 тэрбум буюу жилийн 0.5-1.3 их наяд төгрөг байхаар харагдаж байна. Энэ нь нийт "ЛэндМН ББСБ" ХК-ийн хэрэглэгчийн 65%-тай дүйцнэ гэж үзвэл нийт зах зээлийн багтаамж ойролцоогоор 0.8-2 их наяд хүртэл төгрөг байхаар таамаглагдаж байна.

**Гар утасны апп ашиглан төлбөр тооцоо хийдэг боломжит карт зээлийг 200-500 мянган хүн гэж үзвэл нийт зах зээлийн багтаамж багадаа 849 тэрбумаас 2.1 их наяд төгрөг байхаар таамаглагдаж байна.**

### Г.Өрхийн орлого, хэрэглээний зөрөө, ДНБ-ийн өсөлтөд суурилсан судалгаа

Монгол улсын хувьд өрхийн орлогын хэмжээ эдийн засгийн өсөлтийн хувь хэмжээнээс 95%, өрхийн хэрэглээ нь 79%-ийн хамааралтай байна. 2010 оны дүнтэй зэрэгцүүлэх үнээр тооцсон 2011-2020 оны өрхийн хэрэглээ, орлогын өсөлтийн хувь

2021/05/24

СЗХ
2021.06.23 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

хэмжээг бодит ДНБ-ийн өсөлтийн хувь хэмжээтэй харьцуулахад дараах үр дүн гарч байна.

*График 19: Өрхийн орлого, эдийн засгийн өсөлтийн хамаарал*




*Эх сурвалж: ҮСХ*

Эндээс харахад эдийн засаг болон өрхийн орлого өсөхөд хэрэглээ давж өсдөг бол өрхийн орлого буурахад хэрэглээ дагаж буурдаг ч харьцангуй бага хэмжээгээр буурдаг байна. Мөн өрхийн орлогын өсөлтөөс шалтгаалж үүссэн хэрэглээний өсөлтийн тодорхой хэсэг тогтмол хэрэглээ болж үлддэг байна. 2010 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон өрхийн орлого хэрэглээний зөрөө 2021 онд 2.56 их наяд төгрөг байх тооцоо байгаа ч арилжааны банкны зээл гаргалтын бууралт ББСБ-ын зээлийн үлдэгдэл тогтвортой байх нэг үндэс болж байна. Нөгөө талаас финтек хэлбэрээр зээл олгож байгаа компаниудын зээлийн эрэлт тогтвортой байна гэж харж байна.

Бодит ДНБ, Өрхийн хэрэглээ, Өрхийн орлогыг цалин болон бусад орлогоор тооцож 2010 оны зэрэгцүүлэх үнэд шилжүүлэн харьцуулахад, өрхийн хэрэглээний хэмжээ, өрхийн цалин болон бусад орлогын зөрөөгөөр тодорхойлсон дүн 2015 оны эдийн засгийн хүндрэлээс хойш нэмэгдсээр 2020 онд зөвхөн эрэлтээс шалтгаалан 1.56 их наяд төгрөгт хүрсэн байна.

График 20: Өрхийн хэрэглээ болон орлого, ДНБ-тай харьцуулсан судалгаа /Нэгж: их наяд төг/




*Эх сурвалж: Монгол банк, судлаачийн тооцоолол*

ЛЭНДМН ББСБ
lendmn
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК
ХХК

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

Мөн 2020 оны хувьд Ковид 19 цар тахал болон хөл хорионы улмаас МУ-ын эдийн засгийн өсөлт -5.3% болж буурсан байгаа. Ирээдүйн Өрхийн орлого хэрэглээний зөрөөгөөр тодорхойлсон зах зээлийн хэмжээг 2010 оны зэрэгцүүлэх үнээр тооцон 2030 онд 5.29 их наяд төгрөг хүртэл өсөнө хэмээн таамаглаж байна. Энэ нь дараагийн 10 жилд цэврээр 2.4 дахин өсөх төсөөлөл юм. Энэхүү төсөөлөл дараагийн 5 жилийн Бодит ДНБ-ийн дундаж өсөлтийг 5% гэж тооцсон болно. 2020 онд энэ зөрөө 1.56 их наяд байсан ба банкны 1 жилийн хугацаатай иргэдийн зээлийн үлдэгдэл 1 их наяд, ББСБ-ын хэрэглээний зээл 1.2 их наяд төгрөг байсан байна.

Монгол банкны судалгаагаар иргэд орлогоос давсан санхүүгийн хэрэгцээгээ найз нөхөд, ах дүү, гэр бүл (28%), ломбард (16%), ББСБ(4%)-аас зээл авах хэлбэрээр санхүүжүүлдэг гэсэн байна. Энэ нь судалгаанд оролцсон иргэдийн 48% нь буюу дунджаар нийт 1.2 их наяд төгрөгийг бидний зорилтот нийлүүлэлтийн сувгаар дамжуулан зээлдэг гэж үзэж болохоор байна.

**Өрхийн орлого болон зарлагын зөрөөг санхүүжүүлж буй арга хэрэгслээр нь тооцоход 48% нь найз нөхөд, танил тал, барьцаалан зээлдүүлэх газраас зээл авч байгаа буюу 1.2 их наяд төгрөгийг ЛэндМН ББСБ ХК-ийн зорилтот нийлүүлэлтийн сувгаар дамжуулж авсан байх боломжтой юм.**

### Д. Банкны богино хугацаат зээл болон финтек хэлбэрээр олгосон зээлийн судалгаа

*График 21: Зах зээлийн хэмжээ /их наяд төгрөг/*




*Эх сурвалж: МБ, СЗХ, судлаачийн тооцоолол*

Одоогийн финтек зах зээл нь иргэдэд чиглэсэн, богино хугацаатай 6 сая төгрөг хүртэлх зээлд төвлөрч байна. Финтекийн зах зээлийн боломжит хэмжээг арилжааны банкнуудын богино хугацаат зээлийн үлдэгдэл болон финтек хэлбэрээр олгосон зээлийн үлдэгдлийн дүнд үндэслэв. Ирээдүйн зах зээлийн хэмжээ 2020, 2021 оны эдийн засгийн төсөөлөл болон жилийн 5%-ийн CAGR-р тооцоход 2020 онд 1.2 их наяд төгрөг байх зах зээл 2030 онд 2.3 их наяд төгрөг хүртэл өсөнө хэмээн таамаглаж байна. Энэхүү төсөөлөлд дараагийн 5 жилийн эдийн засгийн өсөлт болон арилжааны банкны зээл гаргалтын өсөлт нөлөөлнө. Богино хугацаат зээл болон финтек хэлбэрээр олгож буй зээлийн зах зээлд нөлөөлөгч үндсэн индикаторууд нь эдийн засгийн өсөлт, өрхийн хэрэглээ болон өрхийн орлогын зөрөө, зах зээл дэх үнийн өсөлт чанаргүй зээлийн түвшин, Интернет банкны хэрэглээний түвшингөөс хамаарна.

**Арилжааны банкуудын богино хугацаат зээлийн үлдэгдэл болон финтек хэлбэрээр олгосон зээлийн үлдэгдлийн дүнд үндэслэхэд зах зээлийн хэмжээ 1.2 их наяд төгрөг байхаар таамаглагдаж байна.**

### Е. Бизнесийн мөчлөг дээр үндэслэсэн зах зээлийн багтаамж

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ☘ 111826 206
УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО АУДИТЫН ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

Хятад улс финтек салбарын хөгжлөөр дэлхийд тэргүүлсээр байна. Тус улсын нийт иргэдийн 76% нь зээлийн картгүй ба финтек шийдлээр зээл олгох боломжтой асар том зах зээл хэвээр буйг Оливер Ваймэн Анализ тайланд 2019 онд дурдсан байна. Үүнд нөлөөлөх болсон гол хүчин зүйл нь Хятадын эрх зүйн орчин, смарт утас хэрэглэгчдийн тооноос гадна финтек бүтээгдэхүүнүүд банкны салбарын хүрч чадаагүй эрэлттэй зах зээл буюу жижиг дунд бизнес болон банкны шаардлага хангаагүй бизнесийнхэнд хүрч эхэлснээр маш том зах зээлийг бий болгож чадсан явдал юм.

*График 22: Хятадын интернет кредит зээлийн үлдэгдэл /их наяд юан/*




*Эх сурвалж: Ант Файнэншл Компанийн IPO проспектусаас*

Хятад улс нь дэлхийд финтек хэрэглэгчдийн тоогоор тэргүүлэгч буюу судалгаанд оролцсон иргэдийн 70% нь финтек хэрэглэдэг гэжээ.

Финтекийн салбарын хамгийн том оролцогчийн бизнесийн мөчлөгийн судалгаан дээр үндэслэн Монгол улсын финтекийн салбар тогтворжилтынхоо үедээ барагцаагаар хүн амын 13-16% -ийг бүрдүүлнэ гэж үзвэл нийт тогтмол хэрэглэгчдийн тоо ойролцоогоор 403,000-496,000 хүн амыг хамрах тооцоотой байдаг.

Манай улсын банкны салбарын тогтворжилтын зах зээлийн бүтцийн жишгээс авч үзэхэд томоохон арилжааны банкнууд бүтээгдэхүүнээсээ хамааран зах зээлийн 20-25%-ийг дангаараа эзэлдэг. Энэ жишгээр финтек шийдлээр зээл олгож буй салбарын зах зээл эзлэлт тогтворжилтынхоо үедээ хэрэглэгчдийн 20%-25%-д үйлчилгээ үзүүлнэ гэж үзвэл 80,600-124,000 харилцагчтай болоход тухайн бүтээгдэхүүний хувьд зах зээл дээр тогтворжин, байр сууриа бататгаж авч байна гэж үзэж болохоор байдаг. Энэхүү үзүүлэлтээр авч үзэхэд өнгөрсөн хугацаанд дижитал санхүүгийн хэрэглээ хэрэглэгчдийн амьдралд харьцангуй сайн хэвшсэн үзүүлэлттэй харагдаж байна.

Ковид цар тахлын нөлөөгөөр иргэдийн орлого буурсантай холбогдуулан хэрэглээ буурч, зээлийн хэмжээ хумигдах хандлагатай байгаа боловч, эдийн засаг хэвийн байдалд ороход иргэдийн хэрэглээ нэмэгдэх төлөвтэй байна. Нөгөө талаас иргэдийн хувьд

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 18267206



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЭХ
2021.06.23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

дижитал санхүүгийн хэв маягт өдөр тутам шилжиж буй нь финтек зээлийн хэрэглээг нэмэгдүүлэх хандлагатай байна.

**Иргэдийн дижитал санхүүгийн хэрэглээний хэв маяг, финтек бичил зээлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй гол тоглогч нарын бизнесийн тогтворжилтын мөчлөгийг тооцон үзэхэд нийт зах зээлийн багтаамж 496,000 иргэд буюу ойролцоогоор 1.3 их наяд төгрөг байхаар таамаглагдаж байна.**

## ДҮГНЭЛТ

“ЛэндМН ББСБ” ХК-ийн үйл ажиллагаа явуулж буй бичил хэрэглээний зээлийн багтаамжийг нас болон орлого, банк болон ББСБ-ын богино хугацаат хэрэглээний зээлийн үзүүлэлт, өрхийн орлого зарлагын зөрөө, Эдийн засгийн өсөлт, технологийн хэрэглээ, бизнесийн мөчлөг дээр үндэслэн тооцоход энэхүү зах зээлийн багтаамж дунджаар 1.28 их наяд төгрөг байна. Монгол улсын Финтект суурилсан бичил хэрэглээний зээлийн зах зээлийн багтаамжийн ерөнхий төсөөлөл :

*Хүснэгт 10: Хэрэглээний зээлийн зах зээлийн багтаамж*

| | Судалгааны арга | Зах зээлийн багтаамж |
|---|---|---|
| 1 | Нас болон орлогын түвшинд суурилсан хэрэглэгчид | 1.9 их наяд |
| 2 | Технологид хэрэглээгээр тодорхойлсон хэрэглэгчид | 849 тэрбум |
| 3 | Өрхийн орлого, зарлагын зөрөө, ДНБ-ын өсөлтийн судалгаа | 1.2 их наяд |
| 4 | Банкны богино хугацаат хэрэглээний зээл болон ББСБ-ын финтек хэлбэрийн зээлийн судалгаа | 1.2 их наяд |
| 5 | Бизнесийн мөчлөг дээр үндэслэсэн зах зээлийн багтаамж | 1.3 их наяд |
| | **Зах зээлийн багтаамж /дундаж/** | **1.28 их наяд** |

## ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА

“ЛэндМН ББСБ” ХК нь Монгол улсын хамгийн анхны хиймэл оюун ухаанд суурилан дэвшилтэт технологийг санхүүгийн үйлчилгээтэй хослуулсан финтек шийдэл бүхий бичил зээл олгох аппликейшн билээ. ЛэндМН нь тус аппликейшнээрээ дамжуулан Супер Ап хэтэвч үйлчилгээг ашиглан төлбөр тооцоо, мөнгөн шилжүүлэг хийх болон барьцаагүй зээл авах боломжийг хэрэглэгчиддээ санал болгодог.Энэхүү аппликешнийг ашиглан хэрэглэгчид 2 сая хүртэлх төгрөгийн зээлийг 7, 14, 21 болон 30 хоногийн хугацаатайгаар авах боломжтой. ЛэндМН аппликейшн нь Google Play Store дээр 500,000+ хандалтыг авч, 3000 гаруй хэрэглэгчдийн сэтгэгдлийг цуглуулж, сэтгэгдлийн үнэлгээгээр 4.3 гэсэн үнэлгээ авсан байна.

2017 онд анх ЛэндМН аппликейшн олон нийтэд танилцуулснаас хойш энэхүү салбарт олон өрсөлдөгчид шинээр орж ирж байгаа нь хэр ирээдүйтэй салбарыг онилон харж зах зээлд түүчээлэн нэвтрүүлж чадсан байна вэ гэдгийг харуулж байна. Мөн түүнчлэн өрсөлдөгчдийн цар хүрээ нэмэгдэх нь хэрэглэгчдэд цаашид өндөр өрсөлдөөн дундаас чанартай үйлчилгээг хүртэх, улам илүү давуу талуудыг олж авах таатай

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 CTC2420

СЗХ
он сар өдөр
2021.06.23
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

боломжуудыг нээж өгч байна. Энэхүү судалгаанд дараах 3 аппликейшнийг өрсөлдөгчдийг төлөөлүүлэн сонгосон бөгөөд товч танилцуулгуудыг хүргэж байна:

**1. Pocket.mn / "Инвескор Хэтэвч ББСБ" ХХК/**

Pocket.mn апп нь "Инвескор Хэтэвч ББСБ" ХХК-иас гаргасан цахим зээл, цахим төлбөр тооцооны үйлчилгээ бүхий финтек болон хиймэл оюун ухааны технологид суурилсан апп бөгөөд харилцагч албан ёсны мэдээллүүдийг бөглөж бүртгүүлсний дараа харилцагчийн зээлжих эрхийг Монгол банкны зээлийн мэдээллийн сан болон системийн хиймэл оюун ухаанд тулгуурлан тогтоодог бичил зээл олгох апп юм. Харилцагчид нь 10 сая хүртэлх төгрөгийг 14 хоногоос 180 хүртэлх хоногийн хугацаатайгаар авах боломжтой бөгөөд Google Play Store дээр 100,000+ хандалтыг авч, 2000 гаруй хэрэглэгчдийн сэтгэгдлийг цуглуулж, сэтгэгдлийн үнэлгээгээр 4.5 гэсэн үнэлгээг авсан байна.

*Эх сурвалж: Play store, компанийн мэдээлэл, үйлчилгээний танилцуулга*

**2. Simple.mn / "Ашид Капитал ББСБ" ХХК/**

Simple.mn апп нь сүүлийн үеийн ухаалаг технологийг ашиглан харилцагчдынхаа цаг, энерги, мөнгийг хэмнэх зорилго бүхий дижитал зээлийн үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд биометрик мэдээлэлд тулгуурлан харилцагчаа таньж мэдэж, мөн зээлийг шийдвэр гаргалт, зээл олголтын үйл явцыг автоматжуулсан финтек апп юм. Харилцагчид нь 10 сая хүртэлх төгрөгийн зээлийг 1-12 сарын хугацаатайгаар авах боломжтой бөгөөд Google Play Store дээр 100,000+ хандалтыг авч, 339 хэрэглэгчдийн сэтгэгдлийг цуглуулж, сэтгэгдлийн үнэлгээгээр 3.5 гэсэн үнэлгээг авсан байна.

*Эх сурвалж:App store, Play store, компанийн мэдээлэл, үйлчилгээний танилцуулга*

**3. Ард апп / "Ард Кредит ББСБ" ХК/**

Энэхүү апп нь мөн технологийн шийдлийг ашиглан харилцагчиддаа хаанаас ч, хэзээ ч өөрийн санхүүгийн санхүүгийн хөрөнгийг удирдах боломжийг олгож байгаа бөгөөд харилцагч апп-ийг татаж, гар утсандаа суулгаж бүртгүүлэн 5 сая төгрөг хүртэлх зээлийг 6 сарын хугацаатайгаар авах боломжтой юм. Мөн энэхүү апп нь Google Play Store дээр 500,000+ хандалтыг авч, 4000 гаруй хэрэглэгчдийн сэтгэгдлийг цуглуулж, сэтгэгдлийн үнэлгээгээр 4.2 гэсэн үнэлгээг авсан байна.

*Эх сурвалж: App store, Play store, компанийн мэдээлэл, үйлчилгээний танилцуулга*

**Өрсөлдөөний үнэлгээгээр ЛэндМН ББСБ ХК-ийн өрсөлдөх чадварыг дурдвал:**

**Хувь хүнд тохирсон үйлчилгээ:** Хиймэл оюун ухаан (AI) нь хэрэглэгчдийн зээлийн үнэлгээг тооцоолж, зээлдэгчийн төлбөрийн чадварт таарсан зээлийг олгоно.

**Үнэнч хэрэглэгчид зориулсан урамшууллын систем:** Урамшууллын систем нь хэрэглэгчдэд илүү их зээлийг бага шимтгэлээр авах боломжийг олгодог. Тиймээс шимтгэл бууруулалт нь дахин зээл авахад хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг нэмж, зээлээ хугацаанд нь төлөх хандлагыг дэмжиж, санхүүгийн сахилга батад сургаж байна.

lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206



УЛААНБААТАР ХОТ
ЭДЗНИЙ ЗӨВЛӨХ КАПИТАЛ ҮЦК
ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2021 06 23
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18
БҮРТГЭВ-03

**Зардлын хэмнэлт:** Финтек компанийн хувьд нэг харилцагчид ногдох үйл ажиллагааны зардал нь банктай болон бусад банк бус санхүүгийн байгууллагатай харьцуулахад бага байна. "ЛэндМН ББСБ" ХК-ийн зэргэлдээ компани буюу "АНД Системс Тех" ХХК нь систем хөгжүүлэлтийг хийдэг ба зээл олголт бүрт төлөх үйлчилгээний хөлс нь тогтмол байдгаараа давуу талтай.

**Онцгой нөөц:** Хиймэл оюун ухаан /AI/ ашиглан харилцагч тус бүрийн зээлжих зэрэглэлийг тогтоож, оновчтой стратегийн хүрээнд чанаргүй зээл нь бусад банкны хэрэглээний зээлийн чанаргүй зээлээс бага байна. Компани нь зах зээлд хүчтэй хоногшуулалт хийж байгаа ба өрсөлдөгч гарч ирэхээс өмнө үнэнч хэрэглэгчдийг татаж байна.

*Зураг 13: Уламжлалт болон Финтек санхүүгийн үйлчилгээний өрсөлдөөний талбар*




ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ЭЙ ЭНД ВАЙ КАПИТАЛ ҮЦК ХХК
5183655
9021031195 СТС2420

СЗХ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

## 2.2 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА

### МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

*Хүснэгт 11: Макро эдийн засгийн үзүүлэлтүүд*

| Үзүүлэлт | нэгж | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|---|---|---|
| **Үндэсний тооцоо** | | | | | | |
| ДНБ, оны үнээр | тэрбум төг | 23,943 | 27,876 | 32,411 | 36,898 | **36,958** |
| ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр | тэрбум төг | 16,036 | 16,892 | 18,116 | 19,040 | **18,034** |
| ДНБ-ний өсөлт бодит | хувь | 1.2% | 5.3% | 7.2% | 5.1% | **-5.3%** |
| Нэг хүнд ногдох ДНБ, оны үнээр | сая төг | 7.9 | 9.0 | 10.3 | 11.6 | **11.4** |
| **Мөнгө санхүү** | | | | | | |
| Мөнгө М1 | тэрбум төг | 2,148 | 2,826 | 4,031 | 3,904 | **4,197** |
| Мөнгө М2 | тэрбум төг | 12,159 | 15,861 | 19,475 | 20,834 | **24,220** |
| Нэгдсэн төсвийн орлого | тэрбум төг | 5,835 | 7,958 | 10,054 | 11,937 | **10,402** |
| Нэгдсэн төсвийн тэнцэл | тэрбум төг | (3,660) | (1,059) | 831 | 508 | **(3,559)** |
| Гадаад валютын албан нөөц | сая ам.дол | 1,296 | 3,008 | 3,549 | 4,349 | **4,774** |
| Засгийн газрын гадаад өр | сая ам.дол | 4,869 | 7,321 | 7,184 | 7,702 | **8,653** |
| Экспорт | сая ам.дол | 4,916 | 6,201 | 7,012 | 7,620 | **7,576** |
| Импорт | сая ам.дол | 3,358 | 4,337 | 5,875 | 6,127 | **5,293** |
| Төлбөрийн тэнцэл | сая ам.дол | (18) | 1,460 | (142) | 453 | **2,282** |
| Гадаадын шууд хөрөнгө оруулалт | сая ам.дол | 1,486 | 2,086 | 2,729 | 2,900 | **2,620** |
| **Хүүгийн түвшин** | | | | | | |
| Бодлогын хүү | % | 14.0% | 11.0% | 11.0% | 11.0% | **6.0%** |
| Инфляцийн түвшин | % | 1.1% | 6.4% | 8.1% | 5.2% | **2.3%** |
| Хадгаламжийн хүү, жилээр | % | 12.4% | 13.0% | 11.2% | 10.6% | **8.3%** |
| Зээлийн хүү, жилээр | % | 19.7% | 19.0% | 16.9% | 16.9% | **15.8%** |
| Төгрөг ам.долларын албан ханш | төг | 2,490 | 2,427 | 2,644 | 2,734 | **2,849** |
| **Банкны салбар** | | | | | | |
| Зээлийн өрийн үлдэгдэл | тэрбум төг | 12,423 | 13,615 | 17,226 | 18,096 | **17,683** |
| Хугацаа хэтэрсэн зээл | % | 7.3% | 6.0% | 4.9% | 4.6% | **7.1%** |
| Чанаргүй зээл | % | 8.5% | 8.5% | 10.4% | 10.1% | **11.2%** |
| Зээлийн хүү, сараар | % | 1.5% | 1.5% | 1.3% | 1.3% | **1.3%** |
| **ББСБ-ын салбар** | | | | | | |
| Зээлийн өрийн үлдэгдэл | тэрбум төг | 478 | 637 | 869 | 1,233 | **1,327** |
| Хугацаа хэтэрсэн зээл | % | 5.6% | 4.7% | 3.8% | 4.5% | **4.9%** |
| Чанаргүй зээл | % | 12.4% | 12.7% | 9.5% | 8.5% | **10.3%** |
| Зээлийн хүү, сараар | % | 4.0% | 3.4% | 3.3% | 3.1% | **3%** |

*Эх сурвалж: ҮСХ, Монголбанк, СЗХ*

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

**2021/05/24**

УЛААНБААТАР ХОТ
ОЛЗИЙ ЭНД КО
ХАРИЛЦАА ҮЙЛ
ХХК

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

Монгол Улсын эдийн засаг уул уурхайн салбараас ихээхэн хамааралтай байгааг доорх харьцуулсан үзүүлэлтээс харж болох юм. 2011 онд үзүүлсэн түүхий эдийн үнийн өсөлтөөс шалтгаалсан эдийн засгийн идэвхжлээс хойш өнөөгийн нөхцөл байдал дахь түүхий эдийн супер циклийг оруулаад сүүлийн 10 жилд 3 удаагийн өсөлт үзүүлээд байна. 2020 онд дэлхий нийтийг хүнд байдалд оруулсан Ковид-19 цар тахал манай орныг ч мөн орхилгүй 2020 онд эдийн засгийн өсөлт -5.3%-д хүрсэн байна. Харин энэхүү цар тахал анх бүртгэгдэж хүнд байдалд ороод байсан БНХАУ халдварыг дотооддоо хумьж, эдийн засаг, үйлдвэрлэл хэвийн түвшинд ирээд байгаа нь эрдэс бүтээгдэхүүний үнэ өндөр байхад хүчтэй нөлөөлж байна.

*График 23: ДНБ-ийн өсөлт, улирлаар*




*Эх сурвалж: ҮСХ*

Монгол Улсын төсвийн орлого 2021 онд уул уурхайн салбарын өсөлтөөс шалтгаалж нэмэгдэх төлөвтэй байна. 2016 онд ДНБ-д эзлэх төсвийн орлого 24.4%-тай байсан бол 2019 онд 32.4%-д хүрсэн байна. Үүний шалтгаан ерөнхий эдийн засгийн сэргэлт, уул уурхайн салбартай холбогдох орлогын огцом өсөлт, зарим татварын бодлогод гарсан өөрчлөлттэй холбоотой. Төсвийн хөрөнгө оруулалтыг эрэмбэлж, төсвийн зардлыг тодорхой хэмжээнд хязгаарласнаар 2016 онд ДНБ-ий 15.3 хувьтай тэнцэх алдагдалтай гарч байсан төсвийн нийт тэнцэл 2018 онд ДНБ-ий 2.6 хувь, 2019 онд 1.4 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай гарч, төсвийн нөөц боломж сайжирсан байна. 2020 онд төсвийн орлого 10.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны үеэс даруй 12.8%-иар буурч ДНБ-д эзлэх хувь хэмжээ 28.1%-д хүрсэн байна. Харин төсвийн зарлага 13.96 их наяд төгрөгт хүрч 22.13%-иар өссөн байна. Энэхүү үйл явдал нь Ковид-19 цар тахалтай холбоотой эдийн засгийг тогтвортой байлгах үүднээс төсвийн зарлага талд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон орлого талдаа хөл хорио, гадаад худалдааны нөхцөл байдал зэрэг нь хүчтэй нөлөөлсөн байна.

ЛЭНДМН ББСБ ХХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
2021 06 23 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

*График 25: ЗГ-ын өр, ДНБ-д эзлэх хувиар*




*График 24: Төсвийн гүйцэтгэл, ДНБ-ийн хувиар*




*Эх сурвалж: Дэлхийн банк, УСХ*

Монголбанк 2020 онд үүссэн нөхцөл байдалд үндэслэн мөнгөний зөөлөн бодлого хэрэгжүүлж бодлогын хүүг тухайн жилд 5 нэгж хувиар бууруулж систем дэх зээлийн хэмжээг тогтвортой байлгах арга хэмжээ авлаа. Мөн тухайн онд эдийн засгийн өсөлт -5.3%, инфляцын түвшин 2.3%-д хүрсэн зэрэг нь эх үүсвэрийн өртөг буурах гол шалтгаан боллоо.

Монгол улсын экспорт 2020 онд өмнөх оны үзүүлэлтээс 40 орчим сая ам.доллараар буурч 7.58 тэрбум долларт хүрсэн байна. Энэ нь мөн цар тахал, хөл хорио, хил гаалийн асуудалтай холбоотой бөгөөд экспортын задаргааг ерөнхий байдлаар харвал эрдэс бүтээгдэхүүний экспорт 17%-иар буурч 5.3 тэрбум долларт хүрсэн байна. Харин бусад бүтээгдэхүүний экспортын хэмжээ 2019-2020 оны хооронд 1.2 тэрбум доллар буюу 150%-иар нэмэгдэж 2 тэрбум долларт хүрсэн байна. Монгол улсын экспорт 2015- 2019 оны хооронд 63.2 хувь өссөн ба энэ нь 2017 онд Хятад улсын нүүрсний эрэлт нэмэгдэж, үнэ өссөн нь Монгол Улсын эдийн засгийн өсөлт сэргэх хамгийн том хүчин зүйл болсон ба уг онд нүүрсний экспорт биет хэмжээгээр 29.4 хувь өссөн бол үнийн дүнгээр 133 хувь өсөж нүүрсний экспортын дүн 2.3 тэрбум ам.долларт хүрсэн байна. Энэхүү дүр зураг дахин ажиглагдаж манай орны гол эрдэс бүтээгдэхүүнүүдийн үнэ өсч, БНХАУ-ын үйлдвэрлэл сэргэж байгаа тул 2015-2019 онд үзүүлсэн өсөлтийг дахин үзүүлэх боломжтой юм.

2020 онд авч хэрэгжүүлсэн цар тахалтай тэмцэх арга хэмжээ /хөл хорио/ нь орлого буурах үндэслэл болж түүнийг дагаад иргэдийн хэрэглээг буурснаар импорт 13.7%-иар буюу 840 сая ам доллараар буурч 5.29 тэрбум ам долларт хүрсэн байна. Импортын задаргааг авч үзвэл тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, тээврийн хэрэгсэл зэрэг бүтээгдэхүүний импортын бууралт дийлэнх хэсгийг эзэлж байна. Харин хүнсний бэлэн бүтээгдэхүүн зэрэг анхдагч хэрэгцээний шинж чанартай бүтээгдэхүүний тоо хэмжээ болон үнийн дүн тогтвортой байна. Вакцин болон өвчлөлийн эрсдэл буурч эдийн засаг

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
9039754 11 267206

УЛААНБААТАР ХОТ
БОСИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5103655
9021031195 СТС2420

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

гадаад худалдаа сайжирч экспорт нэмэгдэх үед уул уурхайн тоног төхөөрөмж зэрэг бүтээгдэхүүний нэр төрлөөр импортын дүн нэмэгдэх төлөвтэй байна.

*График 276: Импорт /тэрбум ам.доллар/*




*График 267: Экспорт, /тэрбум ам.доллар/*




*Эх сурвалж: ҮСХ*

Гадаад валютын албан нөөц (ГВАН) 2021 оны 3-р сарын байдлаар 4.7 тэрбум долларт хүрч түүхэн дээд хэмжээнд хүрээд байна. 2020 оны 4 сард Худалдаа хөгжлийн банкны 500 сая ам долларын бонд төлөлттэй холбоотойгоор ГВАН 3.8 тэрбум ам.доллараас 16.7%-иар буурч 3.2 тэрбум ам.долларт хүрсэн ба цаашид тогтвортой өссөн байна. Энэхүү өсөлтөд өнгөрсөн онд үнэт металл худалдан авалтын хэмжээ өсч 23 тн-д хүрсэн, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн бодлогын арга хэмжээний үр дүн болон валютын ханшийн хүлээлт буурсан зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн болно.

Сүүлийн 5 жилд төгрөгийн ам.доллартой харьцах ханш 47.4%-иар суларч 2021 оны 3 дугаар сарын байдлаар 2,849.64₮ тэнцэж байна.

*График 28: Топ 20 индекс болон төгрөгтэй харьцах ам долларын ханшийн харьцуулалт*




*Эх сурвалж: ҮСХ*

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754
2021/05/24
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО
КАПИТАЛ ҮЦК
ХХК
5183655

СЗХ он сар өдөр 2021.08.23 № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

Төгрөгтэй харьцах ам долларын ханш 2020 оны сүүлийн хагас жилээс өнөөг хүртэл харьцангуй тогтвортой байна. Үүнд АНУ-ын мөнгөний зөөлөн бодлого, урт хугацаатай засгийн газрын үнэт цаасны өгөөж, манай орны импортын бууралт, ГВАН-ын өсөлт зэрэг хүчин зүйлс ханш тогтвортой байх талд нөлөөлж байна.

Бодлогын хүү 2020 онд 5 нэгж хувиар буурч 6%-д хүрэв. Эдийн засгийн хямралаас үүдэж инфляц нам дор түвшинд байсан нь эдийн засгийг өдөөж зээл гаргалтыг нэмэгдүүлэхийн тулд бодлогын хүүг бууруулах орчин бий болгосон байна.Энэ нь зээл гаргах эх үүсвэрийн өртгийг бууруулснаар хадгаламж болон зээлийн хүү 1 жилийн дотор харгалзан 1.8% болон 1.5%-иар буурсан байна. Арилжааны банкны хадгаламжийн хүү буурах болсноор иргэд болон байгууллагууд хөрөнгөө өсгөх өөр арга зам эрэлхийлснээр хөрөнгийн зах зээлийн үнэлгээ болон Топ 20 индекс, томоохон компаниудын хувьцааны ханш өсөж, “Эрдэнэс таван толгой” ХХК-ийн нээлттэй төгрөг болон ам долларын өрийн үнэт цаасаарх хөрөнгө татан төвлөрүүлэх төсөл амжилттай болсноор иргэд болон хөрөнгө оруулагч нар хөрөнгийн зах зээлийг зорьж байна.

*График 29: Хүүгийн түвшин /Нэгж хувь/*




*Эх сурвалж: ҮСХ*

Банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ 2021 оны 3-р сарын байдлаар 7.8%, хугацаа хэтэрсэн зээл нийт зээлд эзлэх хувь 7.3% байна. Энэхүү үзүүлэлт 2019 оны эцэст харгалзан 4.5% болон 6.2% байв. Доорх харьцуулалтаас харахад 2020 оноос Ковид 19 цар тахалтай холбоотойгоор арилжааны банкнууд нөхцөл байдал болон эрсдэлээ үнэлэн зээл гаргалтын хэмжээг бууруулснаар түүнийг дагаад чанаргүй зээл болон хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ буурсан байна.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
2021 он 06 сар 23 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

*График 30: Банкны салбарын зээл (Нэгж: %)*




*Эх сурвалж: УСХ*

## КОВИД-19 ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ

2020 он бол Хятадын Ухань хотод анх илэрсэн Ковид-19 цар тахлын нөлөөнд дэлхийн бүх тив өртсөн жил болсон ба уг өвчний тархалтын хурд, хүрээг үндэслэн Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ) 2020 оны 3 сарын 11-нд уг өвчнийг албан ёсоор "цар тахал" гэж зарласан. Үнэт цаасны танилцуулгыг бичиж байх энэ үед уг тахал нь дэлхийн 220 оронд тархаж 161 сая хүн халдвар авснаас 3.3 сая хүн нас бараад байна. Цар тахал, улс орнуудын уг тахалтай тэмцэх хариу үйлдэл нь дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон шокуудыг үүсгэсэн ба энэ хугацаанд олон төрлийн эдийн засгийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Уг өвчин нь Монгол Улсын эдийн засагт ч томоохон өөрчлөлт авчирсан ба Засгийн газрын зүгээс уг тахлыг хяналтдаа авах, эдийн засагт үзүүлж буй хор уршгийг бууруулах шийдвэрийг тухай бүрт гаргаж байна.

Цар тахлын нөлөөгөөр Монгол Улсын макро эдийн засгийн үзүүлэлтүүд муудаж байсан ч он гарсаар экспорт болон уул уурхайн үйлдвэрлэлийн үзүүлэлт сэргэж эхэлсэн байна. Экспорт 2021 оны эхний улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 60 хувиар тэлсэн байна. Хэдийгээр эдийн засгийн тодорхой бус байдал нэмэгдэж, бизнесийн үйл ажиллагаа зогсонги байдалд шилжсэнээр хөрөнгө оруулалт бүх салбарт буурч, өрхийн хүнсний хэрэглээ бага зэрэг нэмэгдсэн ч хүнсний бус хэрэглээ огцом танагдсан байна. Нөгөө талаас Засгийн газрын хэрэглээ тэлж, нийт эрэлтэд жилийн турш эерэгээр нөлөөлсөн бол экспорт нь оны сүүлийн хагаст нийт эрэлтийг дэмжсэн гол хүчин зүйл байв.

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2020 оны 4 дүгээр улиралд 1,259 сая ам.доллар буюу ДНБ-ний 9.6 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай гарлаа. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1071 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлт болж, улмаар жилийн дүнгээр

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5079754 111826 206

ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЭХ
он сар өдөр
2021 06 23
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18
БҮРТГЭВ-03

төлбөрийн тэнцэл 2020 онд 787 сая ам.долларын ашигтай байв. Тодруулбал, 2020 оны 4-р улиралд экспорт сэргэж, импорт агшиж, орлогын дансны алдагдал буурснаар урсгал тэнцэл 165.4 сая ам.долларын ашигтай гарсны дээр гадаад зээлийн ашиглалт нэмэгдэж, ГШХО-аас бусад хөрөнгө оруулалтын орох урсгал өссөн нь төлбөрийн тэнцэлд эерэгээр нөлөөлжээ. Энэ онд түүхий эдийн үнэ өндөр байгаа нь төлбөрийн тэнцэлд эерэг нөлөөтэй ч дотоодод вирус тархсан нь улс хоорондын ачаа тээврийг хязгаарлаж, улмаар экспорт удаашрах эрсдэлийг үүсгэж байна.

Гадаад худалдааны нөхцөл 2021 оны 1-р сард өмнөх оны мөн үеэс 23.1 хувиар сайжирлаа. Экспортын үнэ өмнөх оны мөн үеэс 19.4 хувиар нэмэгдсэн бол импортын үнэ 3.1 хувиар буурчээ. Гадаад худалдааны нөхцөлийн төсөөлөл 2021 онд өмнөх төсөөллөөс сайжирсан бөгөөд үүнд зэс, нүүрс, төмрийн хүдрийн экспортын үнийн төсөөлөл нэмэгдсэн нь голлон нөлөөллөө.

Гадаад валютын албан нөөц (ГВАН) 2020 оны эхнээс 185.6 сая ам.доллараар өсч, оны эцэст 4534.2 сая ам.долларт хүрэв. Энэ нь сүүлийн гурван сарын дунджаар тооцсон валютын төлбөртэй барааны импортын 10.7 сарын хэрэгцээг хангах түвшин юм.

2020 онд төсвийн шаардлагатай санхүүжилтийн дүн 5.7 их наяд төгрөгт 14 хүрэв. Уг шаардлагатай санхүүжилтийн 2.1 орчим их наяд төгрөгийг Засгийн газар банкны систем дэх хуримтлалаас, 3.4 их наяд төгрөгийг гадаад зээлээр санхүүжүүлснээр Засгийн газрын цэвэр зээл болон гадаад цэвэр актив тус тус нэмэгдсэн байна.

Арилжааны банкнуудын нийт зээлийн үлдэгдэл 2021 оны 1 дүгээр сарын байдлаар жилийн 4.8 хувиар, хэрэглээний зээлийн үлдэгдэл 18.1 хувиар тус тус буурсан байна. Тэтгэврийн зээлийг тэглэсэн арга хэмжээний нөлөөг засварлаж тооцвол хэрэглээний зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар буурчээ.

Сүүлийн саруудад зах зээлийн хүлээлт тогтвортой байсны дээр экспортын үнэ, эрэлтийг даган гадаад валютын орох урсгал сайжирснаар төгрөгийн ханш сулрах дарамт бага байлаа. Тодруулбал, эхний 2 сарын байдлаар нүүрс, төмрийн хүдэр зэрэг экспортын гол бүтээгдэхүүний орлого өмнөх оноос өсч, орох урсгал өмнөх оны мөн үеэс 21 хувиар сайжирч, гарах урсгал 3.5 хувиар буурснаар гадаад валютын урсгал цэвэр дүнгээр 173.2 сая ам.долларын ашигтай гарав.

2021 оны нэгдүгээр сарын эхний 10 хоногт хатуу хөл хорио үргэлжлэн, эдийн засгийн үйл ажиллагаа хязгаарлагдсанаар татварын орлого 93.7 хувийн гүйцэтгэлтэй төвлөрөв. Мөн Засгийн газраас хэрэгжүүлж буй тэтгэвэр, тэтгэмжийн нэмэлт зардлын нөлөөгөөр татаас, шилжүүлгийн зардал өмнөх оны мөн үеэс 46 хувиар өсжээ.

Хөрөнгийн зах 2020 оны 4 дүгээр улирлаас идэвхжиж, ТОП-20 индекс оны эцэст буюу 12 дугаар сард дунджаар 18,126 нэгжид хүрсэн нь 2020 оны доод түвшин болох 6 дугаар сарын дунджаас 12.4 хувиар өссөн үзүүлэлт болж байна. ТОП-20 индексийн өсөлт 2021 он гарсаар үргэлжилж, 1 дүгээр сарын байдлаар өмнөх сарын дунджаас 10.5 хувиар өсөөд байна.

Tendcom
УЛААНБААТАР ХОТ
5039754 1112267206



УЛААНБААТАР ХОТ
ЭДЭЙ ЭНД КО
ХХК
5183655
9021031195 СТС2420

2020 онд "Оюу толгой" ХХК болон бусад ААН-үүдийн ГШХО цэвэр орох урсгал өмнөх оны мөн үеэс 458.2 сая ам.доллараар буюу 2.5 дахин буурч 296.0 сая ам.долларт хүрсэн бол ААН-үүдийн үндсэн төлбөр өмнөх оны мөн үеэс 27 орчим сая ам.доллараар буюу 48.4 хувиар өсч 82.5 сая ам.долларт хүрэв. Түүнчлэн, "Оюу толгой" ХХК-ийн ашигт ажиллагаа нэмэгдсэн голлох нөлөөгөөр орлогын дахин хөрөнгө оруулалт 52.7 сая ам.доллараар буюу 82 хувиар өсч 116.8 сая ам.долларын цэвэр орох урсгалтай байсан байна.

Цаашид хөл хорионы дэглэм суларч, эдийн засгийг дэмжих арга хэмжээ авахтай зэрэгцэн вакцинжуулалт эхэлснээр хэрэглээ, хөрөнгө оруулалт 2021 оны сүүлийн хагаст эргэн сэргэх хүлээлттэй байна.

## 2.3 БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТААМАГЛАЛ

ЛэндМН ББСБ ХК нь олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлж, барьцаагүй бичил зээлийг олгож эхлээд багагүй хугацаа өнгөрөөд байна. Тус компанийн зээлийн бүтээгдэхүүн нь дэвшилтэт техник технологийн шийдлийг ашиглан бичил зээл олгох процессыг бүрэн автоматжуулж олон мянган харилцагч зээлдэгчдийн цаг хугацаа болон бусад нөөцийг хэмнэсэн үйлчилгээ юм. Тухайн бүтээгдэхүүн үйлчилгээ олон нийтийн дунд дэлгэрч, хэрэглэгчид, хөрөнгө оруулагчдаас өндөр үнэлгээ авч санхүүгийн салбарт финтек технологи, бүтээгдэхүүний инновацийн шинэ жишгийг авчирсан нь ялангуяа санхүүгийн салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлж байна.

Бүтээгдэхүүн үйлчилгээний онцлог нь барьцаагүй бичил зээлийг түргэн шуурхай байдлаар ухаалаг гар утсаар дамжуулан олгодог бөгөөд хөрөнгө оруулагч нарт итгэл төрүүлж өндөр өгөөжтэй санхүүгийн бүтээгдэхүүнийг эзэмших боломж олгож байна.

"ЛэндМН ББСБ" ХК /Үнэт цаас гаргагч/-ийн үйл ажиллагаа явуулж буй зах зээл нь нийт өрхийн орлого болон зардлын зөрөө болох -2.52 их наяд төгрөг (2021 оны прогноз) хүртэл тэлэх боломжтой төсөөлөлтэй байна. (2020 он нь Ковид-19 цар тахалтай холбоотой хөл хорио, бизнесийн үйл ажиллагаа болон хэрэглэгчдийн худалдан авалт саатсан зэрэг нь богино хугацааны өрхийн орлого зардлын зөрөөг бүрэн илэрхийлж чадахгүй гэж үзэв). Энэхүү зах зээлд урт хугацаанд санхүүгийн сахилга баттай харилцагчдыг нэмэгдүүлж тэдний богино хугацаат санхүүгийн хэрэгцээг түргэн шуурхай хангаж, салбарын өрсөлдөөн, хөгжлийг түргэсгэж, нийгмийн нөөцийг үр ашигтай зарцуулахад хувь нэмрээ оруулан ажиллахаар зорьж байна.

СЭХ
2021 06 23
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

*График 31: Зээлийн харилцагчдын тоо*




ЛэндМН ББСБ ХК-ийн харилцагчдын тоо 2020 оны эцэст 175,271 болж өмнөх оны мөн үеэс даруй 5.3% өссөн байна. Харилцагчдын тоо хэдийгээр өссөн боловч хөл хорионы улмаас, эдийн засгийн эргэлт удааширсан, өрхийн хэрэглээ буурсантай холбоотойгоор зээлийн дүн буурахад нөлөөлсөн гэж үзэж байна. Гэвч эдийн засаг хэвийн нөхцөлд шилжсэнээр хэрэглээний дүн огцом өсөх хандлагатай юм. Компанийн бизнес төлөвлөгөөний дагуу харилцагчдын өсөлтийн хувь тогтворжиж 2025 оны байдлаар 275,573 харилцагчтай болох төсөөлөлтэй байна. Иймд хүү болон шимтгэлийн орлогын гол үзүүлэлт болох харилцагчдын тооны төсөөллийг ЛэндМН ББСБ ХК-ийн үндсэн үйл ажиллагаатай уялдуулан, өрхийн хэрэглээ болон орлогын зөрөө болох өрхийн ахиу хэрэглээний (зөрөө) түвшинг ашиглан таамаглав.

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТААМАГЛАЛ

*Хүснэгт 12: Санхүүгийн тайлангийн таамаглал (сая төгрөг)*

| | 2018A | 2019A | 2020A | 2021 F | 2022 F | 2023 F | 2024 F | 2025 F |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Нийт хөрөнгө** | **24,323** | **58,100** | **39,681** | **45,797** | **61,491** | **82,939** | **92,400** | **102,424** |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 4,218 | 6,756 | 9,521 | 3,214 | 3,338 | 6,527 | 5,704 | 4,707 |
| Харилцагчдад олгосон нийт зээл | 19,210 | 50,007 | 28,115 | 41,231 | 56,809 | 75,089 | 85,402 | 97,355 |
| Хэвийн зээл | 18,075 | 47,055 | 25,036 | 37,719 | 52,636 | 70,430 | 80,368 | 91,302 |
| Хугацаа хэтэрсэн зээл | 792 | 1,218 | 514 | 678 | 925 | 1,236 | 1,616 | 2,082 |
| Чанаргүй зээл | 343 | 1,734 | 2,565 | 2,834 | 3,248 | 3,423 | 3,418 | 3,971 |
| Зээлийн эрсдэлийн нөөц | (444) | (1,552) | (3,343) | (4,190) | (4,710) | (5,057) | (5,269) | (6,070) |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | - | - | 2,500 | 2,500 | 2,500 | 2,500 | 2,500 | 2,500 |
| Бусад хөрөнгө | 693 | 1,385 | 1,647 | 1,886 | 2,252 | 2,625 | 2,807 | 3,021 |
| Үндсэн хөрөнгө | 258 | 1,162 | 1,063 | 1,011 | 1,188 | 1,173 | 1,203 | 889 |

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855 9021031195 СТС2420

2021/05/24

ХЭХ
2021.06.23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Биет бус хөрөнгө | 388 | 342 | 178 | 145 | 113 | 83 | 53 | 23 |

| | 2018A | 2019A | 2020A | 2021 F | 2022 F | 2023 F | 2024 F | 2025 F |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Өр төлбөр** | **10,969** | **40,902** | **22,159** | **25,708** | **33,334** | **47,864** | **49,925** | **50,276** |
| Зээлийн эх үүсвэр | 9,849 | 37,985 | 20,489 | 23,934 | 31,334 | 45,434 | 47,434 | 47,834 |
| Бондын өр төлбөр | 6,329 | 3,523 | 7,266 | 9,636 | 8,636 | 14,436 | 14,436 | 15,336 |
| Итгэлцэл | - | 13,696 | 10,364 | 11,957 | 19,557 | 19,457 | 21,457 | 21,457 |
| Банкны зээл | 3,520 | 8,604 | 2,859 | 186 | 1,386 | 8,486 | 186 | 686 |
| Бусад зээл | - | 12,162 | - | 2,155 | 1,755 | 3,055 | 11,355 | 10,355 |
| Бусад өр төлбөр | 1,120 | 2,917 | 1,670 | 1,774 | 2,000 | 2,430 | 2,491 | 2,442 |

| | 2018A | 2019A | 2020A | 2021 F | 2022 F | 2023 F | 2024 F | 2025 F |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Эздийн өмч** | **13,354** | **17,198** | **17,522** | **20,089** | **28,157** | **35,075** | **42,476** | **52,148** |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 10,814 | 10,814 | 10,814 | 10,814 | 10,814 | 10,814 | 10,814 | 10,814 |
| Халаасны хувьцаа | 0 | (266) | (989) | (1,493) | (1,493) | (1,493) | (1,493) | (1,493) |
| Тайлант үеийн ашиг (алдагдал) | 2,560 | 4,910 | 2,240 | 3,206 | 5,389 | 6,457 | 8,046 | 9,672 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | (20) | 1,740 | 5,457 | 7,249 | 10,134 | 14,984 | 20,795 | 28,842 |
| Бусад эздийн өмч | - | - | - | 313 | 3,313 | 4,313 | 4,313 | 4,313 |
| **Нийт өр төлбөр болон эздийн өмч** | **24,323** | **58,100** | **39,681** | **45,797** | **61,491** | **82,939** | **92,401** | **102,424** |

*Үүсгэдэж бүй төлөвлөгөө*

**Дүрмийн сан өсөх төлөвтэй байна:** 2019 онд нийт хөрөнгийн 70 гаруй хувийг өр төлбөр эзлэн, түүний дийлэнх хэсгийг итгэлцэл болон банкны зээл эзэлж байсан бол 2020 оны эцэст өр төлбөрийн эзлэх хувь хэмжээ 55.8% болон буурсан байна. Компанийн үйл ажиллагаа тогтвортой нэмэгдсэнээр 2025 онд эздийн өмчийн дүн 2021 онтой харьцуулахад 2.6 дахин өсөх төлөвтэй байна. Компани финтект суурилсан бичил зээлийн эрэлт хэрэгцээ болон зээл гаргалтын дүн, харилцагчдын тоо, зээл гаргах эх үүсвэрийн тогтвортой байдал зэрэг үзүүлэлт дээр үндэслэн өртөг бага санхүүгийн эх үүсвэрээр зээлийн багцын дүнг нэмэгдүүлж ашигт ажиллагааг нэмэгдүүлэх стратеги баримтлан ажиллаж байна.

*Зураг 14: Өр төлбөр ба эздийн өмч*




ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО НОТАРИАТ ХХК

**Нийт хөрөнгө өсөх төлөвтэй байна:** "ЛэндМН ББСБ" ХК-ийн нийт хөрөнгө 2020 оны эцэст 39.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үзүүлэлтээс 31.7%-р буурсан байна. Энэхүү бууралтыг задаргааг харвал өр төлбөр 44.7%-р буурч эздийн өмч 2%-иар өссөн байна. Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого, цар тахалтай холбоотой иргэдийн зээлийн буурах хандлага, бизнесийн зогсонги байдал зэргийг урьдчилан тооцоолж эрсдэлтэй зээлийн багцыг бууруулах, өртөг өндөртэй эх үүсвэрийг хаах зэрэг бодлого авч хэрэгжүүлсэн нь оновчтой байсан гэж дүгнэж болохоор байна. Санхүүгийн зах зээлд зээлийн үйл ажиллагаа эрхлэхэд эх үүсвэр болон олгож буй зээлийн хугацааг зөв удирдах нь маш чухал байдаг. "ЛэндМН ББСБ" ХК-ийн бизнес загвар нь урт хугацаат эх үүсвэрээр богино хугацаат зээл олгодог тул эх үүсвэр болон зээл гаргалтын хугацааны удирдлагын эрсдэлд өртөх магадлал харьцангуй бага байдаг онцлогтой. Компани цар тахлыг эрсдэл багатай даван туулсан нь бизнесийн загварын онцлогыг бататгасан үйл явдал болсон. Компани нь цаашид зээлийн үйл ажиллагаагаа өртөг багатай эх үүсвэрээр тогтвортой нэмэгдүүлснээр 2025 оны байдлаар 2020 онтой харьцуулахад нийт хөрөнгийн дүн 2.6 дахин өсч 102 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөлтэй байна.

## ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ТААМАГЛАЛ

*Хүснэгт 13: Орлогын тайлангийн таамаглал (сая төгрөг)*

| | 2018A | 2019A | 2020A | 2021F | 2022F | 2023F | 2024F | 2025F |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Хүү, шимтгэлийн орлого** | **7,143** | **18,497** | **16,298** | **15,093** | **19,961** | **24,942** | **29,743** | **33,105** |
| Хүүгийн зардал | (512) | (4,487) | (5,229) | (3,567) | (5,076) | (7,226) | (8,545) | (8,692) |
| **Цэвэр хүүгийн орлого** | **6,631** | **14,010** | **11,069** | **11,526** | **14,885** | **17,716** | **21,198** | **24,413** |
| Эрсдэлийн сангийн зардал | (408) | (1,619) | (2,393) | (1,639) | (1,484) | (1,918) | (2,449) | (3,039) |
| **Эрсдэлийн сангийн дараах орлого** | **6,223** | **12,391** | **8,676** | **9,887** | **13,401** | **15,798** | **18,749** | **21,374** |
| Шимтгэлийн зардал | (981) | (1,925) | (1,659) | (1,563) | (1,955) | (2,307) | (2,605) | (2,797) |
| **Шимтгэлийн дараах орлого** | **5,242** | **10,466** | **7,017** | **8,324** | **11,446** | **13,491** | **16,144** | **18,577** |
| Ерөнхий зардал | (1,032) | (2,485) | (2,093) | (2,349) | (2,782) | (3,137) | (3,319) | (3,428) |
| Удирдлагын зардал | (1,345) | (1,950) | (2,382) | (2,412) | (2,677) | (2,945) | (3,297) | (3,454) |
| **Нийт үйл ажиллагааны зардал** | **(2,377)** | **(4,435)** | **(4,475)** | **(4,761)** | **(5,459)** | **(6,082)** | **(6,616)** | **(6,882)** |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг** | **2,865** | **6,031** | **2,542** | **3,563** | **5,987** | **7,409** | **9,528** | **11,695** |
| Татвар | (305) | (1,121) | (302) | (357) | (598) | (952) | (1,481) | (2,023) |
| **Цэвэр ашиг** | **2,560** | **4,910** | **2,240** | **3,206** | **5,388** | **6,457** | **8,047** | **9,672** |

*Хүлээгдэж буй төлөвлөгөө*

### Орлогын таамаглалд дараах үндсэн үзүүлэлтүүд орсон болно:

*Хүснэгт 14: Орлогын таамаглалд орсон үзүүлэлтүүд*

| | Орлогын таамаглалын дэлгэрэнгүй | 2018 | 2019 | 2020 | 2021F | 2022F | 2023F | 2024F | 2025F |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Харилцагчдын тоо /мянган хүн/ | 94.1 | 166.4 | 175.3 | 187.2 | 215.6 | 240.4 | 259.9 | 275.6 |
| 2 | Зээлийн багц /Сая₮/ | 19,410 | 50,007 | 28,115 | 41,231 | 56,809 | 75,089 | 85,402 | 97,355 |
| 3 | Олгосон зээлийн хэмжээ /Сая₮/ | 150,025 | 426,555 | 210,502 | 311,733 | 400,935 | 518,325 | 662,098 | 821,444 |
| 4 | Зээлийн эрсдэлийн сан /Сая₮/ | -443.6 | -1,551.7 | -3,343.4 | -4,190.0 | -4,710.0 | -5,057.0 | -5,269.0 | -6,070.0 |
| 5 | Хүү шимтгэлийн орлого /Сая₮/ | 7,143 | 18,197 | 16,298 | 15,093 | 19,961 | 24,942 | 29,743 | 33,105 |

2021/05/24

СЗХ
2021 .06. 23-ны өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18
БҮРТГЭВ-03

1. **Компанийн харилцагчдын тоо**: ЛэндМН ББСБ ХК-ийн зээлийн харилцагчдын тоо Ковид-19 цар тахалтай холбоотой 2019-2020 онд 5.3%-иар өсч 175.3 мянгад хүрэв. Энэхүү үзүүлэлт цаашид тогтворжин 2020-2025 оны хооронд жилд дунджаар CAGR-9.5%-ийн өсөлт үзүүлэн 2025 оны эцэс гэхэд 275,573-д хүрэх тооцоотой байна. Энэхүү үзүүлэлт нь цаашид орлого болон бусад санхүүгийн төсөөллийн үндсэн хүчин зүйл болно.
2. **Зээлийн багц:** Олгож буй зээлийн багцын хэмжээ 2020 оны эцэст 28.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 43.1%-иар буурсан байдалтай байна. Энэхүү үзүүлэлт "ЛэндМН ББСБ" ХК-ийн гол үйл ажиллагаа болох бичил хэрэглээний зээл олгох үйл ажиллагааны гол хөрөнгийн ангилал юм. 2020 оны энэхүү буурсан үзүүлэлт нь тухайн оны цаг үе, дэлхий нийтийн тулгамдсан асуудлаас үүдэж буй эрсдэлээр тохируулан буурсан бол вакцинжуулалт болон Ковид-19 цар тахалтай холбоотой эрсдэл буурч бизнесийн бүх байгууллагуудын үйл ажиллагаа бүрэн нээгдэх үед түүнийг дагаад уг зээлийн багцын дүнг нэмэгдүүлэх боломжтой юм.
3. **Олгосон зээлийн хэмжээ:** ЛэндМН ББСБ ХК-ийн 2020 онд олгосон зээлийн хэмжээ 210.5 тэрбум төгрөгт хүрсэн ба цаашид жилд дунджаар CAGR-27.4%-иар өсч 2025 он гэхэд нийтдээ 821.4 тэрбум төгрөгийн зээл олгох төлөвтэй байна. Энэхүү өсөлтийг бүтээгдэхүүн төрөлжилт болон хөгжүүлэлт, бичил хэрэглээний зээлийн эрэлт хэрэгцээ, компанийн зээлийн багцын бодлого зэрэг тодорхойлно. /Энэхүү үзүүлэлтийг компанийн ирэх 5 жилийн зээлийн үлдэгдлийн өссөн дүнгээр тооцсон болно./
4. **Зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ:** Зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 2020 оны байдлаар 3.34 тэрбум төгрөгт хүрч нийт чанаргүй зээлийн 130%-иар байгуулсан ба энэ нь бусад ББСБ-ын энэхүү үзүүлэлттэй харьцуулахад харьцангуй өндөр буюу эрсдэлийг бага байлгах үүднээс энэхүү сангийн хэмжээг өндрөөр байгуулсан байна. Мөн зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ өмнөх оны мөн үеэс даруй 4 дахин өссөн нь өнөөгийн нөхцөл байдлын эрсдэлийн үнэлгээ хэр түвшинд байгааг илтгэнэ. Цаашид бизнесийн цар хүрээгээ тэлж 2025 он гэхэд зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ нийт чанаргүй зээлийн 153% байхаар тооцсон байна. Энэхүү үзүүлэлт нь зээлийн цэвэр багц, харилцагчдын тооны өсөлтөөс шууд хамаарч байна.
5. **Хүү шимтгэлийн орлого:** Компанийн хүү шимтгэлийн орлого харилцагчийн тоо болон нийт зээлийн багцаас шууд хамааралтай бөгөөд ирэх 5 жилийн төсөөлөлд харилцагчийн тоо болон нийт зээлийн багцын өсөлтийг эерэгээр харж байгаа учир хүү шимтгэлийн орлого өсөхөөр байна.

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 ☘ 1118267206



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183655
9021031195 СТС2420

Монгол улсын эдийн засгийн өсөлт тогтвортой түвшинд байсан 2019 онд өрхийн нэмэлт хэрэглээ буюу орлогоос давсан хэрэглээний дүн 2.83 их наяд төгрөгт хүрсэн байна. Харин Азийн Хөгжлийн Банкны таамагт дурдсанаар манай улсын эдийн засгийн өсөлт КОВИД-19 вирусийн нөлөөгөөр 2020 онд 2.1%, 2021 онд 4.6% байх төлөвтэй байгаа ба ирэх онд өрхийн орлогоос давсан хэрэглээний өсөлтийг тооцоход банкнаас гаргадаг 1 жилийн хугацаатай зээлийн өсөлтөөс өндөр байгаа нь "ЛэндМН ББСБ" ХК нь барьцаагүй, цахим, богино хугацаат хэрэглээний зээлийн харилцагчид нэмэгдсээр байх үндэслэл болохоор байна.

*График 32: Өрхийн нэмэлт хэрэглээний өсөлт /тэрбум төгрөг/*




*Эх сурвалж: Монгол банк, судлаачийн тооцоолол*

Бонд гаргагч "ЛэндМН ББСБ" ХК-ийн гол бүтээгдэхүүн нь богино хугацаатай хэрэглээний зээл учир тус таамагт ашигласан ахиу хэрэглээний өсөлт нь тогтворжсон зах зээлийн оролцогчид илүү хамаарах боломжтой.

2021/05/24

2021.06.23-ны өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

# МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Маркетингийн төлөвлөгөө нь бизнесийг амжилтад хүргэж, хязгааргүй хэрэглэгчид рүү хөтлөх гүүр болж өгдөг. Маркетингийн төлөвлөгөө нь борлуулалтыг нэмэгдүүлэх гол түлхүүр юм.

## 1. Хураангуй

"ЛэндМН ББСБ" ХК-ийн 2021-2025 оны маркетингийн төлөвлөгөөний ерөнхий төсөөлөл нь одоо байгаа харилцагчдаа хадгалах халамжлах, шинэ харилцагчид руу чиглэсэн хиймэл оюун ухаанд суурилсан шинэ шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээгээр дамжуулан санхүүгийн салбарт шинэ жишиг тогтоож тэлэх бодлогыг баримтлан компанийн өсөлтийг хурдасгах, найдвартай хөрөнгийн эх үүсвэр бий болгоход чиглэж, харилцагчдынхаа өдөр бүрийн хэрэгцээ тулгамдсан асуудлыг шийдэж, зөвлөж байх үнэнч АНД нь байх маркетингийн стратеги, төлөвлөлт, төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэх юм.

## 2. Зорилтот харилцагчид

"ЛэндМН ББСБ" ХК-ийн үйл ажиллагаа нь харилцагчийн тоотой өндөр хамааралтай учир сард дунджаар 200 мянган төгрөгийн зээл авч эргүүлэн төлөх чадвартай харилцагчдынхаа тоог нэмэх, цаашлаад зах зээлийн хамрах хүрээг тэлэхийн тулд дундаас дээш насныханд хүрэх, ирээдүйн харилцагчдаа татахын тулд өсвөр залуу үеийнхэнд чиглэсэн санхүүгийн сахилга баттай байхын үнэ цэнд чиглэсэн тэдний АНД нь байх маркетингийн стратеги хэрэглэх нь зүйтэй юм. Мөн өнөөгийн харилцагчдын онцлог, хэрэглээ болон амьдралын хэв маяг КОВИД-19 вирусийн дараах өөрчлөлтийг урьдчилан таамаглаж маркетингийн төлөвлөлтөө эерэг байдлаар төсөөлж байна.

Бизнес эрхлэгчид аль цаг үеийнхэнд чиглэсэн маркетинг хийж байгаагаас хамаарч тэдний онцлог, өссөн орчин, нийгмийн асуудал, үнэ цэнэ зэргийг маш дэлгэрэнгүй судалж эхэлсэн байна. Ялангуяа ирээдүйн бүхий л бизнес, бараа үйлчилгээний хэрэглэгчид болох Зэт үеийнхнийг /Generation Z/ анхааралтай ажиглаж, тэдний зуршил, амьдралын хэв маяг, үнэ цэнд чиглэсэн тэдэнд илүү ойртож хүрсэн маркетингийн стратеги боловсруулахгүйгээр тухайн бизнес хол явахгүй гэдгийг ойлгож эхлээд байна. Хамгийн сонирхолтой нь Зэт үеийнхэнд бараа үйлчилгээгээ танилцуулж борлуулах хүмүүс нь Икс үеийнхэн болон шинэ мянганыхан учир тэднийг ойлгож мэдэхийн тулд ихээхэн хүчин чармайлт гаргах нь тодорхой байна.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО
ХАМТРАЛ ТЕК
ХХК
9021031196 СТС2420

СЗХ
он сар өдөр
2021.06.23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

*Зураг 15: Монгол харилцагчид, төрсөн оноор*



| Уламжлалтынхан /Traditionalists/ | Бүүмэрс /Boomers/ | Икс үеийнхэн /X generation/ | Шинэ мянганыхан /Millennial/ | Зэт үеийнхэн /Z generation/ |
|---|---|---|---|---|
| 1900-1945 оныхон | 1946-1964 | 1965-1976 | 1977-1997 | 1997-с хойш |
| -Халх голын дайн<br>-Сахилга баттай<br>-Хариуцлагатай<br>-Бүх юманд үнэнч<br>-Нийгмийн идэвхтэй<br>-Даруухан<br>-Арвич хямгач<br>-Юм цуглуулдаг<br>-Өр зээлэнд дургүй<br>-Авдрандаа үнэтэй зүйлсээ хадгалдаг<br>-Бэлэн мөнгөнөөс илүү үнэт эдлэл хэлбэрээр хадгалдаг<br>-Эх оронч | - Дүрэм журам сайн дагаж биелүүлдэг<br>- Хичээл зүтгэлтэй<br>- Маш ажилсаг<br>- Компьютер ашиглаж эхлэсэн анхны хүмүүс<br>- Үл хөдлөх хөрөнгийг чухалчилдаг<br>-Мулти таск сайтай<br>-Гүйлгээ ухаантай<br>-Гэр бүлийн гишүүд олуулаа | - Шилжилтийн Үеийнхэн<br>-Дээд боловсролыг чухалчилдаг<br>- Анхны гар утас хэрэглэгчид<br>- Өөрийнхөөрөө бага зэрэг бүдүүлэг<br>-Анхны хотын Соёлтнууд<br>-Ихэнх нь хувийн наймаа хийж үзсэн<br>-Үнэ төлбөргүй дээд боловсрол | - Картын бараа<br>- Монгол хүн анх сансарт ниссэн<br>- Зээлээс айдаггүй<br>- Хадгаламж хийж эхэлсэн үеийнхэн<br>-Yahoo мессенжер<br>- Google, Facebook<br>-Интернэтийн анхны хэрэглэгчид<br>-Боловсрол төлбөртэй болсон<br>-Өөрчлөлтөнд зохицож чаддаг | - Дижитал ертөнцийнхөн<br>- Эго ихтэй<br>- Өндөр хүлээлттэй<br>-Нийгмийн сүлжээнийхэн<br>- Таблет анх хэрэглэгчид<br>- Санхүүгийн мэдлэгтэй<br>- Бие даасан<br>- Өрсөлдөөнч<br>- Тренд дагадаг |

*Эх сурвалж: Монголын зэт үеийнхэний харж байгаа өнцөг*

## 3. Маркетингийн стратеги

"ЛэндМН ББСБ" ХК-ийн 2021-2025 оны маркетингийн стратегийн баримтлах үндсэн чиглэл урт хугацааны алсын хараа нь дэлхийн энтэй шинэ шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээгээр Монголын санхүүгийн зээлд манлайлахад одоогийн харилцагчид болон зах зээл дээр шинэ шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээнүүдээ танилцуулан санал болгохтой холбоотой тэдгээрт уялдуулсан маркетингийн идэвхжүүлэлтээр тэлэх, өсөх бодлого баримтлан үнэнч харилцагчдаа халамжлах, санхүүгийн зах зээлд тэргүүлэх байр сууриа хадгалах, үнэнч харилцагчдыг нэмэгдүүлэх, ЛэндМН аппликейшнээ харилцагчдад улам хялбар боловсронгуй болгож сайжруулалт хийх дээр анхаарч харилцагчдынхаа үнэнч итгэлт АНД нь байх маркетингийн хоногшилт болон брэндийг өргөжүүлэх стратегийн цогц бодлого хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна.

"ЛэндМН ББСБ" ХК нь дижитал хувьсгалын илрэл болсон сонгодог бүтээгдэхүүнийг санал болгож байгаагийн хувьд харилцагчдын онцлогийг нарийн судалсаар байгаа ба харилцагчдын тоо болон зээл, төлбөр тооцооны хэрэгцээнд үндэслэн дараах стратегийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118207206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨДРИЙН ЭНД КО ...
ХХК
73

**Хоногшуулалтын стратеги маркетинг**

Хоногшуулалт нь янз бүрийн брэндийн ялгааг хэрэглэгчийн оюун ухамсарт хэрхэн мэдрүүлэхтэй холбоотой процесс юм.

Хамгийн энгийн байдлаар “хоногшуулалт” бол таны ухамсарт судлагдаж буй бүтээгдэхүүний дүр зураг юм гэж тодорхойлжээ. Иймээс хоногшуулалтын хувьд бүтээгдэхүүн үйлчилгээний бодит өөрчлөлт гэхээс илүү өрсөлдөгчтэй тухайн бүтээгдэхүүнийг харьцуулсан боломжит хэрэглэгчийн оюуны дүгнэлт, үзэл санаанд өөрчлөлт хийх арга билээ. Одоогийн бүтээгдэхүүн үйлчилгээгээ одоогийн зах зээл дээр улам гүнзгийрүүлэн өргөжүүлэн тэлэх юм.

**Үнэ цэнд чиглэсэн маркетинг /Meaning out/**

Шинэ утга санаа, үнэ цэнийг илэрхийлсэн “meaning” болон аливааг эвдэн ил гарах гэсэн утгатай “coming out” гэсэн үгний нийлбэр ба өмнө нь бусдын өмнө чөлөөтэй илэрхийлж чаддаггүй байсан нийгэм болон хувь хүний хувьд утга учиртай зүйлсээ худалдан авалт, хэрэглээгээрээ илэрхийлэхийг хэлдэг байна. Нийгмийн сүлжээний хөгжлийг дагаад гэр бүлд төвлөрсөн үнэ цэнээс илүүтэй, өөрийн сонирхлоор нэгдсэн коммьюнити/бүлэг/-т нэгдэж, тэндээс хамааралтай хэв маягтай болохыг хэлнэ. Жишээ нь хямд үнээс илүүтэй тухайн үйлчилгээ авах явцад төрсөн сэтгэгдэл, дурсамж, түүх, туршлагад төлбөр төлдөг болсон гэсэн үг юм.

“ЛэндМН ББСБ” ХК нь AI /хиймэл оюун ухаан/, брэндийн үнэ цэнэ, сошиал медиа дах идэвхжүүлэлт болон шинэ бүтээгдэхүүн үйлчилгээгээ зах зээл рүү өргөжилт тэлэлт хийхдээ 2021 оноос 2025 он хүртэл B2C компаниудаас маркетингийн чиг хандлага ялгарлаараа, өнгө төрхөөрөө манлайлна гэсэн амбиц үзэл бодолтойгоор урагшилж байна. Хувь хүний оролцоонд илүү ач холбогдол өгөх, хувь хүний өвөрмөц хэрэгцээ, хүлээлтэд нийцсэн мессеж, санал илгээх, хэрэглэгч бүрийн хувийн хүсэл сонирхлын талаар гүн ойлголт дээр тулгуурлаж ажиллах юм.

Цар тахлын дараах хямралаас сэргэх, дасан зохицох чиглэл рүү шилжиж буй харилцагчидтайгаа илүү ойртож харилцагчидтайгаа нэг түвшинд анд найз шиг нь байх зэрэг хандлагатайгаар бүтээгдэхүүн, үйлчилгээнд итгэл хүлээлгэсэн хэрэглэгчдийн харилцааг бизнесийн үнэ цэнэ болгох онцгой боломж байна гэж үзэж байна.

Гол хэмжүүрүүд болох хэрэглэгчийн амьдралын үнэ цэн, сэтгэл ханамжийн өөрчлөлтийн мэдээллийг ажиглан, хянах нь бидэнд юу нь болж, юу нь болохгүй байгааг "цогцоор нь" харуулж дор бүр нь уян хатан нөхцөлөөр сайжруулалт хийж төлөвлөн ажиллах юм.

**Учир шалтгаантай маркетинг /Cause marketing/**

Байгаль орчин, нийгмийн асуудлыг шийдвэрлэж чадсан компанийн маркетингийн арга барилыг хэлэх ба энэ нь хэрэглэгчдийн хэрэглээнд нөлөөлж, улмаар тухайн компанийн брэндийг үнэлэх, байнгын харилцагч болох түлхүүр болдог байна. Жишээ нь Facebook компани өөрийн уриаг НҮБ-ын тогтвортой хөгжлийн 17 зорилтын нэг болох

2021/05/24

СЗХ
2021 06 23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

"Инноваци, дэд бүтцийг нэмэгдүүлэх" зорилтыг шингээсэн "Бид дэлхийг холбоно" гэсэн байхад Google "Мэдээллийн тэгш хүртээмж" гэсэн байдаг. Цар тахлын үеэр хүмүүсийн гар утас, нийгмийн сүлжээнд зарцуулж буй цаг дээд цэгтээ хүрсэн. Гар утсанд зарцуулах хугацаа ирэх жилүүдэд улам өсөх хандлага төлөв ажиглагдаж байгаа бөгөөд сошиал медиад хуваарилах хэрэглэгчид рүү чиглэсэн учир шалтгаантай сурталчилгаа контент дээрээ илүү анхааран ажиллах шаардлага үүсэж байна.

**Agile маркетинг**

Зах зээлд шинээр нэвтрэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх нь түргэн шуурхай арга барил шаарддаг. Зах зээлд бүтээгдэхүүн үйлчилгээ санал болгодог B2C компаниудын хувьд зах зээлээ тэлэх болон өргөжихөд ямар өөрчлөлт шинэчлэлт хийх нь нэн тэргүүний зорилт хэвээр байна. Байгууллагууд динамикаар маркетингийн стратегитай дасан зохицохын хэрээр Agile маркетингийн хандлага анхаарлын төвд орж байна. Agile маркетинг нь хэрэглэгчийг төв болгон борлуулалтын үе шатанд үзүүлж буй хариу үйлдлийг ажиглах, сорих, хамтран ажиллахад анхаардаг. Түүнчлэн Agile маркетинг нь гол бүтээгдэхүүн, үйлчилгээгээ зах зээлд таниулахад бүх өндгөө нэг сагсанд хийх эрсдэлээс сэргийлэх замаар төсвөө хэмнэх боломжийг олгодог. Хүмүүсийн зан төлөвийн өөрчлөлт, үйлчлүүлэгчид, бизнес эрхлэгчдээс хүлээх хүлээлт болон нийгэм бүхэлдээ маркетингт байнгын өөрчлөлтийг шаардаж байдаг. Борлуулалт ба маркетингийн шинэ юүлүүр нь маркетингийг оролцоо, хуваарилалт, хяналтыг хадгалах хэрэгсэл гэж үздэг. Товчоор хэлбэл, инновац бол маркетингийн удирдлагуудын хувьд хамгийн том давуу тал юм. Байнга шинийг эрэлхийлж, шинэ үнэ цэнийг бий болгох, хамгийн шинэлэг, шилдэг бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэгчдэдээ хүргэхээр бид зорин ажиллаж байна.

Үйлчлүүлэгчидтэйгээ холбоо тогтоох, Ковид 19 цар тахлын дараах итгэлцлийг нэмэгдүүлэхэд хэрэглэгчид рүү чиглэсэн маркетинг, хэрэглэгчдэд бий болж буй сэтгэгдлийг эерэг байлгах зэрэг нь чухал үүрэгтэй. Компанийн хэрэглэгчидтэйгээ эргэх холбоотой байх эсэх нь бүтээгдэхүүн, үйлчилгээтэй адил чухал ач холбогдолтой гэж хэрэглэгчдийн дийлэнх хувь нь үздэг. Үүний үр дүнд хэрэглэгчид үзүүлэх анхаарал, халамж, сурталчилгаанд санаачилгатай байх тал дээр анхаарч ажиллахаар төлөвлөж байна.

**ЛэндМН ББСБ ХК-ийн 6 үнэт зүйл:**

1. Инноваци
2. Хурд
3. Хариуцлага
4. Тасралтгүй суралцагч
5. Ухаалаг ажиллах
6. Хүн төвт

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206



УЛААНБААТАР ХОТ
ХХК
5183856
0021031195 СТС2420

СЗХ
2021 06 23
БҮРТГЭВ
№01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

## 2.4 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Үнэт цаас гаргагч нь эрсдэлийн удирдлагын соёл, сайн засаглалыг бий болгохыг зорин ажилладаг бөгөөд эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, санхүүгийн болон санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэлийг зохистой түвшинд удирдах зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2019 оны 10 сарын 23-ны өдрийн 19/55 тоот тогтоолоор "Эрсдэлийн удирдлагын бодлого"-ыг баталсан. Тус бодлогоор эрсдэлийн "Гурван шатлалт хамгаалалт"-ыг бүрдүүлж үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаж байгаа төдийгүй компанийн бизнесийн үйл ажиллагаа, стратегийг хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хязгаарыг тогтоож, тогтмол хяналт тавин, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд улирал бүр тайлагнадаг.

Мөн зээлийн эрсдэлийн хүрээнд зээл түүнтэй адилтгах, активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах, зарцуулах бодлогыг ТУЗ-ийн 19/55 тоот тогтоолоор батална үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байгаа.

Харин компанийн үйл ажиллагаа зохистой, үр ашигтай байх, санхүүгийн тайлагнал үнэн зөв, бодитой байх, хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөж хэвшүүлэхэд чиглэсэн "Дотоод хяналтын бодлого"-ыг ТУЗ-ийн 2020 оны 12 сарын 23-ны 20/38 тоот тогтоолоор баталсан байна.

Түүнчлэн мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, комплаенсийн эрсдэлийн хүрээнд "Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны журам" болон "Дотоод хяналт эрсдэлийн удирдлагын хөтөлбөр"-ийг шинэчлэн найруулж гүйцэтгэх захирлын №2020/64 тоот тушаалаар баталсан нь СЗХ-ноос МУТС тэмцэх чиглэлээр хэрэгжилтийг хангасан компани гэж дүгнэсэн төдийгүй Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага болох FATF-ын шалгалтаар ирсэн биет төлөөлөгчидтэй ЛэндМН ББСБ ХК нь нийт Финтек -ийн үйл ажиллагаа эрхэлдэг Банк бус санхүүгийн байгууллагуудыг төлөөлж амжилттай оролцсон юм. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь Эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлогын баримт бичгийн дагуу эрсдэлийн тогтолцоо, цар хүрээ, зээлийн багц, эрсдэлийн хяналт зохистой түвшинд, үр дүнтэй байгаа эсэх талаар тайланг улирал бүр хэлэлцэн дүгнэдэг. Энэ нь эрсдэлийг зохистой хэмжээнд удирдах, эдийн засаг, зохицуулалтын орчин, өрсөлдөөн дэх хөгжил, хариу үйлдэл, өөрчлөлтөд бэлэн байх зэрэг төлөвлөгөөг боловсруулахад гол үүрэг гүйцэтгэдэг. Тэр ч утгаараа "ЛэндМН ББСБ" ХК нь КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, санхүүгийн хүндрэлтэй цаг үед харилцагчид, хувьцаа эзэмшигчид болон компанид ирээдүйд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд тухай бүр хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлж, эрсдэлийн удирдлагын үр дүнтэй нэгдсэн тогтолцоог бүрдүүлж ажиллажээ.

Түүнээс дурдвал 2020 онд Эрсдэлийн цар тахлаас үүдэлтэй санхүүгийн хямралтай холбоотойгоор зээлийн эрсдэлийн удирдлага дээр онцгойлон анхаарч зохих шат дараалсан арга хэмжээг авч ажилласан бөгөөд санхүүгийн хүндрэлд орсон 196 харилцагчийн 26.0 сая төгрөгийн зээлийн болон шимтгэлийн дүнг чөлөөлсөн байна. Мөн 2020 онд цар тахлаас үүдэлтэйгээр Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан мэдэгдлийн дагуу зээлийн эргэн төлөлтөд доголдол үүссэн харилцагчдыг өрийн дарамтаас сэргийлэх зорилгоор 179.8 тэрбум төгрөгийн зээлийн, эргэн төлөлтийн

lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨНДӨР ЭНД КО
КАПИТАЛ ҮЦК
ХХК
5183655

СЗХ
2021 06. 23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18
БҮРТГЭВ-03

хугацааг сунгаж зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Мөн харилцагчид зээлийн эргэн төлөлтийн таатай боломжийг олгох зорилгоор ирээдүйд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор зээлийн уян хатан нөхцөлийг санал болгон, төлбөрийг хэсэгчлэн төлөх боломжтой байх зэргээр бусад хөнгөлөлт, урамшууллыг Засгийн газрын шийдвэрийг үндэслэн харилцагч нартаа олгосон байна.

"ЛэндМН ББСБ" ХК зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээлийн үнэ цэнийн бууралтыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-9 (IFRS-9) дагуу тооцдог. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-д заасны дагуу 2020 оны жилийн эцэст 1.6 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц сан байгуулахаар байсан боловч СТОУС-9 (IFRS-9)-ын стандартын дагуу 3.3 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц санг байгуулсан. Энэ нь санхүүгийн зохицуулах хорооны дээрх журмаар тооцвол зээлийн эрсдэлийн нөөц санг хангалттай түвшинд буюу нийт чанаргүй зээлийн багцын 130%-тай тэнцэх хэмжээнд байгуулжээ.

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь улирал бүр компанийн эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөх хэм хэмжээг хэлэлцдэг бөгөөд улирал бүр зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг гарган ажилладаг.

Доорх хүснэгтээс 2018-2020 онуудад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажилласныг харж болно.

*Хүснэгт 15: Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт*

| Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа>10% | 52.10% | 26.00% | 52.10% |
| Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активийн харьцаа>20% | 52.10% | 26.01% | 52.10% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт>8% | 38.00% | 17.80% | 43.20% |
| Нэг зээлдэгч, түүний холбогдох этгээдэд олгох зээл, актив, баталгаа <30% | 0.01% | 0.04% | 0.02% |
| ББСБ-ийн холбогдох этгээдэд олгох зээл, актив, баталгаа <10% | 0.01% | 0.03% | 0.01% |
| Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт)<±40% | 0.03% | -5.30% | 0.50% |

## Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгээс...

### ГУРАВ.ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗАСАГЛАЛ, БҮТЭЦ, ЧИГ ҮҮРЭГ

3.1. "ЛэндМН ББСБ" ХК-ийн эрсдэлийн удирдлага нь засаглалын дараах бүрэлдэхүүнтэй байна.

3.1.1. Хамгаалалтын 3 бүс;

3.1.2. Засаглалын хороод;

3.1.3. Засаглалын бичиг баримт-Бодлого, журам, заавар.

3.2. "ЛэндМН ББСБ" ХК нь эрсдэлийн удирдлагыг дараах бүтцээр хэрэгжүүлнэ:

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

2021/05/24

ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2021.06.29
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03




3.3 "ЛэндМН ББСБ" ХК нь эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ дараах гурван (3) давхар хамгаалалтын бүсийн хяналтыг хэрэгжүүлнэ.

| Хамгаалалтын бүс | Хамаарах нэгж | Чиг үүрэг |
|---|---|---|
| I бүс<br><br>Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ. | Бизнесийн болон тэдгээрт дэмжлэг үзүүлэх нэгж | - Эрсдэлийг хариуцаж, удирдах эзэн буюу нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой гарах эрсдэлийг тодорхойлох, илрүүлэх, хариу арга хэмжээ авах, хяналтад байлгах, удирдах. |
| II бүс<br><br>Эрсдэлийн удирдлагын хяналтыг хэрэгжүүлнэ. | Эрсдэлийн хариуцсан нэгж | - Эрсдэлийн удирдлагын тогтолцоог тодорхойлох, эрсдэлийн удирдлагын бодлого, журам, зааврыг боловсруулах, хянах, шинэчлэх, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ, хязгаарыг тодорхойлох, батлуулах, хянах, мониторинг хийх;<br>- Хамгаалалтын I бүсийн эрсдэлийн удирдлага, хяналтын зохион байгуулалт, үйл ажиллагаанд мониторинг хийх, заавар, зөвлөмжөөр хангах. |
| III бүс<br><br>Хараат бус баталгаажуулалтаар хангана. | Дотоод аудитын нэгж | - Хамгаалалтын I бүсийн хэрэгжүүлж буй хяналтын тогтолцоо, түүний гүйцэтгэлийн хэрэгжилтэд хяналт тавих, дотоод хяналтын тогтолцоонд сайжруулах шаардлагатай сул талуудыг тодорхойлох;<br>- Хамгаалалтын II бүсийн тавьж буй хянан нийцүүлэлт, үнэлгээ, тайлагналын үр дүнтэй байдалд хараат бус үнэлэлт, дүгнэлт өгөх;<br>- Эрсдэлд суурилсан үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлага, түүний засаглал, дотоод хяналтыг баталгаажуулж үнэлэх, ТУЗ-д тайлагнах. |

## ДӨРӨВ. ЭРСДЭЛИЙН ТӨРӨЛ, АНГИЛАЛ

4.1 "ЛэндМН ББСБ" ХК-ийн үйл ажиллагаа, бизнесийн зорилтод сөрөг нөлөө үзүүлсэн эсхүл нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлийг, тэдгээрийн хүчин зүйл, үр дагавраас хамааруулан дараах төрөлд хуваана.

| Эрсдэлийн төрөл | Үүсгэх хүчин зүйл | Эрсдэлийн үйл явдал, үр дагавар |
|---|---|---|
| Зээлийн эрсдэл | Дотоод хүчин зүйл:<br>▪ Бодлого, журам, стандартууд, бүтээгдэхүүний нөхцөл;<br>▪ Зээлийн скоринг, зээлдэгчийн үнэлгээний загвар, аргачлал;<br>▪ Зээлийн төвлөрөл;<br>▪ Зээлийн хяналтын тогтолцоо;<br>▪ Зээл төлүүлэх ажиллагаа; | ▪ Зээлийн багцын чанар буурах;<br>▪ Зээл төлөгдөхгүй байх магадлал (PD) болон зээлийн алдагдал үүсэх (LGD) магадлал нэмэгдэх; |

ЛэндМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118767206

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

2021.06.23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

| | | |
|---|---|---|
| | <u>Гадаад хүчин зүйл:</u><br>▪ Эдийн засгийн тогтворгүй байдал;<br>▪ Зээлдэгчийн төлбөрийн чадвар алдагдах. | ▪ Зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн хэмжээ өсөх;<br>▪ Зээл төлүүлэх ажиллагааны зардал нэмэгдэх. |
| Зах зээлийн эрсдэл | <u>Дотоод хүчин зүйл:</u><br>▪ Гадаад валютын нээлттэй позицийг зохистой түвшинд барихгүй байх;<br>▪ Эх үүсвэр, активын удирдлага (хүүнд мэдрэг хөрөнгө, өр төлбөрийн зөрөө сөрөг байх);<br><u>Гадаад хүчин зүйл:</u><br>▪ Эдийн засаг, зах зээлийн өөрчлөлтөөс үүдэх алдагдал;<br>▪ Гадаад валют, үнэт цаасны ханшийн хэлбэлзэл;<br>▪ Зах зээлийн хүүгийн түвшин өөрчлөгдөх, Зохицуулагч байгууллагаас зохицуулалт хийх. | ▪ Гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс санхүүгийн алдагдал хүлээх;<br>▪ Эх үүсвэр болон активын хүүгийн зөрөөгээс санхүүгийн алдагдал хүлээх. |
| Хөрвөх чадварын эрсдэл | <u>Дотоод хүчин зүйл:</u><br>▪ Төлөвлөлт хангалтгүй байх;<br>▪ Тайлагналт хангалтгүй байх;<br>▪ Дотоод хяналт сул байх;<br>▪ Эх үүсвэр, активын удирдлага-эргэн төлөгдөх хугацааны хуримтлагдсан зөрөө сөрөг байх;<br>▪ Эх үүсвэрийн төвлөрөл;<br><u>Гадаад хүчин зүйл:</u><br>▪ Эдийн засаг, зах зээлийн өөрчлөлт. | ▪ Зохистой харьцаа алдагдах;<br>▪ Төлбөрийн чадвар алдагдах буюу зээлдүүлэгч болон харилцагчийн мөнгөн хөрөнгийг анхны шаардлагаар буцаан төлөх боломжгүй болох;<br>▪ Зээлийн эрэлт, өсөлтийг хангахгүй болох. |
| Өөрийн хөрөнгийн эрсдэл | <u>Дотоод хүчин зүйл:</u><br>▪ Төлөвлөлт хангалтгүй байх;<br>▪ Тайлагналт хангалтгүй байх;<br>▪ Дотоод хяналт сул байх;<br>▪ Үйл ажиллагааны ашиг, алдагдал;<br><u>Гадаад хүчин зүйл:</u><br>▪ Эдийн засаг, зах зээлийн өөрчлөлт;<br>▪ Хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал;<br>▪ Хөрөнгө оруулагчдын ашиг, сонирхол. | ▪ Өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа үзүүлэлт алдагдах;<br>▪ Активын, ялангуяа зээлийн эрэлт, өсөлтийг хязгаарлах. |
| Үйл ажиллагааны эрсдэл | <u>Дотоод хүчин зүйл:</u><br>▪ Дотоод үйл ажиллагааны тохиромжгүй, доголдолтой байдал (бодлого, журам, заавар, стандартгүй, эсхүл тохиромжгүй байх);<br>▪ Дотоод хяналтын тогтолцоо тохиромжгүй, эсхүл сул байх;<br>▪ Бүтээгдэхүүн, үйлчилгээний алдаа;<br>▪ Ажлын байр, хөдөлмөрийн аюулгүй байдлын зөрчил;<br>▪ Дотоод ашиглан;<br><u>Гадаад хүчин зүйл:</u><br>▪ Байгалийн гамшиг;<br>▪ Үймээн самуун;<br>▪ Хууль эрх зүйн өөрчлөлт;<br>▪ Гадны залилан;<br>▪ Гэмт халдлага;<br>▪ Хамтрагч, ханган нийлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа (Банк, ЗМС, Оператор, Цахилгаан, Интернет, бусад). | ▪ Биет эд хөрөнгийн зардал;<br>▪ Бизнесийн үйл ажиллагааны тасалдал;<br>▪ Санхүүгийн хохирол (мөнгөн алдагдал);<br>▪ Санхүүгийн бус хохирол (мөнгөн дүнгээр хэмжих боломжгүй). |

2021/05/24

СЗХ
2021 оны 06 сарын 23 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18
БҮРТГЭВ-03

| | | |
|---|---|---|
| Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл | Дотоод хүчин зүйл:<br>▪ Мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журам, тогтолцоо, түүний хэрэгжилт алдагдах;<br>▪ Програм болон техник хангамж дээр эмзэг байдал бий болох;<br>▪ Ажилтнуудын ёс зүйн зөрчил, мэдлэг, санаатай болон санамсаргүй алдаа дутагдал;<br>Гадаад хүчин зүйл:<br>▪ Нийлүүлэгчийн эрсдэл (програм хөгжүүлэгч, интернет, үүрэн холбооны оператор, цахилгаан эрчим хүч, сервер);<br>▪ Цахим халдлага. | ▪ Мэдээлэл алдагдах, түүнийг буруугаар ашиглах;<br>▪ Мэдээллийн бааз гэмтэх, устах, мэдээлэлд хандах боломжгүй болох;<br>▪ Систем алдаатай ажиллах;<br>▪ Системийн онгорхой, эмзэг байдлыг ашиглах;<br>▪ Бизнесийн үйл ажиллагаа тасалдах зэргийн улмаас Компанид Санхүүгийн хохирол (мөнгөн алдагдал);<br>▪ Санхүүгийн бус хохирол (мөнгөн дүнгээр хэмжих боломжгүй) учрах. |
| Комплаенсийн эрсдэл | Дотоод хүчин зүйл:<br>▪ МУ-ын хууль, тогтоомж, эрх зүйн акт, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк болон бусад зохицуулагч байгууллагын шаардлагыг хангаж ажиллаагүй;<br>▪ Харилцагч, гуравдагч этгээдэд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх;<br>▪ Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хангалтгүй хийх;<br>▪ Гүйлгээнд тавих хяналт алдагдах;<br>▪ Алдаатай бүтээгдэхүүн, үйлчилгээ;<br>▪ Ажилтны ёс зүйн зөрчил, алдаа дутагдал;<br>▪ Ажилтан дотоод бодлого, журам, заавар, стандартыг мөрдөхгүй байх, зөрчих;<br>Гадаад хүчин зүйл:<br>▪ МУ-ын хууль, тогтоомж, эрх зүйн актын ойлгомжгүй, зөрчилтэй байдал, эрх бүхий байгууллагын тайлбар;<br>▪ Зохицуулагч байгууллага, шүүхийн үйл ажиллагаа. | ▪ Дотоод хяналт, дотоод болон хөндлөнгийн аудит, зохицуулагч байгууллагын хяналт шалгалт, харилцагчийн гаргасан гомдол, гэрээт байгууллагаас тавьсан шаардлагын дагуу Компанид:<br>▪ Санхүүгийн хохирол (мөнгөн алдагдал, хохирол, нөхөн олговор, торгууль, анз, алданги, шийтгэл);<br>▪ Санхүүгийн бус хохирол (мөнгөн дүнгээр хэмжих боломжгүй) учрах. |
| Нэр хүндийн эрсдэл | Дотоод хүчин зүйл:<br>▪ Компанийн засаглал, удирдлага болон ажилтнуудын үйл ажиллагаа, нэр хүнд;<br>▪ Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үнэ;<br>▪ Бизнесийн үйл ажиллагааны доголдол буюу Хөрвөх чадвар, Үйл ажиллагаа, Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн хүчин зүйлээс хамаарч Компанийн нэр хүндэд сөрөг нөлөө учрах.<br>Гадаад хүчин зүйл:<br>▪ Сөрөг сэтгэгдэл, нийтлэл, үнэлгээ;<br>▪ Гуравдагч этгээдийн санаатай довтолгоо;<br>▪ Зохицуулалтын өөрчлөлт;<br>▪ Хэрэглэгчээс өөрөөс хамаарсан хүчин зүйл. | ▪ Санхүүгийн хохирол (мөнгөн алдагдал+Хувьцааны ханш, үнэлгээ буурах, унах);<br>▪ Санхүүгийн бус хохирол (мөнгөн дүнгээр хэмжих боломжгүй). |

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨГӨЖ ЭВАКО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
он сар өдөр
2021.06.23
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-05-18
БҮРТГЭЛ-03

| | | |
|---|---|---|
| Стратегийн эрсдэл | Дотоод хүчин зүйл:<br>▪ Компанийн засаглал, Гүйцэтгэх удирдлагын өөрчлөлт;<br>▪ Хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх;<br>▪ Бүтээгдэхүүн, үйлчилгээ;<br>▪ Нэгдэх, нийлэх үйл ажиллагаа.<br>Гадаад хүчин зүйл:<br>▪ Өрсөлдөгчдийн үйл ажиллагаа;<br>▪ Технологийн өөрчлөлт;<br>▪ Зах зээлийн хандлага, хэрэглэгчийн зан төлөв;<br>▪ Сонирхогч талуудын шаардлага, хэрэгцээ;<br>▪ Хууль, эрх зүй, зохицуулалтын өөрчлөлт. | ▪ Санхүүгийн хохирол (мөнгөн алдагдал-Орлого буурах, зардал өсөх, ашигт ажиллагаа буурах, алдагдал өсөх, борлуулалтын хэмжээ, зах зээлд эзлэх хувь хэмжээ, харилцагчийн тоо, хэрэглээ буурах гэх мэт);<br>▪ Санхүүгийн бус хохирол (мөнгөн дүнгээр хэмжих боломжгүй-алдагдсан боломжийн зардал өсөх гэх мэт). |

4.2 "ЛэндМН ББСБ" ХК-д учирч болзошгүй эрсдэлийг хамгаалалтын I болон II дугаар бүсийн түвшинд дараах албан тушаалтан, нэгж хянаж, удирдана.

| Эрсдэлийн төрөл | I бүс | II бүс |
|---|---|---|
| Зээлийн эрсдэл | ▪ Бүтээгдэхүүн хариуцсан нэгж | ▪ Эрсдэлийн удирдлага |
| Зах зээлийн эрсдэл | ▪ Санхүүгийн менежер | ▪ Эрсдэлийн удирдлага |
| Хөрвөх чадварын эрсдэл | ▪ Санхүүгийн менежер | ▪ Эрсдэлийн удирдлага |
| Өөрийн хөрөнгийн эрсдэл | ▪ Санхүүгийн менежер | ▪ Эрсдэлийн удирдлага, Гүйцэтгэх захирал |
| Үйл ажиллагааны эрсдэл | ▪ Бүх нэгж | ▪ Эрсдэлийн удирдлага (үйл ажиллагааны эрсдэл) |
| Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл | ▪ Мэдээллийн технологи хариуцсан нэгж | ▪ Аюулгүй байдал хариуцсан ажилтан |
| Хянан нийцүүлэлтийн эрсдэл | ▪ Бүх нэгж | ▪ Эрсдэлийн удирдлага (эрх зүй, хянан нийцүүлэлт) |
| Нэр хүндийн эрсдэл | ▪ Бизнесийн нэгж | ▪ Эрсдэлийн удирдлага, Гүйцэтгэх захирал |
| Стратегийн эрсдэл | ▪ Гүйцэтгэх захирал | ▪ Төлөөлөн удирдах зөвлөл |

4.3 Эрсдэлийн төрөл тус бүрийн хамгаалалтын I болон II дугаар бүст хамаарах нэгж, албан тушаалтныг "ЛэндМН ББСБ" ХК-ийн Эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж, түүний удирдлага нь бусад эрх бүхий албан тушаалтнуудыг оролцуулан, жилд нэгээс доошгүй удаа хянаж, шаардлагатай тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг оруулах саналыг Эрсдэлийн удирдлагын хороогоор хянуулж, хэлэлцүүлсний үндсэн дээр ТУЗ-д танилцуулж, батлуулна.

## ЗУРГАА. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗАРЧИМ

| Эрсдэлийн удирдлагын зарчим | Агуулга |
|---|---|
| Үнэ цэнийг бий болгох: | Эрсдэлийн удирдлага нь ЛэндМН-ийн үнэт зүйлийг сахин хамгаалах, хууль ёсыг дээдлэн, сайн засаглалыг бүрдүүлэх, стратегийн зорилгыг хэрэгжүүлж, өрсөлдөх чадвартай, үр ашиг бүхий, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүндтэй байгууллагыг бий болгох хувь нэмрээ оруулдаг байх ёстой. |
| Харилцагчийн өмнө хүлээх үүрэг: | ЛэндМН нь өөрийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг тооцоолохоос гадна хувьцаа эзэмшигч болон нийт харилцагч, түншүүдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийг эрмэлзэж ажиллана. |

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2021.06.28
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

| | |
|---|---|
| Бүхий л үйл ажиллагааны салшгүй хэсэг байх: | Эрсдэлийн удирдлага нь ЛэндМН-ийн Гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын хариуцах ажил байхын зэрэгцээ өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөх, хянах үүрэгтэй байна. |
| Шийдвэр гаргах үйл явцын нэг хэсэг байх: | Эрсдэлийн удирдлага нь ажилтнуудад мэдрэмжээрээ бус мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах, эрсдэлийг эрэмбэлэн, нэн чухал эсвэл нэн эрсдэлтэйг эхлэн шийдэх боломжийг олгоход чиглэнэ. |
| Шат дараалсан, уялдаа холбоотой, цаг хугацааны хэмжүүртэй байх: | тууштай, найдвартай бөгөөд эерэг үр дүнг бий болгоход чиглүүлж ажиллана |
| Бодит байдалд суурилах: | Эрсдэлийн удирдлага нь түүхэн мэдээлэл, бусад нэгжийн санал, ажиглалт, урьдчилсан таамаг болон, эрсдэлийн ажилтны дүгнэлт зэрэг бодит мэдээллийг үндэслэх ба хэрэгжих боломжтой байна. |
| Уялдан зохицох: | Гадаад болон дотоод орчны нөхцөл байдлаас шалтгаалж үйл явдал, эрсдэл өөрчлөгдөх магадлалтай. Иймд эрсдэлийг удирдах арга барилаа шинэчилж, сайжруулж ажиллана. |
| Ил тод байх: | ЛэндМН ирээдүйд гарч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцоолж, мэдэгдэж буй бүх эрсдэлийн талаар ажилтан бүр мэдэж байгаа эсэхийг баталгаажуулна. |
| Бүх талуудын оролцоог хангах: | Эрсдэлийн удирдагыг хэрэгжүүлэхэд Компанийн бүхий л ажилтнуудыг зохих байдлаар оролцуулна. Эрсдэлийн удирдлагыг Компанийн гишүүн бүрт хамаатай болгох нөхцөлийг бүрдүүлэн, эрсдэлийг тодорхойлоход ажилтан бүр санал бодол, дуу хоолойгоо илэрхийлэх нөхцөлийг бий болгоно. |
| Эрсдэл, өгөөжийг тэнцвэржүүлэх: | ЛэндМН нь бүхий л үйл ажиллагаандаа эрсдэл, өгөөжийн оновчтой харьцааг хадгалан, хяналт тавьж ажиллана. |
| Хараат бус, бие даасан байх: | Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ хараат бус, хөндлөнгийн байр сууринаас үнэлж, дүгнэнэ. |
| Тайлагнах: | Нэгжийн ажилтан бүр олж илрүүлсэн эрсдэлийг шууд удирдлагадаа шуурхай мэдээлдэг байна. Бүх шатны удирдлагууд өөрийн хариуцсан нэгж болон түүнд хамаарах үйл ажиллагаанд хамаарах эрсдэлийн тайланг Хамгаалалтын II бүс болон Эрсдэл хариуцсан нэгжид тогтмол, үнэн зөв тайлагнана. |
| Эрсдэлийн соёл: | ЛэндМН-ийн нийт ажилтнууд нь эрсдэлийн удирдлагын бодлого, журам заавры дагаж мөрдөн* эрсдэлийн талаарх мэдлэг мэдээлэлтэй байх ба өөрийн хариуцсан ажил, чиг үүргийг хэрэгжүүлэхдээ учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, удирдах үүрэгтэй. ЛэндМН нь эрсдэлийн соёлыг бий болгоход нийт ажилтнуудад эрсдэлийг удирдах техникийн арга барилаас гадна эрсдэлд хандах хандлагыг өөрчлөхөд чиглэсэн сургалтыг зохион байгуулна. |

## ДОЛОО. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

7.1. "ЛэндМН ББСБ" ХК нь эрсдэлийн удирдлагыг дараах процессоор хэрэгжүүлнэ.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЕКТ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
Он 2021 сар 06 өдөр 23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03




*Схем 7: Эрсдэлийн удирдлагын процесс*

7.2. <u>Чиг хүрээг тодорхойлох (Establish Context):</u> Эрсдэлийн удирдлагын чиг хүрээг тодорхойлж, эрсдэлийн төрөл, үйл ажиллагаанаас хамаарч эрсдэлийг хэрхэн илрүүлэх, үнэлэх, хариу арга хэмжээ авах, хянах төлөвлөгөө, чиг, хүрээг хамгаалалтын I болон II бүс хамтран тодорхойлно.

7.3. <u>Эрсдэлийг илрүүлэх/тодорхойлох (Risk Identification):</u> Хамгаалалтын I бүс өөрийн хариуцсан үйл ажиллагаа, чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг тодорхойлох ба энэхүү үе шатанд i) Эрсдэлийн бүртгэл, ii) Эрсдэлийн тайлан гэсэн хоёр төрлийн бичиг баримтыг үйлдэнэ. илрүүлсэн эрсдэл бүрийг Эрсдэлийн бүртгэлд бүртгэж, Хамгаалалтын II бүсэд тухай бүр мэдээлж, тайлагнана.

7.4. <u>Эрсдэлийн үнэлгээ (Risk assessment-Analysis and Evaluation):</u> Илрүүлсэн буюу тодорхойлсон эрсдэл бүрийг Компани удирдах боломжгүй тул Эрсдэлийг чанарын шинжилгээ болон тоон үзүүлэлтээр үнэлэн, Эрсдэлийн түвшинг тогтоож, Эрсдэлийг эрэмбэлэн, хариу арга хэмжээ авах зэрэглэлийг тогтооно.

<u>7.4.1 Эрсдэлийн түвшин (Risk ranking):</u> Илрүүлсэн эрсдэл тус бүрийг эрсдэл тохиолдох магадлал болон түүний бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгө, ашигт ажиллагаанд нөлөөлөх үр дагавраас хамааруулан дараах 4 ангилалд тодорхойлно.

| Эрсдэлийн Түвшин | | Үр дагавар | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Маш бага | Бага | Дунд | Их | Аюултай |
| Магадлал | Маш өндөр | Бага | Дунд | Өндөр | Өндөр | Аюултай |
| | Өндөр | Бага | Дунд | Дунд | Өндөр | Өндөр |
| | Боломжтой | Бага | Бага | Дунд | Дунд | Өндөр |
| | Бага | Бага | Бага | Бага | Дунд | Дунд |
| | Маш бага | Бага | Бага | Бага | Бага | Дунд |

ЛЕНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 11182672

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК
ХХК

2021/05/24

СЭХ
2021.06.23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

7.4.2 Эрсдэлийг эрэмбэлэх (Prioritising risk): Эрсдэлийн түвшинг үндэслэн, Хавсралт 3-т заасны дагуу эрсдэлийн оноог тодорхойлох ба тухайн эрсдэлд хариу арга хэмжээ авах шаардлага, эрэмбийг эрсдэлийн оноон дээр үндэслэн дараах байдлаар тодорхойлно.

| Эрэмбэ | Оноо | Шаардлагатай арга хэмжээ | Нөөцийн шаардлага |
|---|---|---|---|
| Ноцтой | 81-100 | Нэн даруй шуурхай арга хэмжээ авах шаардлагатай (Гүйцэтгэх удирдлага) | Эрсдэл хариуцагчийг томилох |
| Өндөр | 61-80 | Төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх, Гүйцэтгэх удирдлага анхаарал тавих шаардлагатай | Эрсдэл хариуцагчийг томилох |
| Дунд | 41-60 | Тусгай хяналт, журмын зохицуулалт шаардлагатай ба удирдлагын үүрэг, оролцоо, хариуцлагыг тодорхой болгох шаардлагатай (Эрх бүхий албан тушаалтан) | Эрсдэл хариуцагчийн томилох |
| Бага | 0-40 | Компанид мөрдөгдөж буй зохицуулалтын дагуу үйл ажиллагааг явуулах ба тусгай нөөц шаардлагагүй (Эрх бүхий албан тушаалтан болон түлхүүр ажилтнууд) | Хэвийн үйл ажиллагаа |

7.4.3 Хяналтыг үнэлэх (Evaluate existing controls): Эрсдэл хариуцагч өөрийн нэгжийн үйл ажиллагаанд тогтмол хийгддэг дотоод хяналт, тэдгээрийн үр ашигтай байдлыг Олон Улсын COSO-ийн дараах 5 Бүрэлдэхүүн хэсгээр үнэлнэ. Шаардлагатай тохиолдолд Компанийн Дотоод аудитын нэгж дотоод хяналтын үр ашигтай байдлыг үнэлэхэд дэмжлэг үзүүлнэ.

- Дотоод хяналтын орчин / Control Environment /;
- Эрсдэлийн үнэлгээ / Risk Assessment /;
- Дотоод үйл ажиллагааны хяналт / Control Activities /;
- Мэдээлэл харилцаа холбоо;
- Хяналт тавих / Monitoring Activities /;

7.4.4 Эрсдэлийн үнэлгээг хянаж, батлах: Эрсдэл хариуцсан нэгж, түүний удирдлага Эрсдэл хариуцагчийн хийсэн эрсдэлийн үнэлгээг 7.4.3-т заасан Хяналтын үнэлгээтэй харьцуулан хянаж, эрсдэлийн түвшин, түүний эрэмбэ, авах арга хэмжээний зэрэглэлд шаардлагатай засварыг оруулан, Эрсдэлийн хороонд танилцуулж, эрсдэлийн үнэлгээ, түүний эрэмбийг батална.

7.5 Хариу арга хэмжээ (Risk Treatment): ЛэндМН нь олж илрүүлсэн эрсдэл, түүний үнэлгээнд үндэслэн эрсдэлээс хамгаалах хариу арга хэмжээг дараах чиглэлээр төлөвлөж, хэрэгжүүлнэ.

7.5.1 Урьдчилан сэргийлэх (preventive actions) буюу эрсдэл гарахаас хамгаалах, учрах магадлалыг бууруулах, саарuулахад чиглэсэн арга хэмжээ

7.5.2 Эрсдэлийг бууруулах (contingent actions) буюу эрсдэл учрахад түүний үр дагаврыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ.

7.6 Эрсдэлийг удирдахад эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээг харгалзан үзсэний үндсэн дээр дараах арга хэмжээний аль нэгийг эсхүл хэд хэдийг хамтад нь хэрэгжүүлж болно.

| Хариу арга хэмжээ | Хэрэгжүүлэх арга хэмжээ |
|---|---|
| Эрсдэлээс хамгаалах | Эрсдэлээс зайлсхийх бус, Эрсдэлийг удирдах;<br>Үр дүн нь ижил байх арга хэмжээ, эсхүл бусад арга замыг сонгож хэрэгжүүлэхгүй байхад анхаарах; |

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 6267206

ЭЛЭЙН ЭНД ХУУЛЬ ЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
5183655
9021031195 СТС2420

| | |
|---|---|
| Эрсдэлийг бууруулах | Удирдлагын хяналт, үйл ажиллагааг сайжруулж, тохиолдох магадлалыг бууруулах; |
| | Сөрөг үр дагаврыг боломжит бага түвшинд хүргэж бууруулах стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх-Жишээлбэл, Нөөц төлөвлөгөө, Бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө, гэрээний хариуцлагын хамгаалалт; |
| Эрсдэлийг шилжүүлэх | Гэрээний үндсэн дээр хариуцлагыг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн нөгөө талд/гуравдагч этгээдэд, эсхүл даатгалд шилжүүлэх; |
| Эрсдэлийг зөвшөөрөх | Дотоод хяналт зохистой гэж үзсэн тохиолдолд эрсдэлийг хүлээн зөвшөөрөх ба хяналтыг тогтмолжуулж, нөөц төлөвлөгөөг шаардлагатай хэсэгт зориулан боловсруулах. |

7.7 Эрсдэлийн хариу арга хэмжээг төлөвлөх, түүнийг хянаж, баталгаажуулах ажлыг дараах этгээдүүд хэрэгжүүлнэ:

| Эрсдэлийн түвшин | Төлөвлөх | Хянаж баталгаажуулах |
|---|---|---|
| Аюултай | Эрсдэл хариуцагч нэгж болон, Эрсдэл хариуцсан нэгжийн эрх бүхий албан тушаалтан | Эрсдэлийн удирдлагын хороо, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо (шаардлагатай тохиолдолд) |
| Өндөр | | |
| Дунд | Эрсдэл хариуцагч нэгжийн эрх бүхий албан тушаалтан | Эрсдэл хариуцсан нэгж |
| Бага | | |

## ЕС. ЭРСДЭЛИЙН ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛ

9.1. Хамгаалалтын II бүс буюу Эрсдэл хариуцсан нэгж нь эрсдэлийн хяналт болон тайлагналыг үр ашигтай бөгөөд үр дүнтэй зохион байгуулах үүрэгтэй.

9.2. Эрсдэлийн шинжилгээ болон хяналт: Хамгаалалтын I болон II бүс нь өөрийн хяналтад байх эрсдэлд хяналт тавих, шинжилгээ хийх үүрэгтэй. Эрсдэлийн төрөл тус бүрээр эрсдэлийн шинжилгээ, хяналтыг хийх аргачлал, давтамжийг тусад нь холбогдох бодлого, журам, зааврaар зохицуулна.

9.3. "ЛэндМН ББСБ" ХК нь дараах төрлийн хяналт, үнэлгээ, шинжилгээг хийж, үр дүнг тайлагнана:

9.3.1. Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ (Contingent risk analysis)

9.3.2. Урьдчилан төлөвлөөгүй эрсдэлийн үнэлгээ (Ad-hoc assessment)

9.3.3. Шийдвэр гаргахад эрсдэлийн бүрэн хэмжээний үнэлгээ шаардлагатай эсэхийг Эрсдэлийн хариуцсан нэгжийн удирдлага, эсхүл Гүйцэтгэх захирал шийдвэрлэх ба эрсдэлийн хяналт/үнэлгээний үр дүнг холбогдох эрх бүхий этгээд, эсхүл хороо шийдвэр гаргахдаа харгалзан үзнэ.

9.3.4. Тогтмол хяналт (Periodic assessment)

9.3.5. "ЛэндМН ББСБ" ХК нь төсөв боловсруулахдаа төлөвлөсөн санхүүгийн болон бусад тоон үзүүлэлт, зорилтууд нь эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээг хангах хэмжээнд төлөвлөх ба Эрсдэл болон Санхүү хариуцсан удирдлагууд хянаж, баталгаажуулна.

9.3.6. Эрсдэлийн тогтмол үнэлгээг Эрсдэл хариуцсан нэгжийн удирдлага, Санхүүгийн менежер, эсхүл Санхүү хариуцсан захиралтай хамтран

2021/05/24

СЗХ
2021.06.23

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18

хариуцан зохион байгуулах ба үр дүнг эрсдэлийн тайлангийн хамт Эрсдэлийн удирдлагын хороо болон ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд тогтмол тайлагнана.

9.4.<u>Эрсдэлийн тайлан (Risk report):</u> Эрсдэл хариуцсан нэгжийн удирдлага Компанийн эрсдэлийн тайлан цаг хугацаандаа, үнэн зөв, бүрэн гүйцэд бэлтгэгдэн, Эрсдэлийн хороо болон ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд тайлагнах асуудлыг хариуцан, хэрэгжүүлж ажиллана.

9.5.Компанийн эрсдэлийн тайлан нь зөвхөн эрсдэлийн хэмжигдэхүүн, тоон үзүүлэлтээр хязгаарлагдахгүй ба дараах бүтэцтэй байна:

9.5.1. <u>Эрсдэлийн хянах самбар (Risk dashboard)</u>
9.5.2. <u>Эрсдэлийн онцлох сэдэв (Risk theme)</u>
9.5.3. <u>Эрсдэлийн дэлгэрэнгүй тайлан (Detail risk report)</u>

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ХХК

# III. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

СЗХ
Б 2021.06.23
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

## 3. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

### 3.1 ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН НЭРЛЭСЭН ҮНЭ, ХУГАЦАА, НӨХЦӨЛ

| Үнэт цаас гаргагч | "ЛЭНДМН ББСБ" ХК |
|---|---|
| Бондын арилжаа | Нээлттэй |
| Бондын төрөл | Тогтмол хүүтэй бонд |
| Бондын нэрлэсэн үнэ | 100,000 төгрөг |
| Бондын тоо, ширхэг | 50,000 ширхэг |
| Бондын үнийн дүн | 5,000,000,000 төгрөг |
| Бондын хугацаа | 24 сар /365 хоног * 2/ |
| Бондын хүү | 14.0 хувь /жилийн/ |
| Хүү төлөх хугацаа | 6 сар тутам |
| Нийт хүү төлөх давтамж | 4 удаа |
| Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт | Үндсэн үйл ажиллагааны эх үүсвэрт |
| Бондын барьцаа | "АНД Глобал" ПиТиИ ЭлТиДи-ийн 100%-ийн төлбөрийн баталгаа |
| Арилжаалах зах зээл | Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК |
| Андеррайтер | Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК |
| Борлуулалтын хамтрагч | Райнос Инвестмент ҮЦК ХХК |

*Хүснэгт 16: Өрийн хэрэгслийн нөхцөл*

Сүүлийн жилүүдэд бодлогын хүү буурч буйг даган хадгаламжийн хүү зах зээл дээр жил бүр буурч буйтай холбоотойгоор "ЛэндМН ББСБ" ХК-ийн зүгээс 2 жил тогтвортойгоор хүүгээ хадгалах боломжтой бондыг санал болгож байна.

### 3.2 ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

"ЛэндМН ББСБ" ХК нь нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 50,000 ширхэг, нийт 5,000,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий нээлттэй бондыг МХБ-ээр дамжуулан олон нийтэд санал болгож байна. Бондоор татан төвлөрүүлсэн хөрөнгийг компанийн үндсэн бүтээгдэхүүн болох богино хугацаат зээлийн эх үүсвэрт зарцуулна.

**Нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ: 5,000,000,000 /таван тэрбум/ төгрөг**

2020 онд компанийн гэрээт харилцагчийн тоо 175 мянгад хүрч нийт 940 мянган удаагийн зээл олголтоор 210.5 тэрбум төгрөгийн зээлийг харилцагчдадаа олгосон байна. Харин компанийн нийт зээлийн багцын үлдэгдэл 28.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЭХ 2021.06.23 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2021-06-18 БҮРТГЭВ-03

*График 33: Зээлийн үзүүлэлтүүд, улирлаар*




***ЗТ- Зүүн тал, БТ- Баруун тал*** *Эх сурвалж: Компанийн тооцоолол*

Үнэт цаас гаргагч бизнес төлөвлөгөөний дагуу 2020 онд 940 мянган удаагийн зээл олголтоор 210.5 тэрбум төгрөгийн зээлийг харилцагчдад олгож зээлийн багцаа 28.1 тэрбум төгрөгт хүргэсэн байна. 2021 онд 2.6 сая удаагийн зээл олголтоор 312 тэрбум төгрөгийн зээлийг харилцагчдад олгож зээлийн багцын дүнг 41.2 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөсөн байна.

*График 34: Хөрөнгийн, санхүүжилтийн бүтэц*




*Эх сурвалж: Компанийн тооцоолол*

Компанийн нийт хөрөнгийн дүн 2020 онд 39.6 тэрбум төгрөгт хүрсэн ба үүнээс зээлийн багц 28.1 тэрбум төгрөгийг буюу 71 хувийг эзэлсэн байна. Харин эх үүсвэр талыг 22 тэрбум төгрөгийн өр төлбөр, 17.5 тэрбум төгрөгийн эздийн өмч бүрдүүлсэн ба

ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ 5039754 1118267206

2021/05/24

ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ 5183855 9021031195 СТС2420

СЗХ
2021.06.23 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

компанийн санхүүжилтийн бүтцэд өр төлбөр 56 хувийг, эздийн өмч 44 хувийг эзэлж байна. 2021 оны эхний улирлын байдлаар нийт хөрөнгө 39.6 тэрбум төгрөгт хүрч үүнээс зээлийн багц 27.6 тэрбум төгрөг, өр төлбөр 22.3 тэрбум төгрөг эздийн өмч 17.4 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Компани нь 5.0 тэрбум төгрөгийн бондыг нээлттэй санал болгож санхүүжилт татсанаар зээлийн санхүүжилтийн дүн 2021 оны байдлаар 11 хувиар нэмэгдэхээр байна.

*Хүснэгт 17: Санхүүгийн шинжилгээ*

| | 2020P | 2021P | 2022P | 2023P | 2024P | 2025P |
|---|---|---|---|---|---|---|
| **Өсөлтийн шинжилгээ** | | | | | | |
| **Цэвэр орлогын өсөлт** | -18% | 4% | 29% | 19% | 20% | 15% |
| **Цэвэр ашгийн өсөлт** | -55% | 43% | 68% | 20% | 25% | 20% |
| **Зээлийн багцын өсөлт** | -44% | 47% | 38% | 32% | 14% | 14% |
| **Өр төлбөрийн өсөлт** | -45% | 16% | 30% | 44% | 4% | 1% |
| **Ашигт ажиллагааны шинжилгээ** | | | | | | |
| **Нийт хөрөнгийн өгөөж** | 6% | 7% | 9% | 8% | 9% | 9% |
| **Эздийн өмчийн өгөөж** | 13% | 16% | 19% | 18% | 19% | 19% |
| **Нийт ахиуц ашгийн хувь** | 68% | 76% | 75% | 71% | 71% | 74% |
| **Ашгийн түвшин** | 14% | 21% | 27% | 26% | 27% | 29% |
| **Төлбөрийн чадварын шинжилгээ** | | | | | | |
| **Өр төлбөрийн харьцаа** | 56% | 56% | 54% | 58% | 54% | 49% |
| **Хөрвөх чадварын харьцаа** | 43% | 12% | 10% | 14% | 11% | 9% |
| **Хөшүүрэг** | 1.3 | 1.3 | 1.2 | 1.4 | 1.2 | 1.0 |
| **Эрсдэлийн сангийн харьцаа** | 1.3 | 1.5 | 1.5 | 1.5 | 1.5 | 1.5 |

*Эх сурвалж: Андеррайтерийн тооцоолол*

2018 онд Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа олон нийтэд санал болгож, хөрөнгө татаж, хувьцаат компани хэлбэртэй болсноор хувьцааны ханш тухайн жилийн эцэст 71₮-өөр хаагдаж даруй 184%-иар өсөлт үзүүлсэн жил байв. Тухайн жилд цэвэр орлого 634%, цэвэр ашиг10.6 дахин өсч мөн ирэх 2019 онд нь харгалзан 106%, 92%-иар өссөн амжилттай жилийг үдсэн билээ. Харин 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор эрүүл мэнд болон эдийн засгийн хувьд ихээхэн эрсдэл хүндрэл учирсан билээ. Тухайн жилд эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал цар тахлын бий болгож буй эрсдэлийн үндсэн дээр цэвэр орлого 18%, цэвэр ашиг 55%, зээлийн багц 44%, өр төлбөр 45%-иар тус тус буурсан үзүүлэлттэй жил байв. Гэвч 2021 оны эхнээс цар тахлын эсрэг вакцинжуулалт нэмэгдсэнээр түүний бий болгож буй хохирол, эрсдэл буур ч эхэлсэн ба цаашид нийгэм, эдийн засгийн харилцаа хэвийн түвшинд ирснээр бичил хэрэглээний зээлийн эрэлт хэрэгцээ нэмэгдэх үндэстэй байна. Ирэх 5 жилд нийт хөрөнгийн хэмжээ дунджаар 21.3%-иар харилцагчдад олгох зээлийн хэмжээ 29%, өр төлбөрийн хэмжээ 19%-иар нэмэгдэхээр байна.

lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨНӨӨГИЙН ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5103855

ЛэндМН ББСБ ХК үүсгэн байгуулагдсан цагаас хойш харилцагч нартаа бичил хэрэглээний зээлийг технологийн шийдэл ашиглан хүргэж байгаа нь үйл ажиллагааны зардлыг бага түвшинд барьж байна. Нийт хөрөнгийн өгөөж (ROA) 2019 онд 8.5% байсан бол 2020 онд 5.6% болон буурсан ба үүнд орлогын тайланд ногдох эрсдэлийн сангийн зардал 2.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 47.8%-иар нэмэгдсэн нь тодорхой хэмжээнд нөлөөлсөн байна. Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) 2020 онд 13%-тай байна. Цаашид цар тахалтай холбоотой эрсдэл буурах үед ашигт ажиллагаа нэмэгдэхээр хүлээгдэж байна.

Хөрвөх чадварын харьцаа 2020 онд 43%-ийн үзүүлэлттэй буюу мөнгө болон мөнгөнд түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ нийт өр төлбөрийн 43%-ийг ээлж байна. Цаашид эдийн засгийн эрсдэл буур ч зээл гаргалт нэмэгдэх тул энэхүү үзүүлэлт буурах хандлагатай байна.

2021/05/24

СЭХ
2021 .06. 23
No 01

## 3.3 ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН БАТАЛГАА

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18
БҮРТГЭВ-03

**АНД ГЛОБАЛ ПиТиИ ЭлТиДи**
**(Бүгд Найрамдах Сингапур Улсад үүсгэн байгуулагдсан)**
**(Бүртгэлийн дугаар 201708763К)**
**("Компани")**

**КОМПАНИЙН ДҮРМИЙН 100 ДАХЬ ЗҮЙЛИЙГ ҮНДЭСЛЭН ЗАХИРЛУУДЫН ШИЙДВЭРИЙГ ТОГТООХ НЬ:**

**БАТАЛГАА ГАРГАХ**

1. Компани нь Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хувьцаат компани "ЛэндМН ББСБ" ХК (**"Охин компани"**)-ийн нийт гаргасан хувьцааны 75%-ийг эзэмшиж буй эцсийн өмчлөгч болохыг **ТЭМДЭГЛЭЖ БАЙНА**. Охин компани нь 5,000,000,000 (таван тэрбум) төгрөгийн үнэтэй хоёр (2) жилийн хугацаатай бонд (**"Санал болгож буй бонд"**)-ыг олон нийтэд санал болгон санхүүжилт татахаар төлөвлөж байна. Бондыг олон нийтэд амжилттай санал болгох болон бондын аралжаагаар хаахын тулд охин компани нь өөрийн эцсийн өмчлөгч болох Компаниас баталгааны нөхцөлийн дагуу баталгаа (**"Баталгаа"**) гаргаж өгөхийг хүссэн. Баталгааны төслийн хувийг "А" гэж тэмдэглэн, хавсаргав.

2. Доор гарын үсэг зурснаар Компанийн захирал тус бүр Компанийн дүрэм болон Компанийн тухай хуулийн дагуу эдгээр тогтоолуудын үндсэн агуулгатай ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ баталж байна.

**ТОГТООХ НЬ:**

1. Баталгаа гаргах нь Компанийн дээд ашиг сонирхолд харшлахгүй.

2. Компани Баталгаа гаргасныг үүгээр зөвшөөрч, баталгаажуулж, соёрхон баталж байна.

3. Баталгааны нөхцөл болон баталгаагаар хийхээр төлөвлөсөн хэлцлийг үүгээр зөвшөөрч, баталгаажуулж, соёрхон баталж байна. Компанид энд заасан нөхцөл, болзлоор баталгаа гаргах, хүргүүлэх (шаардлагатай бол) болон баталгаагаар хүлээсэн үүргээ биелүүлэх эрхийг үүгээр олгов.

4. Компанийн аль нэг захирал дангаараа дараах заалтын эрхийг эдлэхийг үүгээр зөвшөөрөв:

   (a) Нотариатаар гэрчлүүлсэн, гэрчлүүлээгүй гэдгээс үл хамааран баталгааг тохиролцох, гарын үсэг зурах, үйлдэх болон/эсвэл хүргүүлэх, мөн өөрийн үзэмжээр баталгаанд нэгтгэй өөрчлөлт оруулахааргүй аливаа жижиг нэмэлт, өөрчлөлтийг батлах (Гарын үсэг, тамга эсвэл хуулбар нь тийнхүү батлалсныг нотлох чухал нотолгоо болно);

   (b) Өргөдлийг тэдгээр байгууллага болон хөрөнгийн биржид гаргахад шаардлагатай буюу зохистой гэж үзсэн гэрээ, бичиг баримтыг үйлдэх болон/эсвэл арга хэмжээг авах, тэрхүү гэрээ, бичиг баримтад оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлах (Гарын үсэг, тамга эсвэл хуулбар нь тийнхүү батлалсныг нотлох чухал нотолгоо болно);

   (c) Нотариатаар гэрчлүүлсэн, гэрчлүүлээгүй гэдгээс үл хамааран Компанийг эсвэл түүнийг төлөөлөн өгөх шаардлагатай, өгөхийг зөвшөөрсөн мэдэгдэл, харилцаа холбоо болон баталгааны дагуу, холбоотой өгөх, хавсаргах эсвэл өөрөөр зохих аливаа бусад бичиг баримтад гарын үсэг зурах, үйлдэх болон/эсвэл хүргүүлэх;

DOUBLE CHECK LLC TRANSLATION

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО ХХК
5183855
0021031195 CTC2420

2021/05/24

СЗХ
Б 2021.06.23

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

**АНД ГЛОБАЛ ПиТиИ ЭлТиДи**
**(Бүгд Найрамдах Сингапур Улсад үүсгэн байгуулагдсан)**
**(Бүртгэлийн дугаар 201708763К)**
**("Компани")**

**КОМПАНИЙН ДҮРМИЙН 100 ДАХЬ ЗҮЙЛИЙГ ҮНДЭСЛЭН ЗАХИРЛУУДЫН ШИЙДВЭРИЙГ ТОГТООХ НЬ:**

(d) Бусад гэрээ, гэрээний нэмэлт, өөрчлөлт, өргөдөл, гэрээ, сертификат, бичиг баримт, зөвшөөрөл, хүлээн зөвшөөрөлт, татгалзал, материал, санхүүгийн тайлан, бусад бичиг баримтыг тохиролцох, үйлдэх, хэрэгжүүлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, гаргах, хүргүүлэх эсвэл Компанийг төлөөлөн өөрийн үзэмжээр баталгаа, баталгаагаар хийхээр төлөвлөсөн хэлцэлтэй холбоотой, шаардлагатай буюу зүйтэй гэж үзсэн болон/эсвэл дээр дурдсан зүйлсийг хийх зорилгоор бусад бүх үйлдлийг хийх, хийлгэх, бүх болон бусад арга хэмжээг авах, бүх төлбөр, шилжүүлгийг хийх (тэрхүү санаа нь аль нэг захирлын үйлдлээр илэрсэн нотлогдсон байх);

5. Эдгээр тогтоолуудын бичвэр болон/эсвэл Нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг аль нэг Захирлын шаардсан болон санал болгосон компани, этгээд, аж ахуйн нэгж, төрийн эрх бүхий байгууллага, бусад эрх бүхий байгууллагад гаргаж өгөх;

6. Дээр дурдсан тогтоолуудаар үйлдэх, хийх, авахаар төлөвлөсөн бичиг баримт, хэлцэл, арга хэмжээтэй холбогдуулан Компани, түүний ажилтан, захирал, даргын өмнө нь Компанийн үйлдэл, бичиг баримттай холбоотой авсан аливаа болон бүх арга хэмжээг үүгээр соёрхон баталгаажуулж баталж байна.

7. Компанийн аль нэг захиралд эдгээр тогтоолуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй гэж үзсэн бүх зүйлийг хийх эрхийг үүгээр олгов.

*[Дараагийн хуудсанд гарын үсэг зурах]*

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

УЛААНБААТАР ХОТ
ОЛЗНИЙ ЭНД КО КОНСАЛТИНГ ХХК
5183855
9021031155 СТС2420

2021/05/24

**АНД ГЛОБАЛ ПиТиИ ЭлТиДи**
**(Бүгд Найрамдах Сингапур Улсад үүсгэн байгуулагдсан)**
**(Бүртгэлийн дугаар 201708763K)**
**("Компани")**

**КОМПАНИЙН ДҮРМИЙН 100 ДАХЬ ЗҮЙЛИЙГ ҮНДЭСЛЭН ЗАХИРЛУУДЫН ШИЙДВЭРИЙГ ТОГТООХ НЬ:**

*Эдгээр бичгээр үйлдсэн тогтоолуудыг нэг буюу түүнээс дээш хувь өгч болох бөгөөд хамтдаа нэг баримтыг бүрдүүлнэ.*

**ЗАХИРЛУУД**

| | |
|---|---|
| __*гарын үсэг зурсан*__________________ | ____ *гарын үсэг зурсан* ______________ |
| Чинбаатар овогтой Анар | Очирсүрэн овогтой Болдбаатар |
| __ *гарын үсэг зурсан*______________ | ____ *гарын үсэг зурсан* ____________ |
| Лоу Чин Тай | Такаши Фужинага |

**Огноо: 2021 оны 5-р сарын 20**

*Захирлуудын үйлдсэн шийдвэрийн гарын үсэг зурах хуудас*

СЗХ 2021.06.23 БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2021-06-18 БҮРТГЭВ-03

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24

2021 .06. 23

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18
БҮРТГЭВ-03

**АНД ГЛОБАЛ ПиТиИ ЭлТиДи**
**(Бүгд Найрамдах Сингапур Улсад үүсгэн байгуулагдсан)**
**(Бүртгэлийн дугаар 201708763К)**
**("Компани")**

**КОМПАНИЙН ДҮРМИЙН 100 ДАХЬ ЗҮЙЛИЙГ ҮНДЭСЛЭН ЗАХИРЛУУДЫН ШИЙДВЭРИЙГ ТОГТООХ НЬ:**

**ХАВСРАЛТ А – БАТАЛГАА**
**[*хавсаргав*]**

*Захирлуудын үйлдсэн шийдвэрийн Хавсралт А*

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК
ХХК
5183665

СЭХ
2021.06.23

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

**БАТАЛГАА**

**АНД Глобал ПиТиИ ЭлТиДи ("Компани")**
**Сингапур улс 018936**
**Марина Ийст Цамхаг**
**7 Стройтс Вьюв, #12-00**

2021 оны 5-р сарын 21

"Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК ("Андеррайтер")

Эрхэм Ноён/Хатагтай танаа,

**ЛэндМН ББСБ ХК-аас нийтэд санал болгох бонд гаргах болсонтой холбогдуулан баталгаа гаргах ("Баталгаа") тухай**

Бид Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, Компанийн охин компани болох ЛэндМН ББСБ ХК (Улсын бүртгэлийн дугаар 5039754) (**"ЛэндМН ББСБ"**)-ийн гаргах 5 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй бондын танилцуулгад (**"Танилцуулга"**)-д хамаатуулан уг баталгааг гаргаж байна. Өөрөөр заагаагүй тохиолдолд энэхүү баталгаанд том үсгээр бичсэн нэр томьёо, үг хэллэг нь Танилцуулгад дурдсан нэр томьёо, үг хэллэгтэй адил утгатай байна.

Танилцуулгын дагуу нийтэд санал болгох бонд нь дараах нөхцөлтэй байна. Үүнд:

| | | |
|---|---|---|
| (1) | **Санал болгож буй дүн:** | 5,000,000,000 (5 тэрбум төгрөг) төгрөг |
| (2) | **Хугацаа:** | Бондыг нийтэд санал болгосноос хойш 2 жил |
| (3) | **Гаргах огноо:** | 2021 оны 6 дугаар сар |

**ИЙМД**, "ЛэндМН ББСБ" ХК-ийн хувьцааны 75%-ийг эзэмшиж байгаа эцсийн өмчлөгчийн хувиар Компани нь (бонд эзэмшигчийн ашиг тусын тулд) Андеррайтерын өмнө дараах үүргийг үүгээр хүлээж байна:

**1. ҮҮРЭГ**

Хэрэв ЛэндМН ББСБ нийтэд санал болгосон бондыг хугацаанд нь төлөхгүй бол Компани нь (бонд эзэмшигчийн ашиг тусын тулд) Андеррайтераас бичгээр шаардлага хүлээн авмагцаа ажлын тав (5) хоногийн дотор нийтэд санал болгох бондын нөхцөлийн дагуу ЛэндМН ББСБ-ын бүх өр төлбөр (**"Барьцаагаар хангагдах үүрэг"**)-ийг төлж барагдуулах үүргийг Андеррайтерын өмнө үүгээр хүлээж байна. Барьцаагаар хангагдах үүрэг нь нийтэд санал болгох бондын үнийн дүн (5 тэрбум төгрөг), бүх хуримтлагдсан хүү болон алданги (хэрэв байгаа бол)-ийн нийлбэр дүнгээс хэтрэхгүй.

**2. ХУГАЦАА**

Энэхүү баталгааны хүчинтэй хугацаа баталгааны өдрөөс хойш гурван (3) жил байна.

**3. ЗОХИЦУУЛАХ ХУУЛЬ**

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 др.1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183655
9021031195

СЭХ
2021.06.23

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

Энэхүү Баталгаа болон үүний үндсэн агуулга, бүтцээс үүдэн эсвэл холбоотой гарах аливаа маргаан, нэхэмжлэл (гэрээний бус маргаан, нэхэмжлэл орно)-ийг Сингапур Улсын хуулиар тайлбарлаж, зохицуулна.

## 4. МАРГААНЫГ ХАРЬЯАЛАН ШИЙДВЭРЛЭХ ШҮҮХ

Талууд Сингапур улсын шүүх нь энэхүү гэрээ, үүний үндсэн агуулга эсвэл бүтцээс үүдэн эсвэл холбоотой гарах аливаа маргаан, нэхэмжлэл (гэрээний бус маргаан, нэхэмжлэл орно)-ийг харьяалан шийдвэрлэх эрхтэй байхыг эргэлт буцалтгүйгээр зөвшөөрөв.

Хүндэтгэсэн,

**Анд Глобал ПиТиИ ЭлТиДи-г** төлөөлөн:

___ *гарын үсэг зурсан* ______________
**Чинбаатар овогтой Анар**

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮЛЭЙБЭРЭЛ ХӨ КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031155 ETC2420

СЗХ
2021.06.23

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

**AND GLOBAL PTE LTD.**
(Incorporated in the Republic of Singapore)
(Registration No. 201708763K)
(the "**Company**")

**DIRECTORS' RESOLUTIONS IN WRITING PASSED PURSUANT TO REGULATION 100 OF THE COMPANY'S CONSTITUTION**

**ISSUE OF LETTER OF GUARANTEE**

1. **IT IS NOTED THAT** the Company is the ultimate beneficial owner of 75% of the total issued share capital of LendMN NBFI JSC, a joint stock company incorporated under the laws of Mongolia (the "**Subsidiary**"). The Subsidiary proposes to raise funds by issuing a public bond with the principal amount of MNT 5,000,000,000 (five billion Mongolian togrogs) and with the maturity period of two (2) years (the "**Proposed Bond Issue**"). For the successful offering and closing of the Proposed Bond Issuance, the Subsidiary has requested the Company, as the ultimate beneficial owner of the Subsidiary, to issue a letter of guarantee on the terms and subject to conditions of the letter of guarantee (the "**Letter of Guarantee**"). A draft copy of the Letter of Guarantee is annexed hereto and marked "**A**".

2. Each Director of the Company confirms, by signing below, that he has disclosed all his interests in the subject matter of these resolutions in accordance with the Company's Constitution and the Companies Act.

**RESOLVED THAT:**

1. It is in the best interest of the Company to issue the Letter of Guarantee.

2. The entry into and execution by the Company of the Letter of Guarantee are hereby approved, confirmed and ratified.

3. The terms of and the transactions contemplated by the Letter of Guarantee be and are hereby approved, confirmed and ratified, and the Company be and is hereby authorized to enter into, deliver (if required) and perform its obligations under the Letter of Guarantee on the terms and conditions contained therein.

4. Any Director of the Company, each acting singly, be and is hereby authorized:

   (a) to negotiate, sign, execute and/or deliver, whether under hand or seal, the Letter of Guarantee and in his absolute discretion to approve any minor amendment, alteration or modification which does not make material changes to the Letter of Guarantee and the signing and sealing thereof or of a copy thereof be conclusive evidence of such approval;

   (b) to execute such agreements and documents and/or take such action as may be necessary for the making of such applications to such authorities and securities exchanges as he may, in his absolute discretion, deem fit and to approve any amendment, alteration or modification to such agreements or documents and the signing thereof or of a copy thereof be conclusive evidence of such approval;

   (c) to sign, execute and/or deliver whether under hand or seal, any notice, communications required or permitted to be given by or on behalf of the Company, and any other documents to be given incidental to, pursuant to, ancillary to or expedient in connection with the Letter of Guarantee; and

   (d) to negotiate, make, execute, perform, acknowledge, verify, issue and deliver such other agreements, amendments to such agreements, applications, deeds, certificates, instruments, consents, acknowledgements, waivers, filings, financing statements and other documents or to do or cause to be done all such other acts and things and take all such steps and other actions, and to make all such payments and remittances on behalf of the Company which he may in his discretion think necessary, appropriate, desirable, expedient or advisable in connection with or incidental to the Letter of Guarantee, the transactions contemplated in the Letter of Guarantee and/or for the purpose of giving effect to

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206



2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

2021.06.23

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

**AND GLOBAL PTE LTD.**
(Incorporated in the Republic of Singapore)
(Registration No. 201708763K)
**(the "Company")**

**DIRECTORS' RESOLUTIONS IN WRITING PASSED PURSUANT TO REGULATION 100 OF THE COMPANY'S CONSTITUTION**

the foregoing (such opinion to be conclusively evidenced by the taking of such action by any Director).

5. An extract and/or a certified true copy of these resolutions be furnished to such company, person, entity or governmental or other authority as may be required and recommended by any Director.

6. Any and all actions previously taken by the Company or any of its officers, directors or principals in connection with the documents, transactions and actions contemplated by the foregoing resolutions be, and they hereby are, ratified, confirmed, approved and adopted in all respects as and for the acts and deeds of the Company.

7. Any Director of the Company be and is hereby authorised to complete and do all acts and things as he or she may consider desirable, necessary or expedient to give effect to these Resolutions.

*[Signature page follows]*

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn



2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
2021 .06. 23

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18
БҮРТГЭВ-03

**AND GLOBAL PTE LTD.**
(Incorporated in the Republic of Singapore)
(Registration No. 201708783K)
**(the "Company")**

**DIRECTORS' RESOLUTIONS IN WRITING PASSED PURSUANT TO REGULATION 100 OF THE COMPANY'S CONSTITUTION**

*These written resolutions may be given in multiple counterparts which taken together shall constitute the same instrument.*

**DIRECTORS**

| | |
|---|---|
| Anar Chinbaatar | Boldbaatar Ochirsuren |
| Low Chin Tai | **Takashi Fujinaga** |

**Date:** 20 **May 2021**

***Signature page of Directors' Resolution in Writing***

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
БИЗНЕС ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855 9021031196 СТС2420

СЗХ
2021.06.23
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

**AND GLOBAL PTE LTD.**
(Incorporated in the Republic of Singapore)
(Registration No. 201708763K)
(the "**Company**")

**DIRECTORS' RESOLUTIONS IN WRITING PASSED PURSUANT TO REGULATION 100 OF THE COMPANY'S CONSTITUTION**

**ANNEX A – LETTER OF GUARANTEE**

***[attached]***

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754

***Annex A of Directors' Resolution in Writing***

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

**2021/05/24**

СЗХ
2021.06.23
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

**LETTER OF GUARANTEE**

AND Global Pte. Ltd. (the "**Company**")
7 Straits View, #12-00
Marina East Tower
Singapore 018936

21 May 2021

Ulzii and Co Capital UTsK LLC (the "**Underwriter**")

Dear Sir / Madam

**Letter of guarantee with respect to a public bond to be issued by LendMN NBFI JSC (the "Guarantee Letter")**

We refer to the prospectus (the "**Prospectus**") for the issuance of a MNT 5 billion public bond (the "**Public Bond**") to be issued by LendMN NBFI JSC (State Registration Number 5039754), a joint stock company incorporated under the laws of Mongolia and a subsidiary of the Company ("**LendMN NBFI**"). Unless otherwise stated, the capitalised terms and expressions set out in this letter shall have the same meaning given to such terms and expressions in the Prospectus.

Under the Prospectus, the issuance of the Public Bond will have the following terms:

(1) **Offering amount**: MNT 5,000,000,000 (5 billion togrogs)
(2) **Maturity**: The date falling 2 years after the issuance of the Public Bond
(3) **Issuance date**: June 2021

**NOW, THEREFORE**, the Company hereby undertakes, in its capacity as the ultimate beneficial owner of 75% of the share capital of LendMN NBFI, to the Underwriter (for the benefit of each bondholder of the Public Bond) as follows:

1. **UNDERTAKINGS**

The Company hereby undertakes to the Underwriter (for the benefit of each bondholder of the Public Bond) that the Company will pay and discharge, within five (5) Business Days upon receipt of a written demand issued by the Underwriter, all obligations and liabilities of LendMN NBFI under the Public Bond (the "**Secured Liabilities**") if LendMN NBFI fails to pay any part of the Public Bond when due under the Public Bond. The Secured Liabilities shall not exceed the aggregate of the principal amount of the Public Bond (being MNT 5 billion), all accrued interest and default interest (if any).

2. **TERM**

This Guarantee Letter will be valid from the date of this Guarantee Letter until the date falling three (3) years following the date of this Guarantee Letter.

3. **GOVERNING LAW**

This Guarantee Letter and any dispute or claim arising out of or in connection with it or its subject matter or formation (including non-contractual disputes or claims) shall be governed by and construed in accordance with the laws of Singapore.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО
КАПИТАЛ ҮЦК
ХХК

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

**4. JURISDICTION**

Each party irrevocably agrees that the courts of Singapore shall have non-exclusive jurisdiction to settle any dispute or claim arising out of or in connection with this agreement or its subject matter or formation (including non-contractual disputes or claims).

Yours sincerely

Anar Chinbaatar
**For and on behalf of**
**AND Global Pte. Ltd.**

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

## "АНД ГЛОБАЛ" ПиТиИ ЭлТиДи КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

"АНД Глобал" ПиТиИ ЭлТиДи болон түүний охин компаниудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын Тайлан

| | Групп | | Компани | |
|---|---|---|---|---|
| | 31.12.2020 | 31.12.2019 | 31.12.2020 | 31.12.2019 |
| | ам.доллар | ам.доллар | ам.доллар | ам.доллар |
| ***Хөрөнгө*** | | | | |
| ***Эргэлтийн Хөрөнгө*** | | | | |
| *Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө* | 10,563,743 | 1,140,522 | 1,950,190 | 65,554 |
| *Харилцагчдад олгосон зээл* | 8,950,661 | 18,115,954 | - | - |
| *Бусад хөрөнгө* | 1,385,426 | 1,914,308 | 502,171 | 282,462 |
| *Урьдчилж төлсөн төлбөр* | 137,429 | 103,053 | 65,310 | 17,505 |
| *Санхүүгийн үүсмэл хэрэглүүр* | - | 47,792 | - | - |
| | **21,037,259** | **21,321,629** | **2,517,671** | **365,521** |
| ***Эргэлтийн Бус Хөрөнгө*** | | | | |
| *Урьдчилж төлсөн төлбөр* | 3,021,604 | 3,043,254 | - | - |
| *Урт хугацаат зээлийн авлага* | 13,453 | 17,682 | - | - |
| *Хойшлогдсон татварын хөрөнгө* | 97,928 | 11,956 | - | - |
| *Хөрөнгө оруулалт* | 262,657 | 266,771 | 210,016 | 210,016 |
| *Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт* | - | - | 9,348,236 | 7,412,294 |
| *Биет бус хөрөнгө* | 1,597,127 | 1,151,162 | - | - |
| *Үндсэн хөрөнгө* | 339,047 | 325,453 | 1,056 | 3,906 |
| *Ашиглах эрхтэй хөрөнгө* | 291,661 | 425,313 | - | - |
| *Гүүдвил* | 123,851 | 129,106 | - | - |
| | **5,747,328** | **5,370,697** | **9,559,308** | **7,626,216** |
| ***Нийт Хөрөнгө*** | **26,784,587** | **26,692,326** | **12,076,979** | **7,991,737** |
| ***Богино Хугацаат Өр Төлбөр*** | | | | |
| *Зээл* | 15,896,487 | 18,722,687 | - | - |
| *Бусад өр төлбөр* | 824,047 | 720,107 | 1,266,217 | 4,510,314 |
| *Түрээсийн өр төлбөр* | 123,359 | 117,243 | - | - |
| *Орлогын албан татварын өглөг* | 8,008 | 57,404 | 16,941 | - |
| | **16,851,901** | **19,617,441** | **1,283,158** | **4,510,314** |
| ***Урт Хугацаат Өр Төлбөр*** | | | | |
| *Зээл* | 2,381,608 | 3,880,248 | 1,411,040 | 1,134,890 |
| *Түрээсийн өр төлбөр* | 225,159 | 356,192 | - | - |
| *Санхүүгийн үүсмэл хэрэглүүр* | 288,006 | 586,692 | 244,297 | 244,297 |
| | **2,894,773** | **4,823,132** | **1,655,337** | **1,379,187** |
| ***Нийт Өр Төлбөр*** | **19,746,674** | **24,440,573** | **2,938,495** | **5,889,501** |
| ***Цэвэр Хөрөнгө*** | **7,037,913** | **2,251,753** | **9,138,484** | **2,102,236** |
| ***Эздийн Өмч*** | | | | |
| *Хувьцаат капитал* | 13,213,967 | 4,903,968 | 13,213,947 | 4,903,968 |
| *Хуримтлагдсан алдагдал* | (7,679,794) | (4,708,203) | (4,664,879) | (3,391,128) |
| *Бусад нөөц* | 589,396 | 589,396 | 589,396 | 589,396 |
| *Капитал нөөц* | (31,535) | (102,802) | - | - |
| *Гадаад валют хөрвүүлэлтийн сан* | (1,036,864) | (817,489) | - | - |
| ***Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох өмч*** | 5,055,170 | (135,130) | 9,138,484 | 2,102,236 |
| *Хяналтын эрхгүй хувь оролцоо* | 1,982,743 | 2,386,883 | - | - |
| ***Нийт Эздийн Өмч*** | **7,037,913** | **2,251,753** | **9,138,484** | **2,102,236** |
| ***Нийт Өр Төлбөр Болон Эздийн Өмч*** | **26,784,587** | **26,692,326** | **12,076,979** | **7,991,737** |

*Хүснэгт 18: "АНД Глобал" ПиТиИ ЭлТиДи болон түүний охин компаниудын Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын Тайлан*

2021/05/24

“АНД Глобал” ПиТиИ ЭлТиДи компанийн финтек бизнес модель, тэдгээртэй холбоотой тусламж үйлчилгээ зэргийг нэгтгэсэн Финтек Цогц Үйлчилгээ (“FaaS”) нь нээлттэй платформоор дамжуулан хиймэл оюун ухаанд суурилсан зээлжих зэрэглэлийн үнэлгээ, цахим- хэтэвч, худалдаа, төлбөр тооцоо болон цахим зээлийн систем зэрэг үйлчилгээг санхүүгийн байгууллагууд бизнестээ нэвтрүүлэн ашиглах боломжийг санал болгодгоос гадна тус үйлчилгээнд тулгуурлан бусад салбарын харилцагч байгууллагууд нь бие даасан цахим экосистемийг бүрдүүлэх боломжийг хангаж ажилладаг болно.

“АНД Глобал” ПиТиИ ЭлТиДи компани нь одоогоор Монгол улс болон Филиппин улсад цахим зээлийн үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна.

Түүнчлэн 2020 оны 4 сард “АНД Глобал” ПиТиИ ЭлТиДи компани нь нь өөрсдийн бүтээсэн энэхүү санхүүгийн технологийн (финтек) шийдлүүдээ олон улсад нэвтрүүлэхээр худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Япон улсын “Марубени” корпорацтай стратегийн хамтын ажиллагааг эхлүүлсэн.

“Марубени” корпорац нь мэдээлэл, харилцаа холбооны технологи, хүнс, өргөн хэрэглээний бүтээгдэхүүн, хими, эрчим хүч, цахилгаан станц, тээвэр, үйлдвэрлэлийн машин механизм, санхүү, лизинг зэрэг бизнесийн олон салбарт үйл ажиллагаа эрхлэн явуулдаг Японы хөрөнгө оруулалт, худалдааны чиглэлийн томоохон компани юм. Тус компани нь сүүлийн 150 жилийн туршид Ази, Европ, Хойд Америк болон Ойрх Дорнодын олон улс оронд салбар бүрийн бизнес хөгжүүлэлтийн ноу-хауг хуримтлуулсан арвин туршлагатай бөгөөд шинэ бүтээгдэхүүн, шинэ зах зээлийн боломжуудыг ямагт эрэлхийлж байдаг тэргүүлэгч компани юм.

Энэхүү хамтын ажиллагааны гол зорилго нь “АНД Глобал” ПиТиИ ЭлТиДи компанийн бүтээсэн финтекийн цогц үйлчилгээг (Fintech as a Service) “Марубени” корпорацын санхүү, лизингийн салбар дахь арвин их туршлага мөн уг корпорацын дэлхийн 250 гаруй орныг хамарсан бизнесийн сүлжээнд холбон, санхүү болон бусад салбарын мянга мянган байгууллагын үйл ажиллагаанд тус үйлчилгээг нэвтрүүлэх зорилготой юм.

2020 оны 11 сарын 16 ний өдөр "АНД Глобал" ПиТиИ ЭлТиДи компани нь “Марубени” корпорац болон АНУ-ын TechStars компаниудаас Series A шатны нийт 10.3 сая ам.долларын хөрөнгө оруулалт татах “Хамтын ажиллагаа хөрөнгө оруулалтын гэрээ” байгуулж, 2020 оны 11 сарын байдлаар нийт 8.3 сая доллар татан төвлөрүүлсэн. Харин 2021оны 6 сард гэрээний хүрээнд дахин 2.0 сая доллар татан төвлөрүүлж байгаа.

Дээрх хамтын ажиллагааны хүрээнд "АНД Глобал" компани нь “Марубени” групп компаниудад болон түүнтэй хамаарал бүхий санхүүгийн болон санхүүгийн бус 10 гаруй компаниудад финтекийн цогц үйлчилгээг (Fintech as a Service) үзүүлэх хэлэлцээрүүдийг хийж байгаа.

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ

## 3.4. ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН ХҮҮ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

Бондын хүүг банкны хадгаламжийн болон ЗГҮЦ-ны хүүгээс өндөр, ижил төрлийн бондын хүүтэй өрсөлдөхүйц байхаар зах зээлийн нөхцөл байдлыг харгалзан тогтоов.Сүүлийн жилүүдэд хадгаламжийн хүү тогтмол буурч цаашид жил тутам хадгаламжийн хүү буурах магадлал бий болж байгаа тул "ЛэндМН ББСБ" ХК-ийн зүгээс тул бонд эзэмшигч нартаа хүүгээ 2 жилийн хугацаанд тогтмол хадгалах боломж олгохоор шийдвэрлэснээрээ онцлогтой юм. Түүнчлэн хүүгийн орлогоо хагас жил тутам авах боломжтой тул бонд эзэмшигчийн хувьд бодит өгөөж нь нэмэгдэх боломжтой юм.

Зах зээл дэх хүүгийн түвшинг харгалзан Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад жилийн 14.0%, татварын дараах 13.3%-ийн хүүг санал болгож байна. Үүнд хүүгийн орлогын татварыг ХХОАТ-ын тухай хуулийн 21.5, ААНОАТ-ын тухай хуулийн 20.2.5-д заасны дагуу 5.0 %-аар тооцов.

### *Бодлогын хүү, ЗГҮЦ-ны хүү, банкны хадгаламжийн ЖДХ*

Бондын зах зээлд ЗГҮЦ-ны хүү жишиг хүү болдог хэдий ч Монгол Улсын Засгийн газрын өрийн удирдлагын бодлогын хүрээнд ЗГҮЦ-ны нийлүүлэлтийг 2017 оны 10-р сарын 24-ны өдрөөс хойш зогсоогоод байна. Хамгийн сүүлд арилжаалагдсан 1 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны хүү 11.76% байжээ.

*График 35: Бодлогын хүү, ЗГҮЦ-ны хүү, хадгаламжийн ЖДХ*




Монголбанкнаас тогтоодог бодлогын хүү 2018 оны 11 сараас хойш 2020 оны 3 сарыг хүртэл 11.0%-д хадгалагдсан ба КОВИД-19 өвчний тархалттай холбоотой тодорхой бус байдал нэмэгдэж гадаад эрэлт, түүхий эдийн үнэ буурсан, гадаад болон дотоод эдийн засгийн идэвхжил суларч эдийн засгийн өсөлт саарах эрсдэл нэмэгдсэнээр Монголбанк 2020 оны 3, 4 болон 9 сарууудад бодлогын хүүг тус тус 1 нэгж хувиар бууруулж 8.0%-д хүргэсэн ба мөн оны 11 сард бодлогын хүүг 2 нэгж хувиар бууруулан 6.0%-д тогтоогоод байна.

Зах зээл дэх хүүгийн түвшин бодлогын хүүг дагаж буурсаар байгаа ба арилжааны банкнуудын шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2021 оны 3 сард 7.8% байна.

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРЕНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

### *Банкнуудын хадгаламжийн хүү*

2021 оны 3 сарын байдлаар арилжааны банкнуудын шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 7.8% байсан ба хадгаламж эзэмшигчид очих татварын дараах хүү нь 7.0% байна. Системийн топ-5 арилжааны банкнуудын 12 сарын хугацаатай хадгаламжийн дээд хүү 8.8% байгаа ба татварын дараах хүү 7.9% байна. Харин Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад нэрлэсэн 14.0%-ийн хүү, татварын дараах 13.3%-ийн хүүг санал болгож байна. Санхүүгийн бизнес нь тогтворжсон компанийн хувьд Үнэт цаас гаргагчийн санал болгож буй хүү нь зах зээлийн дунджаас харьцангуй өндөр байна.

*График 36: Банкнуудын 1 жилийн хугацаатай хадгаламжийн хүү*




*Эх сурвалж: Банкуудын цахим хуудас*

### *Компанийн орийн хэрэглийн хүү (татварын дараа)*

Бидний санал болгож буй бондтой хамгийн ижил нөхцөлтэй ойрын хугацаанд гарсан бонд нь 2017 оны 6 сард МХБ-ээр нээлттэйгээр олон нийтэд санал болгосон Сүү бонд байна. Үнэт цаас гаргагч "ЛэндМН ББСБ" ХК болон Сүү бондыг гаргагч "Сүү" ХК нь хоёул МХБ-ийн I самбарт бүртгэлтэй нээлттэй ХК ба бондуудын хугацаа 1 жил, эргэн төлөлт нь хугацааны эцэст хийгдэх нөхцөлтэй. Сүү бондын 17.5%-ийн хүүг хөрөнгө оруулагчдад санал болгож байсан ба тухайн үед бодлогын хүү 12.0% байсан байна.

Сүүлийн нэг жилийн хугацаанд Үнэт цаас гаргагчийн гаргаж буй үнэт цаастай ижил төрлийн буюу бирж дээр арилжаалагддаг хаалттай болон нээлттэй хүрээнд хэд хэдэн бондууд гарсан ба энэ хугацаанд бодлогын хүү 10%-аас 6%-д хүртэл 4 нэгж хувиар буурсан байна. Бирж дээр арилжаалагддаг нээлттэй бондууд дундаа Лэнд Бондын бодит хүүгийн түвшин нь харьцангуй өндөр байна.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031199 СТС2420

СЗХ
2021 .06. 23
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18
БҮРТГЭВ-03

*График 37: Компанийн бондын хүү (татварын дараа)*




*Хүснэгт 19: Нээлттэй бондын давуу тал*

*Эх сурвалж: Компаниудын гаргасан үнэт цаасны*

| | **Хадгаламж** | **Хаалттай бонд** | **ЛэндМН Нээлттэй бонд** |
|---|---|---|---|
| Хүү /дундаж/ | 7.8% | 16.0%*** | **14.0%** |
| Татвар | 10% | 10% | **5%** |
| Татварын дараах хүүгийн орлого | 7.0% | 14.4% | **13.3%** |
| Хүү олгох давтамж | Жилд 1 | Янз бүр | 6 сар тутам |
| Хүү буурахгүй байх магадлал | ✗ | ✗ | ✓ |
| Хугацааны дундуур зарах боломж | ✗ | ✗ | ✓ |
| Ханшийн зөрөөний ашиг олох боломж | ✗ | ✗ | ✓ |
| Баталгаа / Барьцаа | **20* сая.төг** | ✗ даатгалтай байх боломжтой | **"АНД Глобал" ПиТиИ ЭлТиДи компанийн төлбөрийн баталгаа**** |
| Санхүүгийн тайлангийн ил тод байдал | ✓ | ✗ ХК-д хамаарахгүй | ✓ |
| Зохицуулагч байгууллагын зөвшөөрөлтэй эсэх | ✓ | ✗ ХК-д хамаарахгүй | ✓ |
| Зохицуулагч байгууллагаас хяналт тавих эсэх | ✓ | ✗ ХК-д хамаарахгүй | ✓ |
| Олон улсын Аудитын байгууллагаар хянагддаг эсэх | ✓ ✗ | ? | ✓ Эрнэст Энд Янг /E&Y/ |

* *Хадгаламжийн Корпорациас банкны хадгаламжид гаргадаг баталгааны дээд хэмжээ*

** "АНД Глобал" ПиТиИ ЭлТиДи Компани нь 2020 онд Япон улсын Марубени корпорациас 10 сая ам.долларын хөрөнгө оруулалт авсан.

*** *Зах зээл дээр тогтвортой үйл ажиллагаа явуулж буй компаниудын дундаж үзүүлэлтээр авав.*

*** *Зах зээлийн дунджаас дээш хүүтэй аливаа санхүүгийн хэрэгсэл нь эрсдэлийн түвшин тэр хэрээр өндөр байдаг.*

*Эх сурвалж: МБ, компаниудын мэдээлэл*

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

## 3.5 ӨРИЙН ХЭРЭГСЛЭЭР ГЭРЧЛЭГДЭХ ЭРХ, ҮҮРЭГ

**Өрийн бичиг нь түүний эзэмшигчийн дараах эрхийг гэрчилнэ:**

1. Үнэт цаас эзэмшигч, түүний хамтран эзэмшигч нь компанийн санхүүгийн тайлан, үнэт цаасны танилцуулгыг хөрөнгө оруулалтын зорилгоор судлан үзэж, бүрэн танилцсаны үндсэн дээр өрийн бичгийг худалдан авч, хөрөнгө оруулалт хийх шийдвэрийг бие даан гаргах эрхтэй;
2. Үнэт цаас эзэмшигч, түүний хамтран эзэмшигч нь өрийн бичгийн хоёрдогч зах зээлийн үнийн мэдээлэлтэй танилцах эрхтэй.
3. Өрийн бичгийг бирж дээрээс үнэт цаасны компаниараа дамжуулан чөлөөтэй худалдан авах, хоёрдогч зах зээл дээр худалдах;
4. Өрийн бичиг эзэмшигч, түүний хамтран эзэмшигч нь хугацааны эцэст өрийн бичгийг нэрлэсэн үнээр Үнэт цаас гаргагчид эргүүлэн худалдах, худалдан авахыг шаардах, хуримтлагдсан хүүг төлөхийг шаардах эрхтэй ба хэрэв үнэт цаас гаргагч нь энэ үүргээ биелүүлэхгүй бол барьцаалагчийг өрийн бичгийн эргэн төлөлтийг барьцааны гэрээнд заасны дагуу хийхийг шаардах болон Монгол Улсын хуулиар олгогдсон бусад эрхийг эдэлнэ ( КтХ-ийн 41.1);
5. Дээрх 2-т заасан эрхээ тогтоосон хугацаанд хэрэгжүүлэх боломжгүй бол барьцаалагчийг барьцаа хөрөнгийг арилжаалж, үүргийн гүйцэтгэл хангахыг шаардах (КтХ-ийн 41.1, 41.5);
6. Өрийн бичиг гаргагч төлбөрийн чадваргүй болсон буюу үүргийн гүйцэтгэлийг хангах эд хөрөнгийн хэмжээ багассан, эсхүл эд хөрөнгөгүй болсон бол өрийн бичиг эзэмшигч нь тогтоосон хугацаанаас өмнө үүргээ нэн даруй гүйцэтгэхийг түүнээс шаардах ( Иргэний хуулийн 208.6).
7. Хэрэв бонд гаргагч гуравдагч этгээд баталгаа, батлан даалт гаргасан бол тухайн этгээдийн талаарх мэдээлэлтэй танилцах (Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам)

**Өрийн бичиг нь түүний эзэмшигчийн дараах үүргийг гэрчилнэ:**

1. Мөнгөн хөрөнгөө урьдчилан байршуулах нөхцөлөөр өөрийн захиалсан өрийн бичгийн төлбөрийг төлөх, тийнхүү төлөөгүй бол захиалсан өрийн бичгийг ҮЦК худалдах эрхтэйг хүлээн зөвшөөрөх;
2. Өрийн бичиг гаргах шийдвэрт заасан бөгөөд Үнэт цаас гаргагч өөрийн гаргасан өрийн бичгээ төлөгдөх хугацаанаас нь өмнө эргүүлэн худалдан авах эрхээ хэрэгжүүлэхэд саад болохгүй байх (КтХ-ийн 41.6);
3. Үнэт цаас эзэмшигч, түүний хамтран эзэмшигчийн өрийн бичгийн төлбөрт төлсөн мөнгөн хөрөнгө нь түүний хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого бөгөөд "Мөнгө угаах, терроризмтой тэмцэх тухай хууль"-ийн дагуу холбогдох шалгуурыг хангасан, эрх зүйн аливаа доголдолгүй, маргаангүй мөнгөн хөрөнгө болохыг бүрэн баталж, эрсдэл болон өгөөжийг бүрэн тооцоолж хөрөнгө оруулалтын шийдвэрийг бие даан гаргасан талаар баталгаа гаргаж ҮЦК-аас гаргасан анхан шатны маягтыг үнэн зөв мэдээлэх болон түүнд орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэх үүрэгтэй.

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

**Үнэт цаас гаргагчийн үүрэг**

1. Үнэт цаас гаргагч нь өөрийн санхүү болон бусад бодит байдлын талаар үнэн зөв мэдээлэх үүрэгтэй;
2. Өрийн бичгийн үүргийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал үүссэн тохиолдолд үнэт цаасны барьцааны гэрээний дагуу зохих арга хэмжээг авч үнэт цаас эзэмшигчийн хүү болон үндсэн төлбөрийг барагдуулах;
3. Татан төвлөрүүлсэн хөрөнгийг үнэт цаасны танилцуулгад тусгагдсаны дагуу үр ашигтай захиран зарцуулах;
4. Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хугацаанд хүүгийн төлбөрийг төлөх, хугацааны эцэст үндсэн төлбөрийг төлөх үүрэгтэй. Энэхүү үүргээ биелүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллах;
5. Үнэт цаас гаргагч нь холбогдох гэрээнүүд дээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас үнэт цаас эзэмшигчид учруулсан аливаа хохирлыг төлж барагдуулах үүрэгтэй;
6. Үнэт цаас гаргагч нь үндсэн болон хүүгийн төлбөрийг төлбөр хийгдэх өдрөөс ажлын 3 хоногийн өмнө ҮЦТХТ-д байрших өөрийн дансанд шилжүүлнэ. Шилжүүлсэн дүнг ҮЦТХТ нь хөрөнгө оруулагчийн үнэт цаасны данс руу үндсэн болон хүүгийн төлбөр хийгдэх өдөр татна;
7. Холбогдох хууль тогтоомж болон журамд заасны дагуу мэдээллийн ил тод байдлыг тогтмол хангах, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах;
8. Хэрэв Үнэт цаас гаргагчид гуравдагч этгээд баталгаа, батлан даалт гаргасан бол бондын танилцуулгад уг этгээдийн тодорхой үнэн зөв мэдээллийг тусгах;
9. Үнэт цаас гаргагч нь компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд, тодорхой байх зарчмаар буюу хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад хангалттай байдлаар хүргэх;
10. Үнэт цаас гаргагч нь бондын үнэ ханшид нөлөөлж болохуйц аливаа үйл явдлын мэдээллийг нэн даруй олон нийт, Хороо, арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.
11. Үнэт цаас гаргагч буюу нээлттэй бонд гаргагч нь дараах тохиолдолд зохих мэдээллийг Хороо, арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлж, олон нийтэд тухайн үйл явдал болсноос хойш ажлын гурван өдрийн дотор мэдээлнэ.
    - Бондын танилцуулгад заасан үйл ажиллагааны чиглэл, төсөл болон төслийн хэрэгжилтийн явцад өөрчлөлт орсон;
    - Бонд гаргах шийдвэрт заасны дагуу өрийн гаргасан бондыг төлөгдөх хугацаанаас өмнө эргүүлэн худалдан авахаар шийдвэрлэсэн;
    - Бусад санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчаас зээл авсан, тэдний өмнө хүлээсэн нэмэлт үүрэг үүссэн;
    - Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын бүтцэд өөрчлөлт орсон;
    - Хяналтын багц бүхий хувьцаа эзэмшигчийн бүтцэд өөрчлөлт орсон;
    - Эрх бүхий байгууллагын шийдвэрээр бонд гаргагчийн хөрөнгийг битүүмжилсэн, эсхүл хураасан;
    - Бонд гаргагч тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх болсон, хугацааг сунгуулсан, эсхүл түүнийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон;
    - Бонд гаргагч нь гуравдагч этгээдийн өмнөөс баталгаа, батлан даалт гаргасан;

ПЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2021.06.23
Бүртгэв
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

## 3.6 ӨРИЙН ХЭРЭГСЛИЙГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТУХАЙ




*Схем 8: Анхдагч зах зээлд байршуулах тухай*

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12.1-т заасны дагуу нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэл болон хөрөнгийн биржийн бүртгэл аль алинд нь бүртгэгдсэн үнэт цаасыг үнэт цаасны анхдагч зах зээлд худалдана.

Мөн хуулийн 12.2-т зааснаар Үнэт цаасны анхдагч зах зээлд үнэт цаасыг арилжих зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хороо олгох бөгөөд Хороо уг зөвшөөрлийг хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэсэн болон холбогдох бэлтгэлийг хангасан тухай хөрөнгийн биржээс гаргасан тодорхойлолт, үнэт цаас гаргагчийн хүсэлтэд үндэслэн олгох бөгөөд Монголын хөрөнгийн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 10 сарын 25-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-д /ТУЗ-ийн 2021 оны 03 сарын 26-ны өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/ заасны дагуу Үнэт цаас гаргагч болон Андеррайтер компаниуд өрийн хэрэгслийг анхдагч зах зээлд байршуулах дэлгэрэнгүй төлөвлөгөөг танилцуулах болно.

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 21/18 тоот тогтоолын дагуу анхдагч зах зээлд нийт 50,000 /тавин мянга/ ширхэг нэг бүр нь 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий компанийн өрийн хэрэгслийг олон нийтэд нээлттэй санал болгон арилжаалах бөгөөд Хөрөнгийн биржийн Анхдагч зах зээлийн арилжааны тогтоосон үнийн аргыг ашиглан олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн.

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй бондын худалдан авах захиалгын хугацааг Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл гарсны дараа Үнэт цаас гаргагч болон Андеррайтерийн компаниуд харилцан зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэнэ.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК
ХХК

СЭХ
2021 06 23
БҮРТГЭВ
№ 04

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

**Тогтоосон үнээр санал болгох арилжааны арга**

Монголын Хөрөнгийн биржийн 2018 оны 10 сарын 25-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-д заасны дагуу үнэт цаас гаргагчийн тогтоосон тодорхой үнэ/өгөөж/-ээр санал болгон арилжих үйл ажиллагаа юм.

**Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд хэрхэн оролцох вэ?**




*Схем 9: Анхдагч зах зээлийн арилжаанд оролцох заавар*

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

# IV. Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцсон байгууллагууд

СЗХ
2021.06.23

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

## 4. ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

### 4.1.АНДЕРРАЙТЕРИЙН ТАНИЛЦУУЛГА, ДҮГНЭЛТ

| Байгууллагын нэр | "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК |
|---|---|
| Үйл ажиллагааны чиглэл | Андеррайтер, Брокер, Дилер |
| Хаяг | Монгол Улс, Улаанбаатар 14200<br>Сүхбаатар дүүрэг, 8-р хороо<br>Сити центр, 10 давхар, 1003 тоот |
| Утас | +976-7777-6377 |
| Цахим шуудан | info@ucc.mn |

"Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК нь Монголын тэргүүний үнэт цаасны компаниудын нэг бөгөөд хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээг үзүүлэх үндсэн зорилготойгоор 2007 онд байгуулагдсан. Компани нь СЗХ-оос үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер болон андеррайтерийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, МХБ болон МҮЦАЭХ-ийн гишүүн байгууллага юм.

"Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК нь дотоодын үнэт цаасны арилжаа төдийгүй Монголд анх удаа HKEX, LSE, ASX and NYSE зэрэг гадаадын биржийн арилжаанд оролцох үйлчилгээг нэвтрүүлж, энэхүү үйлчилгээгээр дотооддоо тэргүүлсээр байна. "Сүү" ХК-ийн 6.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий бондын санхүүжилт босгох үйл ажиллагаанд хамтрагч андеррайтераар ажилласан. 2018 онд Үндэсний өв соёлыг эрхэмлэгч, НААД брэндийн эрхийг эзэмшигч "Талын Эзэн" ХХК-ийн 420.0 сая төгрөгийн бондыг хаалттай хүрээнд амжилттай арилжаалж, Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв-д бүртгүүлж хөрөнгө оруулагчдын эзэмшлийг баталгаажуулсан нь Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд анхны тохиолдол байв. Мөн оны 6 сард Урбан брэндийн 600.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий "Урбан бонд", 8 сард 1.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий "Бэрс бонд" хаалттай бондуудын санхүүжилт босгох үйл ажиллагаанд хамтрагч андеррайтераар, 2019 оны 4 сард "АБТС ББСБ" ХХК-д зээлийн санхүүжилт зуучлагч андеррайтераар тус тус ажиллаад байна. Мөн 2019 онд банк бус санхүүгийн байгууллагын хоёрдогч IPO болох "Ард Кредит ББСБ" ХХК-ийн IPO-д үндсэн андеррайтераар амжилттай ажиллаад байна.

"Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК нь үнэт цаасны гадаад, дотоод арилжаа, андеррайтерийн ажил үйлчилгээнээс гадна байгууллагын санхүүжилт, M&A болон бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд 2015-2018 онуудад Япон Улсын JICA хамтын ажиллагааны байгууллагад макро эдийн засгийн зөвлөх, "Зэс Эрдэнийн Хувь" ХХК, "Түшиг Уул" ХК, "Eurofeu" ХХК зэрэг компаниудад санхүүгийн зөвлөхийн үүрэг гүйцэтгэсэн. "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК-ийн Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд оруулж буй манай компанийн хувь нэмрийг үнэлж Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн холбооноос 2011 онд "Шилдэг Брокерийн компани"-аар, 2013 онд Монголын хөрөнгийн зах зээлийн дээд шагнал GRAND BULL AWARDS

2021/05/24

“Шилдэг Шинийг Санаачлагч” байгууллагаар тус тус шалгарч байсан бөгөөд 2018 онд Гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр нь Монголын хөрөнгийн зэх зээлийн дээд шагнал GRAND BULL AWARDS “Шилдэг Мэргэжилтэн” –ээр тодорсон билээ.

Андеррайтерийн гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг

Энэхүү гэрээгээр андеррайтер нь Үнэт цаас гаргагчид нээлттэй хүрээнд санхүүжилт татах үйл ажиллагаатай холбоотой Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д заасны дагуу үнэт цаас гаргах төлөвлөгөөг боловсруулах, үнэт цаасны танилцуулга материалыг бэлтгэх, хөрөнгө оруулагчдад санал болгох, хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх, мөн энэхүү үйл ажиллагаатай холбогдуулан СЗХ болон МХБ-тэй үнэт цаас гаргагчийг төлөөлөн харилцах гэх мэт талуудын хоорондын харилцааг зохицуулна.

- Андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4.3 дугаарт заасны дагуу Хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах хэлбэрээр зохион байгуулна.
- Андеррайтер тус бүр нь энэхүү гэрээ болон ажил гүйцэтгэх төлөвлөгөөнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлэх үүрэгтэй бөгөөд андеррайтер тус бүр төлөвлөгөөнд заасан ажлыг заасан хугацаанд гүйцэтгэх үүрэгтэй.
- Үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий этгээд нь нийтэд санал болгох үнэт цаасны үнийг үндэслэлгүйгээр тогтоосон эсхүл тус үнэ нь үнэт цаас гаргах үйл ажиллагааг амжилтгүй болгоход хүргэнэ гэж андеррайтер үзсэн тохиолдолд андеррайтер нь үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эрхтэй.
- Үнэт цаас гаргагч нь андеррайтерийг шаардлагатай бүхий л мэдээ мэдээллээр үнэн зөв, түргэн шуурхай хангаж ажиллах үүрэгтэй.
- Андеррайтер нь гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол Үнэт цаас гаргагч нь гэрээг түдгэлзүүлэх мэдэгдлийг бичгээр үйлдэж, түүнд төлбөл зохих төлбөрийг түдгэлзүүлж болох бөгөөд энэхүү мэдэгдэлд биелүүлээгүй үүргийн шинж чанарыг тодорхойлох ба энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор зөрчлийг арилгах арга хэмжээ авахыг андеррайтераас шаардах эрхтэй.
- Үнэт цаас гаргагч нь тогтоосон хугацаанд аливаа дотоод мэдээллийг андеррайтертай зөвшилцөлгүйгээр олон нийтэд мэдээлсэн, үүний улмаас үнэт цаас гаргагчийн үнэт цаасны үнэлгээнд эрс өөрчлөлт гарсан, хөрөнгө оруулалт, санхүүжилт татах ажиллагаанд саад учруулсан, хөрөнгө оруулагчдад буруу мэдээлэл хүргэсэн болон бусад байдлаар андеррайтерийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд саад учруулсан бол Үнэт цаас гаргагч учирсан хохирлыг өөрөө хариуцна.

2021/05/24

СВХ
2021 .06. 23
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18
БҮРТГЭВ-03

## СИНДИКАТ КОМПАНИ

| Байгууллагын нэр | "Райнос Инвестмент ҮЦК" ХХК |
|---|---|
| Үйл ажиллагааны чиглэл | Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер, Дилер |
| Хаяг | Монгол Улс, Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Централ Тауэр, 13 давхар, 1308Б тоот |
| Утас | +976-7510-0575 |
| Цахим шуудан | info@rhinosinvest.mn |

"Райнос Инвестмент ҮЦК" ХХК нь БНСУ-ын хуулийн этгээд Райнос Эссет Менежмент ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттайгаар 2019 онд анх үүсгэн байгуулагдсан бөгөөд Монгол улсын хөрөнгийн зах зээлд амжилттай үйл ажиллагаагаа явуулахаар зорин ажиллаж байна. "Райнос Инвестмент ҮЦК" ХХК нь Брокер, Дилер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Гадаад улсын зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах, Номинал дансаар дамжуулан үнэт цаасны брокерын цогц үйлчилгээг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлж байгаа бөгөөд гадаадын хөрөнгийн зах зээлд бонд зуучлах, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг үзүүлж эхлээд байна. Үйл ажиллагаа явуулж эхлээд удаагүй боловч манай компани гадаадын зах зээлд арилжаалагдаж буй Монгол Улсын Засгийн Газрын Бонд болон санхүүгийн байгууллагын бондуудад гадаадын хөрөнгө оруулагчдыг амжилттай зуучлаад байна.

"Райнос Инвестмент ҮЦК" ХХК-ийн толгой компани болох Райнос Эссет Менежмент компанийн Монголд хийсэн томоохон хөрөнгө оруулалтууд:

- Монголын анхны финтек компани болон ЛэндМН ББСБ-ын IPO-д стратегийн хөрөнгө оруулалтыг гадаадын мэргэжлийн хөрөнгө оруулагчийн хувиар хийсэн.
- Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд анх удаа АНД Системс ХХК-ийн санхүүжилтэд зориулж хувьцаа барьцаалсан солилцох бондын 7 тэрбум төгрөгийн санг амжилттай байгуулсан.
- 2017 оноос хойш БНСУ-ын хөрөнгө оруулалтын сантай хамтран нийт 14 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, Монголын компаниудыг өсөлт үзүүлэхэд нь дэмжиж ажилласаар ирсэн.
- Монголын Хөгжлийн Банкны гаргасан хадгаламжийн сертификатын (CD) бүтээгдэхүүнд 2017-2019 онуудад хуримтлагдсан дүнгээр нийт 210.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ.
- 2021 онд Технологийн салбарын старт-ап компанид 2.0 сая ам.долларын хөрвөх бондын санхүүжилт хийсэн байна.

lendmn
УЛААНБААТАР ХОТ

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ 2021.06.23

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

# АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ

"Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК /өмнө нь "Ард Капитал ҮЦК" ХХК/ нь Монгол улсын "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"[1], СЗХ-ны "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон МХБ ТӨХК-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"[2]-ийн холбогдох заалтуудын дагуу үнэт цаас гаргагч ЛэндМН ББСБ ХК (РД: 5039754)-тай 2021 оны 05 сарын 20-ны өдөр 2021/13 тоот "Андеррайтер болон зөвлөх үйлчилгээний гэрээ"-г байгуулан ажилласан болно.

Андеррайтер нь гэрээний дагуу Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, үнэт цаас гаргах төлөвлөгөө, санхүүгийн үзүүлэлтийн төсөөллийн хэрэгжих магадлал, татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт, эдийн засгийн үр ашгийн тооцоо болон олон нийтэд санал болгох үнэт цаасны танилцуулгыг боловсруулахад шаардлагатай зөвлөмжөөр хангаж ажиллаа.

2020 он бүхэлдээ Ковид-19 цар тахлын улмаас эдийн засаг агшиж, бизнесийн үйл ажиллагаа хумигдан, иргэдийн хэрэглээ буурч, эдийн засгийн эргэлт буурснаас санхүүгийн байгууллагын зээл гаргалт хумигдан, эргэн төлөлтийн чадавх буурсан амаргүй жил байлаа.

Гэсэн хэдий "ЛэндМН ББСБ" ХК-ийн хувьд эрсдэлийн менежментийн удирдлагыг сайн хэрэгжүүлснээр эх үүсвэрийн дутагдалгүй давсан, зээлийн эргэн төлөлтийн чанарыг сайжруулж чадсан зэрэг амжилттайгаар 2020 оныг даван гарсан гэж дүгнэж байна. Андеррайтер Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох дүрэм журам болон үнэт цаас гаргахтай холбоотой хөндлөнгийн үнэлгээний байгууллагуудын хараат бус дүгнэлтэд үндэслэн энэхүү "Үнэт цаасны танилцуулга"-ыг бэлтгэж, мэргэжлийн дүгнэлтийг танилцуулж байна.

Андеррайтерийн дүгнэлтийн агуулга:

1. Үнэт цаас гаргагч
2. Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа
3. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн мэдээлэл
4. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт
5. Анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө
6. Хөрөнгө оруулалтын өгөөж
7. Хөрөнгө оруулалтын эрсдэл
8. Дүгнэлт

[1] ҮЦЗЗТХ- ийн 5.1.1-д үнэт цаасыг нийтэд санал болгохдоо андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдтэй гэрээ байгуулна гэж заасан бөгөөд, 41.1-д Андеррайтерийн үйл ажиллагааг "Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр түүний үнэт цаасыг нийтэд санал болгон гаргахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, үнэт цаас гаргагчийн үнэт цаасны анхдагч зах зээлд худалдагдаагүй үлдсэн үнэт цаасыг андеррайтерийн гэрээнд заасан хэмжээгээр худалдан авах зэрэг ажиллагааг андеррайтерийн үйл ажиллагаа гэнэ" хэмээн заасан. 

[2] МХБ ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 12 сарын 30-ны өдрийн 2015/14 тоот тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан тус журмын 4.1-д "Хүсэлт гаргагч нь Биржийн бүртгэлд бүртгүүлэх бэлтгэл шатанд хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөлтэй андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээд /цаашид "андеррайтер" гэх/-тэй гэрээ байгуулан бүртгүүлэх ажиллагааны бэлтгэлийг хангана" хэмээн заасан.

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 .1111267206

2021/05/24

ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

Үнэт цаас гаргагч нь 2006 онд үүсгэн байгуулагдан, 2015.06.24-ний өдөр СЗХ-ноос "Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үйл ажиллагаа" эрхлэх тусгай зөвшөөрөл авсан бөгөөд 2016.12.23-нд оноосон нэрийг "ЛэндМН ББСБ" ХК болгон өөрчилсөн байна.

Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн зохицуулах хорооны 2018.02.07-ний өдрийн 60 тоот тогтоолын дагуу нээлттэй хувьцаат компани болон өөрчлөн байгуулагдсан бөгөөд 2018.03.13-ний өдөр МХБ-ээр дамжуулан компанийн нийт хувьцааны 25 хувьтай тэнцэх 200 сая ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгон нийт 5 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн байна.

Хувь эзэмшлийн бүтцийн хувьд нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь нийт хувьцааны 75 хувийг эзэмшиж буй Монгол улсын хуулийн этгээд "АНД Системс" ХХК байна. Харин "АНД Системс" ХХК нь Сингапур улсын хуулийн этгээд "АНД Глобал" ПиТиИ ЭлТиДи компанийн 100 хувийн эзэмшилд байна.

"АНД Глобал" ПиТиИ ЭлТиДи компани нь 2017 онд үүсгэн байгуулагдаж түүнээс хойш өнөөг хүртэл "АНД Системс Тех" ХХК, "АНД Системс" ХХК, "ЛэндМН ББСБ" ХК, "АНД Эф Эс Жи" болон "АНД Эф Си" зэрэг охин компаниудыг байгуулан тэдгээрээр дамжуулж Монгол залуусын зохион бүтээсэн санхүүгийн технологийн хялбар шийдлийг Монгол Улсад төдийгүй бусад улсын хэрэглэгчдэд хүргэж байна. "АНД Глобал" ПиТиИ ЭлТиДи компани нь 2020 оны 11 сард Япон улсын Марубени корпорацаас 10 сая ам.долларын хөрөнгө оруулалт авах гэрээг амжилттай байгуулсан нь манай улсын түүхэнд тэмдэглэгдэх үйл ажиллагаа болсон билээ.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ын гишүүд болон гүйцэтгэх удирдлага нь компанийн засаглалын сургалтад хамрагдсан бөгөөд тухайн салбартаа олон жил ажилласан туршлагатай, мэргэшсэн, хоорондоо нэгдмэл сонирхолгүй, бие даан шийдвэр гаргах бүрэн чадвартай буюу компанийн сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэн компанийн тогтвортой хөгжлийг ханган ажиллах бүрэн боломжтой, МХБ ТӨХК-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 10.5.7[3] болон 10.5.1[4]-ын заалтуудыг тус тус хангасан байна.

[3] эрх бүхий албан тушаалтнууд нь компанийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай мэдлэг туршлагатай байх.

[4] Үнэт цаас гаргагч, түүний хувьцааны хяналтын багцыг эзэмших этгээд, ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал нь татварын болон хугацаа хэтэрсэн их хэмжээний зээлийн өргүй байх



2021/05/24

## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

Үнэт цаас гаргагч нь Монгол улсын санхүүгийн зах зээлд анх удаа гар утаснаасаа түргэн шуурхай бичил хэрэглээний зээл авах "шийдэл"-ийг нэвтрүүлэн иргэдийн өдөр тутмын санхүүгийн зээлийн харилцааг хялбаршуулахад үнэтэй хувь нэмэр оруулсан билээ. ЛэндМН аппликэйшн зах зээлд нэвтэрсний дараагаар маш олон компаниуд ижил төстэй санхүүгийн үйлчилгээ үзүүлж эхэлсэн нь үүнийг баталж байна гэж дүгнэж болох юм.

ЛэндМН ББСБ ХК болон АНД Системс Тех ХХК-тай 2017 оны 7 сарын 1-ний өдөр байгуулсан "Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх(лиценз)-ийн гэрээ"-ээр ЛэндМН аппликейшнийн оюуны өмчийг Монгол улсын нутаг дэвсгэрт 50 жилийн хугацаатай онцгой эрхтэйгээр ашиглах эрхийг олгосон нь технологийн шийдлийн хувьд тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Компани нь 2018 оны байдлаар 93.8 мянган харилцагчтай байсан бол тус үзүүлэлт 2019, 2020 онуудад тус бүр 166.4 мянга болон 175.3 мянга болон өргөжсөн байна. Харин нийт гаргасан зээлийн хувьд 2020 онд 390 тэрбум төгрөг болон тэлж 2018 оны 150 тэрбум төгрөгийн дүнтэй харьцангуй 160 хувь өссөн байна.

Харин 2020 онд зээлийн багцын хувьд 28.1 тэрбум төгрөг буюу 2019 оны багцаас буурсан үзүүлэлттэй гарсан боловч андеррайтерийн зүгээс эрсдэлийн удирдлагыг авч хэрэгжүүлсэн нь цар тахалтай үед оновчтой арга хэмжээ байсан хэмээн үзэж байна. Өөрөөр хэлбэл компани нь цар тахлын нөлөөн дор бизнесийн үйл ажиллагаа доголдолд орох эрсдэлтэй үеийг санхүүгийн үзүүлэлтийн хувьд амжилттай даван гарсан нь үнэт цаас гаргагчийн бизнес загвар зөв байгаа, эрсдэлийн удирдлага сайн байгааг шалгасан үйл явдал боллоо хэмээн дүгнэж байна.

## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ

**Тайлан тэнцлийн таамаглал**

| | 2018A | 2019A | 2020A | 2021 F | 2022 F | 2023 F | 2024 F | 2025 F |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Нийт хөрөнгө** | **24,323** | **58,100** | **39,681** | **45,797** | **61,491** | **82,939** | **92,400** | **102,424** |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 4,218 | 6,756 | 9,521 | 3,214 | 3,338 | 6,527 | 5,704 | 4,707 |
| Харилцагчдад олгосон нийт зээл | 19,210 | 50,007 | 28,115 | 41,231 | 56,809 | 75,089 | 85,402 | 97,355 |
| Хэвийн зээл | 18,075 | 47,055 | 25,036 | 37,719 | 52,636 | 70,430 | 80,368 | 91,302 |
| Хугацаа хэтэрсэн зээл | 792 | 1,218 | 514 | 678 | 925 | 1,236 | 1,616 | 2,082 |
| Чанаргүй зээл | 343 | 1,734 | 2,565 | 2,834 | 3,248 | 3,423 | 3,418 | 3,971 |
| Зээлийн эрсдэлийн нөөц | (444) | (1,552) | (3,343) | (4,190) | (4,710) | (5,057) | (5,269) | (6,070) |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | - | - | 2,500 | 2,500 | 2,500 | 2,500 | 2,500 | 2,500 |
| Бусад хөрөнгө | 693 | 1,385 | 1,647 | 1,886 | 2,252 | 2,625 | 2,807 | 3,021 |

2021/05/24

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үндсэн хөрөнгө | 258 | 1,162 | 1,063 | 1,011 | 1,188 | 1,173 | 1,203 | 889 |
| Биет бус хөрөнгө | 388 | 342 | 178 | 145 | 113 | 83 | 53 | 23 |

| | 2018A | 2019A | 2020A | 2021 F | 2022 F | 2023 F | 2024 F | 2025 F |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Өр төлбөр** | **10,969** | **40,902** | **22,159** | **25,708** | **33,334** | **47,864** | **49,925** | **50,276** |
| Зээлийн эх үүсвэр | 9,849 | 37,985 | 20,489 | 23,934 | 31,334 | 45,434 | 47,434 | 47,834 |
| Бондын өр төлбөр | 6,329 | 3,523 | 7,266 | 9,636 | 8,636 | 14,436 | 14,436 | 15,336 |
| Итгэлцэл | - | 13,696 | 10,364 | 11,957 | 19,557 | 19,457 | 21,457 | 21,457 |
| Банкны зээл | 3,520 | 8,604 | 2,859 | 186 | 1,386 | 8,486 | 186 | 686 |
| Бусад зээл | - | 12,162 | - | 2,155 | 1,755 | 3,055 | 11,355 | 10,355 |
| Бусад өр төлбөр | 1,120 | 2,917 | 1,670 | 1,774 | 2,000 | 2,430 | 2,491 | 2,442 |

| | 2018A | 2019A | 2020A | 2021 F | 2022 F | 2023 F | 2024 F | 2025 F |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Эздийн өмч** | **13,354** | **17,198** | **17,522** | **20,089** | **28,157** | **35,075** | **42,476** | **52,148** |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 10,814 | 10,814 | 10,814 | 10,814 | 10,814 | 10,814 | 10,814 | 10,814 |
| Халаасны хувьцаа | 0 | (266) | (989) | (1,493) | (1,493) | (1,493) | (1,493) | (1,493) |
| Тайлант үеийн ашиг (алдагдал) | 2,560 | 4,910 | 2,240 | 3,206 | 5,389 | 6,457 | 8,046 | 9,672 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | (20) | 1,740 | 5,457 | 7,249 | 10,134 | 14,984 | 20,795 | 28,842 |
| Бусад эздийн өмч | - | - | - | 313 | 3,313 | 4,313 | 4,313 | 4,313 |
| **Нийт өр төлбөр болон эздийн өмч** | **24,323** | **58,100** | **39,681** | **45,797** | **61,491** | **82,939** | **92,401** | **102,424** |

*Хүснэгт 20: Үнэт цаас гаргагчийн тайлан тэнцлийн таамаглал (сая төгрөг)*

## Орлогын тайлангийн таамаглал

| | 2018A | 2019A | 2020A | 2021F | 2022F | 2023F | 2024F | 2025F |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Хүү, шимтгэлийн орлого** | **7,143** | **18,497** | **16,298** | **15,093** | **19,961** | **24,942** | **29,743** | **33,105** |
| Хүүгийн зардал | (512) | (4,487) | (5,229) | (3,567) | (5,076) | (7,226) | (8,545) | (8,692) |
| **Цэвэр хүүгийн орлого** | **6,631** | **14,010** | **11,069** | **11,526** | **14,885** | **17,716** | **21,198** | **24,413** |
| Эрсдэлийн сангийн зардал | (408) | (1,619) | (2,393) | (1,639) | (1,484) | (1,918) | (2,449) | (3,039) |
| **Эрсдэлийн сангийн дараах орлого** | **6,223** | **12,391** | **8,676** | **9,887** | **13,401** | **15,798** | **18,749** | **21,374** |
| Шимтгэлийн зардал | (981) | (1,925) | (1,659) | (1,563) | (1,955) | (2,307) | (2,605) | (2,797) |
| **Шимтгэлийн дараах орлого** | **5,242** | **10,466** | **7,017** | **8,324** | **11,446** | **13,491** | **16,144** | **18,577** |
| Ерөнхий зардал | (1,032) | (2,485) | (2,093) | (2,349) | (2,782) | (3,137) | (3,319) | (3,428) |
| Удирдлагын зардал | (1,345) | (1,950) | (2,382) | (2,412) | (2,677) | (2,945) | (3,297) | (3,454) |
| **Нийт үйл ажиллагааны зардал** | **(2,377)** | **(4,435)** | **(4,475)** | **(4,761)** | **(5,459)** | **(6,082)** | **(6,616)** | **(6,882)** |
| **Татвах төлөхийн өмнөх ашиг** | **2,865** | **6,031** | **2,542** | **3,563** | **5,987** | **7,409** | **9,528** | **11,695** |
| Татвар | (305) | (1,121) | (302) | (357) | (598) | (952) | (1,481) | (2,023) |
| **Цэвэр ашиг** | **2,560** | **4,910** | **2,240** | **3,206** | **5,388** | **6,457** | **8,047** | **9,672** |

*Хүснэгт 21: Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн таамаглал (сая төгрөг)*

2021/05/24

Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөөний үндэслэл, санхүүгийн таамаглал, болон Ковид19 цар тахлын үеийг амжилттай даван гарсан зэрэг үзүүлэлтийг авч үзэхэд ЛэндМН ББСБ ХК нь бизнес төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулан санхүүгийн үзүүлэлтээ хангах бүрэн боломжтой хэмээн дүгнэж байна.

## ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТУХАЙ

ЛэндМН ББСБ ХК-ийн 2021 оны 05 сарын 20-ны өдрийн ТУЗ-ийн 21/18 тоот тогтоолд "Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор компанийн өрийн бичгийг нийтэд санал болгон гаргахаар шийдвэрлэсүгэй" гэж заасныг үндэслэн нийт 5'000'000'000 (таван тэрбум) төгрөгийг өрийн бичиг гаргах замаар олон нийтээс татан төвлөрүүлж бичил хэрэглээний зээлийн санхүүжилтэд зарцуулахаар шийдвэрлэжээ.

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлтийг үндэслэн "Олон нийтээс санхүүжилт татан төвлөрүүлэх" үндэслэл нь дараах байдлаар тодорхойлогдож байна.

1.1 Үнэт цаас гаргагч бизнес төлөвлөгөөний дагуу 2020 онд нийт 1.6 сая удаагийн зээл олголтоор 312 тэрбум төгрөгийн зээлийг харилцагчдад олгож зээлийн багцын үлдэгдлийг 47 тэрбум байхаар төлөвлөсөн ба үүний 5 тэрбум төгрөгийг нээлттэй өрийн бичиг гаргах замаар санхүүжүүлэх шийдвэр гаргасан.

1.2 Үнэт цаас гаргагчийн судалгаагаар иргэдийн бичил хэрэглээний зээлийн эрэлт 2018 онтой харьцуулахад даруй 30 хувь өссөн үзүүлэлттэй байх тул компанийн үндсэн бизнес болох зээлийн эрэлт хангалттай буюу бондын зарцуулалт төлөвлөгөөний дагуу зарцуулагдах бүрэн боломжтой хэмээн үзэж байна.

## АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

**2.1 МХБ ТӨХК бүртгэлийн шалгуур:**

Үнэт цаас гаргагч нь МХБ ТӨХК-ийн ТУЗ-ийн 2018.01.25-ны өдрийн 2018/01 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 14 дүгээр зүйлд заасны дагуу Өрийн хэрэгслийн шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа гэж үзэж байна.

**2.2 Санал болгох үнэ:**

Үнэт цаас гаргагч нь нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 50,000 ширхэг өрийн хэрэгслийг 2 жилийн хугацаатай 14.0 хувийн өгөөжтэйгөөр анхдагч зах зээлд байршуулахаар төлөвлөж байна.

Энэ нь бодлогын хүү буурахтай зэрэгцэн хадгаламжийн хүү буурч буй өнөө үед бонд эзэмшигчдэд 2 жилийн хугацаанд, харьцангуй өндөр өгөөжтэй тогтвортой хүү эзэмших боломжийг олгож буйгаараа онцлогтой юм.

СЗХ
2021.06.23

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



***Татварын хөнгөлөлт***

Компанийн нээлттэй бондын хувьд 5%-ийн хүүгийн татвар төлөх зохицуулалттай байгаа тул бонд эзэмшигчдийн хувьд өгөөжөө нэмэгдүүлэх давуу талтай юм.

***Харьцангуй өндөр өгөөж***

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад 14.0 хувь, татварын дараах 13.3 хувийн хүүг санал болгож байгаа нь зах зээл дээр арилжаалагдаж буй нээлттэй бондуудаас хамгийн боломжит өндөр хүүтэй байна.

Өнгөрсөн оны мөн үеэс бодлогын хүү 3%, хадгаламжийн хүү 3%-6% буурсантай харьцангуй ЛэндМН ББСБ ХК-ийн санал болгож буй бондын татварын дараах өгөөж нь 2.85 хувь буурсан нь хадгаламжийн хүүгээс 5.83% өндөр хүү санал болгох боломжийг бий болгосон байна. Түүнчлэн өнөөдөр зах зээл дээр арилжаалагдаж буй жишиг бонд буюу 2021 оны 4 сард гарсан ЭТТ бондын татварын дараах өгөөжөөс 3.8 хувиар өндөр байгаа нь бонд эзэмшигчдэд хөрөнгөө илүү өгөөжтэй удирдах таатай боломжийг бий болгож байна.

*График 38: Өгөөж /татварын дараа/*




** Инвескор Актив ТЗК-ын гаргасан ХБҮЦ-ны хувьд үндсэн төлбөр нь 3 сар тутам буюу 24 сарын хугацаанд нийт 8 хуваагдаж эргэн төлөгдөх нөхцөлтэй тул бодит өгөөж нь анх оруулсан дүнгээс тооцогдохгүй юм.*

*Эх сурвалж: Бүтээгдэхүүн тус бүрийн танилцуулга*

***2 жил хүүгээ бууруулахгүй эзэмших боломж***

Сүүлийн жилүүдэд хадгаламжийн хүү тасралтгүй буурч байгаатай холбогдуулан иргэд мөнгөн хуримтлалын өгөөжөө бууруулахгүй удирдах боломжийг эрэлхийлэх хандлагатай байна. Үнэт цаас гаргагчийн хувьд тус үнэт цаасыг 2 жилийн хугацаатай санал болгосноор иргэд, байгууллагуудад хуримтлалын өгөөжөө тогтвортой хадгалах боломжийг олгож байна.

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК
ХХК
5183855
CTC2420

*Хугацааны дундуур хүү авах боломж /6 сар тутам/*

Үнэт цаас гаргагч нь 6 сар тутам хүүгээ олгох төлөвлөгөөтэй байгаа тул бонд эзэмшигчийн хувьд авсан хүүгээ дахин удирдаж өгөөжөө нэмэгдүүлэх боломжтой.

*Хугацааны дундуур зарах боломж*

Нээлттэй бондыг худалдан авснаар бонд эзэмшигч нь хэрэгцээтэй үедээ эзэмшсэн бондоо хэсэгчилэн болон бүхэлд нь зарах боломжтой байдаг.

*Арилжааны зөрөөгийн ашиг хүртэх боломж*

Нээлттэй бондыг эзэмшиж байх хугацаанд зах зээл дээр хадгаламжийн хүү буурах юм уу эсвэл бондын эргэн төлөлтийн хугацаа дөхөх тусам бондын үнэ өссөнөөр бонд эзэмшигч нарын хувьд арилжааны зөрөөний ашиг олох боломж бий болдог.

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРСДЭЛИЙН ТУХАЙ

Аливаа санхүүгийн бүтээгдэхүүн нь тодорхой төвшний эрсдэлтэй байдаг тул хөрөнгө оруулагч та шийдвэр гаргах бүртээ сайн судлах шаардлагатай юм. Хөрөнгө оруулалтын эрсдэлийн талаар анхааруулж буй агуулга нь бүх боломжит эрсдэлийг дурдаагүй байж болох бөгөөд Ковид-19 цар тахал ч үүний нэгэн жишээ болсон билээ.

**Бизнесийн эрсдэл**

*Эргэн төлөлт муудах*

Аливаа санхүүгийн харилцаанд орохдоо жишээ нь мөнгөө хадгалуулах, бонд эзэмших, мөнгө зээлэх үедээ харилцагчид тухайн банк, ББСБ-ын эргэн төлөлтийн чадавх, санхүүгийн тайлангийн байдлыг судлах боломж тэр бүр байдаггүй нь эрсдэх нөхцөлийг бий болгодог.

Ковид-19 цар тахалтай холбоотой санхүүгийн хэрэглэгчдийн эргэн төлбөрийн чадвар муудсанаар том үнийн дүнтэй зээл гаргагч санхүүгийн байгууллагуудын эргэн төлөлт удаашрах, хойшлох, сунгагдах хандлагатай байна. Түүнчлэн хөл хорио тогтоосонтой холбоотойгоор технологийн хөгжүүлэлтгүй санхүүгийн байгууллагуудын хувьд эрсдэлийн түвшин өндөр байх магадлалтай юм.

**Харин ЛэндМН ББСБ ХК-ийн хувьд** бизнесийн загвар нь зах зээл дээр тогтворжсон, эрсдэлийн удирдлага чадавхижсан зэрэг нь ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг бусад байгууллагуудтай харьцангуй чанаргүй зээлийн хэмжээ бага байх нөхцөлийг олгох боломжтой гэж харж байна. Өөрөөр хэлбэл оновчтой бизнес загвар, чадавхижсан эрсдэлийн удирдлага нь тус компанийн зах зээл дээр эзлэх байр суурьа хадгалах үндсэн суурь болж өгч байна. Үүнд:

1. Харьцангуй урт хугацааны эх үүсвэрээр богино хугацаат зээл гаргаж буй тул хөрвөх чадварын эрсдэл харьцангуй бага

2. Зах зээл дээр харилцагчдын тооны хувьд тогтворжих мөчлөгтөө орон, харьцангуй чанартай харилцагчдыг бий болгосон
3. Нэг хүнд олгох зээлийн дүн бага
4. Өөрсдийн хөгжүүлсэн хиймэл оюун ухааны тусламжтайгаар харилцагчийн зээлжих чадварын үнэлгээг цаг алдалгүй шинэчилж байгаа
5. Бизнес эрсдэх магадлалтай урт хугацаат уламжлалт зээл рүү зах зээлээ тэлээгүй

***Эх үүсвэр***

Санхүүгийн байгууллагуудын хувьд гадаад эх үүсвэрийн дутагдлаас үүдэн эх үүсвэрийн дийлэнх нь богино буюу 1 жил дотор эргэн төлөгдөхөөр байдаг. Энэ нь нөгөө талаас санхүүгийн байгууллагуудын урт хугацаат зээл гаргах боломжийг хязгаарлаж, эх үүсвэрээ дахин санхүүжүүлэх шаардлагыг бий болгодог. Өөрөөр хэлбэл богино хугацаат эх үүсвэрээр урт хугацаат зээл олгон эх үүсвэрийн байнгын дутагдалтай байдаг санхүүгийн байгууллагуудын хувьд ирэх жилүүдэд хямрах магадлалтай байдаг.

Харин үнэт цаас гаргагчийн хувьд үндсэн зээл олголтын төрөл нь 7-30 хоногтой байхад эх үүсвэрийн дийлэнх нь 1 жил хүртэл хугацаатай байдаг нь эх үүсвэрийн зохистой удирдлагыг хэрэгжүүлснээр мөнгөн урсгалаа зохицуулах боломжийг олгох онцлогтой.

***Эрсдэлийн менежментийн бодлого***

Санхүүгийн байгууллага нь зээлийн эрсдэл, зах зээлийн эрсдэл, багцын эрсдэл, ханшийн эрсдэл, хүүгийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл зэрэг олон эрсдэлийг үүрдэг. Ялангуяа санхүүгийн байгууллага нь өндөр хүү амлах тусам эрсдэл өндөр байх магадлалтай байдаг гэдгийг иргэд анхаарч байх нь зүйтэй юм. Үнэт цаас гаргагч нь 2019 онд эрсдэлийн бодлогоо сайжруулан журамлаж, дотоод хяналтын системээ чангаруулах арга хэмжээ авсан нь 2020 оны цар тахлын амаргүй үеийг амжилттай давах туулахад нөлөөлсөн гэж үзэж байна.

***Бизнес төлөвлөгөөний биелэлт***

2020 оны цар тахлын эдийн засгийн хүнд үеийн дараагаар эдийн засаг хэвийн байдалд ороход иргэдийн эдийн засгийн хэрэглээ нэмэгдэх магадлалтай байгаа нь бизнес төлөвлөгөөг биелүүлэхэд эерэгээр нөлөөлнө гэж харж байна. Гэвч санхүүгийн байгууллагуудын хувьд эх үүсвэрийн дутмагшил, эргэн төлөлтийн чадавх муудах зэрэг нь хамгийн том бэрхшээл хэвээр байх төсөөлөлтэй байна.

Үнэт цаас гаргагчийн хувьд харьцангуй богино хугацааны зээл гаргаж байгаа тул эрсдэх магадлалтай зээлийг маш хурдан илрүүлэх боломжтой бөгөөд, өөрсдийн технологийг ашиглан хэрэглэгчдийн дахин үнэлгээ хийх замаар зээлийн чанараа сайжруулах боломжтой гэж харж байна.

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
2021/05/24

*Технологийн эрсдэл*

Санхүүгийн байгууллагын хувьд технологио өөрөө хөгжүүлэх боломжгүй хараат байх нь техникийн алдаа гарах, үйл ажиллагааны эрсдэлд орох зэрэг эрсдэлүүдийг нэмэгдүүлэх боломжтой. Үнэт цаас гаргагчийн хувьд ЛэндМН ББСБ ХК-ийн толгой компани болох АНДСистемс ХХК-нь 50 жилийн онцгой нөхцөлтэйгөөр технологио ашиглуулж байгаа нь энэхүү эрсдэлийг бууруулж байна гэж дүгнэж байна.

## ДҮГНЭЛТ

ЛэндМН ББСБ ХК нь финтек шийдлээр бичил зээл олгох бизнесийг анхлан нэвтрүүлж түүчээлж байсан бол толгой компани болох Сингапур улсад бүртгэлтэй "АНД Глобал" ПиТиИ ЭлТиДи компани нь 2020 оны 11 сард Япон улсын тэргүүлэгч компани болох "Марубени" корпорацтай стратегийн хамтын ажиллагаа эхлүүлэн 10 сая ам.долларын хөрөнгө оруулалт авахаар болсон нь мөн л түүхэн үйл явдал байлаа.

Зээл олгодог байгууллагын хувьд харилцагчаа танин мэдэх технологи байгаа эсэх, нэг хэрэглэгчдэд олгосон зээлийн дүн өндөр эсэх, зээлийн төвлөрөл өндөр эсэх, эх үүсвэрээ татах чадвар зэрэг үзүүлэлт нь чухал үзүүлэлт байдаг.

Харин ЛэндМН ББСБ ХК нь зах зээлийн түүчээлэгчийн хувьд харилцагчийн үзүүлэлт тогтворжиж, хэрэглэгч бүрийн төлбөрийн чадварт тохирсон зээлийн үнэлгээг тооцоолох чадвар нэмэгдсэн, эрсдэлээ удирдах чадвар нэмэгдсэн зэрэг нь 2020 оны цар тахлыг давж гарсан үзүүлэлтээс харагдаж байна. Андеррайтерийн зүгээс цар тахлын хүнд үеийг оновчтой даван гарсан үзүүлэлтийг дараах хүчин зүйлстэй холбоотой болов уу хэмээн үзэж байна.

- эх үүсвэрийн оновчтой удирдлага
- болзошгүй эрсдэлийн удирдлага
- технологийн давуу тал дээр түшиглэн чанартай хэрэглэгчдээ авч үлдэх боломж
- 1 харилцагчид олгосон зээлийн дүн бага
- байгууллагын хэрэглэгчдэд зээл олголт төвлөрөөгүй тул зээлийн эдийн засагч, зээл олгогчоос хамааралтай буюу зээл олголтонд хүний хүчин зүйл бага байсан

**Андеррайтер нь "Нээлттэй бонд"-ыг олон нийтэд санал болгох үр ашгийг дараах байдлаар дүгнэж байна.**

1. Олон нийтэд хуримтлалаа төрөлжүүлэн удирдах боломжийг олгох.
2. Олон нийтийн бондын хөрөнгө оруулалтын тухай мэдлэгийг нэмэгдүүлэх.
3. Бондын хөрвөх чадварыг нэмэгдүүлснээр хөрөнгө оруулагчдад өгөөжийн зөрөөний ашиг хүртэх боломж олгох.

2021/05/24

СЭХ
2021 .06. 23
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18
БҮРТГЭВ-03

4. Нээлттэй арилжаалагдах өрийн бичгийн хүүгийн орлогод ногдох татвар 5 хувь байдаг тул хөрөнгө оруулагчдын хүртэх өгөөж нэмэгдэх.

5. Байгууллагуудад репо арилжаа хийх замаар хөрөнгөө өгөөжтэй удирдах боломж олгох

6. Нээлттэй бонд гаргах сонирхолтой компаниудыг нэмэгдүүлэн, эх үүсвэрийн удирдлагыг хөрөнгийн зах зээл рүү чиглүүлэх.

7. Бондыг олон нийтэд санал болгох үйл ажиллагаанд Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК болон Райнос Инвестмент ҮЦК ХХК хамтран ажилласнаар хөрөнгө оруулагчдын бүтцийг олон талт болгох боломжтой.

8. Үнэт цаас гаргагчийн толгой компани болох "АНД Глобал" ПиТиИ ЭлТиДи компани баталгаа гаргаж байгаа нь эргэн төлөгдөх чадварыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагчдын эрсдэлийг бууруулах.

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2021.06.23

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

## 4.2.АУДИТЫН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА, ДҮГНЭЛТ

| Аудитын байгууллагын нэр | "Эрнст энд Янг Монголия Аудит" ХХК |
|---|---|
| **Үйл ажиллагааны чиглэл** | Аудитын үйлчилгээ |
| **Хаяг** | Монгол улс, Улаанбаатар хот 14251, Сөүлийн гудамж, Найман Зовхис төв 200 тоот |
| **Утас** | +976-11-314032 |
| **Факс** | +976-11-312042 |
| **Веб хуудас** | www.ey.com |

Эрнст энд Янг Монголия Аудит ХХК нь Монгол Улсад 1999 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд баталгаажуулалт, татвар болон зөвлөхийн үйлчилгээ гэх зэрэг төрөл бүрийн мэргэжлийн үйлчилгээг үзүүлдэг компани юм. Эрнст энд Янг нь 1999 оноос хойш Монгол улсын Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа анхлан Монгол Банканд аудитын үйлчилгээг үзүүлж байсан ба либералчлал болон даяаршилтай нүүр тулгарч буй орон нутгийн аж ахуй нэгжүүдэд санхүүгийн тайлагнал болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартуудыг танилцуулж байсан. Эрнст энд Янг Монголия Аудит ХХК нь Монгол Улсад анх удаа СТОУС-ын сургалт зохион байгуулсан ба олон Монгол компаниудад шилжилт хийхэд хамтарч ажилласан. Эрнст энд Янг нь 2001 онд Эрнст энд Янг Монголия Аудит ХХК-ийг ("ЭЯ Монгол") байгуулсан ба Монголд анхдагч аудитын тусгай зөвшөөрөлтэй олон улсын компани юм.

Одоогийн байдлаар Эрнст энд Янг Монголия Аудит ХХК нь 95 гаруй ажилтантай ба үүнээс 75 нь аудитын мэргэшсэн ажилчид ба 20 нь татварын мэргэшсэн ажилчид байна. Тэд дотооддоо өөрсдийн мэргэжлийн нөөцийг бий болгосон төдийгүй Эрнст энд Янг-ийн олон улс дах салбарууд болох Хонг Конг болон Филиппин улсуудаас бусад чиглэлээр мэргэшсэн ажилчдыг авч ажиллуулдаг.

**Аудитын үйлчилгээний гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг**

Энэхүү гэрээний зорилго нь Монгол улсын "Иргэний хууль", "Нягтлан бодох бүртгэл", " Аудитын тухай" хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм , журам, заавар, олон улсын хэмжээнд дагаж мөрддөг санхүүгийн тайлагналын болон аудитын стандарт ("СТОУС")-ын дагуу үнэт цаас гаргагчийн 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланд аудит хийж, тайлан дүгнэлт гаргахад оршино.

- Аудит нь Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргахдаа холбогдох хууль, дүрэм, журам, олон улсын стандарт, компанийн дотоод стандарт, бодлого журам, горим, аргачлалыг үндэслэн санхүүгийн тайланд тусгагдсан гол үзүүлэлтүүдийг нотлох баримтыг шалгаж, удирдлагын ашигласан бүртгэлийн бодлого, зарчим болон гол чухал тооцооллуудыг үнэлж,

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183858
9021031155 СТС2420

аудитын явцад илэрсэн дотоод хяналтын сул тал ба материаллаг болон материаллаг бус зөрчил дутагдлуудын талаар тайлан бичиж дүгнэлт гаргах үүрэгтэй.

- Аудит нь санхүүгийн тайлан нь бүхэлдээ эсвэл алдааны улмаас үүссэн аливаа нэг материаллаг буруу илэрхийлэл байхгүй эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах мөн тухайн санхүүгийн тайлан нь Компанийн санхүүгийн байдал, санхүүгийн үзүүлэлт болон мөнгөн гүйлгээг үнэн зөв, шударгаар илтгэсэн эсэх талаар СТОУС-ын дагуу дүгнэлт гаргах, алдаа дутагдал илэрсэн тохиолдолд эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэх, аудитын тайлангийн үнэн зөвийг хариуцах үүрэгтэй.
- Аудитын үйл ажиллагааны явцад олж цуглуулсан компанийн бизнесийн нууцлалтай холбоотой мэдээлэл, баримт материалыг задруулахгүй байх үүрэгтэй.
- Үнэт цаас гаргагч нь санхүүгийн үйл ажиллагаагаа нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд стандартын дагуу үнэн зөв тусгаж, холбогдох баримт материал, тайлбарыг бүрэн танилцуулах үүрэгтэй бөгөөд үүнээс үүсэх аливаа хариуцлагыг хүлээх тухай тодорхойлолтыг аудиторт гаргаж өгөх үүрэгтэй.

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

**ЛэндМН ББСБ ХК**
**(Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)**

**Нэгтгэсэн аудитлагдсан санхүүгийн тайлан**
**2020 оны 12 дугаар сарын 31**

2021/05/24

СЗХ
он сар өдөр
2021.06.23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

**АГУУЛГА**

**Ерөнхий мэдээлэл**

**Гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл**

Хараат бус аудиторын тайлан ........ 1
Нэгтгэсэн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан ........ 7
Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан ........ 8
Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 9
Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 10

**Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд**

1 Компанийн талаарх мэдээлэл ........ 12
2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо ........ 13
3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого болон тодруулгад орсон өөрчлөлтүүд ........ 23
4 Нягтлан бодох бүртгэлийн гол тооцоолууд болон үнэлэмжүүд ........ 24
5 Хүү болон түүнтэй адилтгах цэвэр орлого ба сегментийн мэдээлэл ........ 26
6 Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдал ........ 26
7 Удирдлага болон үйл ажиллагааны зардал ........ 27
8 Бусад орлого/(зардал), цэвэр дүнгээр ........ 27
9 Орлогын албан татвар ........ 27
10 Нэгж хувьцаанд ногдох ашиг ........ 30
11 Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө ........ 30
12 Харилцагчид олгосон зээл болон урьдчилгаа ........ 31
13 Санхүүгийн үүсмэл хэрэглүүр ........ 34
14 Бусад хөрөнгө ........ 34
15 Биет бус хөрөнгө ........ 35
16 Үндсэн хөрөнгө ........ 36
17 Түрээс ........ 37
18 Зээл ........ 37
19 Бусад өр төлбөр ........ 39
20 Хувьцаат капитал болон нөөц ........ 39
21 Эрсдэлийн удирдлагын толилуулга ........ 40
22 Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага ........ 47
23 Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хэмжилт ........ 47
24 Холбоотой талуудын ажил гүйлгээ ........ 49
25 Тайлагналын өдрийн дараах үйл явдал ........ 50
26 Монгол хэл дээрх орчуулга ........ 50

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
БИЭЙЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855

СЭХ
он сар өдөр
2021.06.23
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

**ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

| | |
|---|---|
| Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга: | Ц. Одмаа |
| Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд: | Н. Цэвэгмид<br>В. Баярсайхан<br>О. Болдбаатар<br>Б. Дэлгэржаргал<br>С. Энх-Амгалан |
| Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд: | С. Боргил<br>Ж. Жаргалсүрэн<br>Б. Өлзийбаяр |
| Албан ёсны хаяг: | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо, Жуулчны гудамж 34, Сувд Төв |
| Харилцагч банкууд: | Хаан Банк ХХК<br>Төрийн Банк ХХК<br>Голомт Банк ХХК<br>Хас Банк ХХК<br>Худалдаа Хөгжлийн Банк ХХК<br>Кредит Банк ХХК |
| Аудитор: | Эрнст энд Янг Монголия Аудит ХХК<br>Мэргэшсэн нягтлан бодогчид |

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195

2021/05/24

СЭХ
2021.06.23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

## ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

**ЛэндМН ББСБ ХК /цаашид "Компани" гэх/ мен түүний охин компани (хамтран "Групп" гэх)-ийн** Гүйцэтгэх захирал **Очирсүрэн овогтой Болдбаатар**, группийн нэгтгэсэн санхүүгийн удирдлагыг хариуцан ажилладаг ерөнхий нягтлан бодогч **Сэргэлэн овогтой Азжаргал** бид 1-ээс 50 дугаар хуудаснаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайлан нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Группийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон мен тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн үйл ажиллагааны үр **дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээг** Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Зөвлөл ("НББОУЗ")-ийн гаргасан Санхүүгийн тайлагналын **олон улсын** стандарт ("СТОУС")-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн болохыг үүгээр мэдэгдэж **байна.**

**О. Болдбаатар**
Гүйцэтгэх захирал

**С. Азжаргал**
Ерөнхий **нягтлан бодогч**

**Огноо: 2021 оны 2 дугаар сарын 5**

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ЭКЗИТ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

2021/05/24

СЗХ
2021.06.23

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

EY
Building a better working world

Ernst & Young Mongolia Audit LLC
Suite 200, 8 Zovkhis Building
Seoul Street 21
Ulaanbaatar 14251
Mongolia

Tel: +976 11 314032 / +976 11 312005
Fax: +976 11 312042
ey.com

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

**ЛэндМН ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд**

---

**Дүгнэлт**

Бид ЛэндМН ББСБ ХК ("Компани") мөн түүний охин компани (хамтдаа "Групп")-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон нэгтгэсэн санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Группийн нэгтгэсэн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн нэгтгэсэн үйл ажиллагааны үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын зөвлөл ("НББОУЗ")-ийн гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд ("СТОУС")-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт ("АОУС")-уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн *"Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага"* хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан *"Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"*-ийн дагуу Группээс хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

**Аудитын гол асуудлууд**

Аудитын гол асуудлууд гэдэг нь тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн ач холбогдолтой байсан гэж аудиторын мэргэжлийн үнэлэмжээр үзсэн асуудлууд юм. Эдгээр асуудлуудыг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь анхаарч, аудиторын дүгнэлт өгөхдөө авч үзсэн бөгөөд бид уг асуудлуудын талаар тусдаа дүгнэлт гаргадаггүй болно. Аудитын гол асуудал нэг бүрийг бид хэрхэн авч үзсэн талаарх тайлбарыг доор өгөв.

*Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* хэсэгт дурдсан үүрэг хариуцлагууд болон эдгээр асуудлуудтай холбоотой үүрэг хариуцлагыг бид бүрэн биелүүлсэн. Үүний дагуу бид нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын материаллаг буруу илэрхийллэгдэх эрсдэлийн үнэлгээнд тохирсон аудитын горимуудыг гүйцэтгэсэн. Дор дурдсан асуудлыг анхаарч үзэхдээ гүйцэтгэсэн горимуудыг багтаасан аудитын горимуудын үр дүн нь энд хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад өгсөн бидний аудитын дүгнэлтийн үндэслэл болно.

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
2021.06.23

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

EY
Building a better working world

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)**

**ЛэндМН ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд**

**Аудитын гол асуудлууд (үргэлжлэл)**

| Аудитын гол асуудал | Аудитын гол асуудлыг хэрхэн анхаарч ажилласан тухай |
|---|---|
| ***Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралт*** | |
| Группийн удирдлага нь харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтыг үнэлэмж болон өндөр түвшний хийсвэр төсөөлөл ашиглан тооцоолдог.<br><br>Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Группийн нийт хөрөнгөд 62 хувь эзэлж байгаа бөгөөд холбогдох тооцооллын тодорхойгүй байдлаас үүдэн харилцагчдад олгосон эдгээр зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтыг бид аудитын гол асуудал гэж үзсэн.<br><br>Үнэ цэнийн бууралтын аргачлал нь ирээдүйн Зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал ("ЗҮЦХА")-ын загварт суурилсан. Энэхүү загвар нь томоохон тооцоолол болон төсөөллүүдийг шаарддаг. Үүнд:<br><br>• Санхүүгийн хөрөнгийн шатлал;<br>• Зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын (ЗҮЦХА) загвар боловсруулах, Чанаргүйдлийн магадал ("ЧМ") болон Алдагдалд хүргэх чанаргүйдэл ("АХЧ") зэрэг өгөгдлүүдийг сонгох;<br>• Олгохоор батлагдсан зээлээс зээлд хөрвөх магадлалыг оруулан Чанаргүйдэлд ертөх дүн ("ЧӨД")-г тодорхойлох;<br>• Макро эдийн засгийн төсөөллүүд, эдийн засгийн өгөгдлүүд болон ЗҮЦХА-ын тооцоололд орох өгөгдлүүдийн нөлөөлөл хоорондын хамаарлыг тодорхойлох;<br>• ЗҮЦХА-ын загварын өгөгдлүүдийг тодорхойлох ирээдүйн макро эдийн засгийн төсөөллүүд, тэдгээрийн магадлаар жигнэсэн дүнг сонгох;<br>• Ковид-19 цар тахлаас үүдэн гарах нөлөөллийг оруулан ЗҮЦХА-ын загварыг дахин үнэлэх. | 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөрх харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдлын санг үнэлэх бидний аудитын горимд харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтыг ЗҮЦХА-ын загвараар тооцоолоход Группийн ашигласан аргачлал, өгөгдөл болон төсөөллүүдийг үнэлэх ажил багтсан.<br><br>Бид энэхүү аргачлалыг үнэлэхэд, Группийн ЗҮЦХА-ын загвар болон удирдлагын ашигласан аргачлал болон төсөөллүүдийн үндэслэлийн талаарх ойлголтуудыг олж авсан. Бид загварын зохистой эсэхийг үнэлэхэд дотоод мэргэжилтнээс туслалцаа авсан ба салбарын практиктай харьцуулж үзсэн. Мөн бид ашигласан төсөөллүүдийн зохистой эсэхийг үнэлсэн. Үүнд: Чанаргүйдэлд ертөх дүнг 3-н шатлалд ангилах болсон үндэслэл, ЧМ, АХЧ, ЧӨД-ийн тодорхойлолт болон загварт ашигласан ирээдүйн макро эдийн засгийн хувьсагчдыг зөв зохистой тодорхойлсон эсэхийг тус тус үнэлсэн.<br><br>Шатлалын ангилал зохистой эсэхийг шалгахдаа бид насжилтын тайлангийн юк бүрэн эсэхийг насжилтын тайланд тусгасан дүнг санхүүгийн бүртгэл дээрх дүнтэй тулгах замаар шалгасан. Мөн бид насжилтын мэдээллийн үнэн зөв байдлыг санамсаргүй түүвэр зарчмаар сонгож мэдээллийг анхан шатны баримттай тулгах замаар шалгасан.<br><br>Бид ЗҮЦХА-ын загварт ашигласан гол өгөгдлүүдийг Группийн дотоод түүхэн мэдээлэл, тухайн салбар, санхүү болон эдийн засгийн гадны мэдээллүүдтэй харьцуулсан. Бидний шалгалтад дараах ажлууд багтсан:<br><br>• Түүхэн ЧМ, АХЧ-ийг тодорхойлох тооцоололд ашигласан дотоод өгөгдлүүдийг үнэн зөв эсэхийг санамсаргүй түүвэр зарчмаар сонгож шалгасан; |

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183865
9021031195 СТС2420

2021/05/24

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)**

**ЛэндМН ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд**

**Аудитын гол асуудлууд (үргэлжлэл)**

| Аудитын гол асуудлууд | Аудитын гол асуудлыг хэрхэн анхаарч ажилласан тухай |
|---|---|
| ***Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралт*** | |
| Холбогдох нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо, нягтлан бодох бүртгэлийн гол тооцооллууд болон үнэлэмжүүдийг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Тодруулга 2 болон 4-т тус тус толилуулсан.<br><br>Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа мөн түүнтэй холбогдох зээлийн эрсдэлийн удирдлагын тодруулгуудыг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Тодруулга 6, 12 болон 21.3-т тус тус толилуулсан. | • Олон хувилбарт шинжилгээнд ашигласан сар бүрийн америк долларын монгол төгрөгтэй харьцах дундаж ханшийн мэдээлэл болон бусад хэмжүүрүүдийг гадаад эх сурвалжийн мэдээллүүдтэй тулгасан;<br>• ЧӨД-ийн ЖК бүрэн эсэх болон олгохоор батлагдсан зээлээс зээлд хэрвээ магадлалын үнэн зөв байдлыг түүхэн мэдээлэлтэй тулгасан.<br>• Удирдлагын Ковид-19 цар тахлын нөлөөллөөс үүдэн ЗҮЦХА-г дахин үнэлэхэд ашигласан тооцооллын талаар ойлголтыг олж авсан ба тооцооллын үнэн зөв байдлыг шалгасан. Бид мөн загварын зохистой эсэхийг үнэлэхэд дотоодын мэргэжилтний туслалцаа авсан ба салбарын практиктай харьцуулж үзсэн. Үүнд:<br>  - Групп сегментчлэл хийх шаардлагатай эсэхийг үнэлсэн.<br>  - Удирдлагын макро эдийн засгийн хувилбаруудын хувааринлалтыг дахин үнэлэхэд ашигласан чанарын хүчин зүйлүүдийн зохистой эсэхийг шалгасан.<br><br>Бид ЗҮЦХА-ын загварын гол өгөгдлүүдэд хэрэглэсэн үнэлэмжийн түүштай байдлыг авч үзсэн.<br><br>Бид нэгтгэсэн санхүүгийн тайланд холбогдох тодруулгуудыг хангалттай, зохистой толилуулсан эсэхийг мөн үнэлсэн. |

A member firm of Ernst & Young Global Limited

3

2021/05/24

СЗХ
2021.06.23
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭЭ-03

EY
Building a better working world

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)**

**ЛэндМН ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд**

---

**Жилийн тайланд тусгагдсан бусад мэдээлэл**

Захирлууд болон Гүйцэтгэх удирдлагууд бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт аудитын тайлан гарсан өдрөөс хойш гарахаар хүлээгдэж буй жилийн тайланд тусгагдах нэгтгэсэн санхүүгийн тайлангууд болон тэдгээрт хамаарах аудиторын тайлангаас бусад мэдээлэл ("Бусад хэсэг") багтана.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй бөгөөд тэдгээрт аливаа хэлбэрийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын аудиттай холбоотой бидний хүлээх хариуцлага нь бусад мэдээллийг унших, тэдгээр нь нэгтгэсэн санхүүгийн тайлангууд эсвэл аудитын явцад бидний олж авсан мэдээллээс материаллаг байдлаар зөрүүтэй эсвэл алдаатай эсэхийг харгалзаж үзэх явдал юм.

Жилийн тайлангийн "Бусад хэсэг"-ийг унших үед тэнд материаллаг буруу илэрхийлэл байна гэж дүгнэвэл уг асуудлын талаар бид засаглал хариуцсан этгээдэд мэдэгдэх шаардлагатай байдаг.

**Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага**

Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг дүнг буруу илэрхийлэлгүй нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Группийн удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Группийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Группийн үйл ажиллагаагаар тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд нь Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

**Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага**

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206



2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031196 СТС2474

СЗХ
2021.06.23

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

EY
Building a better working world

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)**

**ЛэндМН ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд**

---

**Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (үргэлжлэл)**

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох нэгтгэсэн санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Группийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Группийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Группийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд дүгнэлт гаргахын тулд Группийн санхүүгийн мэдээлэл болон бизнесийн үйл ажиллагаатай холбоотой хангалттай, зохистой аудитын нотолгоо олж авах. Бид Группийн аудитыг чиглүүлэх, хянах, гүйцэтгэх үүрэг хүлээнэ. Бид өөрсдийн аудитын дүгнэлтэд дангаараа хариуцлага хүлээнэ.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдэд мэдэгддэг.

Бид түүнчлэн засаглал хариуцсан этгээдэд хараат бус байдлын талаарх холбогдох ёс зүйн шаардлагуудыг хангасан тухай мэдэгдлийг гаргаж өгдөг ба бидний хараат бус байдалд үндэстэйгээр нөлөөлсөн байж болзошгүй харилцаа болон бусад асуудлууд байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд энэ талаар мэдэгддэг.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
5039754

A member firm of Ernst & Young Global Limited

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

EY
Building a better working world

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)**

**ЛэндМН ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд**

---

**Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (үргэлжлэл)**

Засаглал хариуцсан этгээдэд мэдэгдсэн асуудлуудаас тайлант хугацааны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн ач холбогдолтой гэж үзсэн асуудлуудыг бид аудитын гол асуудлууд гэж тодорхойлдог. Уг асуудлын талаар нийтэд мэдээллэхийг хууль журмын дагуу хориглосон эсвэл маш ховор тохиолдолд энэ тухай мэдээллэснээс үүсэх үр дагавар нь олон нийтийн ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай гэж үзсэнээс бусад үед аудитын гол асуудлыг бид аудиторын тайланд толилуулдаг.

**Бусад**

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Группийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Группийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд аливаа гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

*Ernst & Young Mongolia Audit LLC*

**Эрнст энд Янг Монголия Аудит ХХК**
Мэргэшсэн нягтлан бодогчид

Гарын үсэг зурсан:

**Доржбатын Мандахбаяр**
**Захирал**

Батлагсан:

**Адриан Чу**
**Партнер**

**Улаанбаатар хот, Монгол Улс**
**Огноо: 2021 оны 2 дугаар сарын 5**

2021/05/24

СЗХ
2021 .06. 23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18
БҮРТГЭВ-03

*ЛэндМН ББСБ ХХ болон охин компани*
*2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн*
*Нэгтгэсэн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан*

| | Тодруулга | 2020 мян.төг | 2019 мян.төг |
|---|---|---|---|
| Хүү болон түүнтэй адилтгах орлого | 5 | 16,377,802 | 18,321,082 |
| Хүүгийн зардал | 5 | (4,723,510) | (4,654,241) |
| **Цэвэр хүү болон түүнтэй адилтгах орлого** | | 11,654,292 | 13,666,841 |
| Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал | 6 | (2,360,681) | (1,618,802) |
| **Үнэ цэнийн бууралтын зардлын дараах цэвэр хүү болон түүтэй адилтгах орлого** | | **9,293,611** | **12,048,039** |
| Удирдлага болон үйл ажиллагааны зардал | 7 | (5,738,460) | (5,565,125) |
| Бусад орлого/(зардал), цэвэр | 8 | (799,670) | (451,539) |
| **Татварын өмнөх ашиг** | | 2,755,481 | 6,031,375 |
| Орлогын албан татварын зардал | 9 | (323,288) | (1,121,186) |
| **Тайлант жилийн цэвэр ашиг буюу толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох нийт дэлгэрэнгүй орлого** | | **2,432,193** | **4,910,189** |
| **Нэгж хувьцаанд ногдох ашиг** | | төг | төг |
| Толгой компанийн хувьцаа эзэмшигчид | | | |
| Нэгж хувьцаанд ногдох үндсэн болон шингэрсэн ашиг | 10 | 3.06 | 6.16 |

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24



УЛААНБААТАР ХОТ
ЭЙЧ ЭЛ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031155 СТС2418

СЗХ
он сар өдөр
2021.06.23
ХҮЛЭЭН АВАВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

*ЛэндМН ББСБ ХК болон охин компани*
*2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх*
*Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан*

| | Тодруулга | 2020.12.31 мян.төг | 2019.12.31 мян.төг |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | | | |
| Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө | 11 | 10,348,101 | 2,382,196 |
| Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа | 12 | 25,430,960 | 49,457,676 |
| Санхүүгийн үүсмэл хэрэглүүр | 13 | - | 130,642 |
| Бусад хөрөнгө | 14 | 3,274,193 | 4,571,315 |
| Урьдчилж төлсөн төлбөр | | 5,650 | - |
| Орлогын албан татварын авлага | 9.2 | 92,699 | - |
| | | 39,151,603 | 56,541,829 |
| **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ** | | | |
| Биет бус хөрөнгө | 15 | 403,145 | 342,002 |
| Үндсэн хөрөнгө | 16 | 537,256 | 385,882 |
| Ашиглах эрхтэй хөрөнгө | 17 | 573,727 | 776,219 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 9.3 | 54,152 | 48,186 |
| Урьдчилж төлсөн төлбөр | | 15,577 | 6,835 |
| | | 1,583,857 | 1,559,124 |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | | 40,735,460 | 58,100,953 |
| **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | | |
| Зээл | 18 | 19,424,810 | 32,475,285 |
| Түрээсийн өр төлбөр | 17 | 203,766 | 170,427 |
| Бусад өр төлбөр | 19 | 1,082,163 | 1,297,090 |
| Санхүүгийн үүсмэл хэрэглүүр | 13 | 124,549 | - |
| Орлогын албан татварын өглөг | 9.2 | 18,913 | 151,395 |
| | | 20,854,201 | 34,094,197 |
| **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | | |
| Зээл | 18 | 1,690,790 | 6,104,737 |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | 9.3 | - | 23,124 |
| Түрээсийн өр төлбөр | 17 | 476,651 | 680,417 |
| | | 2,167,441 | 6,808,278 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | 23,021,642 | 40,902,475 |
| **ЭЗДИЙН ӨМЧ** | | | |
| Хувьцаат капитал | 20.1 | 10,756,859 | 10,756,859 |
| Халаасны хувьцаа | 20.2 | (988,939) | (266,086) |
| Бусад нөөц | 20.3 | 57,348 | 57,348 |
| Хуримтлагдсан ашиг | | 7,888,550 | 6,650,357 |
| **НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ** | | 17,713,818 | 17,198,478 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БОЛОН ЭЗДИЙН ӨМЧ** | | 40,735,460 | 58,100,953 |

Хавсралтын тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

8

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК
5183855
9021031155 СТС2420

СЭХ
он сар өдөр
2021.06.23 В
№01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

***ЛэндМН ББСБ ХК болон охин компани***
***2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн***
***Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан***

| | Хувьцаат капитал мян.төг (Тод.20.1) | Халаасны хувьцаа мян.төг (Тод.20.2) | Бусад нөөц мян.төг (Тод.20.3) | Хуримт-лагдсан ашиг мян.төг | Нийт эздийн өмч мян.төг |
|---|---|---|---|---|---|
| **2019.01.01-ний өдрийн байдлаар** | **10,756,859** | **-** | **57,348** | **2,540,168** | **13,354,375** |
| Тайлант жилийн цэвэр ашиг болон тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого | - | - | - | 4,910,189 | 4,910,189 |
| Ногдол ашиг (Тод. 20) | - | - | - | (800,000) | (800,000) |
| Халаасны хувьцаа | - | (266,086) | - | - | (266,086) |
| **2019.12.31-ний өдрийн байдлаар** | **10,756,859** | **(266,086)** | **57,348** | **6,650,357** | **17,198,478** |
| Тайлант жилийн цэвэр ашиг болон тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого | - | - | - | 2,432,193 | 2,432,193 |
| Ногдол ашиг (Тод. 20) | - | - | - | (1,194,000) | (1,194,000) |
| Халаасны хувьцаа | - | (722,853) | - | - | (722,853) |
| **2020.12.31-ний өдрийн байдлаар** | **10,756,859** | **(988,939)** | **57,348** | **7,888,550** | **17,713,818** |

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 11... 267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
БДСЕК ЭНД КО ... КАПИТАЛ ... ХХК
5183855
9021031195 СТС2420

СЭХ
2021.06.23
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

***ЛэндМН ББСБ ХК болон охин компани***
***2020 оны 12 дугаар сарын 31-нйй өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн***
***Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан***

| | Тодруулга | 2020 мян.төг | 2019 мян.төг |
|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| Татварын өмнөх ашиг | | 2,755,481 | 6,031,375 |
| *Тохируулга:* | | | |
| Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтын зардал | 6 | 2,393,273 | 1,592,096 |
| Ашиглах эрх бүхий хөрөнгө болон үндсэн хөрөнгийн элэгдэл | 7 | 360,981 | 321,072 |
| Биет бус хөрөнгийн хорогдуулга | 7 | 53,256 | 46,332 |
| Олгогдохоор батлагдсан зээлийн үүргийн үнэ цэнийн бууралт/(буцаалт) | 6, 19 | (32,592) | 26,706 |
| Түрээсийн хөнгөлөлтийн олз | 8, 17 | (37,817) | - |
| Түрээсийн өглөгийн хуримтлагдсан хүү | 5, 17 | 139,545 | 167,108 |
| Зээлийн хүүний зардал | 5 | 4,583,965 | 4,487,133 |
| Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийн (олз)/гарз | 8, 14 | 255,191 | (130,642) |
| Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус зардал | 8 | 269,253 | 197,266 |
| **Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг** | | **10,740,536** | **12,738,445** |
| Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтүүд: | | | |
| Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны цэвэр (өсөлт)/бууралт | | 21,633,443 | (31,850,406) |
| Бусад хөрөнгийн цэвэр (өсөлт)/бууралт | | 1,443,049 | (4,315,984) |
| Урьдчилж төлсөн төлбөрийн цэвэр (өсөлт)/бууралт | | (14,392) | 41,328 |
| Бусад өр төлбөрийн цэвэр өсөлт/(бууралт) | | (58,689) | 71,593 |
| **Үйл ажиллагаанаас орсон/(-нд зарцуулсан) мөнгөн гүйлгээ** | | **33,743,947** | **(23,316,024)** |
| Орлогын албан татварын төлөлт | 9.2 | (577,559) | (1,002,543) |
| Түрээсийн өглөгийн хүүний төлөлт | | (139,545) | (167,106) |
| Хүүний төлбөр | | (4,593,064) | (4,064,203) |
| **Үйл ажиллагаанаас орсон/(-нд зарцуулсан) цэвэр мөнгөн гүйлгээ** | | **28,433,779** | **(28,548,876)** |
| **Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ** | | | |
| Үндсэн хөрөнгийн худалдан авалт | 16 | (309,863) | (250,646) |
| Биет бус хөрөнгийн худалдан авалт | 15 | (114,399) | (550) |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ** | | **(424,262)** | **(251,196)** |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| Халаасны хувьцааны худалдан авалтын төлөлт | | (722,853) | (266,066) |
| Хвалттай бонд гаргаснаас орсон мөнге | | 6,199,955 | 4,143,883 |
| Зээлийн эх үүсвэрээс орсон мөнге | | 19,099,777 | 30,050,429 |
| Итгэлцлийн үйлчилгээнээс орсон мөнге | | 2,260,908 | 14,766,321 |
| Хвалттай бондын эргэн төлөлт | | (2,413,711) | (7,028,000) |
| Зээлийн эх үүсвэрийн эргэн төлөлт | | (37,052,730) | (12,864,666) |
| Итгэлцлийн үйлчилгээний эргэн төлөлт | | (5,970,667) | (1,331,464) |
| Түрээсийн өр төлбөрийн үндсэн төлбөрийн төлөлт | | (132,610) | (127,867) |
| Төлсөн ногдол ашиг | | (1,194,000) | (660,000) |
| **Санхүүгийн үйл ажиллагаанаас орсон/(-нд зарцуулсан) цэвэр мөнгөн гүйлгээ** | | **(19,925,931)** | **26,682,650** |
| **Мөнге, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/(бууралт)** | | **8,083,586** | **(2,117,524)** |
| Мөнге, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 11 | 1,417,931 | 3,535,455 |
| **Мөнге, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 11 | **9,501,517** | **1,417,931** |

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК
ХХК

2021/05/24

СЭХ
он сар өдөр
2021.06.23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



| | | 2020 мян.төг | 2019 мян.төг |
|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ /хүү/** | | | |
| Хүлээн авсан хүү | | 15,154,634 | 17,981,554 |
| Хүүний орлого | 5 | 15,813,659 | 18,118,680 |
| | | | |
| **Мөнгөн бус гүйлгээ:** | | | |
| Урьдчилж төлсөн төлбөрөөс шилжүүлсэн үндсэн хөрөнгө | | - | 87,500 |
| Үндсэн хөрөнгийн борлуулалт | 16 | - | 91,735 |

**Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөрийн тохируулгыг доор үзүүлэв:**

| | Зээл | | Түрээсийн өр төлбөр | |
|---|---|---|---|---|
| | 2020 мян.төг | 2019 мян.төг | 2020 мян.төг | 2019 мян.төг |
| 1-р сарын 1-нээр | 38,580,022 | 10,092,417 | 850,844 | - |
| Анхдагч хүлээн зөвшөөрөлт | - | - | - | 978,711 |
| Татсан эх үүсвэр | 27,560,640 | 48,960,633 | - | - |
| Эргэн төлөлт | (45,437,108) | (21,224,130) | - | - |
| Тайлант жилийн хүүний зардал | 4,583,965 | 4,487,133 | 139,545 | 167,108 |
| Төлсөн хүү/түрээсийн төлбөр | (4,593,084) | (4,064,203) | (272,155) | (294,975) |
| Түрээсийн хөнгөлөлт | - | - | (37,817) | - |
| Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус алдагдал | 421,145 | 328,172 | - | - |
| 12-р сарын 31-нээр | 21,115,600 | 38,580,022 | 680,417 | 850,844 |

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 Д.1178267206



2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО АУДИТ ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2021.06.23 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



## 1 Компанийн талаарх мэдээлэл

ЛэндМН ББСБ ХК (цаашид "Компани" гэх) нь Монголын Хөрөнгийн Биржид (цаашид "МХБ" гэх) бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг, хувь нийлүүлсэн хувьцаат компани. Компани нь 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдөр МХБ дээр бүртгэлтэй болсноор нээлттэй хувьцаат компани болсон. Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос (цаашид "СЗХ" гэх) 2015 оны 6 дугаар сарын 24-ний өдөр олгосон 1/493 тоот банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Уг тусгай зөвшөөрлөөр Монгол улсад зээлийн үйл ажиллагаа явуулах мөн онлайн төлбөр тооцоо гүйцэтгэх эрхийг олгодог. Түүнчлэн Компани нь СЗХ-оос 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдөр олгогдсон 45 тоот дугаартай Итгэлцлийн болон Факторингийн үйлчилгээ, 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдөр олгогдсон 128 тоот дугаартай Гадаад валютын арилжаа эрхлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрлүүдийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

*Үндсэн үйл ажиллагаа.* Компани болон түүний охин компани (хамтад нь "Групп" гэх) нь зэргэлдээ охин компани болох Монгол Улсад үүсгэн байгуулагдсан Анд Системс Тех ХХК ("АНД Системс Тех") -ийн хөгжүүлэн гаргасан ЛэндМН технологийг ашиглан зээлийн үйлчилгээ огт/хангалттай хэмжээнд аюулгүй чадвартай хүмүүст гар утсанд суурилсан санхүүгийн үйлчилгээ буюу 24/7 цахим зээлийн үйлчилгээг үзүүлдэг. ЛэндМН технологи нь Анд Системс Тех-ийн хөгжүүлэн гаргасан "финтек" шийдэл бүхий технологи бөгөөд технологийн лицензийг Анд Системс Тех эзэмшдэг. 2018 онд Компани нь ЛэндМН технологиор дамжуулан төрөл бүрийн төлбөр тооцоо, санхүүгийн гүйлгээ хийх "Лэнд Хэтэвч" шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлэн үйл ажиллагааны цар хүрээгээ өргөжүүлсэн.

Компанийн эцсийн толгой компани нь Сингапур Улсад бүртгэлтэй, финтек компани болох Анд Глобал Пти.Лтд.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр заасныг бусад тохиолдолд мянганы орноор, Монгол төгрөг ("төг")-өөр тайлагнасан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн шийдвэрээр Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг баталсан.

2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр Компани нь цахим эко системийн платформ болон төлбөрийн шийдлийг ЛэндМН гар утасны аппликэйшнээр дамжуулан үйлчилгээ үзүүлэх Супер Ап Хэтэвч ХХК гэх 100% өөрийн эзэмшлийн охин компанийг байгуулсан. 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдөр, Супер Ап Хэтэвч ХХК нь төлбөрийн үйлчилгээ үзүүлэхээр 6 дугаартай Имоней үйлчилгээний тусгай зөвшөөрлийг Монгол Банк-наас авсан.

2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн охин компанийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг доор үзүүлэв:

| Нэр | Бүртгэлтэй улс | Санал болгосон энгийн хувьцаа | Компанийн эзэмших хувь | Үндсэн үйл ажиллагаа |
|---|---|---|---|---|
| Супер Ап Хэтэвч ХХК | Монгол Улс | 2,500,000 мян.төг | 100% | Цахим эко системийн платформ болон төлбөрийн шийдлүүдийг санал болгох |

Компанийн албан ёсны хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо, Жуулчны гудамж 34, Сувд төв.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ЭЛБИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5162555
2021031165 СТС2420

## 2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо

***Тайлан бэлтгэх суурь ба нийцлийн мэдэгдэл.*** Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс ("НББОУСЗ") баталж гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ("СТОУС")-ын (үүнд СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт ("НББОУС") болон тэдгээрийн тайлбарууд бүгд орно) дагуу бэлтгэгдсэн. Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь бодит үнэ цэнээр бүртгэгддэг санхүүгийн үүсмэл хэрэглүүрээс бусад тохиолдолд түүхэн өртгийн зарчим дээр үндэслэн бэлтгэгдсэн. Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоог доор толилуулав. Өөреөр заагаагүй бол тус бодлогуудыг (үүнд Тодруулга 3-т толилуулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт орно) толилуулж буй бүх тайлант үеүдэд тууштай мөрдсөн болно.

**Нэгтгэлийн үндэслэл.** Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компани болон түүний охин компанийн санхүүгийн тайлангуудаас бүрдэнэ. Компани охин компанийг хянаж буй үед тайланг нэгтгэнэ. Групп нь хүлээн авагчаас хувьсах өгөөжийг хүлээн авах эрхтэй болсон ба өөрийн эрх мэдлийг ашиглан тэдгээр өгөөжид нөлөөлөх чадвартай байгаа үед хөрөнгө оруулагч нь хөрөнгө хүлээн авагч компанийг хянаж байна гэж үзнэ. Тодруулбал зөвхөн дараах тохиолдолд Групп нь хөрөнгө хүлээн авагч компанийг хянаж байна гэж үзнэ:

- Хөрөнгө хүлээн авагч компанид эрх мэдэлтэй байх (өөрөөр хэлбэл, хөрөнгө хүлээн авагч компанийн холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх өнөөгийн чадварыг олгох хүчин төгөлдөр эрхтэй байх)
- Хөрөнгө хүлээн авагч компани дахь өөрийн хувь оролцооноос хувьсах өгөөж хүртэх эрхтэй байх
- Хөрөнгө хүлээн авагч компани дахь өөрийн эрх мэдлийг ашиглан өөрт ногдох өгөөжид нөлөөлөх чадвартай байх

Ерөнхийдөө, олонхийн санал өгөх эрхтэй үед хяналттай байна гэсэн таамаглал байдаг. Группд санхүүжигчийн санал өгөх эсвэл ижил төстэй эрхийн дийлэнх хувь байхгүй үед Групп бүх холбогдох баримт, нөхцөл байдлуудыг харгалзан санхүүжигчийн хувьд эрх мэдэлтэй байгаа эсэхээ үнэлдэг. Эдгээр баримт, нөхцөл байдал гэдэг нь:

- Хөрөнгө хүлээн авагч компанийн зорилго болон загвар
- Хамааралтай үйл ажиллагаа болон эдгээр үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хэрхэн гаргадаг. Компани дээрх үйл ажиллагааг удирдан чиглүүлэх чадвартай эсэх
- Худалдан авах, зарах, дампуурүүлэх гэх мэт гэрээний зохицуулалтууд
- Компанийн хөрөнгө хүлээн авагч компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгө хүлээн авагч компани дахь өөрийн хувь оролцооноос хувьсах өгөөж хүртэх эрхтэй эсэх болон хөрөнгө хүлээн авагч компани дахь өөрийн эрх мэдлийг ашиглан өөрт ногдох өгөөжид нөлөөлөх чадвартай эсэх

Хэрэв дээрх гурван хяналтын элементээс нэг юм уу түүнээс илүүд өөрчлөлт орсон нь баримт, нөхцөл байдлаар нотлогдвол Групп нь хөрөнгө хүлээн авагч компанийг хянаж байгаа эсэхийг дахин үнэлэн үзнэ. Охин компанийг нэгтгэх үйл ажиллагаа нь Групп охин компани хяналтаа тогтоосон үед эхлэх ба хяналтаа алдах үед зогсоно. Тайлант жилийн хугацаанд худалдан авсан эсвэл борлуулсан охин компанийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг Групп охин компанид хяналтаа тогтоосон өдрөөс хяналтаа алдсан өдөр хүртэлх хугацааны нэгтгэсэн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд толилуулна.

Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын бүрэлдэхүүн хэсэг нэг бүрийг Группийн хувьцаа эзэмшигчид болон хяналтын бус бүлэгт (хяналтын бус хувь оролцоог алдагдалтай болгоход хүргэх байсан ч хамаагүй) хувь тэнцүүлэн хуваарилна. Шаардлагатай үед Группийн нягтлан бодох бүртгэлийн бодлоготой охин компаниудын нягтлан бодох бүртгэлийн бодлогыг нийцүүлэх үүднээс тэдгээр охин компаниудын санхүүгийн тайлангуудыг залруулга хийнэ. Нэгтгэсэн тайлангуудыг гаргахдаа Группийн гишүүдийн хооронд хийсэн гүйлгээтэй холбоотой үүссэн хөрөнгө, өр төлбөр, өөрийн хөрөнгө, орлого, зардал, мөнгөн гүйлгээнүүдийг нийт дүнгээр нь устгана.

Хяналтаа алдахгүйгээр охин компанийн хувь эзэмшилд өөрчлөлт орсон тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн өөрийн хөрөнгийн аргаар бүртгэнэ. Хэрэв Групп охин компани дахь хяналтаа алдвал, холбогдох хөрөнгө (гүдвиллийг оролцуулан), өр төлбөр, хяналтын бус хувь оролцоо, эздийн өмчийн бусад хэсгийг үл хүлээн зөвшөөрөх ба үүнээс үүссэн олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Үлдсэн хөрөнгө оруулалтыг хяналтаа алдсан өдрийн бодит үнэ цэнээр нь бүртгэнэ.



2021/05/24

СЗХ
2021.06.23
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



**2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)**

**Тасралтгүй байх зарчим.** Группийн удирдлага тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадвартай эсэхийг үнэлсэн ба Групп нь ирээдүйд бизнесийн үйл ажиллагаагаа явуулахад хангалттай нөөц боломжтой гэж дүгнэсэн. Мөн түүнчлэн, удирдлага нь Группийн тасралтгүй байх зарчмыг үргэлжлүүлэх чадварт нөлөөлөх материаллаг тодорхойгүй байдал үүсээгүй гэж үзэж байна. Иймд, нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь үргэлжлүүлэн тасралтгүй байх зарчимд үндэслэн боловсруулагдаж байна.

***Санхүүгийн хэрэглүүр - Анхлан хүлээн зөвшөөрөлт.*** Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа, бусад авлагаас бусад санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүдийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө арилжаа хийсэн өдөр (Компани тухайн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон өдөр) хүлээн зөвшөөрнө. Үүнд 'хэвийн нөхцөлтэй арилжаа' буюу санхүүгийн хөрөнгө худалдан авах, худалдахад холбогдох хөрөнгийг зах зээлийн журам, хэлцлээр тогтоосон хугацаанд зайлшгүй шилжүүлэхийг шаарддаг арилжаа орно. Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа, бусад авлагыг харилцагчдын дансанд мөнгө шилжсэн үед хүлээн зөвшөөрнө.

***Санхүүгийн хэрэглүүрийн анхлан хэмжилт.*** Анхлан хүлээн зөвшөөрч буй санхүүгийн хэрэглүүрийн ангилал нь тэдгээрийн гэрээний нөхцөл болон уг санхүүгийн хэрэглүүрийг зохицуулж буй бизнес загвараас хамаардаг. Санхүүгийн хэрэглүүрийг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдалд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрөөс бусад тохиолдолд ажил гүйлгээний зардлыг бодит үнэ цэнээс хассан дүнгээр анхлан бүртгэнэ.

*Гүйлгээний зардал* гэж санхүүгийн хэрэглүүрийн худалдан авалт, гаргалт болон борлуулалт зэрэгтэй шууд холбоотой нэмэгдэл зардлуудыг хэлнэ. Нэмэгдэл зардал гэж хэрэв тухайн ажил гүйлгээ хийгдээгүй тохиолдолд гарахгүй байсан зардлыг хэлнэ. Гүйлгээний зардалд нь агент, борлуулагч агентын үүрэг гүйцэтгэж буй ажиллагсад, зөвлөх, брокер, дилерүүдэд төлсөн хураамж шимтгэл, зохицуулах агентлаг болон хөрөнгийн биржийн ногдуулсан хураамж төлбөрүүд, мөн шилжүүлэлтэд ногдуулсан татвар хураамжууд хамаарна. Гүйлгээний зардалд өрийн хямдруулалт буюу нэмэгдэл, санхүүжилтийн зардлууд, дотоод удирдлагын буюу хадгалалтын зардлууд багтахгүй.

*Бодит үнэ цэнэ* нь ажил гүйлгээг бүртгэх өдөр зах зээлд оролцогчдын хооронд байнга хийгдэх арилжаагаар хөрөнгийг худалдах эсвэл өр төлбөрийг шилжүүлэх үнэ юм. Бодит үнэ цэнийг хамгийн сайн илэрхийлэх дүн нь идэвхтэй зах зээлийн арилжааны үнэ юм. Идэвхтэй зах зээл гэдэг нь хөрөнгө болон өр төлбөрийн хэлцэлд нь үнийн мэдээллээр тогтмол хангахуйц түвшинд явагддаг зах зээлийг хэлнэ.

Идэвхтэй зах зээлд арилжаалагдаж буй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тухайн хөрөнгө болон өр төлбөрийн арилжигдаж буй үнэ болон байгууллагын эзэмшиж буй тоо хэмжээгээр үржүүлэн гаргана. Зах зээлийн өрдийн өдрийн арилжааны хэмжээ компанийн эзэмшиж байгаа хэмжээтэй харьцуулахад хангалтгүй ба нэг арилжаагаар позицийг худалдах захиалга байршуулж арилжааны үнэд нөлөөлж болзошгүй байдал үүссэн ч дээрх аргыг ашиглах боломжтой.

Зах зээлийн мэдээлэл хомс зарим санхүүгийн хэрэглүүрийн хувьд тэдгээрийн бодит үнэ цэнийг хорогдуулсан мөнгөн урсгалын аргаар эсвэл санхүүжигч талын санхүүгийн мэдээлэл зэргийг үндэслэн тооцоолно. Мөн зах зээл дээрх харилцан хамааралгүй этгээдүүдийн хооронд сүүлд хийгдсэн ажил гүйлгээний үнийг баримтална.

Бодит үнэ цэнийг дотор нь түвшингээр нь ангилан тодорхойлох ба эдгээр түвшинг дараах байдлаар тодорхойлно. Ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхтэй зах зээл дах зарласан (тохируулаагүй) үнийг ашиглан бодит үнэ цэнийг хэмжсэн бол 1-р түвшин, тухайн хөрөнгө болон өр төлбөртэй холбоотой шууд (үнэ) болон шууд бус (үнэ) боломжит өгөгдлүүдийг ашиглан үнэлгээний аргуудаар бодит үнэ цэнийг тооцоолон гаргасан бол 2-р түвшин, зах зээл дээрх бэлэн өгөгдлүүд дээр бус зах зээл дээр мэдэгдэхгүй байгаа өгөгдлүүдийг илүү тусгаарлан бодит үнэ цэнийг хэмжсэн бол 3-р түвшний бодит үнэ цэнэ гэж тус тус ангилна.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮДК ХХК

СЗХ
2021.06.23
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



**2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)**

***Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн хэмжилт.*** Групп санхүүгийн хөрөнгүүдээ тэдгээрийг зохицуулж буй хөрөнгө удирдлагын бизнес загвар болон гэрээний нөхцлөөс хамааруулан доорх ангиллын аль нэгээр ангилдаг:

- Хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх,
- Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх, эсвэл
- Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэгдэх.

***Санхүүгийн хэрэглүүр – Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа.*** Групп харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааг зөвхөн дараах нөхцлүүд биелсэн тохиолдолд хорогдуулсан өртгөөр хэмждэг:

- Санхүүгийн хөрөнгө нь гэрээний дагуух мөнгөн урсгалыг нь цуглуулахын тулд эзэмших зорилготой бизнесийн загварт багтдаг,
- Санхүүгийн хөрөнгө нь тодорхой өдрүүдэд зөвхөн үндсэн болон үндсэн төлбөрийн үлдэгдэл дүнгээс бодсон хүүгээс бүрдсэн мөнгөн урсгалыг өгдөг гэрээний нөхцөлтэй.

Групп бизнесийн зорилгодоо хүрэхийн тулд санхүүгийн хөрөнгийн багцыг хэрхэн удирдахаас хамаарч бизнес загвараа тодорхойлдог. Группийн бизнесийн загварыг хэрэглүүр тус бүрээр тодорхойлдоггүй бөгөөд харин нэгтгэсэн багцаар нь тодорхойлдог.

Ангиллын үйл явцын 2 дугаар алхамын дагуу Компани санхүүгийн хөрөнгүүдийн гэрээний нөхцөлийг тэдгээр нь үндсэн төлбөр болон хүүний төлбөр төлөх шалгуурыг хангаж байгаа эсэхийг тодорхойлохын тулд үнэлдэг. Энэхүү үнэлгээний зорчмын хүрээнд, анхдагч хүлээн зөвшөөрөлтөөр санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийг "Үндсэн төлбөр" гэж үзэх бөгөөд санхүүгийн хөрөнгийн хугацааны турш өөрчлөгдөх болно. (Жишээ нь: Хэрэв үндсэн төлбөрийн эргэн төлөлт эсвэл урамшуулал/хөнгөлөлтийн хорогдуулга байгаа бол). Зээлийн авлагын хамгийн чухал элементүүд нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон зээлийн эрсдэлийг харгалзан үзэж байгаа явдал юм.

*Хорогдуулсан өртөг* нь санхүүгийн хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс үндсэн дүнгийн аливаа эргэн төлөлтийг хасч, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралттай холбоотой аливаа хасагдуулгыг хийсэн дүн юм. Хуримтлагдсан хүүнд анх хүлээн зөвшөөрөх үед хойшлуулсан гүйлгээний зардлын хорогдуулга болон үр ашигт хүүний аргаар тооцсон хөнгөлөлт, урамшууллын хорогдуулга ордог. Хуримтлагдсан хүүний орлого, хуримтлагдсан хүүний зардал, мөн хуримтлуулсан купон, хорогдуулсан урамшуулал, хөнгөлөлтийг (мөн аливаа хойшлогдсон шимтгэлийн хамт) тусад нь толилуулдаггүй бөгөөд тэдгээрийг санхүүгийн байдлын тайлангийн холбогдох зүйлийн дансны үнэд оруулан тайлагнадаг.

*Олгохоор батлагдсан зээлийн үүрэг* нь Групп урьдчилан тодорхойлсон нөхцлийн дагуу харилцагчдад зээл олгох үүрэг юм.

***Санхүүгийн өр төлбөр – Гаргасан өрийн бичиг болон бусад зээлийн санхүүжилт.*** Гаргасан өрийн бичиг болон бусад зээлийн санхүүжилт нь гадаад дотоодын санхүүгийн байгууллагуудын өмнө гэрээгээр хүлээсэн үүрэг юм.

Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, гаргасан өрийн бичиг болон бусад зээлийн санхүүжилтыг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг тооцохдоо зээл авах үеийн хөнгөлөлт, урамшуулал ба үр ашигт хүүний салшгүй хэсэг болж буй зардлуудыг авч үзнэ.

Группийн гаргасан өрийн бичиг болон бусад зээлийн санхүүжилтийн шинжилгээг Тодруулга 18-д толилуулсан.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО
ХХК

СЗХ
2021.06.23
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



**2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)**

***Санхүүгийн хэрэглүүр – ангилал болон анхдагч хэмжилт (үргэлжлэл)***

***Санхүүгийн үүсмэл хэрэгслийн өнөөгийн үнэ цэнийн ашиг, алдагдал.*** Санхүүгийн үүсмэл хэрэгсэл гэдэг нь доор дурдсан 3-н шинж чанарыг агуулсан санхүүгийн хэрэгсэл буюу гэрээг хэлнэ:

- Бусад хувьсагчдаас шалтгаалан үнэ цэнэ нь өөрчлөгддөг буюу хүү, санхүүгийн хэрэгслийн үнэ, бараа бүтээгдэхүүний үнэ, гадаад валютын ханш, хүү эсвэл үнийн индекс, зээлийн түвшин зэргээс хамаардаг, үүнд санхүүгийн бус хувьсагч бол тухайн хувьсагч нь гэрээнд оролцогч талуудад тусгайлан хамааралтгүй болно.
- Анхны цэвэр хөрөнгө оруулалт шаардлагатгүй эсвэл бусад төрлийн гэрээнээс анхны цэвэр хөрөнгө оруулалт багатай байж болдог.
- Ирээдүйд төлөгдөх нөхцөлтэй.

Групп нь бусад санхүүгийн байгууллагатай валютын своп гэх мэт санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцлийг хийдэг. Санхүүгийн үүсмэл хэрэгслийг өнөөгийн үнэ цэнээр хэмжих ба өнөөгийн үнэ цэнэ нь эерэг бол хөрөнгөөр, сөрөг бол өр төлбөрөөр бүртгэнэ. Санхүүгийн үүсмэл хэрэгслийн өнөөгийн үнэ цэнийн өөрчлөлт буюу ашиг эсвэл алдагдлыг санхүүгийн үүсмэл хэрэгслийн ашиг/(алдагдал)-аар бүртгэнэ.

***Санхүүгийн хөрөнгийг данснаас хасах.*** Санхүүгийн хөрөнгийг (эсвэл санхүүгийн хөрөнгийн хэсгийг эсхүл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгийн хэсгийг) тухайн хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон тохиолдолд бүртгэлээс хасдаг.

***Санхүүгийн өр төлбөрийг данснаас хасах.*** Санхүүгийн өр төлбөрийн төлөх үүргийн хугацаа дууссан, санхүүгийн өр төлбөр төлөх үүргээс чөлөөлөгдсөн эсвал уг үүрэг нь цуцлагдсан үед санхүүгийн өр төлбөрийг данснаас хасна. Санхүүгийн өр төлбөрийн хугацаа дуусаагүй үед тухайн өр төлбөрийн нөхцөл ихээхэн өөрчлөгдсөн, эсвэл зээлдүүлэгчээс хуучин өр төлбөрийн оронд өөр нөхцөлтэй шинэ өр төлбөр хүлээж авсан тохиолдолд өмнөх өр төлбөрийг данснаас хасч, шинэ өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх бөгөөд шинэ болон хуучин өр төлбөрийн дансны үнийн зөрүүг ашиг алдагдлын тайланд бүртгэнэ.

***Үр ашигт хүүний арга.*** СТОУС 9-ийн дагуу хорогдуулсан өртгөөр хэмжигддэг бүхий л санхүүгийн хэрэглүүрийн хүүний орлогыг үр ашигт хүүний түвшний ("ҮАХТ") аргаар бүртгэдэг. ҮАХТ нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн орлого, гарах зарлагыг санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны эсвэл шаардлагатай бол түүнээс богино хугацааны туршид дискаунтлаж, санхүүгийн хэрэглүүрийн бүртгэлийн цэвэр дүнг гаргаж авах хүүний хувь юм. ҮАХТ-ийг (хөрөнгийн хорогдуулсан өртөг) худалдан авалтын хөнгөлөлт эсвэл урамшууллыг харгалзан тооцдог бөгөөд шимтгэл, зардлууд нь ҮАХТ-ний салшгүй нэг хэсэг юм. Групп зээлийн хүлээгдэж буй хугацааны турш тогтмол өгөөж хүртэнэ гэсэн хамгийн сайн тооцооллыг илэрхийлэх өгөөжийн хувиар хүүний орлогоо хүлээн зөвшөөрдөг. Хүүний зардал нь хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн бүх санхүүгийн өр төлбөрийг ҮАХТ аргаар тооцоолно. ҮАХТ нь ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгалын орлогыг санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хүлээгдэж буй ашиглалтын хугацаагаар бууруулж тооцсон хүү юм. ҮАХТ-ний аргад санхүүгийн хөрөнгийг худалдан авсаны төлбөр, хураамж, зардал зэргийг оруулж тооцох шаардлагатай.

***Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт.*** Групп бүх зээл, бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдалд бүртгэгдэхээс бусад санхүүгийн хөрөнгө болон зээлийн үүрэгт үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын сан бүртгэж байна.

***Зээлийн чанаргүйдэл.*** Зээлдэгч гэрээний төлөлтийн хуваарийн дагуу хийгдэх төлбөрийг 90 хоногоос дээш хугацаа хэтрүүлсэн тохиолдолд Групп тус санхүүгийн хэрэглүүрийг чанаргүйдэлд орсон гэж үзэн ЗҮЦХА-ын тооцооллын Шатлал 3 гэж ангилна. Групп нь гэрээнд тусгагдсан ажлын өдөрт тухайн гүйлгээ багтаж хийгдээгүй тохиолдолд банкны баланс болон бусад авлагыг чанаргүйдэлд орсон гэж тооцон шуурхай арга хэмжээ авна.

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24



УЛААНБААТАР ХОТ
ЭРНСТ ЭНД ЯНГ
КАПИТАЛ УДИК
ХХК
5183835
9071031193 СТС2420

СЭХ
2021.06.23 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



## 2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)

*ЗҮЦХА-ын загварын ерөнхий тойм.* ЗҮЦХА санг хөрөнгийн нийт ашиглах хугацаанд суурилан (зээлийн үнэ цэнийн ашиглах нийт хугацааны туршид хүлээгдэж буй алдагдал буюу ЗҮЦАНХХА) байгуулах ба хэрэв тухайн хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрснөөс хойш түүний зээлийн эрсдэлд нэлээ бүхий өсөлт ажиглагдахгүй бол 12 сарын хугацаанд хүлээгдэж буй алдагдлын санг ("ЗҮЦ12сХА") байгуулна. ЗҮЦ12сХА нь ЗҮЦНХХА-ын нэг хэсэг бөгөөд энэ нь тайлангийн өдрөөс хойш 12 сарын хугацаанд үүсч болзошгүй санхүүгийн хэрэглүүрийн чанаргүйжих үйл явдлын үр дүнд үүсэх хүлээгдэж буй алдагдлыг илэрхийлдэг. Санхүүгийн хэрэглүүрийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа зээлийн эрсдэлд нэлээ бүхий өсөлт гарсан эсэхийг тус санхүүгийн хэрэглүүрийн үлдэх хугацааны туршид зээлийн чанаргүйжих эрсдэл нь хэрхэн өөрчлөгдөхийг харгалзан үзэж шийдвэрлэнэ. Үүнийг үндэслэн санхүүгийн хөрөнгийг Шатлал 1, Шатлал 2, Шатлал 3 болон худалдан авахад эсвэл анх олгоход үнэ цэнийн бууралттай байсан зээл гэж бүлэглэсэн.

- Шатлал 1: Санхүүгийн хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрөхөд үнэ цэнийн бууралтыг ЗҮЦ12сХА-д суурилан тооцно. Шатлал 1-т мөн зээлийн эрсдэл нь сайжирч, Шатлал 2-оос шилжиж орж ирсэн санхүүгийн хөрөнгө багтана.
- Шатлал 2: Санхүүгийн хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа зээлийн эрсдэлд нэлээ бүхий өсөлт ажиглагдсан хөрөнгөд үнэ цэнийн бууралтыг ЗҮЦНХХА-д суурилан тооцно. Шатлал 2-т мөн зээлийн эрсдэл нь сайжирч, Шатлал 3-аас шилжиж орж ирсэн санхүүгийн хөрөнгө багтана.
- Шатлал 3: Санхүүгийн хөрөнгийг чанаргүй болсон гэж үзэх бөгөөд үнэ цэнийн бууралтыг ЗҮЦНХХА-д суурилан тооцно.
- Худалдан авахад эсвэл анх олгоход үнэ цэнийн бууралттай байсан зээл: Худалдан авахад эсвэл анх олгоход үнэ цэнийн бууралттай байсан зээл нь анхлан бүртгэх үед зээлийн үнэ цэнэ буурсан байсан санхүүгийн хөрөнгө юм. Худалдан авахад эсвэл анх олгоход үнэ цэнийн бууралттай байсан зээлийг анхлан бодит үнэ цэнээр бүртгэх ба дараа нь хүүний орлогыг зээлийн тооцоолсон үр ашигт хүүнд үндэслэн бүртгэнэ. Зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал өөрчлөгдөх үед ЗҮЦХА-ыг хүлээн зөвшөөрнө.

*ЗҮЦХА-ын тооцоолол.* Компани ЗҮЦХА-ыг тооцохдоо хүлээгдэж буй мөнгөн хөрөнгийн дутагдлыг хэмжих жинлэсэн магадлалын гурван хувилбарт үндэслэн тооцоолно. Мөнгөн хөрөнгийн дутагдал нь байгууллагын гэрээний дагуу авахаар тохирсон мөнгөн урсгал болон хүлээн авахаар хүлээж буй мөнгөн урсгалын хоорондох зөрүү юм. ЗҮЦХА-ын тооцооллын аргачлал болон гол элементүүдийг доор тодилуулав. Үүнд:

- Чанаргүйдлийн магадлал ("ЧМ") нь өгөгдсөн хугацааны туршид хөрөнгийн чанаргүй болох магадлалын тооцоолол юм. Зээлийг данснаас хасаагүй ба санхүүгийн тайлангийн өдөр багцад байгаа тохиолдолд, уг зээл нь үнэлгээний хугацааны тодорхой нэг цэгт чанаргүй болох болно.
- Чанаргүйдэлд өртөх дүн ("ЧӨД") нь үндсэн төлбөр ба хүүний эргэн төлөлт, зээлийн төлбөрийн хоцролт дээр хуримтлуулсан хүү, гэрээгээрх хуваарьт эсвэл хүлээгдэж буй зээлийн үүргийн хүрээнд нэмж олгох дүн гэх мэт тайлагналын өдрийн дараах бүртгэлийн дүнд нөлөөлөх хүчин зүйлсийг харгалзан үзэж ирээдүйд чанаргүй болох өдрийн зээлийн дүнгийн тооцооллыг хална.
- Алдагдалд хүргэх чанаргүйдэл ("АХЧ") нь өгөгдсөн хугацаанд санхүүгийн хөрөнгө нь чанаргүй болсоны улмаас хүлээх алдагдлын тооцоолол юм. Энэ нь гэрээний дагуу тохирсон мөнгөн урсгал болон Компани авахаар хүлээж буй мөнгөн урсгал хоорондын зөрүүнд үндэслэнэ. АХЧ нь ихэвчлэн ЧӨД-ийн хувиар илэрхийлэгддэг.

Групп нь ЗҮЦХА-ын тооцоололд гурван хувилбарыг (суурь хувилбар, хамгийн сайн хувилбар болон хамгийн муу хувилбар) харгалзан үздэг. Эдгээр хувилбарууд тус бүр өөр өөр ЧМ, ЧӨД болон АХЧ-ийн дүнтэй байна. Тодруулга 21.3 харна уу.

Групп олгохоор батлагдсан зээлийн үүргийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлыг тооцохдоо хүлээгдэж буй хугацааны туршид олгогдох, олгохоор батлагдсан зээлийн үүргийн хүлээгдэж буй хэсгийг харгалзан үздэг. 2020 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх үлдэгдэлтэй зээл болон авлагатай холбогдох ЗҮЦХА-ыг зээл болон авлагын тодруулгад хамт тайлагнасан. Олгохоор баталсан зээлийн үүргийн ЗҮЦХА нь бусад өр төлбөрийн хэсэгт бүртгэгдсэн.

ЛЭНДМН ББСБ ХК
landmn
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ЭНЭРНЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
2021/05/24
149

СЗХ
2021.06.23
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



**2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)**

*Ирээдүйн таамаглаж буй мэдээлэл.* Групп нь ЗҮЦХА-ын загварт эрсдэл хүрээний, ирээдүйг таамагласан эдийн засгийн өгөгдлүүдийг оруулсан. Үүнд:

- Ам.долларын төгрөгтэй харьцах ханшийн сарын өөрчлөлтийн хувь,
- Ам.долларын төгрөгтэй харьцах сарын дундаж ханш (Үнэмлэхүй утга),
- Инфляцийн сарын түвшин,
- Инфляцийн түвшний сарын өөрчлөлтийн хувь,
- Сарын ажилгүйдлийн түвшин,
- Сарын дундаж цалин,
- Сарын Жини коэффициент,

*Барьцаа.* Группийн зээл болон авлага нь (банкин дахь мөнгөн хөрөнгө болон харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа) барьцаагүй болно.

*Данснаас хасах.* Хөрөнгийг нөхөн төлүүлэх бүхий л шаардлагатай арга хэмжээг авч, алдагдлын дүнг тодорхойлсны дараа эргэн төлөгдөхгүй хөрөнгийг холбогдох үнэ цэнийн бууралтын сангаар данснаас хасна. Өмнө нь данснаас хассан авлагаас тайлагналын дараа үед цуглуулсан буюу эргэн төлөгдсөн дүнг тухайн тайлант хугацааны орлогын тайлангийн үнэ цэнийн бууралтын алдагдал дансны кредитэд бүртгэнэ.

*Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө.* Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөд кассан дахь бэлэн мөнгө, банкинд байршуулсан хугацаагүй хадгаламжууд, мөн 3 болон түүнээс доош сарын хугацаатай өндөр хөрвөх чадвар бүхий хөрөнгө оруулалт (голдуу банкинд байршуулсан хугацаатай хадгаламж) орно. Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөд хязгаарлалт бүхий мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг оруулаагүй.

*Үндсэн хөрөнгө.* Группийн эзэмшиж буй үндсэн хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдэл болон шаардлагатай бол үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг хассан дүнгээр тусгана. Урсгал засварын зардал, үйлчилгээний өртгийг гарсан үед нь зардлаар бүртгэнэ. Үл хөдлөх хөрөнгө болон тоног төхөөрөмжийн томоохон бүрэлдэхүүн хэсгийг шинэчилсэн бол холбогдох өртгийг капиталжуулж, солигдсон хуучин хэсгийг данснаас хасна.

Тайлант хугацааны эцэст удирдлага үндсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсныг илтгэх аливаа үзүүлэлт байгаа эсэхийг үнэлнэ. Хэрэв ийм үзүүлэлт байгаа нөхцөлд хөрөнгийн нөхөгдөх үнийг тооцоолох ба энэ нь хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах өртгийг хассан дүн болон түүний ашиглалтын үнэ цэнийн аль өндрөөр тодорхойлогддог. Дансны үнийг нөхөгдөх өртөг хүртэл бууруулан үнэ цэнийн бууралтын зардлыг тухайн жилийн ашиг, алдагдлын тайланд бүртгэдэг. Хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ эсвэл бодит үнэ цэнээс борлуулалтын өртгийг хассан тооцоолол өөрчлөгдсөн нөхцөлд өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрөгдсөн үнэ цэнийн бууралтын зардлыг буцааж болно. Хөрөнгө борлуулсны олз, гарзыг тодорхойлохдоо борлуулалтаас олсон орлогыг дансны дүнтэй харьцуулан тооцож, тухайн жилийн ашиг, алдагдлын тайланд (үйл ажиллагааны бус орлого, зардал хэсэгт) бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн элэгдлийг тэдгээрийн өртгийг доорх хүлээгдэж буй ашиглах хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан үлдэх өртөг хүртэл нь бууруулан хуваарилж тооцно:

| | Ашиглалтын жил |
|---|---|
| Тавилга, оффисын тоног төхөөрөмж болон тээврийн хэрэгсэл | 10 жил |
| Компьютер ба техник тоног төхөөрөмж | 3 жил |
| Оффисийн түрээсийн сайжруулалт | 5 жил |

Хөрөнгийн үлдэх өртөг гэдэг нь хөрөнгө хуучирсан, ашиглагдах хугацаа нь дууссан байгаа гэж үзвэл Групп хөрөнгийг борлуулснаас олох боломжтой үнээс борлуулалтын зардлыг хассан дүнг хэлнэ. Хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын жилийг тайлант үе бүрийн эцэст хянаж, шаардлагатай гэж үзвэл өөрчилнө.

**Түрээс.** Групп нь аливаа гэрээг түрээсийн гэрээ эсвэл түрээсийн мөн чанарыг агуулж байгаа эсэхийг гэрээ байгуулах үед үнэлж тогтооно. Өөрөөр хэлбэл ямарваа нэгэн төлбөр төлж, тухай гэрээгээр тодорхой хугацааны туршид тодорхой нэг хөрөнгийг ашиглах эрхийг олж авч байгаа эсэхийг үнэлнэ.



landmn
УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ АНД КАПИТАЛ ХХК

СЗХ
2021.06.23
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



**2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)**

*Групп - Түрээслэгч*

Групп нь богино хугацаат болон бага үнэ цэнэтэй түрээсээс бусад бүх төрлийн түрээсийн хувьд хүлээн зөвшөөрөлт болон хэмжилтийн нэг л аргыг ашиглана. Групп нь тухайн хөрөнгийг ашиглах эрхийг ашиглах эрх бүхий хөрөнгөөр, харин түрээсийн төлбөрүүдийг түрээсийн өр төлбөрөөр тус тус хүлээн зөвшөөрнө.

*i) Ашиглах эрх бүхий хөрөнгө*

Групп нь ашиглах эрх бүхий хөрөнгийг түрээсийн хугацаа эхэлсэн өдөр (тухайн хөрөнгийг ашиглаж эхлэх боломжтой өдрөөс) хүлээн зөвшөөрдөг. Ашиглах эрх бүхий хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг хассан дүнгээр тусгаж, түрээсийн өр төлбөрийн дахин хэмжилтийн дүнгээр тохируулагдана. Ашиглах эрх бүхий хөрөнгийн өртөг нь хүлээн зөвшөөрсөн түрээсийн өр төлбөрийн дүн, анхдагч шууд зардлууд, түрээс эхлэх өдөр эсвэл түүнээс өмнө төлсөн түрээсийн төлбөр, болон түрээсийн урамшууллаас бүрдэнэ. Ашиглах эрх бүхий хөрөнгийг тухайн хөрөнгийг ашиглахаар тооцсон хугацаа болон түрээсийн гэрээний хугацааны аль бага хугацаагааны туршид шулуун шугамын аргаар элэгдүүлнэ. Үүнд:

- Оффисийн барилга – Группд түрээсийн хөрөнгийг 5 жилийн туршид эзэмшлэх эрхийг шилжүүлсэн

Түрээслэгч хөрөнгийг түрээслэж эхэлсэн өдрөөс эхлэн тухайн хөрөнгийн өртгийн загвар ашиглан хэмжинэ. Өртгийн загварын дагуу түрээсийн хөрөнгийг тухайн хөрөнгийн өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хасч тооцно. Түрээсийн хөрөнгийн цэнийн бууралтыг мөн хэмжинэ. Түрээсийн хөрөнгийг "Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт" болон Тодруулга 17-оос харна уу.

*ii) Түрээсийн өглөг*

Групп түрээсийн хугацаа эхэлсэн өдөр түрээсийн өглөгийг түрээсийн хугацааны турш төлөх нийт төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр хүлээн зөвшөөрнө. Түрээсийн төлбөрт түрээсийн тогтмол төлбөрөөс гадна ашиглах эрх бүхий хөрөнгөтэй холбоотой урамшууллын авлага, үнийн индекс эсвэл хүүний хувь хэмжээнээс хамаарах хувьсах түрээсийн төлбөр, үлдэгдэл үнийн баталгааны дагуу хүлээгдэж буй төлбөрийг оруулан тооцно. Үнийн индекс эсвэл хүүний хувь хэмжээнээс хамаарахгүй хувьсах түрээсийн төлбөрийг зардлаар (бараа материалыг үйлдвэрлэхэд зориулж гаргаагүй тохиолдолд) хүлээн зөвшөөрнө.

Түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг тооцохдоо Компани нь түрээсийн гэрээний үр ашигт хүүний хэмжээг тодорхойлох боломжгүй тул түрээсийн эхэн үеийн нэмэгдүүлсэн зээлийн хүүний түвшинг ашигладаг. Түрээсийн хугацаа эхэлснээс хойших түрээсийн өглөгийн үнийн дүн нь хуримтлагдсан хүүний дүнгээр өсөх ба түрээсийн төлбөрийн төлөлтийн дүнгээр буурна. Мөн түүнчлэн түрээсийн хугацаа өөрчлөгдөх болон түрээсийн төлбөрийн дүнд өөрчлөлт орсон (жишээлбэл хувьсах түрээсийн төлбөрийн хувьд үнийн индекс эсвэл хүүний хувь хэмжээнд өөрчлөлт орж ирээдүйн түрээсийн төлбөр өөрчлөгдсөн) эсвэл тухайн хөрөнгийг худалдан авах сонголтын үнэлгээний өөрчлөлт зэргээс шалтгаалан түрээсийн өглөгийн үнийн дүнг дахин үнэлнэ. Дэлгэрэнгүйг Тодруулга 17-оос харна уу.

***Биет бус хөрөнгө.*** Гүүдвилээс бусад биет бус хөрөнгө нь ашиглалтын тодорхой хугацаатай бөгөөд Группийн үндсэн биет бус хөрөнгө нь лиценз юм.

Худалдан авсан компьютерийн программ хангамжийн лицензүүдийн өртөг дээр тэдгээрийг ашиглахад бэлэн болгохтой холбогдон гарсан зардлыг нэмсэн дүнгээр хүлээн зөвшөөрнө. Биет бус хөрөнгийг тэдгээрийн ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар хорогдуулна.

| | **Ашиглалтын жил** |
|---|---|
| ЛэндМН технологийн лицензүүд (Зээлийн болон хэтэвчийн үйлчилгээний систем) | 10 жил |
| Имонэй (Emoney) гаргах үйлчилгээний лиценз | 4 жил |

Үнэ цэнэ нь буурсан бол биет бус хөрөнгийн дансны үнийг хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ болон түүний бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүнгийн аль их дүн хүртэл бууруулна.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
2021/05/24

СЭХ
2021.06.23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



**2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)**

***Орлогын албан татвар.*** Орлогын албан татварыг тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр хэрэглэгдэж байсан, хэрэгжих нь тодорхой болсон хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрнө. Орлогын албан татварын зардал нь тухайн жилийн болон хойшлогдсон татвараас бүрдэх бөгөөд уг зардлуудтай холбоотой ажил гүйлгээг тухайн буюу өөр тайлант хугацаанд бусад дэлгэрэнгүй орлогод эсвэл шууд өмчид бүртгэдсэнээс бусад тохиолдолд тухайн жилийн ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө. Тайлант хугацааны татвар нь тухайн болон өмнөх тайлант хугацааны татвар ногдох ашиг, алдагдалтай холбоотой татварын байгууллагад төлөхөөр хүлээгдэж буй эсвэл түүнээс нөхөн авах дүн болно. Санхүүгийн тайланг холбогдох татварын албанд тушаахаас өмнө баталгаажуулсан бол татвар ногдуулах ашиг, алдагдлыг урьдчилан тооцно. Орлогоос бусад зүйлд ногдуулсан албан татваруудыг үйл ажиллагааны зардал хэсэгт бүртгэдэг.

Ирээдүйд шилжүүлэх татварын алдагдлын хувьд балансын өр төлбөрийн аргыг ашиглан хойшлогдсон орлогын татварыг бүртгэдэг ба санхүүгийн байдлын тайлангийн өдрөөрх хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь болон тэдгээрийн санхүүгийн тайлагналын зорилгоор тооцсон дансны үнийн хооронд үүссэн түр зөрүүнд суурилна. Хойшлогдсон татварын үлдэгдлийг тайлант хугацааны эцэст хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан эсвэл хүчин төгөлдөр мөрдөж байгаа татварын хувь хэмжээгээр хэмжих ба энэ хувь хэмжээг түр зөрүүг буцаах эсвэл татварын алдагдлыг ирээдүйд шилжүүлэн ашиглах тайлант үеүдэд мөрдөнө. Хасагдах түр зөрүүнд болон татварын алдагдлыг шилжүүлэхэд үүсэх хойшлогдсон татварын хөрөнгийг зөвхөн тухайн хасагдлыг ашиглаж болохуйц ирээдүйн татварын ашигтай байх магадлалтай үед хүлээн зөвшөөрнө.

***Татварын тодорхой бус нөхцөл байдал.*** Группийн татварын тодорхой бус нөхцөл байдлын талаар удирдлага тайлант хугацаа бүрийн эцэст үнэлж үздэг. Татварын албанаас анхаарал хандуулж буй татварын тодорхой бус нөхцөл байдал үүссэн үед удирдлагын тодорхойлсноор нэмэлт татвар ногдуулахгүй байхаас илүүтэй орлогын албан татвар ногдуулна гэж үзэж байгаа бол өр төлбөр бүртгэнэ. Үнэлгээг тайлант үеийн эцэст хэрэглэгдэж байсан, үндсэндээ хэрэгжих нь тодорхой болсон татварын хууль тогтоомжийн тайлбар, мэдэгдэж буй шүүхийн болон тухайн асуудлын талаарх бусад зохицуулалтад үндэслэн хийдэг. Орлогоос бусад зүйлд ногдуулсан татвар хураамж, хүү, торгуулийн өр төлбөрийг тайлант хугацааны эцэст тэдгээрийг барагдуулахад шаардагдах, удирдлагын хамгийн сайн гэж тооцоолсон зардлын дүнд үндэслэн хүлээн зөвшөөрдөг.

***Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ).*** Монгол Улсын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу санхүүгийн үйлчилгээний орлого нь (зээлийн хүү) НӨАТ-аас чөлөөлөгддөг ба удирдлагын зүгээс Компани санхүүгийн бус үйлчилгээнээс үүдэлтэй НӨАТ-ын өр төлбөргүй гэж үзсэн. Тиймээс 2020 оны 12 дугаар сарын 31 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Групп нь НӨАТ төлөгчөөр бүртгүүлээгүй болно.

***Зардал болон өр төлбөрийн нөөц сан.*** Зардал болон өр төлбөрийн нөөц сан нь төлөгдөх хугацаа болон дүн нь тодорхойгүй санхүүгийн бус өр төлбөр юм. Групп нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн хуулийн эсвэл өс заншлын үүрэг байгаа бөгөөд уг үүргийг биелүүлэхэд эдийн засгийн өгөөж агуулсан баялгийг зарцуулах нь тодорхой болсон ба үүргийн дүнг найдвартайгаар тооцоолох боломжтой үед тухайн нөөц санг хуримтлуулан бүртгэнэ.

***Бусад өглөг.*** Харилцагч тал гэрээнд заасан үүргээ биелүүлсэн үед бусад өглөгийг хуримтлуулан тооцож, хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

***Орлого, зардлын хүлээн зөвшөөрөлт.*** Хүүний орлого эсвэл хүүний зардлыг чанаргүй төлөвт орсон хэрэглүүрээс бусад санхүүгийн хэрэглүүрийн хувьд үр ашигт хүүний аргыг ашиглан аккруал сууриар бүртгэнэ. Энэ аргын дагуу гэрээний талуудын хооронд төлөгдсөн эсвэл хүлээн авсан бүх хураамж, гүйлгээний зардал болон бүх урамшуулал, хөнгөлөлтийг үр ашигт хүүнд оруулан тооцож, цаг хугацааны хувьд хойшлуулан хүүний орлого эсвэл зардалд бүртгэдэг. Үр ашигт хүүний бүрэлдэхүүн хэсэг болох хураамжид санхүүгийн хөрөнгийг худалдан авах эсвэл санхүүгийн өр төлбөрийг үүсгэхтэй холбоотойгоор нэмэгдэн гарсан, Группийн төлсөн эсвэл хүлээн авсан хураамжууд багтдаг ба жишээлбэл үүнд төлбөрийн чадварыг үнэлэх, санхүүгийн хэрэглүүрийн нөхцөл тохиролцох, холбогдох баримт бичиг боловсруулахтай холбоотойгоор нэмэгдэн гарсан аливаа хураамжууд орно. Зээлийн олголт бүрд ногдуулж буй ЛэндМН хураамжийн орлого нь хүүний орлого гэж нэрлэгдэхгүй боловч үр ашигт хүүний нэг хэсэг юм.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
20
152

СЗХ
2021 06 23
№ 01

МОНГОЛЫН ХӨРЕНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18
БҮРТГЭВ-03



**2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)**

***Орлого, зардлын хүлээн зөвшөөрөлт (Үргэлжлэл)***

Санхүүгийн хөрөнгө нь чанаргүй төлөвт орж, ЗҮЦХА-ын загварын 3-р шатлалын хөрөнгөөр ангилагдсан тохиолдолд Групп нь хүүний орлогыг санхүүгийн хөрөнгийн цэвэр хорогдуулсан өртгөөс үр ашигт хүүний түвшинг ашиглан тооцдог.

Хэрэв санхүүгийн хөрөнгийн чанар сайжирч, чанаргүй төлөвөөс гарсан тохиолдолд хүүний орлогыг эргээд нийт дансны үнээс тооцно. Групп нь худалдаж авахад эсвэл анх олгоход үнэ цэнийн бууралттай байсан (ХАОҮЦБ) санхүүгийн хөрөнгийн хүүний орлогыг хөрөнгийн хорогдуулсан өртгөөс зээлийн тохируулсан үр ашигт хүүний түвшинг ашиглан тооцно. Зээлийн тохируулсан үр ашигт хүү гэдэг нь анхлан хүлээн зөвшөөрөлтийн өдрөөр тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг (зээлийн алдагдлыг оруулсан) ХАОҮЦБ хөрөнгийн хорогдуулсан өртөг рүү дискаунтлах хүүний хувь юм.

Бусад бүх шимтгэл, хураамж болон бусад орлого, зардлын зүйлүүдийг нийтлэг байдлаар нь аккруэл сууриар тухайн ажил гүйлгээний гүйцэтгэлтэй уялдуулан хүлээн зөвшөөрөх бөгөөд гүйцэтгэлийг нийт үзүүлэх үйлчилгээнд эзлэх бодитоор үзүүлсэн үйлчилгээний хэсэгт үндэслэн тооцдог.

***Хувьцаат капитал ба нөөц.*** Энгийн хувьцааг өөрийн өмчид ангилдаг. Шинэ хувьцаа гаргахтай шууд холбогдон гарсан нэмэгдэл зардлуудыг өөрийн өмчийн хэсэгт, хувьцаа гаргалтаас хүлээн авсан нийт дүнгээс хасах утгатайгаар (татвар хассаны дараах байдлаар) тусгадаг. Буцаан худалдан авсан ("халаасны хувьцаа") өөрийн өмчийн хэрэглүүрийг өртгийн аргаар хүлээн зөвшөөрч өөрийн өмчөөс хасаж бүртгэнэ. Групп нь өөрийн өмчийн хэрэглүүрийг худалдан авах, борлуулах, гаргах эсвэл хүчингүй болгоход ашиг, алдагдалд ямар ч олз, гарзыг хүлээн зөвшөөрөхгүй. Халаасны хувьцааг дахин гаргах үед үүсэх дансны дүн болон хүлээн авсан төлбөрийн зөрүүг хувьцааны урамшууллаар бүртгэнэ.

***Гадаад валютын хөрвүүлэлт.*** Группийн үйл ажиллагааны валют нь түүний үйл ажиллагаагаа явуулж буй эдийн засгийн үндсэн орчны валют юм. Группийн үйл ажиллагааны болон тайлагналын валют нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөг юм.

Мөнгөн зүйлст тооцогдох хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлант хугацаа бүрийн эцэст тухайн өдрийн Монгол Банк (МБ)-ны албан ханшаар Группийн үйл ажиллагааны валютруу хөрвүүлнэ. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ болон гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлант хугацааны эцсийн өдрийн Монгол Банкны албан ханш руу хөрвүүлснээс үүсэх ханшийн олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг. Түүхэн өртгөөр бүртгэдэг мөнгөн бус зүйлүүдийг тайлант хугацааны эцсийн хаалтын ханшаар хөрвүүлэхгүй.

***Хөрөнгө, өр төлбөрийг цэвэр дүнгээр тусгах.*** Бүртгэсэн дүнгүүдийг хооронд нь хаах эрх зүйн үндэслэл байгаа бөгөөд төлбөрийг цэвэр дүнгээр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг худалдаж, өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөөтэй тохиолдолд санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хооронд нь хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр тусгана.

***Ажиллагсдын зардал болон холбогдох шимтгэлүүд.*** Цалин хөлс болон цалинтай холбоотой бусад зардлуудыг Группийн ажиллагсад холбогдох ажил үйлчилгээ үзүүлсэн жилд зардлаар хүлээн зөвшөөрдөг. Цалинтай ээлжийн амралт гэх мэт богино хугацааны, хуримтлагдах цалинтай чөлөөг ирээдүйд цалинтай чөлөө авах эрхээ нэмэгдүүлэн, ажил үйлчилгээ үзүүлсэн тайлант хугацаанд хүлээн зөвшөөрнө. Өвчний чөлөө гэх мэт богино хугацааны хуримтлагддаггүй цалинтай чөлөөг чөлөө авсан үед нь хүлээн зөвшөөрнө. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй компаниуд хуулийн дагуу улсын тэтгэврийн, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын сангуудад шимтгэл төлдөг. Эдгээр шимтгэлүүдийг үүссэн үед нь ашиг алдагдлын тайланд зардлаар бүртгэдэг. Энд дурьдсан тогтмол шимтгэлтэй улсын сангууд болон тогтмол шимтгэлтэй хөтөлбөрт төлдөг төлбөрүүдээс гадна Групп өөр ямар нэгэн тэтгэврийн болон адил төсөөтэй тэтгэмжийн төлбөр төлөх хууль эрх зүйн бөгөөд зохиомол үүрэг хүлээгээгүй болно.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 Д.1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО АУДИТ ХХК

СЗХ
2021.06.23 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



## 2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)

***Хувьцаанд суурилсан төлбөр.*** Группийн эцсийн толгой компани болох АНД Глобал Пти.Лтд-аас Группийн гол удирдах албан тушаалтанд Ажилтанд хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн дагуу өмчөөр төлөгдөх хувьцаанд суурилсан төлбөр бүхий урамшуулал олгосон ба хувьцаанд суурилсан ажил гүйлгээний бодит үнэ цэнэ нь түүнийг олгох өдрөөр тодорхойлогдож, хэрэгжих хугацааны туршид шулуун шугамын аргаар орлого, үр дүнгийн тайланд ажилчдын зардлаар бүртгэгдэж, өөрийн өмчийг өсгөнө. Хэрэгжихээр хүлээгдэж буй хувьцааны тоог тодорхойлох таамаглалд зах зээлийн бус хэрэгжилтийн нөхцөлүүдийг харгалзан үзнэ. Групп тайлагналын өдрөөр хэрэгжих магадлалтай хувьцааны тоо ширхэгийг шинэчлэн тооцоолдог. Тооцооллыг шинэчилснээс үүсэх тохируулгыг орлого, үр дүнгийн тайланд бүртгэж, холбогдох өөрийн өмчийн хэсгийг тохируулдаг. Групп СТОУС 2-т тодорхойлсон мөнгөөр төлөгдөх хувьцаанд суурилсан төлбөрийн схем эсвэл мөнгөөр төлөгдөх сонголттой хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээ хийдэггүй.

***Сегментийн тайлагнал.*** Үйл ажиллагааны сегментүүдийг Компанийн үйл ажиллагааны гол шийдвэр гаргагчдад зориулан бэлтгэдэг дотоод тайлан мэдээлэлд нийцүүлэх маягаар тайлагнадаг. Нийт сегментүүдийн орлого, үр дүн болон хөрөнгийн 10 ба түүнээс дээш хувийг дангаараа бүрдүүлж буй сегментийг тусад нь тайлагнана.

***Нэгж хувьцаанд ногдох ашиг.*** Нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох тайлант жилийн цэвэр ашгийг тухайн тайлант хугацааны турш оролцоотой байсан энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд хувааж тооцно. Нэгж хувьцаанд ногдох шингэрүүлсэн ашгийг Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдох тайлант хугацааны цэвэр ашгийг (хувьцаанд хөрвөх давуу эрхтэй хувьцааны хүү эсвэл хувьцаанд хөрвөх нөхцөлтэй бондын хүүний татварын дараах зардлуудаар тохируулсан) тухайн тайлант хугацааны турш оролцоотой байсан жигнэсэн дундаж энгийн хувьцааны тоон дээр шингэрүүлэх боломжит хувьцааг энгийн хувьцаанд хөрвүүлснээс үүсэх жигнэсэн дундаж энгийн хувьцааны тоог нэмсэн нийт энгийн хувьцааны тоонд хувааж тооцно.

***Холбоотой талуудын ажил гүйлгээ.*** Групптэй дараах байдлаар холбогдсон аж ахуй нэгж болон хувь хүнийг холбоотой талууд гэнэ. Үүнд:

(а) Групптэй дараах байдлаар холбогдсон хувь хүн эсвэл тэдгээрийн ойрын төрөл садан нь:
- (i) Группд дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон;
- (ii) Группд томоохон нөлөөлөлтэй; эсвэл
- (iii) Группийн гол удирдах албан тушаалтнуудын нэг.

(б) Дараах нөхцөлүүдийн аль нэгийг хангасан аж ахуйн нэгж нь Группийн холбоотой тал болно. Үүнд:
- (i) Аж ахуйн нэгж болон Групп нь нэг ижил Группийн гишүүд байх (толгой компани, охин компани болон зэргэлдээ охин компани бүр бусадтайгаа холбоотой).
- (ii) Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийнхээ хараат компани эсвэл хамтарсан компани байх (эсвэл нөгөө аж ахуйн нэгж нь гишүүн болох Компанийн хараат компани эсвэл хамтарсан компани байх).
- (iii) Аж ахуйн нэгжүүд нь нэг ижил гуравдагч этгээдийн хамтарсан компаниуд.
- (iv) Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч этгээдийн хамтарсан компани бөгөөд нөгөө аж ахуйн нэгж нь гуравдагч этгээдийн хараат компани.
- (v) Аж ахуйн нэгж нь Группийн ажиллагсдыг урамшуулах зорилгоор ажил эрхлэлтийн дараах тэтгэмж олгодог. Хэрэв Групп нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бол дэмжлэг хүртэж буй ажиллагсад нь мөн Групптэй холбоотой тал болно.
- (vi) Аж ахуйн нэгжийг (а)-д тодорхойлсон хувь хүн дангаараа эсвэл хамтран хянадаг.
- (vii) (а)(i)-д тодорхойлсон хувь хүн нь аж ахуйн нэгжид томоохон нөлөөлөлтэй эсвэл уг аж ахуйн нэгжийн (эсвэл толгой компанийн) гол удирдах албан тушаалтнуудын нэг.
- (viii) Групп эсвэл Группийн толгой компанийг гол удирдах албан тушаалтнаар хангадаг, группийн гишүүн аж ахуйн нэгж.

Холбоотой талуудын боломжит бүх хамаарлыг харгалзан үзэхдээ зөвхөн хуулийн хэлбэрийг биш хамаарлын мөн чанарыг чухалчлан анхаарсан болно. Холбоотой талуудтай хийсэн бүх материаллаг ажил гүйлгээ болон үлдэгдлийг энэхүү санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгуудад тодруулсан бөгөөд дэлгэрэнгүйг Тодруулга 24-өөс харна уу.

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 ☘ 11 267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
22
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ УЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЭХ
2021 /06/ 23
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18
БҮРТГЭВ



**3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого болон тодруулгад орсон өөрчлөлтүүд**

Групп 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа доорх стандарт болон стандартын нэмэлт өөрчлөлтүүдээс бусад хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг өмнөх санхүүгийн жилд мөрдөж байсантай адил бөгөөд тадгээрийг тууштай мөрдөж байгаа.

Шинэ болон өөрчлөгдсөн стандарт болон стандартын тайлбарууд

| | |
|---|---|
| • СТОУС 3 нэмэлт өөрчлөлт | *Бизнесийн тодорхойлолт* |
| • СТОУС 7, СТОУС 9 болон НББОУС 39 нэмэлт өөрчлөлт | *Хүүгийн жишигт орсон шинэчлэл* |
| • НББОУС 1, НББОУС 8 нэмэлт өөрчлөлт | *Материаллаг тодорхойлолт* |
| • Санхүүгийн тайлангийн үзэл баримтлалын хүрээ | *2018 оны 3 дугаар сарын 29-ний өдөр гаргасан* |
| • СТОУС 19 нэмэлт өөрчлөлт | *Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлт* |

**СТОУС 3 нэмэлт өөрчлөлт: Бизнесийн тодорхойлолт**

СТОУС 3 Бизнесийн нэгдэлд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр бизнесийг нэгтгэн үзэхийн тулд үйл ажиллагаа болон хөрөнгийн нэгдсэн цогц нь хамгийн багадаа орц, гарц, бодитой үйл явцыг багтаасан байх ёстой. Цаашилбал, бизнес нь бүх оролт болон процессыг оруулалгүйгээр оршин тогтнох боломжтой болохыг тодруулсан болно. Эдгээр нэмэлт өөрчлөлт нь Группийн санхүүгийн тайланд нөлөөлөөгүй болович Групп аливаа бизнесийн нэгдэлд орох тохиолдолд ирээдүйд нөлөөлж болзошгүй юм.

**СТОУС 7, СТОУС 9 болон НББОУС 39 нэмэлт өөрчлөлт: *Хүүний жишигт орсон шинэчлэл***

СТОУС 9 ба НББОУС 39 нэмэлт өөрчлөлт, Санхүүгийн хэрэгслүүд: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтэд оруулсан нэмэлт өөрчлөлтүүд нь хүүний жишиг шинэчлэлд шууд нөлөөлж буй бүх хеджийн харилцаанд хамаарах хэд хэдэн хөнгөлөлтийг үзүүлдэг. Хэрэв шинэчлэл нь хеджийн зүйл эсвэл хеджийн хэрэгслийн жишигт суурилсан мөнгөн урсгалын цаг хугацаа ба / эсвэл хэмжээнд тодорхойгүй байдал үүсгэж байвал хеджийн харилцаанд нөлөөлнө. Эдгээр нэмэлт өөрчлөлт нь хүүний хеджийн харилцаагүй тул Группийн санхүүгийн тайланд нөлөөлөхгүй.

**НББОУС 1, НББОУС 8 нэмэлт өөрчлөлт: "Материаллаг" тодорхойлолт**

Нэмэлт өөрчлөлтүүд нь шинэ тодорхойлолтыг "тухайн мэдээллийг орхисон, буруу бичсэн эсвэл тодорхой бус орхисон тохиолдол нь санхүүгийн тайлангийн үндсэн хэрэглэгчдийн санхүүгийн тайланг үндэслэн гаргасан шийдвэрт нөлөөлөх болно гэж тусгажээ. Нэмэлт өөрчлөлтүүд нь материаллагийг санхүүгийн тайлангийн агуулгаар мэдээллийн шинж чанар, хэмжээ, дангаар нь эсвэл бусад мэдээлэлтэй хослуулан авч үзнэ гэж тодорхойлжээ. Мэдээллийн бурууташаа байдал нь анхдагч хэрэглэгчдийн гаргасан шийдвэрт нөлөөлөхүйц үндэслэлтэй гэж үзэж болох юм. Эдгээр нэмэлт, өөрчлөлт нь санхүүгийн тайланд нөлөөлөөгүй бөгөөд цаашид Группд нөлөөлөхгүй гэж үзэж байна.

**2018 оны 3 дугаар сарын 29-ний өдөр гаргасан Санхүүгийн тайлангийн үзэл баримтлалын хүрээ**

Энэхүү үзэл баримтлалын хүрээ нь стандарт биш бөгөөд үүнд агуулагдах ойлголтуудын аль нь ч ямар ч стандартын үзэл баримтлал, шаардлагыг үгүйсгэхгүй. Энэхүү үзэл баримтлалын хүрээний зорилго нь НББОУСЗ-д стандарт боловсруулахад туслах, холбогдох стандарт байхгүй тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тууштай бодлого боловсруулахад туслах, бүх талуудад стандартыг ойлгох, тайлбарлахад туслах явдал юм. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогоо үзэл баримтлалын хүрээнд үндэслэн боловсруулсан аж ахуйн нэгжүүдэд нөлөөлнө. Шинэчилсэн үзэл баримтлалын хүрээнд зарим шинэ ойлголт, шинэчилсэн тодорхойлолт, хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх шалгуурыг багтаасан бөгөөд зарим чухал ойлголтуудыг тодруулсан болно. Эдгээр нэмэлт өөрчлөлт нь Группийн санхүүгийн тайланд нөлөөлөөгүй.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 118267205
2021/05/24



УЛААНБААТАР ХОТ
ЭРНСТ ЭНД ЯНГ КОНСАЛТИНГ
КАПИТАЛ ТҮЦ
ХХК
5103855
9021031105
СТС2420

## 3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого болон тодруулгад орсон өөрчлөлтүүд (Үргэлжлэл)

Шинэ болон өөрчилсөн стандартууд болон тодруулгууд (Үргэлжлэл)

**СТОУС 16-д оруулсан Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлт болон нэмэлт өөрчлөлтүүд**

2020 оны 5 дугаар сарын 28-нд НББОУС3 нь Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлтийн тухай СТОУС 16-д түрээсийн нэмэлт, өөрчлөлт оруулсан. Нэмэлт өөрчлөлтүүд нь түрээслэгчдэд Covid-19 цар тахлын шууд үр дагавраас үүдэлтэй түрээсийн хөнгөлөлтийг бүртгэх түрээсийн өөрчлөлтийн бүртгэлийн талаарх СТОУС 16-н зааврыг хэрэгжүүлэхэд хөнгөлөлт үзүүлдэг. Энэхүү хөнгөлөлтийн зорилго нь түрээслэгч нь түрээслүүлэгчээс Ковид-19-тэй холбоотой авсан түрээсийн хөнгөлөлтийг нь түрээсийн өөрчлөлт мөн эсэхийг үнэлэхгүй байж болох сонголтыг оруулж өгсөн. Энэ сонголтыг хийсэн түрээслэгч нь Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлтийг СТОУС 16-д заасан түрээсийн өөрчлөлт гэж үзээгүй үед тооцсонтой адил аргаар тооцно. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2020 оны 6-р сарын 1-ний өдрөөс хойших жилийн тайлангийн хугацаанд хамаарна. Групп нь түрээсийн тооцоолол хийхэд энэхүү стандартын өөрчлөлтийг авч үзсэн.

Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй стандартууд

Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргах өдрөөр батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй Стандартууд болон тайлбаруудыг доор харуулав. Групп нь хүчинтэй болмогц холбогдох стандартуудыг дагаж мөрдөх төлөвлөгөөтэй байна.

| | |
|---|---|
| • СТОУС 17 | *Даатгалын гэрээ* [3] |
| • НББОУС 1 нэмэлт өөрчлөлт | *Эргэлтийн эсвэл эргэлтийн бус өр төлбөрийн ангилал* [3] |
| • СТОУС 3 нэмэлт өөрчлөлт | *Үзэл баримтлалын хүрээний зээлэмж* [2] |
| • НББОУС 16 нэмэлт өөрчлөлт | *Үндсэн хөрөнгө: Зориулалтаар ашиглаж эхлэхээс өмнө орлого*[2] |
| • НББОУС 37 нэмэлт өөрчлөлт | *Дөвөөдөшгүй гэрээ - Гэрээний үүргээ биелүүлэх зардал*[2] |
| • СТОУС 1, СТОУС-ыг анхлан авч хэрэгжүүлэх | *Охин компани нь анхлан хэрэгжүүлэгч*[2] |
| • СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр | *Санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөхтэй холбоотой '10 хувь'-ийн хязгаарын тест*[2] |
| • НББОУС 41 Хөдөө аж ахуй | *Бодит үнэ цэнийн хэмжилтэд татвар нөлөөлөх*[2] |

*1 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.*
*2 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.*
*3 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.*

## 4 Нягтлан бодох бүртгэлийн гол тооцооллууд болон үнэлэмжүүд

Групп нь санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүнгүүд болон дараагийн тайлант хугацааны хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд нөлөөлөх таамаглал болон тооцооллуудыг байнга хийдэг. Тооцоолол болон үнэлэмжүүдийг тасралтгүй үнэлдэг бөгөөд энэ нь удирдлагын туршлага болон тухайн нөхцөл байдалд үндэслэлтэй гэж үзсэн ирээдүйн үйл явдлуудын талаарх хүлээлт, таамаглал зэрэг бусад хүчин зүйлүүд дээр суурилдаг. Удирдлага нь тооцооллоос гадна, нягтлан бодох бүртгэлийн бодлогоо хэрэгжүүлэх явцад тодорхой үнэлэмжүүд хийх шаардлагатай болдог. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүнд хамгийн ихээр нөлөөлөх үнэлэмжүүд болон дараагийн тайлант хугацааны хөрөнгө, өр төлбөрийн дансны дүнд томоохон залруулга хийгдэж болох тооцооллуудыг нэгтгэн толилуулж байна:

**Ковид-19**

Ковид-19 цар тахал нь 2019 оны сүүлээр анх бүртгэгдсэн. Тухайн үед Хятад Улсын Хубэй мужийн нийслэл Вухан хотод "хатгалгааны үл мэдэгдэх хэлбэр" гэсэн шинж тэмдэгтэй өвчлөл олноор илэрч эхэлсэн. 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Хятад Улс Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-д энэхүү шинэ вирусны талаар анхааруулсан. 2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр, ДЭМБ-ийн Олон улсын эрүүл мэндийн зохицуулалтын онц байдлын зөвлөлөөс тархалтыг "Олон улсын нийтийг хамрах эрүүл мэндийн онц байдал" хэмээн зарласан. Түүнээс хойш, энэхүү вирус нь дэлхий даяар тархсан. 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдөр, ДЭМБ нь Ковид-19-ийг цар тахал гэж албан ёсоор зарласан.

2021.06.23

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



**4 Нягтлан бодох бүртгэлийн гол тооцооллууд болон үнэлэмжүүд (Үргэлжлэл)**

**Ковид-19 (Үргэлжлэл)**

Ковид-19 цар тахал нь хөрөнгө болон өр төлбөрийн хамаарагдахуунтай холбоотой төсөөлөл болон тооцооллын тодорхойгүй байдалд нөлөөлсөн. Тиймээс, Групп нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд санхүүгийн тайланг бэлтгэхэд ашигласан үнэлэмжүүдийг ойлгоход шаардлагатай нэмэлт тохируулга шаардлагатай эсэхийг анхааралтай авч үзсэн.

***Зээл болон авлагын үнэ цэнийн бууралтын алдагдал.*** СТОУС 9-ийн дагуу санхүүгийн бүх ангиллын хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлын тооцоололд үнэлэмж шаардагддаг бөгөөд тухайлбал зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн эсэхийг тодорхойлох, үнэ цэнийн алдагдлыг тооцоолохын тулд ирээдүйн мөнгөн урсгалын цаг хугацаа, дүнг тооцоолох дээр нэлээдгүй үнэлэмж шаардагддаг. Эдгээр тооцооллууд олон тооны үзүүлэлтүүдээс хамаарах бөгөөд тэдгээрийн өөрчлөлтүүд нь үнэ цэнийн бууралтын өөр өөр үр дүнд хүргэнэ. Группийн ЗҮЦХА-ын тооцоолол нь хувьсах өгөгдлүүдийн сонголт, тэдгээрийн харилцан хамааралаас шалтгаалсан хэд хэдэн суурь таамаглалуудтай загварын үр дүн юм. Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж болон тооцоололд хамаарагддаг ЗҮЦХА-ын загварын элементүүдэд дараах зүйлс багтана. Үүнд:

- ЗҮЦХА-ыг бүлгээр үнэлэх үед тэдгээр санхүүгийн хэрэгслүүдийн шатлал тодорхойлох;
- ЗҮЦХА-ын загвар боловсруулах, өгөгдлүүдийг сонгох;
- Макро эдийн засгийн хувилбарууд хоорондын уялдаа холбоо, ам.доллар/төгрөгийн харьцах ханш, инфляцийн түвшин гэх мэт эдийн засгийн өгөгдлүүд, ЧМ, ЧӨД, АХЧ-д үзүүлэх нөлөөг тодорхойлох;
- ЗҮЦХА-ын загварт эдийн засгийн өгөгдлүүдийг тодорхойлох ирээдүйг таамагласан макро эдийн засгийн хувилбарууд болон тэдгээрийн жигнэсэн магадлалыг сонгох.

Группийн бодлогоор энэхүү загварыг бодит алдагдалтай харьцуулан тогтмол нягталж үздэг ба шаардлагатай үед тохируулга хийдэг.

Удирдлага нь хөрөнгийн ирээдүйн мөнгөн урсгалыг төлөвлөхдөө ижил төрлийн зээлийн эрсдэлийн шинж чанартай хөрөнгө болон үнэ цэнийн бууралтын бодит нотлох баримттай хөрөнгүүдийн түүхэн алдагдлын туршлагад үндэслэн тооцоолдог. Тооцоолсон болон бодит алдагдлын зөрүүг багасгах зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалын дүн болон хугацааг тооцоход ашигласан аргачлал, таамаглалыг тогтмол хянадаг.

Групп нь ЗҮЦХА-ын нягтлан бодох бүртгэлийн стандарт болон зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн эсэхийг тодорхойлох тогтвортой хэрэглээг хангахын тулд ЗҮЦХА-ын нягтлан бодох бүртгэл: Ковид-19 цар тахлаас үүдэн гарч буй өнөөгийн тодорхойгүй үеийн СТОУС 9-ийн хэрэглээг авч үзсэн. Групп Ковид-19 цар тахлын улмаас дараах шинэчлэлүүдийг ЗҮЦХА-ын тооцоололд оруулж өгсөн.

- Зохистой болон эх үүсвэртэй мэдээллийг ашиглах
- Эдийн засгийн байдлын томоохон өөрчлөлтүүд, макро эдийн засгийн хувилбар болон төсөөллүүдэд орсон нөлөө
- Зээлийн багц эсвэл авлагын бүлэг дэх дахин сегментчлэл
- Зээл, авлага болон санхүүгийн хэрэгслийн тусгай болон бүлгийн үнэлгээ
- Төлбөрийн нөхцөлийг сунгах. Санхүүгийн зохицуулах хорооноос өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ба ЗҮЦХА-ын тооцоололд гарах нөлөөг тодорхойлохын тулд зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн эсэхийг тодорхойлохыг хамарсан зээл сунгах нөхцөлүүдийг үнэлсэн.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮНЭТ ЦААС ХХК
2021/05/24
157

СЭХ
2021.06.23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



**5 Хүү болон түүнтэй адилтгах цэвэр орлого ба сегментийн мэдээлэл**

2020 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд Групп бизнесийн нэг сегментэд үйл ажиллагаа явуулсан бөгөөд энэ нь Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэдэд шуурхай зээлийн үйлчилгээ үзүүлэх юм. Группийн гол шийдвэр гаргагчдад нөөцийн хуваарилалт, гүйцэтгэлийн үнэлгээний зорилгоор тайлагнасан мэдээлэлд Группийн үйл ажиллагааны үр дүнг бүхэлд нь нэг цогц сегмент гэж үзэн тайлагнадаг бөгөөд Группийн нөөц бүхэлдээ нэгтгэгдэг тул салангид үйл ажиллагааны сегментийн санхүүгийн мэдээлэл байхгүй болно. Тиймээс үйл ажиллагааны сегменттэй холбоотой мэдээлэл тусгагдаагүй болно. Группийн үндсэн үйл ажиллагаа болон үйлчлүүлэгчид нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байршсан тул газар зүйн сегментийн мэдээлэл мөн тусгагдаагүй болно. 2020 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд Группийн орлогын 10 өөс түүнээс дээш хувийг дангаараа бүрдүүлсэн харилцагч байгаагүй.

| | 2020<br>мян.төг | 2019<br>мян.төг |
|---|---|---|
| **Хүүгийн орлого** | | |
| Банкинд байршуулсан харилцах, хадгаламжийн хүү | 332,619 | 202,402 |
| Үнэт цаас гаргасны хүүгийн орлого | 231,524 | - |
| **ЛэндМН шимтгэлийн орлого** | | |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа - ЛэндМН систем | 15,813,659 | 18,118,680 |
| **Нийт хүү болон түүнтэй адилтгах цэвэр орлого** | **16,377,802** | **18,321,082** |
| **Хүүгийн зардал** | | |
| Зээлийн хүүгийн зардал | (4,583,965) | (4,467,133) |
| Түрээсийн өглөгийн хүүгийн зардал (Тод. 17) | (139,545) | (167,108) |
| **Нийт хүү болон түүнтэй адилтгах зардал** | **(4,723,510)** | **(4,634,241)** |

ЛэндМН шимтгэлийн орлого нь ЛэндМН системээр олгогдож байгаа зээлийн нэг удаагийн шимтгэлийн орлогыг илэрхийлдэг. Энэхүү шимтгэлийн орлого нь СТОУС-ын дагуу үр ашигт хүүгийн нэг хэсэг бөгөөд тухайн зээлийн гэрээний хугацааны туршид хүлээн зөвшөөрөгддөг.

**6 Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдал**

Дараах хүснэгтэнд ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдсөн, санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлын зардлыг үзүүлэв:

| | 2020<br>мян.төг | 2019<br>мян.төг |
|---|---|---|
| **Үнэ цэнийн бууралтын алдагдал** | | |
| Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдал (Тод. 12) | 2,393,273 | 1,592,096 |
| Олгохоор баталсан зээлийн үүргийн үнэ цэнийн бууралтын алдагдал (Тод. 19) | (32,592) | 26,706 |
| **Нийт үнэ цэнийн бууралтын алдагдал** | **2,360,681** | **1,618,802** |

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 №1152267206



УЛААНБААТАР ХОТ
ЭЗЭРЖИД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
он сар өдөр
2021.06.23
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



## 7 Удирдлага болон үйл ажиллагааны зардал

| | 2020 мян.төг | 2019 мян.төг |
|---|---|---|
| Цалингийн зардал | 2,070,104 | 1,862,989 |
| ЛэндМН системийн техник үйлчилгээний зардал (Тод. 24) | 1,144,609 | 1,362,523 |
| Мэргэжлийн үйлчилгээний зардал | 1,079,054 | 302,823 |
| Түрээсийн болон үндсэн хөрөнгийн элэгдэл (Тод. 16 ба Тод. 17) | 360,961 | 321,072 |
| Зар сурталчилгаа, маркетингийн зардал | 275,827 | 625,745 |
| Банкны шимтгэл | 186,310 | 476,524 |
| Нийгмийн даатгалын шимтгэл | 122,652 | 229,566 |
| Биет бус хөрөнгийн хорогдол (Тод. 15) | 53,268 | 46,332 |
| Засвар үйлчилгээний зардал | 8,190 | 35,360 |
| Түрээсийн зардал | - | 19,404 |
| Бусад зардал | 437,075 | 262,787 |
| **Нийт удирдлага болон үйл ажиллагааны зардал** | **5,738,460** | **5,565,125** |

## 8 Бусад орлого/(зардал), цэвэр дүнгээр

| | 2020 мян.төг | 2019 мян.төг |
|---|---|---|
| Данснаас хассан зээлийн эргэн төлөлтөөс олсон олз | 91,354 | - |
| Түрээсийн хөнгөлөлтийн орлого | 37,817 | - |
| Бусад орлого | 4,730 | 13,313 |
| Бусад зардал | (126,585) | (182,213) |
| Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус алдагдал, цэвэр | (269,253) | (197,265) |
| Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн бодит алдагдал, цэвэр | (282,542) | (216,016) |
| Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз/(гарз) | (255,191) | 130,642 |
| **Нийт бусад зардал** | **(799,670)** | **(451,539)** |

## 9 Орлогын албан татвар

### 9.1 Орлогын албан татварын зардал

Тайлант жилийн ашиг, алдагдлын тайланд тусгагдан орлогын албан татварын зардлыг доор үзүүлэв:

| | 2020 мян.төг | 2019 мян.төг |
|---|---|---|
| **Тайлант жилийн татвар:** | | |
| Тайлант жилийн орлогын албан татвар (Тод. 9.2) | 352,378 | 1,146,248 |
| **Хойшлогдсон татвар:** | | |
| Түр зөрүүгийн үүсэлтэй холбоотой (Тод. 9.3) | (29,090) | (25,062) |
| **Тайлант жилийн орлогын албан татварын зардал** | **323,288** | **1,121,186** |

Групп орлогын албан татварын зардлыг санхүүгийн тайлангийн татварын өмнөх ашгийг орлогын татвар ногдохгүй орлого болон татвар ногдуулах орлогоос хасагдахгүй зардлаар тохируулга хийх замаар тооцон бүртгэдэг. Групп нь Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу 6 тэрбум (2019: 3 тэрбум) хүртэлх төгрөгний албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 10 хувиар, 6 тэрбум (2019: 6 тэрбум) төгрөгнөөс дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар (2019: 25 хувь) орлогын албан татвар төлдөг.

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ЭРНСТ ЭНД ЯНГ КАПИТАЛ ҮЦК ХХК

СЭХ
он сар өдөр
2021.06.23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭЭ-03



**9 Орлогын албан татвар (Үргэлжлэл)**

**9.1 Орлогын албан татварын зардал (Үргэлжлэл)**

Татварын өмнөх ашгаас хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын албан татварын зардлыг Группд хүчин төгөлдөр үйлчлэх орлогын татварын хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардлын тохируулгыг дараах байдлаар үзүүлэв.

| | 2020 мян.төг | 2019 мян.төг |
|---|---|---|
| **Татварын өмнөх ашиг** | **2,755,481** | **6,031,375** |
| Хуулиар заасан 10 хувиар тооцсон татварын зардал (2019: 25%) | 275,546 | 1,507,844 |
| Татварын нөлөө: | | |
| - Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал | 36,711 | 93,702 |
| - Тусгайлсан хувь хэмжээтэй татвар | - | (30,360) |
| - 25 хувиас бага хувиар тооцсон татварын нөлөө | - | (450,000) |
| - Нягтлан бодох бүртгэлийн ашиг болон татварын зардал (орлого) хоорондын тохируулгын бусад татварын нөлөө | 11,029 | - |
| **Тайлант жилийн орлогын албан татварын зардал** | **323,288** | **1,121,186** |

Группийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн орлогын албан татварын бодит хувь нь 11.70% (2019: 18.60%) байсан.

**9.2 Орлогын албан татварын өглөг/(авлага)**

| | 2020 мян.төг | 2019 мян.төг |
|---|---|---|
| **1-р сарын 1-ний байдлаар** | **151,395** | **7,690** |
| Тайлант жилийн орлогын албан татварын зардал (Тод. 9.1) | 352,378 | 1,146,248 |
| Тайлант жилийн орлогын албан татварын төлөлт | (577,559) | (1,002,543) |
| **12-р сарын 31-ний байдлаар** | **(73,786)** | **151,395** |

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ф.11 8267206

2021/05/24



УЛААНБААТАР ХОТ
ЭРНСТ ЭНД ЯНГ ЭНД КО
КАПИТАЛ ҮЦК
ХХК
5183855
9021031119 СТС2420

**9 Орлогын албан татвар (Үргэлжлэл)**

**9.3 Хойшлогдсон татварын үлдэгдэл**

Хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийг гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө болон өр төлбөрөөс үүссэн ханшийн бодит бус зөрүү, санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнийн өөрчлөлт болон түрээсийн хөрөнгийн элэгдэл, түүний хуримтлагдсан хүүний зардал зэргээс үүссэн татвар ногдох хугацааны зөрүү болон татварын хасагдах зардал зэргээс тооцож бүртгэсэн.

| 2020 | Эхний үлдэгдэл мян.төг | Ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдсөн мян.төг (Тод. 9.1) | Эцсийн үлдэгдэл мян.төг |
|---|---|---|---|
| **Хойшлогдсон татварын хөрөнгө:** | | | |
| Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус алдагдал | 34,977 | (16,694) | 18,283 |
| Түрээсийн хөрөнгийн элэгдэл болон хүүний зардал | 13,209 | (2,640) | 10,669 |
| Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн алдагдал | - | 12,455 | 12,455 |
| Ирээдүйн татвар ногдох орлоготой цэвэрлүүлэх татварын алдагдал | - | 12,745 | 12,745 |
| | **48,186** | **5,966** | **54,152** |
| **Хойшлогдсон татварын өглөг:** | | | |
| Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз | (23,124) | 23,124 | - |
| | **(23,124)** | **23,124** | - |
| **Хойшлогдсон татварын хөрөнгө** | **25,062** | **29,090** | **54,152** |
| **2019** | | | |
| **Хойшлогдсон татварын хөрөнгө:** | | | |
| Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус алдагдал | - | 34,977 | 34,977 |
| Түрээсийн хөрөнгийн элэгдэл болон хүүний зардал | - | 13,209 | 13,209 |
| | - | **48,186** | **48,186** |
| **Хойшлогдсон татварын өглөг:** | | | |
| Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз | - | (23,124) | (23,124) |
| | - | **(23,124)** | **(23,124)** |
| **Хойшлогдсон татварын хөрөнгө** | - | **25,062** | **25,062** |

СЗХ
он сар өдөр
2021 .06. 23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18
БҮРТГЭВ-03



**10 Нэгж хувьцаанд ногдох ашиг**

Группд шингэрүүлэх боломжтой энгийн хувьцаа байхгүй учир нэгж хувьцаанд ногдох үндсэн болон шингэрүүлсэн ашгийн дүн тэнцүү болно.

| | 2020 | 2019 |
|---|---|---|
| **Тайлант жилийн цэвэр ашиг буюу Группийн хувьцаа эзэмшигчдэд ногдох нийт дэлгэрэнгүй орлого (мян.төг)** | 2,432,193 | 4,910,189 |
| Нэгж хувьцаанд ногдох үндсэн болон шингэрүүлсэн ашгийг тооцоолоход ашиглах энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоо* | 795,712,773 | 797,458,537 |
| **Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөг)** | **3.06** | **6.16** |

| **Нэгж хувьцаанд ногдох ашиг** | **2020 төг** | **2019 төг** |
|---|---|---|
| Группийн хувьцаа эзэмшигчдийн тайлант хугацааны: | | |
| Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг | 3.06 | 6.16 |
| Нэгж хувьцаанд ногдох шингэрүүлсэн ашиг | 3.06 | 6.16 |

*Энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд тайлант хугацаанд халаасласан хувьцааны нөлөөллийг харгалзан үзсэн. Тодруулга 20.2-ыг харна уу.

**11 Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө**

| | 2020.12.31 мян.төг | 2019.12.31 мян.төг |
|---|---|---|
| Кассанд байгаа бэлэн мөнгө | 111 | 914 |
| Банкны харилцах данс | 10,347,990 | 2,381,282 |
| **Нийт мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө** | **10,348,101** | **2,382,196** |
| (-) Лэнд хэтэвчинд байршуулсан харилцагчдын мөнгө (Тод. 19) | (846,584) | (964,265) |
| **Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор тайлагнасан нийт мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө** | **9,501,517** | **1,417,931** |

Банкин дахь мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө нь Монголын арилжааны банкуудад байршуулсан харилцах дансууд бөгөөд барьцаанд тавиагүй болно. Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн дансны дүн нь бодит үнэ цэнэтэй ойролцоо. 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар банкны харилцах дансан дахь мөнгөн хөрөнгийн жилийн хүү нь 0.0%-9.00% байна (2019: 0.0%-9.75%).

Групп 2020 оны 12 дугаар сарын 31 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр СТОУС 9-ийн дагуу мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөнд үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын сан тооцоолсон. Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгүүдийн ихэнхи нь харилцах данс, хугацаагүй хадгаламж учир ЗҮЦХА нь материаллаг бус дүнтэй гэж тооцоолон дүгнэсэн. Тиймээс Групп 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нэгтгэсэн санхүүгийн тайланд мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын сан байгуулаагүй.

Харилцагч тус бүрийн хэтэвч дэх бэлэн мөнгөний үлдэгдлийг хэзээ ч ашиглахад бэлэн байлгах зорилгоор Групп санхүүжилтийн эх үүсвэр болгож ашиглах боломжгүй байдаг учраас энэхүү хөрөнгийг мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөөд тусад нь бүртгэдэг. 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хэтэвч дэх мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө нь 846,584 мянган төгрөг (2019: 964,265 мянган төгрөг) байсан.

ЛэндМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1116267206

2021/05/24



УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ
№ 04

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



## 12 Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа

| | 2020.12.31 мян.төг | 2019.12.31 мян.төг |
|---|---|---|
| ЛэндМН системээр олгосон зээл | 28,774,338 | 51,009,394 |
| Хасах нь: ЗҮЦХА-ын сан | (3,343,378) | (1,551,718) |
| **Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа** | **25,430,960** | **49,457,676** |

Группийн бизнесийн загварын дагуу ЛэндМН технологийг ашиглан зээл авсан зээлдэгчид нь богино хугацаанд санхүүгийн хэрэгцээгээ санхүүжүүлэх зорилготой хувь хүмүүс байдаг.

Групп нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 2.7 тэрбум төгрөгийн (2019: 10.4 тэрбум төгрөг) хэвийн зээлийн багцыг зээлийн шугам болон бусад санхүүгийн байгууллагаас авсан зээлийн барьцаанд байршуулсан. Тодруулга 18-ыг харна уу.

**Ковид-19 нөлөө**

Групп цар тахлын үед зээлийн багцыг удирдах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн:

- Групп 2020 оны 4 дүгээр сард зээл олголтыг бүрэн зогсоож, харилцагчдыг зээлийн үлдэгдлээ бүрэн төлж барагдуулах хүсэлт гаргасан ба харилцагчдын хамгийн сүүлийн үеийн санхүүгийн мэдээлэлд үндэслэн харилцагчдын зээлжих түвшинийг дахин үнэлсэн. Хугацаа хэтэрсэн харилцагчдын зээлийн эрхийг түдгэлзүүлсэн. Групп 2020 оны 6 дугаар сараас эхлэн зээл олгож эхэлсэн.
- Групп 15 өдөр хугацаа хэтэрсэн зээлүүдийн зээлийн эрхийг цуцалсан.
- Групп үндсэн зээлийн 10 хувь болон зээлийн хүүг бүрэн төлсөн харилцагчдад зээлийн хугацааг сунгах сонголтыг санал болгосон.

### 12.1 Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сан

Групп нь харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдлыг СТОУС 9-ийн дагуу тооцоолсон. Ерөнхий аргачлалын дагуу Групп зээлийн багцаа Шатлал 1, 2 болон 3 гэж дараах байдлаар ангилж, магадлалаар жигнэсэн ирээдүйг таамагласан ЧМ болон АХЧ-ыг шатлал тус бүрт тооцоолсон. ЗҮЦХА-ын сангийн бодлого болон тооцооллын дэлгэрэнгүйг Тодруулга 21.3-т тайлбарлав.

Шатлал 1: Хэвийн зээлийн багц болон • 31-ээс бага хоног хугацаа хэтэрсэн зээлийн багц
Шатлал 2: 31-90 хоног хугацаа хэтэрсэн зээлийн багц
Шатлал 3: 90-ээс дээш хоног хугацаа хэтэрсэн зээлийн багц

2020 оны 12 дугаар сарын 31 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар шатлал бүрээр тооцсон харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтын санг доор үзүүлэв:

| ЗҮЦХА | Зээлийн үлдэгдэл | Ирээдүйн ЧМ | Ирээдүйн АХЧ | ЗҮЦХА-ын сан |
|---|---|---|---|---|
| **2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар** | | | | |
| Шатлал 1 | 24,129,938 | 1.46% | 69.38% | 244,828 |
| Шатлал 2 | 1,423,467 | 87.47% | 69.38% | 863,863 |
| Шатлал 3 | 3,220,933 | 100.00% | 69.38% | 2,234,687 |
| | **28,774,338** | | | **3,343,378** |
| **2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар** | | | | |
| Шатлал 1 | 48,210,148 | 0.77% | 56.22% | 208,775 |
| Шатлал 2 | 978,532 | 58.26% | 56.22% | 320,154 |
| Шатлал 3 | 1,820,714 | 100.00% | 56.22% | 1,022,789 |
| | **51,009,394** | | | **1,551,718** |

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24



УЛААНБААТАР ХОТ
ЭРНСТ ЭНД ЯНГ КО
КАПИТАЛ ҮЦК
ХХК
5183855

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



**12 Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа (Үргэлжлэл)**

**12.1 Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сан (Үргэлжлэл)**

Нийт зээлийн багцын эрсдэлийн чанарыг доорх хүснэгтэд үзүүлэв.

| | Шатлал 1<br>мян.төг | Шатлал 2<br>мян.төг | Шатлал 3<br>мян.төг | Нийт<br>мян.төг |
|---|---|---|---|---|
| **2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар** | | | | |
| Хэвийн зээл | 24,129,938 | - | - | 24,129,938 |
| Хэвийн бус зээл | - | 1,423,467 | 3,220,933 | 4,644,400 |
| **Нийт** | **24,129,938** | **1,423,467** | **3,220,933** | **28,774,338** |
| **2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар** | | | | |
| Хэвийн зээл | 48,210,148 | - | - | 48,210,148 |
| Хэвийн бус зээл | - | 978,532 | 1,820,714 | 2,799,246 |
| **Нийт** | **48,210,148** | **978,532** | **1,820,714** | **51,009,394** |

Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны нийт дансны дүн болон холбогдох ЗҮЦХА-ын сангийн өөрчлөлтийн дэлгэрэнгүйг доор үзүүлэв:

| | Шатлал 1<br>мян.төг | Шатлал 2<br>мян.төг | Шатлал 3<br>мян.төг | Нийт<br>мян.төг |
|---|---|---|---|---|
| **2020 оны 1-р сарын 1-нээрх зээлийн нийт дансны дүн** | **48,210,148** | **978,532** | **1,820,714** | **51,009,394** |
| Шинээр олгосон эсвэл худалдан авсан зээл | 213,964,654 | - | - | 213,964,654 |
| Үл хүлээн зөвшөөрсөн эсвэл эргэн төлөгдсөн зээл | (219,063,280) | (8,358,197) | (8,176,620) | (235,598,097) |
| Шатлал 2-т орсон шилжилт | (18,981,584) | 18,981,584 | - | - |
| Шатлал 3-т орсон шилжилт | - | (10,178,452) | 10,178,452 | - |
| Данснаас хассан | - | - | (601,613) | (601,613) |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх** | **24,129,938** | **1,423,467** | **3,220,933** | **28,774,338** |

| | Шатлал 1<br>мян.төг | Шатлал 2<br>мян.төг | Шатлал 3<br>мян.төг | Нийт<br>мян.төг |
|---|---|---|---|---|
| **2019 оны 1-р сарын 1-нээрх зээлийн нийт дансны дүн** | **19,019,885** | **259,329** | **363,708** | **19,642,922** |
| Шинээр олгосон эсвэл худалдан авсан зээл | 439,329,846 | - | - | 439,329,846 |
| Үл хүлээн зөвшөөрсөн эсвэл эргэн төлөгдсөн зээл | (407,194,307) | (151,800) | (133,333) | (407,479,440) |
| Шатлал 2-т орсон шилжилт | (2,945,276) | 2,945,276 | - | - |
| Шатлал 3-т орсон шилжилт | - | (2,074,273) | 2,074,273 | - |
| Данснаас хассан | - | - | (483,934) | (483,934) |
| **2019 оны 12-р сарын 31-нээрх** | **48,210,148** | **978,532** | **1,820,714** | **51,009,394** |

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ



2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК
ХХК
164

СЗХ
2021.06.23
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-05-18
БҮРТГЭВ-03



**12 Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа (Үргэлжлэл)**

**12.1 Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сан (Үргэлжлэл)**

| | Шатлал 1<br>мян.төг | Шатлал 2<br>мян.төг | Шатлал 3<br>мян.төг | Нийт<br>мян.төг |
|---|---|---|---|---|
| **2020 оны 1-р сарын 1-нээрх ЗҮЦХА-ын сан** | **208,775** | **320,154** | **1,022,789** | **1,551,718** |
| Шинээр олгосон эсвэл худалдан авсан зээл | 2,170,934 | - | - | 2,170,934 |
| Үл хүлээн зөвшөөрсөн эсвэл эргэн төлөгдсөн зээл | (2,222,666) | (5,072,363) | (5,672,950) | (12,967,979) |
| Шатлал 2-т орсон шилжилт | (192,591) | 192,591 | - | - |
| Шатлал 3-т орсон шилжилт | - | (6,177,027) | 6,177,027 | - |
| Тайлант хугацааны туршид шатлал хооронд шилжсэн ЗҮЦХА-д орсон нөлөө болон ЗҮЦХА-ын тооцоололд ашигласан өгөгдлүүдийн өөрчлөлт | 280,376 | 11,600,508 | 1,309,434 | 13,190,318 |
| Данснаас хассан | - | - | (601,613) | (601,613) |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх** | **244,828** | **863,863** | **2,234,687** | **3,343,378** |
| | | | | |
| **2019 оны 1-р сарын 1-нээрх ЗҮЦХА-ын сан** | **100,125** | **106,021** | **237,410** | **443,556** |
| Шинээр олгосон эсвэл худалдан авсан зээл | 1,902,524 | - | - | 1,902,524 |
| Үл хүлээн зөвшөөрсөн эсвэл эргэн төлөгдсөн зээл | (1,763,360) | (49,666) | (74,901) | (1,887,927) |
| Шатлал 2-т орсон шилжилт | (12,755) | 12,755 | - | - |
| Шатлал 3-т орсон шилжилт | - | (678,656) | 678,656 | - |
| Тайлант хугацааны туршид шатлал хооронд шилжсэн ЗҮЦХА-д орсон нөлөө болон ЗҮЦХА-ын тооцоололд ашигласан өгөгдлүүдийн өөрчлөлт | (17,759) | 929,700 | 665,558 | 1,577,499 |
| Данснаас хассан | - | - | (483,934) | (483,934) |
| **2019 оны 12-р сарын 31-нээрх** | **208,775** | **320,154** | **1,022,789** | **1,551,718** |

Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сангийн хөдөлгөөнийг доор үзүүлэв.

| | 2020.12.31<br>мян.төг | 2019.12.31<br>мян.төг |
|---|---|---|
| **1 дүгээр сарын 1-ний байдлаар** | **1,551,718** | **443,556** |
| **Тайлант жилд байгуулсан (Тод. 6)** | **2,393,273** | **1,592,096** |
| **Тайлант жилд хасагдсан** | **(601,613)** | **(483,934)** |
| **12 дугаар сарын 31-ний байдлаар** | **3,343,378** | **1,551,718** |

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 Д.1118267205



2021/05/24
УЛААНБААТАР ХОТ
ЭРДЭНЭ ЗИНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
165

СЗХ
2021.06.23
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭЛ-03



**13 Санхүүгийн үүсмэл хэрэглүүр**

Тодруулга 2 буюу нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын товчоо хэсэгт тайлбарласнаар Групп гадаад валютын ханшийн эрсдэлийг удирдлах зорилгоор санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн хэлцэл хийсэн. Эрсдэлийн удирдлагын зорилгоор эзэмшиж буй үүсмэл хэрэглүүрт гадаад валютын арилжааны своп хэлцэл багтах ба уг хэлцэл нь хэйджийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагыг хангаагүй. Доорх хүснэгтэд хөрөнгө/өр төлбөрөөр бүртгэгдсэн санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнэ болон нэрлэсэн үнийн дүнг харуулав. Нэрлэсэн үнэ нь тухайн үүсмэл хэрэглүүрийн хөрөнгө/өр төлбөрийн дүн, стандарт хүүний түвшин эсвэл үнийн индексийн нийт дүн бөгөөд үүсмэл хэрэгслийн үнэ цэнийн өөрчлөлтийг хэмжих суурь нь болж өгдөг. Нэрлэсэн үнийн дүн нь жилийн эцсийн байдлаарх дуусаагүй ажил гүйлгээний дүн бөгөөд зах зээлийн эрсдэл болон зээлийн эрсдэлийн аль аль нь ч харуулахгүй.

| Үүсмэл хэрэглүүр | Хөрөнгийн бодит үнэ цэнэ мян.төг | Өр төлбөрийн бодит үнэ цэнэ мян.төг | Нэрлэсэн дүн мян.төг |
|---|---|---|---|
| **2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар** | | | |
| Гадаад валютын арилжааны своп хэлцэл | - | (124,549) | 4,901,157 |
| **2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар** | | | |
| Гадаад валютын арилжааны своп хэлцэл | 130,642 | - | 9,621,990 |

Групп 2020 оны 6 дугаар сар болон 2020 оны 12 дугаар сард (2019: 2019 оны 11 дүгээр сар) банктай гадаад валютын арилжааны богино хугацаат своп хэлцлүүд хийж эхэлсэн. Группийн богино хугацаат ам.доллар/төгрөгийн своп хэлцлүүд нь 6-аас 12 сарын (2019: 6-аас 8 сар) хугацаатай. Своп хэлцэл нь гадаадын санхүүгийн байгууллагуудаас авсан ам.долларын зээлийн мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг зохицуулах, ханшийн эрсдэлээс хамгаалах зорилготой юм. 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Групп нийт 1,720,000 ам.доллар буюу 4,901,157 мянган (2019: 7,580,000 мянган ам.доллар буюу 9,621,990 мянган төгрөг) төгрөгийн нэрлэсэн үнэтэй богино хугацаат гадаад валютын своп хэлцлүүдийг арилжааны банктай хийсэн.

Групп эхлээд ам.долларыг байршуулж, оронд нь гэрээнд тохиролцсон суурь ханшнаас 2-оос 3 хувиар бага хөрвүүлсэн үнийн дүн бүхий төгрөгийг хүлээн авах ба гэрээний хугацаа дуусах үед тохиролцсон 2,985.06 төгрөг болон 3,048.72 төгрөгийн форвард ханшаар (2019: 2,623.19 төгрөг, 2623.92 төгрөг, 2,645.43 болон 2,649.32 төгрөг) төгрөгийг байршуулаад, оронд нь ам.доллар авах нөхцөлтэй. Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийн талаар Тодруулга 23-аас харна уу. Эрсдэлийн удирдлагын бодлого болоод эрсдэлийг удирдахад уг бодлогыг хэрхэн хэрэгжүүлдэг талаар Тодруулга 21-ээс харна уу.

**14 Бусад хөрөнгө**

| | 2020.12.31 мян.төг | 2019.12.31 мян.төг |
|---|---|---|
| Хугацаатай хадгаламж | 2,849,510 | 4,373,632 |
| Бусад авлага | 393,379 | 165,500 |
| Хангамжийн материал | 29,861 | 30,324 |
| Бусад татварын авлага | 1,443 | 1,859 |
| **Нийт бусад хөрөнгө** | **3,274,193** | **4,571,315** |

2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх хугацаатай хадгаламж нь Худалдаа Хөгжлийн Банкинд байршуулсан 1,000,000 ам.долларын (2019: 1,600,000 ам.доллар), жилийн 5.4%-ийн хүүтэй, 2021 оны 4 дүгээр сарын 29-нд хугацаа дуусах богино хугацаат хадгаламжийг илэрхийлнэ. Бусад авлагын дунд 101,598 мянган төгрөгийн (2019: 127,479 мянган төгрөг) хугацаатай хадгаламжийн хуримтлагдсан хүүний авлага, 240,879 мянган төгрөгийн (2019: 0) гуравдагч талаас авах авлага багтсан. Гуравдагч талаас авах бусад авлагын эргэн төлөгдөх магадлалыг зээлдэгчийн зээлийн түүхийг үндэслэн үнэлсэн ба 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх ЗҮЦХА-ын хамжээг материаллаг бус гэж үзсэн.

ЛЭНДМН ББСБ ХК
Lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ☏ 11 267206



2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ОПИНИОН ОДИТ КО
КАПИТАЛ ҮЦК
ХХК
5183855
2021031195 СТ02420

### 14 Бусад хөрөнгө (Үргэлжлэл)

Групп СТОУС 9-ын дагуу 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх хугацаатай хадгаламжийн хүлээгдэж буй үнэ цэнийн алдагдлын хэмжээг тооцсон. Хугацаатай хадгаламжийг барьцаалан арилжааны банкнаас зээл авсан. Тодруулга 18 (ii)-аас харна уу. Групп уг хугацаатай хадгаламжаас чанаргүйдэлд өртөх дүн байхгүй гэж үзсэн учраас хүлээгдэж буй үнэ цэнийн алдагдлын хэмжээг материаллаг бус гэж үзсэн. Иймд, Групп 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн тайланд хугацаатай хадгаламжийн хүлээгдэж буй үнэ цэнийн алдагдал хүлээн зөвшөөрөөгүй.

### 15 Биет бус хөрөнгө

| | 2020<br>мян.төг | 2019<br>мян.төг |
|---|---|---|
| **Өртөг** | | |
| 1-р сарын 1-нээр | 457,014 | 456,464 |
| Нэмэгдсэн | 114,399 | 550 |
| **12-р сарын 31-нээр** | **571,413** | **457,014** |
| **Хуримтлагдсан хорогдол** | | |
| 1-р сарын 1-нээр | 115,012 | 68,680 |
| Тайлант жилийн хорогдол (Тод. 7) | 53,256 | 46,332 |
| 12-р сарын 31-нээр | 168,267 | 115,012 |
| **Дансны цэвэр дүн** | **403,145** | **342,002** |

Группийн биет бус хөрөнгө нь зэргэлдээ охин компани болох Анд Системс Тех-ээс худалдаж авсан зээлийн үйл ажиллагаа явуулах болон хэтэвчний гүйлгээ хийх зориулалт бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглах ЛэндМН технологийн тусгай эрхийн лицензээс бүрдэнэ. Харилцагч бүртгэх, харилцагч үнэлэх, зээлийн шийдвэр гаргах, зээл олгох, төлөлт хийх, тайлагнах, харилцагчид техникийн туслалцаа үйлчилгээ үзүүлэх модулиуд болон ЛэндМН аппликэйшнээс бүрдэх ЛэндМН зээлийн технологийн лицензийг анх 2016 оны 12 сард Анд Системс Тех-ээс худалдан авсан. ЛэндМН системийн тусгай лицензийг анхад 1 удаа 300,000 мянган төгрөг төлсөн. Тайлант хугацаанд Групп Монгол Банкнаас Имоней (Emoney) гаргах үйлчилгээний лицензийг 100,000 мянган төгрөгөөр худалдан авсан.

Цахим хэтэвч үйлчилгээг нэвтрүүлэхтэй холбоотойгоор Групп 2018 оны 11 дүгээр сарын 1-нд холбоотой тал болох Анд Системс Тех-тэй гэрээ байгуулан, хэтэвчтэй холбоотой бүх төрлийн гүйлгээ хийх цахим хэтэвч аппликэйшныг ашиглах тусгай эрхийг худалдан авсан. Цахим хэтэвч аппликэйшн нь зээлийн бүх үндсэн функцийг агуулсан, зээлийн аппликэйшны сайжруулсан хувилбар юм. ЛэндМН цахим хэтэвчийг ашиглах тусгай эрхийг анхад 1 удаа 150 сая төгрөг төлсөн байна.

Талууд харилцан тохиролцсон эсвэл Группийн зээл олгох тусгай зөвшөөрөл цуцлагдсанаас бусад тохиолдолд дээр дурдсан хоёр тусгай эрхийг эзэмших гэрээнүүд цуцлагдахгүй. Лицензийн хугацаа хязгааргүй ч 50 жил боловч удирдлага лицензийн ашиглалтын хугацааг 10 жил гэж дүгнэж байгаа тул ЛэндМН технологийн лицензийг 10 жилээр, цахим хэтэвч аппликэйшныг ЛэндМН технологийн лицензийн үлдсэн ашиглалтын хугацаанд хорогдуулан бүртгэсэн.

СЗХ
2021 06 23
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05- 18



**16 Үндсэн хөрөнгө**

| | Тавилга, оффисын хэрэгсэл, тээврийн хэрэгсэл мян.төг | Компьютер, тоног төхөөрөмж мян.төг | Оффисын сайжруулалт мян.төг | Нийт мян.төг |
|---|---|---|---|---|
| **2020 оны 12 дугаар сарын 31** | | | | |
| **Өртөг** | | | | |
| **2020 оны 1-р сарын 1-нээр** | 106,438 | 258,194 | 180,448 | 545,080 |
| Нэмэгдсэн | 185,290 | 104,585 | 19,988 | 309,863 |
| **2020 оны 12-р сарын 31-нээр** | **291,728** | **362,779** | **200,436** | **854,943** |
| **Хуримтлагдсан элэгдэл** | | | | |
| **2020 оны 1-р сарын 1-нээр** | 18,512 | 116,489 | 24,197 | 159,198 |
| Тайлант жилийн элэгдэл (Тод. 7) | 27,763 | 91,567 | 39,159 | 158,489 |
| **2020 оны 12-р сарын 31-нээр** | **46,275** | **208,056** | **63,356** | **317,687** |
| **Дансны цэвэр дүн** | **245,453** | **154,723** | **137,080** | **537,256** |
| **2019 оны 12 дугаар сарын 31** | | | | |
| **Өртөг** | | | | |
| **2019 оны 1-р сарын 1-нээр** | 60,695 | 146,239 | 123,310 | 330,244 |
| Нэмэгдсэн | 45,743 | 111,955 | 180,448 | 338,146 |
| Борлуулсан | - | - | (123,310) | (123,310) |
| **2019 оны 12-р сарын 31-нээр** | **106,438** | **258,194** | **180,448** | **545,080** |
| **Хуримтлагдсан элэгдэл** | | | | |
| **2019 оны 1-р сарын 1-нээр** | 8,643 | 44,199 | 19,351 | 72,193 |
| Тайлант жилийн элэгдэл (Тод. 7) | 9,869 | 72,290 | 36,421 | 118,580 |
| Борлуулсан | - | - | (31,575) | (31,575) |
| **2019 оны 12-р сарын 31-нээр** | **18,512** | **116,489** | **24,197** | **159,198** |
| **Дансны цэвэр дүн** | **87,926** | **141,705** | **156,251** | **385,882** |

Үндсэн хөрөнгийн өртөгт капиталжуулсан зээлийн хүүний зардал байхгүй. Мөн Групп ер төлбөрийн барьцаанд тавьсан үндсэн хөрөнгө байхгүй.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118967206

2021/05/24



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК
168
5183855
9021031196 СТС2420

СЭХ
он сар өдөр
2021 +06 12 э В
№ 01

2021 ... 10
ВГ ... 03



## 17 Түрээс

Групп 2018 оны 10 дугаар сард шинэ оффисийн түрээсийн гэрээг 5 жилийн хугацаатай байгуулсан. Группийн түрээсийн гэрээгээр хүлээсэн үүрэг нь түрээслүүлэгчийн түрээслүүлсэн хөрөнгийн өмчлөлөөр баталгаажсан. Гэрээний дагуу Групп түрээсийн гэрээг өөр этгээдэд шилжүүлэх болон дахин түрээслүүлэх хориотой. Групп түрээсийн гэрээний хугацааг урьдчилгаа төлбөр төлж, мэдэгдэл өгөлгүйгээр дахин 2 жилээр сунгах сонголттой. Мөн Групп түрээсийн хугацаа дуусахаас 2 сарын өмнө урьдчилан мэдэгдэж, гэрээг нэмэлт төлбөргүй цуцлах боломжтой.

Тайлант хугацаанд хүлээн зөвшөөрсөн ашиглах эрх бүхий хөрөнгө болон түүний хөдөлгөөний дүнг доорх хүснэгтэд харуулав:

| | 2020<br>мян.төг | 2019<br>мян.төг |
|---|---|---|
| **1 дүгээр сарын 1-нээр** | **776,219** | **978,711** |
| Элэгдлийн зардал (Тод. 7) | (202,492) | (202,492) |
| **12-р сарын 31-нээр** | **573,727** | **776,219** |

Тайлан хугацааны түрээсийн өглөг болон хөдөлгөөнийг доорх хүснэгтэд харуулав:

| | 2020<br>мян.төг | 2019<br>мян.төг |
|---|---|---|
| **1 дүгээр сарын 1-нээр** | 850,844 | 978,711 |
| Хүүгийн зардал (Тод. 5) | 139,545 | 167,108 |
| Түрээсийн төлбөр | (272,155) | (294,975) |
| Түрээсийн хөнгөлөлт (Тод. 8) | (37,817) | - |
| **12-р сарын 31-нээр** | **680,417** | **850,844** |
| | | |
| Богино хугацаат | 203,766 | 170,427 |
| Урт хугацаат | 476,651 | 680,417 |

2020 онд Групп нь түрээслэгчээс үзүүлсэн хөнгөлөлтийн дагуу 37,817 мянган төгрөгийн түрээсийн хөнгөлөлтөөс үүссэн олзыг хүлээн зөвшөөрсөн.

Түрээсийн өр төлбөрийн дуусах хугацааны шинжилгээг Тодруулга 21.4-т толилуулсан.

## 18 Зээл

**2020 оны 12 дугаар сарын 31**

| | | Жилийн хүү | Богино хугацаат | мян.төг<br>Урт хугацаат | Нийт |
|---|---|---|---|---|---|
| Бонд | (i) | 17% | 5,311,870 | - | 5,311,870 |
| Хаалттай бонд | (ii) | 9%-20% | 2,424,487 | 20,000 | 2,444,487 |
| Зээл | (iii) | 15.6%-24.4% | 2,873,336 | - | 2,873,336 |
| Итгэлцлийн үйлчилгээ | (iv) | 9%-20% | 8,815,117 | 1,670,790 | 10,485,907 |
| Нийт зээл | | | **19,424,810** | **1,690,790** | **21,115,600** |

**2019 оны 12 дугаар сарын 31**

| | | Жилийн хүү | Богино хугацаат | мян.төг<br>Урт хугацаат | Нийт |
|---|---|---|---|---|---|
| Хаалттай бонд | (ii) | 11.24%-18.5% | 2,507,756 | 1,093,408 | 3,601,164 |
| Зээл | (iii) | 11.1%-19.2% | 18,333,646 | 2,800,000 | 21,133,646 |
| Итгэлцлийн үйлчилгээ | (iv) | 10%-19% | 11,633,883 | 2,211,329 | 13,845,212 |
| Нийт зээл | | | **32,475,285** | **6,104,737** | **38,580,022** |

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 ... 118267206

2021/05/24

37
УЛААНБААТАР ХОТ
... КАПИТАЛ ХХК
5182855
9921031195 СТС2420

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



**18 Зээл (Үргэлжлэл)**

(i) 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Групп өөрийн хувьцааг барьцаалан МХБ дээр жилийн 17 хувийн хүүтэй, нэгж нь 100 мян.төгрөгийн нэрлэсэн үнэтэй 50,000 ширхэг, нийт 5,000,000 мян.төгрөгийн үнэ бүхий бондыг олон нийтэд гаргасан. Уг бондын хугацаа 2021 оны 6 дугаар сарын 19-ний өдөр дуусна.

(ii) 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Групп нь нийт 686 ширхэг (2019: 2,435 ширхэг), тус бүр нь 1,000,000 (2019: 1,000,000 төгрөг) төгрөгийн нэрлэсэн үнэтэй, улирал болон хагас жил тутам хүү төлөх нөхцөлтэй, жилийн 17-20%-ийн хүүтэй (2019: 17-18.5% жилийн хүү), 2020 оны 12 дугаар сарын 11-ны өдрөөс 2021 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн хооронд 11 удаагийн эргэн төлөлт хийгдэх хаалттай бонд гаргасан. Групп мөн нийт 595 ширхэг (2019: 4 ширхэг), тус бүр нь 1,000 ам.долларын (2019: 100,000 ам.доллар) нэрлэсэн үнэтэй, улирал болон хагас жил тутам хүү төлөх нөхцөлтэй, жилийн 9-11.8%-ийн хүүтэй (2019: 11.24% жилийн хүү), 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хооронд 5 удаагийн эргэн төлөлт хийгдэх хаалттай бонд гаргасан. Зарим нэг хаалттай бонд худалдан авагчдад толгой компани болох Анд Системс ХХК ("АНД Системс") нь 400,000 ам долларын төлбөрийн баталгаа гаргасан.

(iii) Групп 2018 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр 1,200,000 мян.төгрөгийн харилцагчдад олгосон зээл буюу урьдчилгааны хэвийн багц болон арилжааны банкинд байршиx харилцах дансдаар ирээдүйд орж ирэх 1,450,000 мян.төгрөгийн орлогоо барьцаалан Худалдаа Хөгжлийн Банкнаас 1,200,000 мян.төгрөгийн овердрафт зээлийн шугамыг авсан. 2020 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр овердрафт зээлийн хэмжээг 200 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт 1,400,000 мян.төгрөгт хүргэсэн ба дуусах хугацааг 1 жилээр сунгасан. Энэхүү зээлийн хугацаа 2021 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр дуусгавар болно. 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Групп энэхүү овердрафт зээлийг ашиглаагүй (2019: 1,118,324 мян.төг) байна.

Групп 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар арилжааны банкнуудаас нийт 2,860,000 мян.төгрөг (2019: 6,409,000 мян.төг)-ийн зээлийг 1,000,000 ам.долларын хугацаатай хадгаламжийг барьцаалж авсан. Энэхүү зээлийн хугацаа нь 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр дуусна.

Групп 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Анд Системс-ээс 5 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүнтэй, сар бүр хүү төлөх нөхцөлтэй, жилийн 24.44%-ийн хүүтэй, 2 жилийн хугацаатай буюу 2021 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хугацаа нь дуусах зээлийн шугамыг авсан. 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар энэхүү зээлийн шугамыг ашиглаагүй (2019: 2,800,000 мян.төг) байна.

2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Групп 3,796,000 мян.төгрөгийн болон 1,752,000 ам.долларын үнийн дүнтэй, улирал эсвэл хагас жил тутам хүү төлөх нөхцөлтэй, жилийн 11.1-21.11%-ийн хүүтэй, 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрөөс 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд 16 эргэн төлөлт хийгдэх зээлүүдийг Анд Системс-ээс авсан. Энэ зээл нь 2020 онд бүрэн төлөгдөж хаагдсан.

(iv) 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Групп 3,495,835 мян.төгрөгийн (2019: 4,748,000 мян.төг) үнийн дүнтэй, сар, улирал болон хагас жил тутамд итгэлцлийн өгөөж төлөх нөхцөлтэй, жилийн 17-20%-ийн (2019: 16.5-19% жилийн хүү) хүүтэй, 2021 оны 4 дүгээр сарын 29-ны өдрөөс 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хооронд 13 эргэн төлөлт хийгдэх итгэлцлийн үйлчилгээний санхүүжилтыг авсан. Мөн Групп 2,308,688 ам.долларын (2019: 3,287,470 ам.доллар) үнийн дүнтэй, сар, улирал болон хагас жил тутам хүү төлөгдөх нөхцөлтэй, жилийн 9-13.8%-ийн (2019: 10-18.57% жилийн хүү) хүүтэй, 2021 оны 4 дүгээр сарын 23-ны өдрөөс 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд 15 эргэн төлөлт хийгдэх итгэлцлийн үйлчилгээний санхүүжилтыг авсан.

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1119267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
2021031105 СТС2420

СЗХ
он сар өдөр
Б Ү 2021.06.23
№ 01

БҮРТГЭВ-03



**19 Бусад өр төлбөр**

| | 2020.12.31 мян.төг | 2019.12.31 мян.төг |
|---|---|---|
| **Бусад санхүүгийн өр төлбөр** | | |
| Хувь хүн, байгууллагад өгөх өглөг | 1,067,723 | 1,076,324 |
| Бусад өглөг | 1,081 | 168,627 |
| **Нийт** | **1,068,804** | **1,244,951** |
| | | |
| **Бусад санхүүгийн бус өр төлбөр** | | |
| Бусад татварын өглөг | 241 | - |
| Татварын болзошгүй өр төлбөрийн сан | - | 6,429 |
| Олгохоор баталсан зээлийн үүргийн үнэ цэнэ бууралтын сан (Тод. 21.3) | 13,118 | 45,710 |
| **Нийт** | **13,359** | **52,139** |
| | | |
| **Нийт бусад өр төлбөр** | **1,082,163** | **1,297,090** |

Хувь хүн, байгууллагад өгөх өглөгийн дунд мерчант буюу хувь хүн эсвэл байгууллагын цахим хэтэвчийн дансны үлдэгдэл болон өглөг болох 846,584 мянган төгрөг (2019: 964,265 мянган төгрөг) багтсан. Бусад өглөгийн үлдэгдэл дүн нь мерчантууд болон бусад талуудтай хамтарсан хамтын ажиллагаанаас үүссэн өглөгүүд болно.

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар бусад өглөгийн дунд толгой компани болох Анд Системс-д өгөх 140,000 мянган төгрөгийн ногдол ашгийн өглөг багтсан. Ногдол ашиг зарласан мэдээллийг Тодруулга 20.1-ээс харна уу.

Групп СТОУС 9-ийг хэрэгжүүлснээр зээл болох өндөр магадлалтай олгохоор батласан зээлийн үүрэгт ЗҮЦХА-ыг тооцоолсон. Олгохоор батласан зээлийн үүргийн үнэ цэнэ бууралтын сангийн хөдөлгөөнийг доор үзүүлэв:

| | 2020 мян.төг | 2019 мян.төг |
|---|---|---|
| **1 дүгээр сарын 1-нээр** | **45,710** | **19,004** |
| Олгохоор батласан зээлийн үүргийн ЗҮЦХА-ын зардал/(буцаалт) (Тод. 6) | (32,592) | 26,706 |
| **12 дугаар сарын 31-нээр** | **13,118** | **45,710** |

**20 Хувьцаат капитал болон нөөц**

**20.1 Хувьцаат капитал**

Компани нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, хязгаарлагдмал хариуцлагатай компани. Нийт зөвшөөрөгдсөн бөгөөд гаргасан энгийн хувьцааны тоо ширхэг нь 800,000,000 (2019: 800,000,000) бөгөөд нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 10 төгрөг (2019: 10 төгрөг). Гаргасан бүх хувьцаа нь бүрэн төлөгдсөн. Нэгж энгийн хувьцаа нь 1 саналын эрхтэй.

Компани 2018 оны 3 дугаар сарын 14-ны өдөр МХБ дээр нэгж нь 25 төгрөгийн үнэтэй 200,000,000 ширхэг хувьцаа шинээр гаргаж, өөрийн өмчийг 5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн.

Компанийн шууд толгой компани нь Анд Системс бөгөөд эцсийн толгой компани нь Сингапур улсад бүртгэлтэй, финтек гараан компани болох Анд Глобал Пти.Лтд.

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

2021/05/24



УЛААНБААТАР ХОТ
ЭРНСТ ЭНД ЯНГ КАПИТАЛ ҮНЭТ ЦААС ХХК
171

СЗХ
он сар өдөр
Б2021Р.06Г29В
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2021 -06- 10
БҮРТГЭВ-03



**20 Хувьцаат капитал ба нөөц (Үргэлжлэл)**

**20.1 Хувьцаат капитал (Үргэлжлэл)**

Хувьцаа эзэмшигчид болон тэдгээрийн эзэмшлийн хувийг доорх хүснэгтэд харуулав:

| | 2020.12.31 | 2019.12.31 |
|---|---|---|
| Анд Системс | 75% | 75% |
| Олон нийт | 21.5% | 24.5% |
| Халаасны хувьцаа | 3.5% | 0.5% |
| | 100% | 100% |

2020 оны 2 дугаар сард, Групп хувьцаа эзэмшигчиддээ 1,194,000 мян.төгрөгийн (2019: 800,000 мян.төг) ногдол ашиг тараахаар болсон.

**20.2 Халаасны хувьцаа**

Групп 2020 онд, 23,856,526 ширхэг хувьцааг (2019: 4,000,000 хувьцаа) нэгж бүр нь зах зээлийн дундаж ханш болох 30.30 төгрөгөөр (2019: 66.52 төгрөг нэгж хувьцаа) буюу нийт 722,853 мян.төгрөгөөр (2019: 266,086 мян.төг) 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн (2019: 2019 оны 4 дүгээр сарын 19-ний өдрөөс 2019 оны 6 дугаар сарын 21) хооронд буцаан худалдан авсан.

**20.3 Бусад нөөц сан**

Группийн эцсийн толгой компани болох Анд Глобал Пте.Лтд-с 2018 оны 6 дугаар сард Группийн гол удирдлагад хувьцаанд суурилсан урамшуулал олгосон. Групп урамшууллын төлбөрийг барагдуулах үүрэг хүлээгээгүй учир энэхүү хувьцаанд суурилсан урамшууллыг өмчөөр төлөгдөх хувьцаанд суурилсан төлбөрийн акил гүйлгээгээр бүртгэсэн. Урамшууллыг 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн жилд тодорхой заасан, зах зээлийн бус гол гүйцэтгэлийн үзүүлэлтийг хангасан, Группид үргэлжлүүлэн ажиллах буй нөхцөлд удирдлагад олгосон. Тайлант хугацаанд бусад нөөц санд ямар нэгэн өөрчлөлт ороогүй болно.

**21 Эрсдэлийн удирдлагын танилцуулга**

**21.1 Танилцуулга**

Группийн үйл ажиллагаанд учрах үндсэн эрсдэлд зээлийн эрсдэл, төлбөрийн чадварын эрсдэл, болон үйл ажиллагааны эрсдэл багтах ба уг эрсдэлүүдийг Группийн Гүйцэтгэх захирал удирдан зохицуулна. Эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь эрсдэлийг тогтмол тодорхойлж, хэмжиж, хянах ба ингэснээр эрсдэлийг хангалттай хэмжээнд нөхөх өгөөжийг өгөх бизнесийн сегментрүү хөрөнгө оруулах, Группийн хөрөнгө оруулалтын эрсдэлийг тохируулсан өгөөжийг боломжит хамгийн их хэмжээнд барих явдал юм. Эрсдэлийн удирдлагын дээрх процесс нь Группийн тогтвортой хөгжилд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд Группийн пицүүн бүр өөр өөрсдийн ажил үүргийн хүрээн дэх эрсдэлд хариуцлагатай хандах ёстой.

Бие даасан эрсдэлийн удирдлагад байгаль орчин, техник технологи болон эдийн засгийн салбарын эрсдэлүүд хамаарахгүй бөгөөд тэдгээрийг Группийн стратеги болон бизнес төлөвлөгөөгөөр зохицуулна.

Групп нь эрсдэлийн удирдлагын албан ёсны нэгдсэн бодлоготой бөгөөд энэ бодлого нь эрсдэлийг өрөлгөх бус, эрсдэл болон өгөөжийн харьцааг хамгийн ашигтай хэмжээнд барих явдал юм. Эрсдэлийн удирдлагын албан ёсны бодлоготой байснаар:

(i) Эрсдэлийг удирдах пицүүд нь эрсдэлийн удирдлагын шаардлага болон хяналтын системийн талаар бүрэн ойлголттой байна;
(ii) Хөрөнгийг хуваарилан зарцуулахдаа эрсдэлийг тооцоолно; ба
(iii) Группийн үйл ажиллагааны чиглэл нь зөвшөөрөх эрсдэлийн хэмжээтэй уялдана.

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 д.1118267206

2021/05/24



УЛААНБААТАР ХОТ
ЭЛЭЙН ЭНД КО
КАПИТАЛ ҮЦК
ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2021.06.23 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



**21 Эрсдэлийн удирдлагын топилуулга (Үргэлжлэл)**

**21.2 Эрсдэлийн удирдлагын бүтэц**

Ерөнхий эрсдэлийн удирдлагыг одоогоор Гүйцэтгэх захирал хариуцан ажиллаж байгаа бөгөөд үүний хүрээнд Гүйцэтгэх захирал эрсдэлийн бодлого болон авч чадах/хүлээн зөвшөөрөх эрсдэлийг тусгасан зээлийн эрсдэлийн бодлогыг баталдаг. Хувьцаа эзэмшигчид 2018 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийг 9 гишүүнтэйгээр томилсон. 2019 оны 4 дүгээр сард, Гүйцэтгэх захирал Группийн эрсдэлийн удирдлагын бүтцийг тодорхойлох үндсэн үүрэг хариуцлагатай ахлах эрсдэлийн менежерийг томилсон. ТУЗ нь дотоод аудиторыг 2018 оны 8 дугаар сарын 21-ний өдөр томилсон.

**21.3 Зээлийн эрсдэл**

**Ковид-19-ийн нөлөө**

Өнөөгийн нөхцөл байдал болон ирээдүйн таамаглалуудыг хэдийд хэрхэн тохиолдох болох төсөөлөл дээр үндэслэн оруулсан бөгөөд эдгээр нь Группийн хяналтаас давсан үйл явдал учир ирээдүйд өөрчлөгдөж болно. Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд томоохон нөлөө бүхий үнийн дүнгээр хүлээн зөвшөөрсөн зүйлсийн хувьд удирдлагын зүгээс үнэлэмж болон тооцооллыг хэрхэн хэрэглэж авч үзсэнийг доор тайлбарласан.

Ковид-19 цар тахал нь гэнэтийн байдлаар шинээр гарч буй эрсдэл учир түүний үргэлжлэх хугацаа болон санхүүгийн нөлөөлөл нь одоогийн байдлаар тодорхойгүй бөгөөд үүнээс үүдэн гарч буй засгийн газар болон төв банкны авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр нөлөө мөн адил тодорхойгүй байна. Энэхүү нөхцөл байдлын үргэлжлэх хугацааны тооцоолол болон ирээдүйд гарч болон хүндрэлийн ноцтой эсэх нь тодорхойгүй байгаа ба Ковид 19 цар тахал нь Группийн үйл ажиллагаа, санхүүгийн үр дүн болон ирээдүйн нөхцөл байдалд материаллаг байдлын хувьд хэрхэн сөргөөр нөлөөлөх талаар таамаглаллууд нь мөн адил тодорхойгүй байгаа болно. Иймд, Ковид-19 цар тахлын улмаас удирдлагын зүгээс Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхэд ашигласан үнэлэмж, тооцоолол болон таамаглалын тодорхойгүй байдал нь орлого, зардал, хөрөнгө, өр төлбөр болон тодруулгад материаллаг дүнтэй тохируулга хийгдэхэд хүргэж болно.

Групп Монгол Улсын Засгийн Газар, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Төв Банкны авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг хэрглэзэн үзэж ЗҮЦХА-ын загварыг боловсруулсан. Мөн Групп нь тайлагналын өдрөөрх сүүлийн үеийн мэдээллийг ашиглан ирээдүйн таамаглалд тохируулга хийсэн ба тооцоололдоо макро эдийн засгийн хүнд нөхцөл байдлуудыг авч үзсэн.

Групп өнөөгийн эдийн засгийн тогтворгүй байдлын боломжит нөлөөллийг Группийн санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгийн тайлагнасан дүнг тодорхойлоход харгалзаж үзсэн ба эдгээр нь боломжит мэдээлэлд үндэслэсэн Удирдлагын хамгийн сайн үнэлгээ байсан. Зах зээл тогтворгүй байсаар байгаа бөгөөд бүртгэгдсэн дүнгүүд нь зах зээлийн хэлбэлзэлд мэдрэг хэвээр байна.

**Үнэ цэнэ бууралтын үнэлгээ**

Группийн зээлийн үндсэн эрсдэл нь одоо явуулж буй зээлийн үйл ажиллагааны үр дүнд олгосон зээл нь эргэн төлөгдөхгүй байх эрсдэл юм. Зээлийн эрсдэл нь 1) зээлийн эрх тогтоон, батлах болон 2) зээл олгосны дараа зээлийн хугацаанд гүйцэтгэлийг хянах үед үүсч болно. Зээлийн эрх тогтоон, батлах үед үүсэх эрсдэл нь ЛэндМН системийн зээлжих түвшинг тогтоох модуль нь зээлдэгчийн зээлжих түвшинг буруу гаргаснаар тухайн зээлдэгчийн зээлийн хязгаар болон шимтгэлийн дүнг буруу тогтоох эрсдэл юм. ЛэндМН системийн зээлжих түвшинг тогтоох уг модуль нь зээлийн хугацаа хэтэрсэн байдал, хугацаа хэтэрч төлөгдсөн зээл зэрэг системийн түүхэн мэдээллүүд дээр тулгуурлан, зээлжих түвшин тогтоох үнэлгээний процессоо байнга засаж сайжруулдаг машинчилсан алгоритм бүхий модуль юм. Уг модуль нь шинэ мэдээлэл системд орж ирэх бүрт зээлдэгчдийн зээлжих түвшинг автоматаар шинэчлэн, дараа дараагийнхаа зээлжих түвшинг тогтоох алгоритмаа шинэчлэн засах бүтэц бүхий өөрөө өөрийгөө автоматаар засаж сайжруулдаг систем юм.

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 д.1118207200

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
БОЛОР ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
ХХК

## 21 Эрсдэлийн удирдлагын толилуулга (Үргэлжлэл)

### 21.3 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

**Үнэ цэнэ бууралтын үнэлгээ (Үргэлжлэл)**

Группийн удирдлагууд зөвхөн зээлийн эрхийн дүн болон шимтгэлийн түвшинг системд оруулж өгөх ба ЛэндМН систем нь өөрөө автоматаар зээлийн шийдвэрээ гаргаж, зээлжих түвшинг тогтоох алгоритмаа улам сайжруулаад ядаг байна. Компани хугацаа хэтэрсэн зээлийг хугацаа хэтэрсэн хоногоор нь 1, 30, 60, 90-с дээш хоног гэж тус тус багцлан, тэдгээрийн дүнг зорилтот хувьтай харьцуулан, хянаж ядаг.

Групп 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн зээлийг чанаргүй зээл гэж үзэн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын тооцооллын Шатлал 3 (үнэ цэнэ буурсан зээл)-д оруулдаг тооцдог.

Группийн зээлийн эрсдэл нь ЛэндМН Системийн зээл олгох шийдвэр гарсны дараа болон зээл олгосны дараа ч үүсч болно. Авлага цуглуулах алба болон дуудлагын төвийн багийнхан хамтдаа зээлдэгчийн эргэн төлөлтийн чиг хандлагыг тодорхойлох замаар хугацаа хэтэрсэн зээлийг өдөр тутам хянадаг. Авлага цуглуулах алба нь ЛэндМН системийн хугацаа хэтэрсэн зээлийг мэдэгдэх үүрэг бүхий модуль үр дүнтэй ажиллаж байгааг шалган ажилладаг бөгөөд тухайн модулийн мэдээллийг зээлдэгчийн эргэн төлөлтийн чиг хандлага өөрчлөгдөхөд шинэчилдэг. Дуудлагын төв нь авлага цуглуулах албыг дэмжиж ажиллах ба авлага цуглуулах албаны шууд удирдлага дор харилцагчдад зээлийн эргэн төлөлтийн үнэн зөв мэдээлэл, зөвлөгөөг түргэн шуурхай үзүүлдэг.

*Зээлийн чанаргүйдэл*

Зээлдэгч гэрээний төлөлтийн хуваарийн дагуу хийгдэх төлбөрийг 90 хоногоос дээш хугацаа хэтрүүлсэн тохиолдолд Групп тус санхүүгийн хэрэглүүрийг чанаргүйдэлд орсон гэж үзэн ЗҮЦХА-ын тооцооллын Шатлал 3 гэж ангилна.

*Группийн ЧМ-ыг тооцоолох үйл явц*

ЧМ-ийг зээлийн түүхэн алдагдлын туршлагад үндэслэн доор дурдсан бусад хүчин зүйлүүдээр тохируулан тооцсон.

*Харилцагчдад олгосон богино хугацаат зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтын үнэлгээ*

Групп нь ирээдүйг таамагласан, магадлалаар жинлэсэн чанаргүйдлын магадлалыг тооцоходоо өөрийн түүхэн зээлийн алдагдлын түвшин болон дараах ирээдүйг таамагласан макро-эдийн засгийн үзүүлэлтүүдийг ашигладаг:

- Ам долларын төгрөгтэй харьцах ханшийн сарын өөрчлөлтийн хувь,
- Ам долларын төгрөгтэй харьцах сарын дундаж ханш (Үнэмлэхүй утга),
- Инфляцийн сарын түвшин,
- Инфляцийн түвшний сарын өөрчлөлтийн хувь,
- Сарын ажилгүйдлийн түвшин,
- Сарын дундаж цалин,
- Сарын Жини коэффициент,

Групп нь макро-эдийн засгийн ямар үзүүлэлт Группийн зээлийн бүтээгдэхүүний ирээдүйн ЧМ-ыг хамгийн сайн таамаглаж байгааг тодорхойлохын тулд өнгөрсөн 46 сарын хугацааны сар бүрийн ЧМ болон дээрх макро эдийн засгийн үзүүлэлтүүд дээр шугаман регрессийн аргыг ашиглан шинжилгээ хийсэн. Шинжилгээний үр дүнд Макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн нэг болох ам.долларын төгрөгтэй харьцах ханшийн сар бүрийн өөрчлөлт нь Компанийн зээлийн чанаргүй болох магадлалыг хамгийн сайн таамаглаж байна гэж үзсэн.

*Чанаргүйдэлд өртөх дүн*

Чанаргүйдэлд өртөх дүн ("ЧӨД") гэдэг нь үнэ цэнийн бууралтын тооцоолол хийгдэж буй санхүүгийн хэрэглүүрийн нийт дансны үнийг илэрхийлэх бөгөөд ингэхдээ чанаргүй болох хандлагатай зээлийн өсөх зээлдэгчийн чадамж болон эрт төлбөр төлөх боломжийг тус тус харгалзан үзнэ.



2021/05/24

СЗХ 2021.06.23

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



**21 Эрсдэлийн удирдлага тодруулга (Үргэлжлэл)**

**21.3 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)**

**Үнэ цэнэ бууралтын үнэлгээ (Үргэлжлэл)**

*Алдагдалд хүрэх чанаргүйдэл*
Групп дараах томьёог ашиглан 2017 оны 3 дугаар сараас 2020 оны 12 дугаар сарын хоорондох өөрийн түүхэн зээлийн мэдээлэл дээр үндэслэн АХЧ-ыг сар бүрээр тооцоолон гаргасан:

АХЧ =1-(90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн зээлийн буцаан төлөлт/90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн зээл)

Зээлийн түүхэн ЧМ дээр хийсэн регрессийн шинжилгээтэй ижил регресс шинжилгээг түүхэн 46 сарын АХЧ дээр хийж үзсэн ба эцсийн загварт ам.долларын төгрөгтэй харьцах ханшийн сарын өөрчлөлтийн хувийг бие даасан хувьсагчаар оруулсан. Энэхүү загвар нь тоон болон чанарын шалгуурыг статистикийн ач холбогдолтой коэффициентийн хувьд 95 хувийн итгэлцлийн түвшинд давсан.

Групп нь АХЧ-г гурван боломжит хувилбараар тооцож, хамгийн сайн хувилбар 0%, суурь хувилбар 60% болон хамгийн муу хувилбар 40%-ын (2019: 25%, 45% болон 30%) магадлалтай гэж үзэн тэдгээрийн жигнэсэн дунджаар эцсийн АХЧ-г тооцож гаргасан. Тооцооллын үр дүнд магадлалаар жигнэсэн ирээдүйг таамагласан АХЧ 69.38% хувь гарсан.

Зээлийн дундаж хугацаа 27 хоног ба мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг ЗҮЦХА-ын тооцоолold оруулаагүй болно.

*Зээлрүү хөрвөх магадлал*
Зээлрүү хөрвөх магадлалыг сүүлийн 46 сарын түүхэн мэдээллийн дундаж үзүүлэлт дээр үндэслэн 37% (2019: 43%) байна гэж тооцоолсон.

*Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт*
Групп нь ЗҮЦХА тооцох шаардлагатай бүх хөрөнгийг тогтмол хянадаг. Санхүүгийн хэрэглүүр эсвэл санхүүгийн хэрэглүүрийн багцын ЗҮЦХА-г ЗҮЦ12сХА эсвэл ЗҮЦАХХА-ын алингаар тооцох зохистойг тодорхойлохын тулд Групп нь зээлийг анхлан хүлээн зөвшөөрснөөс хойш тухайн хөрөнгийн зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт ажиглагдсан эсэхийг үнэлдэг. Групп нь зээлийн үлдэгдэл 31 хоногоос дээш хугацаа хэтрэлттэй тохиолдолд зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн гэж үзэн зээлийг Шатлал 2-руу ангилдаг. Харин зээлийн үлдэгдэл 90 хоног хугацаа хэтрэлттэй бол зээлийг чанаргүй болсон гэж үзэж зээлийг Шатлал 3-руу ангилдаг.

*ЗҮЦХА-ын загварын өөрчлөлтийн шинжилгээ*
ЗҮЦХА-ын тооцооллын аргачлалын тоймыг Тодруулга 2, *Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо* болон Тодруулга 4 *Нягтлан бодох бүртгэлийн гол тооцоолууд болон үнэлэмжүүд* хэсэгт толилуулсан. Групп мэдээллийн бүрэн бүтэн байдал болон үнэн зөв байдлыг хангахын тулд гуравдагч талын эх сурвалжаас ашигласан мэдээллийг (Монгол Банк, Үндэсний Статистикийн Хороо гэх мэт) ашиглан, ЗҮЦХА-ын загварын өгөгдлүүд (хувилбаруудтай холбоотой жинлэсэн дүн тодорхойлох гэх мэт)-ийн үнэн зөв байдлыг шалгадаг.

Дараах хүснэгтэд ЗҮЦХА-ын загварын хувилбарууд тус бүрт ашигласан, ирээдүйг таамагласан эдийн засгийн гол хувьсагч/таамаглалын хувийг харуулав.

| Макро эдийн засгийн хувьсагч/Тооцоолсон ЧМ | Хамгийн сайн (Сүүлийн 46 сарын хамгийн бага) | Суурь (Сүүлийн 46 сарын дундаж) | Хамгийн муу (Сүүлийн 46 сарын хамгийн их) |
|---|---|---|---|
| Доллар/Төгрөгийн ханшийн сарын дундаж хувь (үнэмлэхүй үнэ) | 0.00% | 5.83% | 13.11% |
| Тооцоолсон ЧМ | 0.00% | 3.50% | 5.24% |

ЛЭНДМН ББСБ ХК
Lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 11187267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ЭРДЭНЭЗЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
2021.06.23
№01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



## 21 Эрсдэлийн удирдлагын тодруулга (Үргэлжлэл)

### 21.3 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

**Барьцаа хөрөнгө болон бусад зээлийн сайжруулалт**

Группийн банкин дахь мөнгө, харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа нь барьцаа хөрөнгөөр баталгаажаагүй (Тодруулга 12).

**ЗҮЦХА загвар дах Ковид-19-ийн нөлөө**

*Сегментчлэл*

Групп цар тахлаас үүдэн харилцагчдын хөдөлмөр эрхлэлтийн салбараас хамааран зээлийн эрсдэлийн шинж чанарт өөрчлөлт орсон эсэхийг тодорхойлохын тулд сегментчилэлийг хэрэглэх үзсэн. Группийн гүйцэтгэсэн сегментийн шинжилгээгээр, хөдөлмөр эрхлэлтийн салбаруудад томоохон зээлийн эрсдэлийн шинж чанар илрээгүй. Групп богино хугацаатай бичил зээл олгодог тул ЗҮЦХА-ын загвар нь зээл чанаргүйдэх өөрчлөлтийг цаг тухай бүрт нь илрүүлэх боломжтой. Иймд, удирдлагаас хувь хүний зээлийн чанарын өөрчлөлтийг илрүүлэхгүй байх эрсдэл байхгүй гэж үзсэн.

*Төлбөрийн нөхцөлийн хугацаа сунгалт*

Ковид-19 цар тахлын улмаас Монгол Улсын Засгийн Газраас зээлийн үндсэн төлбөрийг 2021 оны 7 дугаар сарын 1 хүртэл хойшлуулах мөн хэвийн зээлийн хугацаа хэтрэх өдрийг нэмэгдүүлэхээр хэд хэдэн тогтоол гаргасан. Засгийн Газар болон Санхүүгийн Зохицуулах Хорооны шийдвэрийн дагуу Групп нийт харилцагчиддаа тодорхой нөхцөлийн дагуу зээлийн эргэн төлөх хугацааг сунгах сонголтыг олгосон. Төлбөрийн нөхцөлийн хугацаа сунгалтыг хүн бүрийн санхүүгийн байдлаас хамааралгүйгээр бүх харилцагчдад ижил тэгш олгосон тул энэ нь СТОУС 9-ийн дагуу шатлал хооронд шилжих шалтгаан болохгүй.

*Макро эдийн засгийн хувилбарууд*

Групп нь Ковид-19-ийн нөлөөллөөс үүдэн макро эдийн засгийн олон хувилбаруудыг ашиглан бэлтгэдэг өөрсдийн загварын хамгийн сайн, суурь болон хамгийн муу хувилбаруудыг шинэчлэн тогтоосон. Групп нь ЧМ-г гурван боломжит хувилбараар тооцож, хамгийн сайн хувилбар 0%, суурь хувилбар 60% болон хамгийн муу хувилбарыг 40% (2019: 25%, 45% болон 30%) гэж үзэн тэдгээрийн жигнэсэн дундаж ЧМ-өөр эцсийн ЧМ-ийг тодорхойлсон. Хувилбар бүрийн магадлалыг Ковид 19-ийн нөлөөг оруулан тодорхойлохын тулд, удирдлага гадаад валютын нөөц, төгрөгийн ам.доллартай харьцах ханш, Ковид 19-ийн эсрэг вакцинжуулах төлөвлөгөө, өнөөгийн эдийн засаг болон улс төрийн үйл явдлууд, Монголын уул уурхайн салбарын үйл ажиллагаа болон 2021 оны Улсын төсөв зэрэг хэд хэдэн хүчин зүйлсийг харгалзаж үзсэн.



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
2021/05/24
УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗНИЙ ЭНД КО КАПИТАЛ АУДИТ ХХК
5183855
CTC2420

## 21 Эрсдэлийн удирдлагын толилуулга (Үргэлжлэл)

### 21.4 Төлбөрийн чадварын эрсдэл

Групп нь үндсэн үйл ажиллагаанаасаа хүрээнд өдөр бүр зах зээлийн эрэлт нь өсөн нэмэгдэж байгаа зээлийн бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд олгоход болон компанийн өр төлбөрийг барагдуулахад шаардлагатай, хангалттай хэмжээний санхүүжилтийн эх үүсвэртэй байх явдал нь төлбөрийн чадварын эрсдэлийн удирдлагын гол зорилго юм. Хэрэглэгчдэд олгох зээлийн бүтээгдэхүүний шаардлагатай эх үүсвэрийг холбоотой талаас өрийн эсвэл өмчийн хэлбэрээр, гуравдагч талаас өрийн хэлбэрээр татан авдаг.

**Санхүүгийн өр төлбөрийн дуусвар хугацааны шинжилгээг доор үзүүлэв:**

Дараах хүснэгтэд 2020 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Группийн санхүүгийн өр төлбөрийн дуусвар хугацааны шинжилгээг гэрээнд тусгагдсан дискаунтчилаагүй дүнгээр үзүүлэв.

| | Хэтэрсэн үед мян.төг | 3 сарын дотор мян.төг | 3-6 сарын дотор мян.төг | 6-1 жилийн дотор мян.төг | 1-5 жилийн дотор мян.төг | 5-с дээш жил мян.төг | Нийт санхүүгийн өр төлбөр (Дискаунт-чилаагүй) мян.төг |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2020 оны 12-р сарын 31-нээр** | | | | | | | |
| Олгохоор батлагдсан зээл | 1,292,893 | - | - | - | - | - | 1,292,893 |
| Зээл | 367,618 | 1,428,132 | 16,052,450 | 3,099,803 | 1,817,509 | - | 22,765,512 |
| Түрээсийн өр төлбөр | - | 77,493 | 77,493 | 154,986 | 562,255 | - | 872,227 |
| Бусад өр төлбөр | 1,067,804 | 1,000 | - | - | - | - | 1,068,804 |
| | 2,728,315 | 1,506,625 | 16,129,943 | 3,254,789 | 2,379,764 | - | 25,999,436 |
| **2019 оны 12-р сарын 31-нээр** | | | | | | | |
| Олгохоор батлагдсан зээл | 7,517,004 | - | - | - | - | - | 7,517,004 |
| Зээл | - | 3,708,973 | 22,310,219 | 10,102,508 | 7,761,870 | - | 43,883,570 |
| Түрээсийн өр төлбөр | - | 77,493 | 77,493 | 154,986 | 872,227 | - | 1,182,199 |
| Бусад өр төлбөр | 964,265 | 253,364 | - | - | - | - | 1,217,629 |
| | 8,481,269 | 4,039,830 | 22,387,712 | 10,257,494 | 8,634,097 | - | 53,800,402 |

Группийн удирдлага олгохоор батлагдсан зээл нь бүгд богино хугацаанд олгогдоно гэж үзэхгүй байна



СЗХ 2021 06 23 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2021-06-18 БҮРТГЭВ-03
ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ 5039754
2021/05/24
УЛААНБААТАР ХОТ БЛЭКСТОУН КО КАПИТАЛ ҮЦК ХХК
177

СЗХ
2021.06.23
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



**21 Эрсдэлийн удирдлагын тодруулга (Үргэлжлэл)**

**21.5 Зах зээлийн эрсдэл**

Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн урсгал нь хүүний түвшний өөрчлөлт, эсвэл гадаад валютын ханшийн өөрчлөлт гэх мэт зах зээлийн хүчин зүйлийн өөрчлөлтөөс болж өөрчлөгдөх эрсдэлийг зах зээлийн эрсдэл гэнэ. Групп уг эрсдлийг мэдрэг байдлын шинжилгээг ашиглан удирдан мөн хянан зохицуулдаг.

**21.6 Хүүний эрсдэл**

Хүүгийн эрсдэл гэдэг нь зах зээлийн хүүний түвшний өөрчлөлтөөс санхүүгийн хэрэглүүрийн ирээдүйн мөнгөн урсгал эсвэл бодит үнэ цэнэ хэлбэлзэх эрсдэлийг хэлнэ. Группийн хүүний эрсдэл харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа, банкны зээлээс үүснэ. Групп зээлийн хүүний эрсдэлийг удирдахдаа хөндлөн ашигладагтүй. Группийн хүүний эрсдэл нь Группийн банкин дахь тогтмол хүүтэй харилцах данснууд, харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа болон банкны зээлийн хүүний өөрчлөлттэй хамааралтай. Группд тайлагналын өдрөөр хувьсах хүүтэй санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөр байхгүй учир хүүний эрсдэлийг хэмжих мэдрэг байдлын шинжилгээ хийгээгүй.

**21.7 Гадаад валютын ханшийн эрсдэл**

Гадаад валютын ханшийн эрсдэл гэдэг нь валютын ханшийн өөрчлөлт болон ханшийн тогтворгүй байдлаас Группд үүсах боломжит алдагдлын хэмжээг хэлнэ. Групп нь гадаад валютын позицуудын эрсдэлийн хязгааруудыг тогтоож, тэдгээрийн гүйцэтгэл хүлээн зөвшөөрөх хэм хэмжээндээ байгаа эсэхэд тогтмол хяналт тавин ажилладаг.

| | 2020.12.31 | | 2019.12.31 | |
|---|---|---|---|---|
| | Хөрөнгө мян.төг | Өр төлбөр мян.төг | Хөрөнгө мян.төг | Өр төлбөр мян.төг |
| Гадаад валютаар илэрхийлэгдсэн | 3,521,392 | 8,336,314 | 14,126,197 | 15,029,435 |

Гадаад валютын мэдрэг байдлын шинжилгээ

Групп нь ихэвчлэн ам.долларын ("гадаад валют" гэх) хөрөнгө, өр төлбөртэй байна. Доорх хүснэгтэд гадаад валюттай харьцах төгрөгийн ханш 10%-аар өсөх болон буурахад Группд үзүүлэх мэдрэг байдлыг харуулсан. Мэдрэг байдлын шинжилгээг хийхдээ тайлант хугацааны эцсээр гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийг тэдгээр валютын ханшийг 10%-аар өөрчлөн тохируулсан. Энэхүү шинжилгээнд бусад бүх эрсдлийн хувьсагчид тогтмол байна гэж үзсэн.

| | Өөрчлөлт | 2020 мян.төг | 2019 мян.төг |
|---|---|---|---|
| Татварын өмнөх ашиг/алдагдалд үзүүлэх нөлөө | +/-10% | (481,492)/ 481,492 | 541,069/ (1,202,682) |

**21.8 Үйл ажиллагааны эрсдэл**

Үйл ажиллагааны эрсдэл нь системийн алдаа, хүний алдаа, залилан, болон гадны нөлөөллийн улмаас алдагдал хүлээх хохирол юм. Уг эрсдлийг удирдан хянахгүй бол, компанийн үйл ажиллагаа доголдох бөгөөд ингэснээр компанийн нэр хүнд муудах, хуулийн хариуцлага хүлээх, санхүүгийн алдагдалд орох гэх мэт сөрөг үр дагавартай. Групп нь үйл ажиллагааны эрсдлийг бүхэлд нь арилгаж чадахгүй ч, эрсдлийн удирдлагын нэгдсэн бодлогыг чанд мөрдөх, үйлчилгээний бүс болон ерөнхий үйл ажиллагааны бүсийн ажил үүргийг тусгаарлах, системийн аюулгүй байдлыг бүрэн хангах, болон ажиллагсдын ур чадвар, мэдлэг боловсролыг дээшлүүлэх замаар үйл ажиллагааны эрсдлийг удирдан, багасган ажиллаж байна.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ₮ 1118267 06

2021/05/24



УЛААНБААТАР ХОТ
ЭЛИТ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
2021.08.23

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



## 22 Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага

***Заргаа маргаан.*** Групп нь бизнесийн хэвийн үйл ажиллагааныхаа хүрээнд өөрийн эсрэг нэхэмжлэл хүлээн авах магадлал бий. Удирдлага өөрсдийн үнэлгээ, тооцоо, компанийн мэргэжилтнүүдийн зөвлөмжид үндэслэн заргаа, нэхэмжлэлтэй холбоотой материаллаг хохирол хүлээхгүй гэж үзэж байгаа тул санхүүгийн тайланд үүнтэй холбогдуулж аливаа сан хүлээн зөвшөөрөөгүй болно.

***Татварын хууль, зохицуулалт.*** Монгол улсын татвар, валют болон гаалийн зохицуулалттай холбоотой хууль тогтоомжууд нь өөр хоорондоо зөрүүтэйгээр тайлбарлагдах, мөн үе үе өөрчлөгдөх болзошгүй байдаг. Удирдлагын үнэлгээ, тайлбараар хууль журмыг ажил гүйлгээ, үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн байдлыг холбогдох төрийн албаны зүгээс хүлээн зөвшөөрөхгүй байх тохиолдол гардаг.

Монгол Улсын татварын алба хууль тогтоомжийг тайлбарлан үнэлэхдээ илүү хатуу байр суурь баримтлах талтай байдаг ба өмнө нь санал зөрөлдөж байгаагүй үйл ажиллагаа, ажил гүйлгээг татварын алба хожим нь үгүйсгэх боломжтой. Үүнээс үүдэж томоохон хэмжээний нэмэлт татвар, торгууль болон алдангийг ногдуулах магадлалтай байдаг. Татварын хяналт шалгалт орох үед өмнөх таван жилийн татварыг шалгадаг тул эдгээр татварын жилүүд хяналт шалгалтад нээлттэй хэвээр үлддэг. Зарим тохиолдолд татварын хяналт шалгалтад илүү урт хугацааг хамруулах явдал байдаг.

Монгол Улсын татварын хууль журам, зохицуулалтаар нэмэгдсэн өртгийн албан татвар, суутган татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үнэ шилжүүлэлт болон бусад зүйлстэй холбоотой зарим зүйл, заалт, асуудлаар тодорхой зааварчилгаа байдаггүй. Зарим нэг тохиолдолд удирдлага хуулийн энэхүү тодорхой бус зүйлсийн тухайд Группийн татварын ерөнхий хувийг бууруулах чиглэлд тайлбарлан хэрэглэдэг. Сүүлийн үед явагдсан захиргааны болон шүүхийн практик шийдвэрлэлийн үр дүнд дээрх тодорхой бус байдлын талаарх байр суурь илүү их хатуу хяналт шалгалтад өртөх талтай болсон. Хэдийгээр татварын албанаас тавигдах шаардлага компанийн санхүүгийн байдал болон нийт үйл ажиллагаанд материаллаг нөлөө үзүүлэх боломжтой болович, холбогдох нөлөөллийг найдвартай хэмжих боломжгүй юм.

Группийн удирдлага холбогдох хууль тогтоомжийг зохистойгоор тайлбарлан хэрэглэсэн гэж үзэж байгаа бөгөөд Групп нь татвар болон бусад хууль тогтоомжийн талаарх компанийн байр суурийг тогтвортой хадгалах болно. Удирдлага одоогоор татвар болон бусад хууль тогтоомжоос үүсэх эрсдэлийг бага гэж дүгнэж байгаа бөгөөд татварын эрсдэлийг цаашид тогтмол эргэн харж үнэлэх бөгөөд дээрх дүгнэлт нь одоогоор урьдчилан мэдэгдэх боломжгүй ирээдүйн нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгдөж магадгүй.

***Олгохоор баталсан зээлийн үүрэг.*** Энэхүү үүргийн үндсэн зорилго нь харилцагчдад шаардлагатай үед нь санхүүжилтийн эх үүсвэр бэлэн байлгахад оршино. Зээл олгохоор амласан амлалт нь харилцагчийн ЛэндМН системээс түүнд олгохоор батлагдсан нийт зээлийн ашиглаагүй байгаа хэсгийг хэлнэ. Хэдийгээр энэхүү зээлийн амлалт нь санхүүгийн тайланд тусгагдаагүй болович өөрөө зээлийн эрсдэлийг агуулж байдаг тул Групп нийт эрсдэлдээ оруулан тооцдог. Олгохоор баталсан зээлийн үүргийн эрсдэлийн хувьд Групп нийт дүнгээр зээлийн эрсдэлд орох болно. Гэхдээ харилцагч тусгайлан заасан зээлийн нөхцөлүүдийг биелүүлсэн нөхцөлд зээлийг бодитоор олгох боломжтой учир зээлийн эрсдэлийн дүн нь олгохоор баталсан зээлийн үүргийн нийт дүнгээс бага байна.

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр Группийн олгохоор баталсан зээлийн үүргийн нийт дүн нь 1,292,893 мян.төгрөг байна (2019 оны 12 дугаар сарын 31: 7,517,004 мян.төгрөг).

## 23 Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хэмжилт

<u>Бодит үнэ цэнээрээ тусгагдаагүй санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнэ</u>

Санхүүгийн тайланд бодит үнэ цэнээрээ хараахан бүртгэгдээгүй байгаа санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийг тодорхойлоход ашиглах аргачлал, таамаглалыг доор харуулав.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ЭНЭРЖИ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
2021 .06. 23
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18
БҮРТГЭВ-03



**23 Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хэмжилт (Үргэлжлэл)**

*Бодит үнэ цэнэ нь дансны үнэтэйгээ ойролцоо санхүүгийн хэрэгслүүд*
Группийн санхүүгийн хэрэгслүүд нь урт хугацаат зээлээс бусад нь бүгд богино хугацаатай бөгөөд нэг жил хүртэлх дуусгавар хугацаатай. Дээр дурьдсан бодит үнэ цэнийн үнэлгээн дээр үндэслэн эдгээр богино хугацаат санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн хөлийн эдгээрх тооцоолсон бодит үнэ цэнэ нь богино дуусгавар хугацаанаас шалтгаалан нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд үзүүлсэнчлэн дансны үнэтэйгээ ойролцоо байна.

Урт хугацаат тогтмол хүүтэй зээл нь ижил төстэй санхүүгийн хэрэглүүрүүдийн санал болгож байгаа зах зээлийн хүүний түвшинтэй харьцуулан үзвэл дансны үнэ нь бодит үнэ цэнэтэйгээ ойролцоо байна.

Дараах хүснэгтэд бодит үнэ цэнээрээ бүртгэгдсэн санхүүгийн хэрэглүүрүүдийг бодит үнэ цэнийн түвшинээр нь ангилан үзүүлэв.

| | Түвшин 1<br>мян.төг | Түвшин 2<br>мян.төг | Түвшин 3<br>мян.төг | Нийт<br>мян.төг |
|---|---|---|---|---|
| **2020 оны 12-р сарын 31-нээр** | | | | |
| *Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд тусгагдсан санхүүгийн хэрэглүүр* | | | | |
| Санхүүгийн өр төлбөр | - | - | (124,549) | (124,549) |
| | - | - | (124,549) | (124,549) |
| **2019 оны 12-р сарын 31-нээр** | | | | |
| *Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд тусгагдсан санхүүгийн хэрэглүүр* | | | | |
| Санхүүгийн хөрөнгө | - | - | 130,642 | 130,642 |
| | - | - | 130,642 | 130,642 |

Группийн үүсмэл санхүүгийн хэрэглүүр нь Түвшин 3-т хамаарах ба бодит үнэ цэнээр бүртгэгдсэн. 2020 оны 12-р сарын 31-ний өдөрөөрх бодит үнэ цэнийг үнэлэхэд үнэлгээний аргачлал болон өгөгдлүүдийг тууштай ашигласан. 2020 оны 12-р сарын 31-нээр өдөр дуусгавар болсон тайлант жилд 225,191 мян.төгрөгийн цэвэр гэрээр ашиг, алдагдлын тайланд бүртгэсэн (Тодруулга 8).

Доорх хүснэгтэд 2020 болон 2019 оны 12-р сарын 31-ний өдрөөрх Түвшин 2-ийн бодит үнэ цэнийн хэмжилтэд ашигласан үнэлгээний аргачлал болон өгөгдлийн тодорхойлолтыг харуулав.

| Санхүүгийн хөрөнгө | Үнэлгээний аргачлал | Өгөгдөл |
|---|---|---|
| Санхүүгийн үүсмэл хэрэглүүр | Дискаунтчилсан мөнгөн урсгалын загвар | Ам.долларын хөнгөлөлтийн хүү, төгрөгийн хөнгөлөлтийн хүү, хүүний түвшинээр харьцуулсан Төг/Ам.долларын форвард ханш |

Доорх хүснэгтэд бусад бүх зүйл тогтмол үед ажиглагдахуйц бус өгөгдөлд өөрчлөлт ороход санхүүгийн хэрэглүүрийн мэдрэг чанарыг харуулсан болно.

| | Ажиглагдахуйц бус өгөгдөл | Хүрээ | Өгөгдлийн бодит үнэ цэнэ дэх мэдрэг байдал<br>2020<br>мян.төг | <br>2019<br>мян.төг |
|---|---|---|---|---|
| Санхүүгийн үүсмэл хэрэглүүр | Төгрөгийн хөнгөлөлтийн хүү | +100 суурь оноо | 27,509 | 40,625 |
| | | -100 суурь оноо | (27,856) | (41,002) |

**Түвшин хоорондын шилжилт**
2020 болон 2019 оны туршид бодит үнэ цэнээрээ бүртгэгдсэн санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийн 1 болон 3 дугаар түвшний хооронд ямар нэг хөдөлгөөн гараагүй.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

2021/05/24



УЛААНБААТАР ХОТ
ЭРНСТ ЭНД ЯНГ КО
КАПИТАЛ ҮЦК
ХХК

СЗХ
он ... сар ... өдөр
2021.06.23
Бүртгэв
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



## 24 Холбоотой талуудын ажил гүйлгээ

Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ болон үлдэгдлийг доор толилуулав.

Гол удирдах ажилтнуудын нийт олговрыг 2020 болон 2019 оны байдлаар доорх хүснэгтээр харуулав:

| | 2020 мян.төг | 2019 мян.төг |
|---|---|---|
| Цалин ба бонус | 537,103 | 344,506 |
| Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл | 26,092 | 43,715 |
| | 563,195 | 388,221 |

2020 оны 12 дугаар сарын 31 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар холбоотой талуудын үлдэгдлийг доорх хүснэгтээр харуулав:

| | Тодруулга | 2020.12.31 мян.төг | 2019.12.31 мян.төг |
|---|---|---|---|
| Холбоотой талд ЛэндМН системээр олгосон зээл | (i) | 4,074 | 1,726 |
| Толгой компаниас авсан зээл | (ii) | - | 12,238,420 |
| Холбоотой талуудад өгөх өглөг | (iii) | 120,599 | 360,307 |

2020 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд холбоотой талуудтай хийсэн, орлогын тайланд тусгагдсан ажил гүйлгээний дүнг доорх хүснэгтээр харуулав:

| | | 2020 мян.төг | 2019 мян.төг |
|---|---|---|---|
| Зээлийн хүүний орлого - ЛэндМН систем | (i) | 1,628 | 1,818 |
| Олгосон зээлийн шимтгэлийн орлого | (vii) | 13,370 | - |
| ЛэндМН системийн үйлчилгээний төлбөр (Тод. 7) | (iv) | 1,144,809 | 1,362,623 |
| Зөвлөх үйлчилгээний төлбөр | (vi) | 440,000 | 43,573 |
| Хөлтэй бондын хүүний орлого | (v) | 231,524 | - |
| Зээлийн хүүний зардал | (ii) | 749,719 | 910,491 |

(i) Холбоотой талд ЛэндМН системээр олгосон зээл гэдэг нь Группийн болон толгой компанийн гол удирдах ажилтнуудад ЛэндМН системээр олгосон зээлийг хэлнэ. Групп 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд 38,242 мян.төгрөгийн (2019: 53,470 мян.төг) зээлийг Группийн болон толгой компанийн гол удирдах ажилтнуудад олгосноос 34,169 мян.төгрөг (2019: 51,745 мян.төг) нь бүрэн төлөгдөж, 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр зээлийн үлдэгдэл 4,074 мян.төгрөг (2019: 1,726 мян.төг), хуримтлагдсан хүүний үлдэгдэл 111 мян.төгрөг (2019: 189 мян.төгрөг) байна.

(ii) 2019 онд, Групп толгой компани болох Анд Системс-ээс нийт 22.8 орчим тэрбум төгрөгийн дүнтэй зээл авсан ба үүнээс 9 орчим тэрбум төгрөгийн зээлийг бүрэн төлсөн бөгөөд 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 11.4 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэл, 201,279 мян.төгрөгийн хуримтлагдсан хүүний өглөгтэй байна. Энэхүү зээлийг 2020 оны 2 дугаар сарын 14 болон 2020 оны 5 дугаар сарын 4-ний өдрүүдэд зээлийн үндсэн төлбөрийг бүрэн төлж барагдуулсан.

Групп 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ТУЗ-ын гишүүнээс итгэлцлийн үйлчилгээгээр 320,000 ам.долларыг авсан ба 2020 оны 6 дугаар сарын 16-ны өдөр бүрэн төлсөн.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118257206

2021/05/24



УЛААНБААТАР ХОТ
ЭЙВИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5153855
2021031195 CTC2420

СЭХ
2021.06.23-ны өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



**24 Холбоотой талуудын ажил гүйлгээ (Үргэлжлэл)**

(iii) 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар холбоотой талд өгөх өглөг нь Диджитал Молл ХХК болон СалПэй зээлийн үлдэгдэл 115,309 мян.төгрөг болон холбоотой талд өгөх хэтэвчээрх 5,290 мян.төгрөгийн өглөгөөс бүрдсэн.

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар холбоотой талд өгөх өглөг нь 2020 оны 2 дугаар сар болон 5 дугаар сарын хооронд бүрэн төлсөн холбоотой талаас авсан зээлийн хүүний хуримтлагдсан өглөг 204,924 мян.төгрөг, Анд Системс-д өгөх 140,000 мян.төгрөгийн ногдол ашгийн өглөг болон 2020 оны 4 дүгээр сард төлж барагдуулсан 15,383 мян.төгрөгийн барьцаагүй хүүний өглөгөөс бүрдсэн.

(iv) Групп 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Анд Системс Тех-тэй ЛэндМН системийн засвар үйлчилгээний гэрээ байгуулсан. Энэхүү гэрээний дагуу Анд Системс Тех-д сар бүр төлөх дүн нь тухайн сарын зээлийн ажил гүйлгээний тоо ширхэг дээр тулгуурладаг. Түүнчлэн Анд Системс Тех-тэй нэмэлтээр 2018 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр ЛэндМН цахим хэтэвчийн засвар үйлчилгээний болон техникийн сайжруулалтын гэрээ байгуулсан. Энэхүү гэрээний дагуу Анд Системс Тех-д сар бүр төлөх дүн нь тухайн сарын цахим хэтэвчээр хийгдсэн гүйлгээний тоо ширхэг (зээлийн гүйлгээнээс гадна) дээр тулгуурладаг.

(v) Групп барьцаагүй, жилийн 17 хувийн хүүтэй, 1 сарын хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй хаалттай бондыг 2020 оны 2 дугаар сарын 11-ний өдөр толгой компани болох Анд Системс-д гаргасан. Бондын хуримтлагдсан хүү болох 231,524 мян.төгрөгийн төлбөр нь үндсэн төлбөрийн хамт 2020 оны 7 дугаар сарын 9-ний өдөр бүрэн төлөгдсөн.

(vi) 2020 онд Групп нь толгой компани болох Анд Системс-ээс менежментийн зөвлөх үйлчилгээг сарын 40,000 мян.төгрөгөөр авсан.

(vii) 2020 онд Групп Банана Молл-аар дамжуулж СалПэй үйлчилгээгээр харилцагчдад олгосон зээлээс 4.75% шимтгэлийн орлого олсон.

**25 Тайлагналын өдрийн дараах үйл явдал**

Удирдлага нэгтгэсэн санхүүгийн тайланд нөлөөлөхөөр үйл явдал тайлагналын өдрийн дараа гараагүй гэж үзсэн.

**26 Монгол хэл дээрх орчуулга**

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Англи хэл дээр мөн бэлтгэсэн болно. Монгол, Англи хувилбарын хооронд утга, агуулгын зөрүү гарах тохиолдолд Англи хувийг дагана.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ☎1118267206

2021/05/24

50
УЛААНБААТАР ХОТ
ЭРНСТ ЭНД ЯНГ КАПИТАЛ ХХК
5193835
9021031185 CTC2420

СЭХ
он сар өдөр
Б 2021 .06. 23
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18
БҮРТГЭВ-03

## 4.3 ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА, ДҮГНЭЛТ

| Үнэлгээний компанийн нэр | “Итгэлт-Эстимэйт” ХХК |
|---|---|
| **Үйл ажиллагааны чиглэл** | Бизнес үнэлгээ<br>Үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ<br>Зөвлөх үйлчилгээ<br>Даатгалын хохирлын үнэлгээ<br>Амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлын үнэлгээ |
| **Хаяг** | Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Олимп Плаза, 4 давхар, 401 тоот |
| **Утас** | +976-7600 5638, 9902-5638 |
| **Цахим шуудан** | Itgelt.estimate@gmail.com |

“Итгэлт-Эстимэйт” ХХК нь 1999 онд Хууль Зүйн Яам, Сангийн Яамнаас тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа эхэлсэн салбартаа анхдагч, тэргүүлэгч компани юм. Тус компани нь үнэлгээний олон улсын стандартыг Монголдоо баримтлан ажиллаж, хэвшүүлэх, энэ зах зээлийг хөгжүүлж, салбартаа тэргүүлэгч компани байх эрхэм зорилготой ажиллаж байна.

2008 оноос Санхүүгийн Зохицуулах Хорооноос Даатгалын хохирол үнэлгчийн тусгай зөвшөөрөл авснаар даатгалын хохирлын үнэлгээ, 2010 оноос Дэлхийн банкны буцалтгүй тусламж, олон улсын төсөл хөтөлбөрүүдэд гүйцэтгэлийн болон хэрэгжилтийн үнэлгээ хийх мөн зөвлөх үйлчилгээ үзүүлэх болсон байна. 2015 оноос БНСУ болон Монгол Улсын хохирол үнэлэгчдийн холбоод хамтран зохион байгуулсан Хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл санааны хохирлын үнэлгээ хийх сургалтад хамрагдаж тусгай эрх бүхий үнэлгээчид энэ чиглэлийн үнэлгээг хийж байна.

Тус компани нь 7 мэргэшсэн үнэлгээчинтэй нийт 18 чадварлаг боловсон хүчинтэй, Баянзүрх, Баянгол-1, Баянгол-2, Хөвсгөл аймаг, Сүхбаатар аймаг дахь 5 салбар нэгжүүдээрээ дамжуулан үйлчилгээгээ үзүүлэн ажиллаж байна.

**Бизнесийн үнэлгээний гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг**

Энэхүү гэрээний зорилго нь Монгол улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журам, болон шаардлагын хүрээнд Үнэлгээний Олон Улсын Стандарт (“ҮОУС”)-ын дагуу үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө болон холбогдох мэдээллүүдэд тургуурлан хийж гүйцэтгэхэд оршино.

- Компанийн үйл ажиллагаа, бизнес төлөвлөгөө болон холбогдох баримт бичгүүдтэй нарийвчлан танилцаж, үнэлгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээт хугацаанд хийж гүйцэтгэнэ. Гэрээт ажлын явцад ажлын төлөвлөгөө

НОМИН БҮСЬ ХК
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ХХК

зохиох, мэдээлэл цуглуулах, түүнийг шалгах, үнэлгээ хийх, тайлан бичих, хүлээлгэн өгөх графикийг захиалагчтай хамтран боловсруулж мөрдөнө.

- Үнэлгээний ажлыг гэрээнд заасан хугацаанд холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу үнэн зөв, шаардлага хангасан үнэлгээний тайланг ҮОУС, Сангийн сайдын 207-р тушаалын дагуу бичиж хүлээлгэн өгнө.
- Үнэлгээчин нь тухайн үнэлгээний ажилд шаардлагатай баримт, мэдээллийг захиалагчаас гаргуулан авч ашиглах эрхтэй бөгөөд Үнэт цаас гаргагчийн бизнесийн нууцыг хадгалах, задруулахгүй байх үүрэгтэй. Үнэлгээ хийх явцдаа үйлчлүүлэгч болон гуравдагч этгээдээс авсан баримт бичгийн бүрэн бүтэн байдлыг хангаж архивын нэгж бүрдүүлэн 5-аас доошгүй жил хадгална.
- Үнэт цаас гаргагч нь үнэлгээнд шаардлагатай баримт бичиг болон материалыг Үнэлгээчинд үнэн зөв гаргаж өгөх шаардлагатай бөгөөд Үнэлгээчиний хийсэн тайлантай танилцаад үнэлгээний ажлыг стандарт, хууль тогтоомж, холбогдох дүрэм журмын дагуу гүйцэтгээгүй, хангалтгүй гэж үзвэл дахин тодруулах, нэмэлт тайлбар гаргуулах, дахин хугацаа тогтоож шаардлага хангасан тайлан дүгнэлтийг гаргуулах эрхтэй.

## ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

СЗХ
2021 .06. 23 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18
БҮРТГЭВ-03

ИТГЭЛТ ЭСТИМЭЙТ

БИЗНЕС ҮНЭЛГЭЭ
ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

# БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| | |
|---|---|
| Захиалагч: | "ЛэндМН ББСБ" ХК |
| Захиалагчийг төлөөлж: | Гүйцэтгэх захирал О.Болдбаатар |
| Үнэлсэн хөрөнгийн нэр: | "ЛэндМН ББСБ" ХК-ийн бизнесийн үнэ цэнэ |
| Үнэлсэн хөрөнгийн байршил: | Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж 34, Pearl Tower |
| Үнэлгээний дүн: | 54,104,500,000 (Тавин дөрвөн тэрбум нэг зуун дөрвөн сая таван зуун мянга)-н төгрөг |
| Огноо: | 2021.05.20 |

Улаанбаатар хот

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 18267200

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
185
5183955
9021031193 СТС2420

СЗХ
2021.06.23
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

# "ИТГЭЛТ ЭСТИМЭЙТ" ХХК

БИЗНЕС, ҮЛ ХӨДЛӨХ, ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

## ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН

*(Хураангуйлал)*

| | |
|---|---|
| **Захиалагчийн нэр:** | **"ЛэндМН ББСБ" ХК** |
| **Захиалагчийг төлөөлж:** | **О.Болдбаатар (Гүйцэтгэх захирал)** |
| **Компанийн регистрийн дугаар:** | 5039754 |
| **УБ-ийн гэрчилгээний дугаар:** | 9010002001 |
| **Үнэлсэн хөрөнгийн нэр:** | **"ЛэндМН ББСБ" ХК-ийн бизнесийн үнэ цэнэ** |
| **Хөрөнгийн байршил:** | **Чингэлтэй дүүрэг 3-р хороо, Жуулчны гудамж-34, Pearl Tower** |
| **Үнэлгээний дүн:** | **54,104,500,000 (тавин дөрвөн тэрбум нэг зуун дөрвөн сая таван зуун мянга)-н төгрөг** |
| **Гүйцэтгэгч:** | **Итгэлт-Эстимэйт ХХК**<br>**Регистр 2866641**<br>**Улсын бүртгэлийн дугаар 24/4539**<br>**Утас: 76005638, 99115638**<br>**E-mail: itgelt_estimate@itgeltgroup.mn**<br>**Web: www.itgeltgroup.mn** |
| **Ерөнхий захирал:** | **Э.Ганбаатар нь СЯ-ны хөрөнгийн үнэлгээ хийх эрхийн 140600038 тоот тусгай зөвшөөрөлтэй (Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээчнээр 6-н жил, Машин, тоног төхөөрөмжийн үнэлгээчнээр 6-н жил, Бизнесийн үнэлгээчнээр 6 жил тасралтгүй ажиллаж байгаа болно)** |
| **Тайлан бичсэн огноо:** | **2021 оны 05 дугаар сарын 20-ний өдөр** |

ЛЭНДМН ББСБ ХК
landmn
УЛААНБААТАР ХОТ
5039754

**2021/05/24**



УЛААНБААТАР ХОТ
ГЭЗЭЙ ЭНТ КО КАПИТАЛ ҮЦК ХХК

186

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ
№ 04

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭЭ-03

# "ИТГЭЛТ ЭСТИМЭЙТ" ХХК

БИЗНЕС, ҮЛ ХӨДЛӨХ, ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

## БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021-05-10 № 97/01 Улаанбаатар хот

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Бид "ЛэндМН ББСБ" ХК-ийн 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн бизнесийн үнэлгээ хийлгэх хүсэлтийн дагуу 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр 2021/08 тоот бизнес үнэлгээ хийх гэрээг байгуулж "ЛэндМН ББСБ" ХК-ийн бизнесийн үнэ цэнийг Монгол улсын хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Үнэлгээний Олон Улсын Стандарт болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн бие даасан хараат бус байдлаар хийж гүйцэтгэв. Бид энэхүү санал, дүгнэлтээ "ЛэндМН ББСБ" ХК-ийн бизнесийн өнөөгийн зах зээлийн үнийг тогтоох зорилгоор хийсэн болно.

<u>**Зах зээлийн үнэ цэнэ**</u> гэдэг нь зохих маркетинг сурталчилгаа хийгдсэний дараа, талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй бөгөөд албан шахалт шаардлагагүйгээр оролцох тохиолдолд арилжаанд оролцохоод бэлэн байгаа худалдан авагч ба борлуулагчийн хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгө, өр төлбөрийг арилжвал зохино гэж үнэлгээний өдрөөр тооцоолсон дүн юм.

<u>**Бизнесийг үргэлжлүүлэн ашиглах**</u> гэдэгт үндсэндээ дараах тохиолдлууд орно.
Үүнд:
- ✓ Тухайн бизнес нь үзүүлж буй үйлчилгээнийхээ эдийн засгийн шаардлагыг хангасан байх;
- ✓ Бизнес нь цаашид урт хугацаанд тасралтгүй үргэлжлэх боломжтой байх;
- ✓ Хариуцлагатай өмчийн эзэн, чадварлаг менежменттэй байх;
- ✓ Өөр зорилгоор ашиглах нь эдийн засгийн хувьд тохиромжгүй, хууль зүйн хувьд зөвшөөрөгдөхгүй байх;
- ✓ Одоогийн, эсвэл түүнтэй төстэй хэрэглэгчид өнөөгийн ашиглалтыг цааш нь үргэлжлүүлэх;

Бид бодит байдлыг шинжилж үзээд компанийн ирээдүйд олох боломжит орлогод тулгуурлан бизнесийн үнэ цэнийг тогтоосон болно.

<u>**Нийт хөрөнгө**</u> гэдэг нь бүхий л биет хөрөнгө (барилга, байгууламж, тоног төхөөрөмж, ажлын капитал) болон үргэлжлүүлэн ашиглах биет бус хөрөнгийн нийлбэр юм.

<u>**Цэвэр өөрийн хөрөнгө**</u> нь нийт хөрөнгөөс бусдад төлөх өр төлбөрийг хассан зөрүүгээр тодорхойлогдсон.

Бид "ЛэндМН ББСБ" ХК-ийн бизнесийн үнэлгээг "ЛэндМН ББСБ" ХК-ийн 3 жилийн бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөлөлд үндэслэн бизнесийн үнийг нь тогтоосон болно.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5339754 ⁂ 1116267206



УЛААНБААТАР ХОТ
ЭЛИТ ЭКИКО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



# ХОЁРДУГААР БҮЛЭГ. БИЗНЕСИЙН ОРЧИН БА ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖИЛГЭЭ

## 2.1 МАНАЙ ОРНЫ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

### ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

2013 онд 11.6 хувийн өсөлттэй эдийн засаг олон улсад хамгийн өндөр өсөлттэй эдийн засагт тооцогдож байсан. Гэвч дэлхийн санхүү, эдийн засгийн хүндрэл, түүний дотор олборлох салбарын түүхий эдийн үнийн уналт болон уул уурхайн томоохон ордуудын ашиглалтаас авахаар тооцож байсан орлогын хэт өөдрөг төсөөллийн улмаас зээлийн хөрөнгөөр төсвийн зардлаа огцом өсгөсөн зэргээс шалтгаалан Монгол Улсын эдийн засагт хүндрэл учран, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 2016 онд 1 хувь хүртэл буурсан байдаг. Олон улсын зах зээл дээрх олборлох салбарын түүхий эдийн үнийн өсөлт болон эдийн засагт үүссэн хүндрэлүүдийг арилгах, төсвийн үндсэн тэнцлийн алдагдлыг үе шаттайгаар бууруулах замаар эдийн засгийг сэргээх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээтэй уялдан 2017 он гарсаар эдийн засгийн өсөлт эрчимжиж, ДНБ 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2017 оны жилийн эцэст 16.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 826 (5.1%) тэрбум төгрөгөөр өссөн бол 2018 онд 18.1 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.2 (6.9%) их наяд төгрөгөөр өссөн байдаг. 2019 онд энэхүү үзүүлэлт 920 (5%) тэрбумаар өссөн байна.

***График 1.** Дотоодын нийт бүтээгдэх үүн, 2010 оны зэрэгцүүлэх үнээр /их наяд төгрөг/*




***Эх сурвалж.** Үндэсний Статистикийн Хороо*

Доорх хүснэгтээс үзвэл 2017-2018 оны хооронд боловсруулах үйлдвэрлэл, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны салбар, мэдээлэл холбооны салбарын өсөлт өндөр эрчимтэй байна. 2019 оны байдлаар боловсруулах салбар 11%, Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны өсөлт 10.3%-ийн өсөлттэй байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт байна.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК

СЗХ
2021.06.23
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



*Хүснэгт 1. ДНБ-ий өсөлт салбаруудаар*

| № | Салбар | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур | 1.8 | 4.5 | 8.4 | 6.2 |
| 2 | Уул уурхай, олборлолт | -5.5 | 6.1 | -0.6 | -9.4 |
| 3 | Боловсруулах үйлдвэрлэл | 19.9 | 15.7 | 11.0 | 1.3 |
| 4 | Цахилгаан, хий, уур, агааржуулалт | 5.5 | 8.2 | 8.2 | 2.4 |
| 5 | Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа | 1.4 | 8.2 | 0.4 | -2.3 |
| 6 | Барилга | 11.4 | 4.7 | 5.8 | -7.4 |
| 7 | Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ | 6.8 | 2.2 | 7.2 | -11.1 |
| 8 | Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 14.2 | 7.6 | 3.2 | -20.1 |
| 9 | Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ | 9.7 | 11.6 | 4.5 | -29.7 |
| 10 | Мэдээлэл, холбоо | 13.3 | 7.8 | 9.5 | 0.4 |
| 11 | Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 9.1 | 5.5 | 10.3 | 0.9 |
| 12 | Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 6.7 | 6.9 | 1.9 | -1.9 |
| 13 | Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | -5.9 | 7.2 | 4.8 | -0.2 |
| 14 | Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | 9.5 | 4.0 | 3.5 | -10.6 |
| 15 | Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал | 1.2 | 0.6 | 4.8 | 0.7 |
| 16 | Боловсрол | 3.0 | 2.6 | 3.2 | 2.3 |
| 17 | Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа | 2.0 | 2.6 | 4.1 | 1.4 |
| 18 | Урлаг, үзвэр, тоглоом, наадам | 1.1 | 0.6 | 4.9 | -1.1 |
| 19 | Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 4.1 | 2.4 | 5.0 | -3.8 |
| 20 | Бүтээгдэхүүний цэвэр татвар | 18.5 | 20.1 | 5.4 | -9.8 |

***Эх сурвалж.*** *Үндэсний Статистикийн Хороо*

Азийн Хөгжлийн Төлөв эдийн засгийн шинжилгээ, төсөөллийн энэ жилийн тайланд өгүүлснээр Монгол Улсын эдийн засаг 2020 оны 5.3%-ийн огцом агшилтаас сэргэж 2021 онд 4.8%-иар, дотоод эрэлт, хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн зээл өсч, сэргэлт эдийн засгийн салбаруудыг бүрэн хамарснаар 2022 онд 5.7%-иар тус тус өснө гэж таамаглаж байна.

## ИНФЛЯЦИ

Улсын инфляцийн түвшин 2015 онд 1.9 хувь, 2016 онд 1.0 хувь болж буурч 2017 онд 6.4 хувь, 2018 онд 8.1 хувь болж өссөн. Инфляцийн түвшин бууруч нам түвшинд хүрэхэд эдийн засгийн өсөлт саарч, дотоод эрэлт хумигдсан нь голлон нөлөөлж байв. Мөн мах болон хатуу түлшний үнийн өсөлт голлон нөлөөлөв. Мах экспортлох эрэлт шинээр үүссэн, тээврийн зардал өссөн зэргээс шалтгаалан махны үнэ улирлын чиг хандлагаас зөрж өссөн. Мөн Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлах бодлогын нөлөөгөөр хатуу түлшний үнэ 2018 онд түүхэндээ хамгийн өндөр буюу 64.6 хувиар өссөн нь нөлөөлжээ. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэлд Монголбанк инфляцийг 2020 онд 8 хувийн орчимд тогтворжуулах зорилтыг тавьсан. Сангийн яамны

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ☏1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
... КАПИТАЛ ҮЦК
ХХК

СЗХ
2021.06.23
ХҮЛЭЭН АВСАН/БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



хэрэглээний үнийн өсөлтийн талаар 2020-2022 он хүртэлх хийсэн төсөөлөлд мөн 8 хувь байна гэж таамаглаж байна. 2021 оны 3-р сарын байдлаар инфляцийн түвшин 2.3% байна.

*График 2. Инфляцийн т үвшин*




*Эх сурвалж. Үндэсний Статистикийн Хороо*

**АЖИЛГҮЙДЭЛ**

Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2020 оны 3 дугаар сарын эцэст ажилгүй 4.4 мянган иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 1.1 мянган иргэн ажилд зуучлагдан орж, 4.6 мянган иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2020 оны 3 дугаар сард 4.4 мянган хүн шинээр бүртгүүлсний 58.7 хувь нь ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан иргэд байсан бол энэ жилийн энэ сард хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2021 оны 2 дугаар сард 3.6 мянган хүн шинээр бүртгүүлсний 877 нь ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан иргэд байгаа нь өмнөх дүнгээс өссөн үзүүлэлт. Улсын хэмжээнд ажилгүй иргэдийн 243 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд бөгөөд 123 нь эмэгтэйчүүд. Боловсролын хувьд бүртгэлтэй ажилгүй хоёр хүн тутмын нэг нь бүрэн дунд, гурван хүн тутмын нэг нь дипломын болон бакалаврын дээд боловсролтой. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн дийлэнх 52.4%-ийг 15-34 насны залуучууд эзэлж байна.

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206





УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



## ГАДААД ХУДАЛДАА

Монгол Улс 2020 оны эцсийн байдлаар нийт 146 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 11.7 тэрбум америк доллар, үүнээс экспорт 6.9 тэрбум америк доллар, импорт 4.9 тэрбум америк доллар байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 897.6 (28.1%) сая америк доллар, үүнээс экспорт 200.4 (2.8%) сая америк доллароор, импорт 697.2 (9.7%) сая америк доллароор тус тус буурчээ.

*График 3. Экспорт, импорт, тэнцэл, сараар, сая америк доллар*



*Эх сурвалж. Үндэсний Статистикийн Хороо /2021 оны 5 дугаар сар 18/*

## МӨНГӨ, ЗЭЭЛ, ҮНЭТ ЦААС

Мөнгөний нийлүүлэлт (М2) 2021 оны 3 дугаар сарын эцэст 25.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.6 (3.5%) их наяд төгрөгөөр өсөхөд валютын хадгаламж 689 (18.6%) тэрбум төгрөгөөр өсөж, валютын харилцах 314.2 (12.1%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

Бага мөнгө (М1) 2021 оны 3 дугаар сарын эцэст 4.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 194.9 (4.7%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 851.3 (24.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Бага мөнгө (М1)-ний 3.5 (82.8%) их наяд төгрөг нь төгрөгийн харилцах, 0.7 (17.2%) их наяд төгрөг нь хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө байна.

Бараг мөнгө 2021 оны 3 дугаар сарын эцэст 20.7 их наяд төгрөг болж, өмнөх сараас 205.0 (1.0%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 3792.5 (22.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Бараг мөнгөний 14.1 (67.9%) их наяд төгрөг нь төгрөгийн хадгаламж, 4.3 (21.0%) их наяд төгрөг нь валютын хадгаламж, 2.2 (11.1%) их наяд төгрөг нь валютын харилцах байна.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2021 оны 3 дугаар сарын эцэст 1005.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 158.1 (18.6%) тэрбум төгрөгөөр, төгрөгийн харилцах 3.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 682.9 (23.7%) тэрбум төгрөгөөр, хадгаламжийн

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn



2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨВӨЙ ЭЦЭЭ НОТАРИАТ
ХХК 191

СЭХ
Ь 2021 т06 28
№01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



байгууллагаас гадуурх мөнгө 739.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 168.4 (29.5%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

*Хүснэгт 2. Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, жил бүрийн 3 дугаар сарын эцэст*

| Нэр | 2018 III | 2019 III | 2020 III | 2021* III | 2021* III / 2020 III |
|---|---|---|---|---|---|
| | тэрбум төгрөг | | | | хувь |
| Мөнгө M2 | 16073.9 | 19 699.6 | 20390.3 | 25034.1 | 122.7 |
| Бага мөнгө M1 | 2 776.7 | 3 666.6 | 3 446.1 | 4 297.4 | 124.7 |
| Төгрөгийн харилцах | 2 201.4 | 3 058.0 | 2 875.4 | 3 558.3 | 123.7 |
| Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө | 575.3 | 608.6 | 570.7 | 739.1 | 129.5 |
| Бараг мөнгө | 13 297.3 | 16 032.9 | 16944.2 | 20736.7 | 122.3 |
| Төгрөгийн хадгаламж | 8 859.4 | 11 147.8 | 10682.4 | 14100.1 | 131.9 |
| Валютын хадгаламж | 2 513.2 | 2 896.8 | 3 686.2 | 4 375.2 | 118.6 |
| Валютын харилцах | 1 924.6 | 1 988.3 | 2 575.6 | 2 261.4 | 87.8 |
| Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө | 840.4 | 897.8 | 847.8 | 1 005.9 | 118.6 |

*Эх сурвалж. Монгол банк*

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны 3 дугаар сарын эцэст 17.6 их наяд төгрөг болж, өмнөх сараас 494.2 (2.8%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 489.9 (2.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.2 (46.6%) их наяд төгрөг нь иргэдийнх байна.

Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны 3 дугаар сарын эцэст 14.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 560.3 (4%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 169.8 (1.2%) тэрбум төгрөгөөр өссөн. Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 81.3 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.3 пунктээр буурсан байна.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

2021/05/24



УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК
ХХК
5183655
9021031195 СТС2430

СЗХ
2021.06.23
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

# "ИТГЭЛТ ЭСТИМЭЙТ" ХХК

БИЗНЕС, ҮЛ ХӨДЛӨХ, ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

*Хүснэгт 3. Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл, зээлийн ангиллаар, сарын эцэст*

| Нэр | 2018 III | 2019 III | 2020 III | 2021 III | 2021 III / 2020 III |
|---|---|---|---|---|---|
| | тэрбум төгрөг | | | | хувь |
| Зээлийн өрийн үлдэгдэл | 14 139.5 | 17461.9 | 17146.5 | 17 636.4 | 102.8 |
| Хэвийн зээл | 11 971.8 | 14683.0 | 14163.3 | 14 333.2 | 101.2 |
| Хугацаа хэтэрсэн зээл | 935.9 | 913.7 | 1 150.3 | 1 282.5 | 111.4 |
| Чанаргүй зээл | 1 231.8 | 1 865.2 | 1 832.9 | 2 020.7 | 110.2 |

*Эх сурвалж. Монгол банк*

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24



УЛААНБААТАР ХОТ
ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
193
5183855
9021031195 СТС2420

СЭХ
2021.06.23
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭЗ-03



Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны 3 дугаар сарын эцэст 1.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 69.6 (5.1%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 132.2 (11.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.2 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.5 пунктээр өссөн байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2021 оны 3 дугаар сарын эцэст 2.02 их наяд төгрөг болж, өмнөх сараас 4.1 (0.2%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 187.8 (10.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 11.4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс өөрчлөлтгүй байна.

***Хүснэгт 4.** Банкны зээл, хадгаламжийн хүү 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар*

| № | Зээл, хадгаламж | | Хаан банк | Хас банк | Голомт банк | Худалдаа хөгжлийн банк | Төрийн банк |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хэрэглээний зээл | Цалингийн зээл | 14.4%-18.0% | 14.4%-18.0% | 14.4%-22.8% | 14.4%-18.0% | 15.6%-18.0% |
| 2 | | Өрхийн зээл | 18.0%-19.2% | 21.6% | 30% | 21.6%-24% | |
| 3 | | Хэрэглээний зээл | 18.0% | 24.0% | 17.4%-20.4% | 20.4%-22.8% | |
| 4 | | Тэтгэврийн зээл | 15.6% | | 15.6% | 15.6% | 15.6% |
| 5 | | Сургалтын зээл | | | | | |
| 6 | | Ногоон зээл | 18.6% | | | 14.4% | 19.2% |
| 7 | Хадгаламжийн хүү | Энгийн хадгаламж | 8.6% | 7.2% | 8.5% | 9.0% | 8.6% |
| 8 | | Хуримтлалын хадгаламж | 8.0% | | | | |
| 9 | | Хүүхдийн хадгаламж | 8.5% | 9.2% | 8.6% | 9.6% | 9.0% |
| 10 | | Малчны хадгаламж | 8.8% | | | | 4.0%-9.0% |

***Эх сурвалж.** Банкуудын албан ёсны цахим хуудас*



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754

УЛААНБААТАР ХОТ
ӨНЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
2021 .06. 23
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18



***Хүснэгт 5. Банк бус Санхүүгийн байгууллагын зээлийн хүү 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар***

| № | Нэр | | Зээлийн хүү | Эх сурвалж |
|---|---|---|---|---|
| 1 | "Хөгжил Финанс" ББСБ | Бизнесийн зээл | 34.80% | http://www.dfi.mn/product?id=1 |
| 2 | | Төслийн зээл | 24.00% | http://www.dfi.mn/product?id=2 |
| 3 | | Хэрэглээний зээл | 34.80% | http://www.dfi.mn/product?id=3 |
| 4 | | Авто машины зээл | 42.00% | http://www.dfi.mn/product?id=5 |
| 5 | "Инвескор" ББСБ | Бизнесийн зээл | 33.60% | https://www.invescore.mn/view/loan/?page=item&id=4 |
| 6 | | Хэрэглээний зээл | 42.00% | https://www.invescore.mn/view/loan/?page=item&id=1 |
| 7 | | Авто машины зээл | 40.80% | https://www.invescore.mn/view/loan/?page=item&id=2 |
| 8 | "Ард кредит" ББСБ | Бизнесийн зээл | 27.60% | http://www.ardcredit.com/mn/business_loan |
| 9 | | Төслийн зээл | Гэрээгээр тохиролцоно | http://www.ardcredit.com/mn/business_loan |
| 10 | | Жижиг дундын бизнесийн зээл /Хөр Ор/ | 27.60% | http://www.ardcredit.com/mn/business_loan |
| 11 | | Жижиг дундын бизнесийн зээл /Хөр Ор/ | 27.60% | http://www.ardcredit.com/mn/business_loan |
| 12 | | Зээлийн шугам | 27.60% | http://www.ardcredit.com/mn/business_loan |
| 13 | Зээл.мн | Зээл | 22.8% | https://zeel.mn/mn/ |
| 14 | Бид ББСБ | Бизнесийн зээл | 42.00% | https://www.bid-finance.mn/#about |
| 15 | | Авто машины зээл | 33.60% | https://www.bid-finance.mn/#about |
| 16 | | Хэрэглээний зээл | 42.00% | https://www.bid-finance.mn/#about |
| 17 | "Очир үндраа ОМЗ" ББСБ | Бизнесийн зээл | 34.80% | www.omz.mn |
| 18 | | Төслийн зээл | 30.00% | |
| 19 | | Авто машины зээл | 34.8% | |
| 20 | | Цалингийн зээл | 20.40% | |
| 21 | | Боловсролын зээл | 36.00% | |

***Эх сурвалж.** Банк бус санхүүгийн байгууллагуудын албан ёсны цахим хуудас*



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК
ХХК

СЭХ
2021.06.23
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

# "ИТГЭЛТ ЭСТИМЭЙТ" ХХК

БИЗНЕС, ҮЛ ХӨДЛӨХ, ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

## ТЕХНОЛОГИЙН ОРЧИН

Өнөөгийн 21-р зуунд техник технологийн хөгжил хурдсахын хэрээр хэрэглэгчид цаг хугацаа бага шаардсан, илүү хялбар цахим үйлчилгээнүүдийг илүүд үзэх хандлага бий болсон. Түүнийгээ дагаад банк санхүүгийн салбарт ч бэлэн бус төлбөр тооцоо, цахим үйлчилгээ, шинэ дэвшилтэт бүтээгдэхүүн үйлчилгээнүүд хурдацтай хөгжиж байна. Монголбанк, арилжааны банкууд, санхүүгийн зохицуулах хороо зэрэг бусад байгууллагуудын төлөөллүүдээс бүрдсэн "Төлбөр тооцооны үндэсний зөвлөл" гэх байгуулагдсан ба энэхүү зөвлөлөөс гаргасан "Монгол Улсын төлбөр тооцооны системийг 2009-2016 онд хөгжүүлэх стратеги" д бэлэн бус төлбөрийн хэрэгсэл болон төлбөр тооцооны системийн шинэ хэлбэрийг хөгжүүлэх стратегийг тодорхойлсон байна.

Fintech (Financial Technology) буюу Санхүүгийн технологи гэх нэр томъёо сүүлийн жилүүдэд нэлээд яригдах болсон. Техник технологи тэр дундаа Блокчейн технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний зах зээл дэлхийд өндөр хөгжсөн ба Краудфандинг, Хиймэл оюун ухаан, Үүлэн технологи, Кибер аюулгүй байдал хэмээх ойлголтууд бидний өдөр тутмын амьдралд хэрэглэгдэх болж олон төрлийн цахим мөнгө бий болсоор байна. Технологид суурилсан санхүүгийн үйлчилгээнүүд нь нэг талаасаа өндөр дэвшилтэт технологи, аюулгүй байдлыг хангах давуу талтай тул хэрэглэгчдийн итгэлийг хүлээх давуу талтай байдаг.

***График 4. Финтекийн хөгжил***



*Эх сурвалж: http: www.helsinki.fintech.fi*

Банкны салбарын хувьд технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээ хурдацтай хөгжиж Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкууд өөр өөрсдийн онцлог бүхий цахим бүтээгдэхүүн үйлчилгээнүүд санал болгож, банкинд оочер үүсгэдэг цаг үеэ өнгөрөөсөн. ATM (Automated Teller Machine) буюу бэлэн мөнгөний орлого, зарлага, шилжүүлэг хийх боломжтой автомат машин, Зөөврийн компьютер болон ухаалаг утасны аппликейшнүүд зэрэг олон үйлчилгээ нэвтэрч хэрэглэгчдийн өдөр тутмын амьдралын нэгээхэн хэсэг болсон. ББСБ-уудын үйл ажиллагаа ч мөн адил технологийн дэвшлийг нэвтрүүлэх болсноор хэрэглэгчдийн тоо өсөж, Активын дүн өсөж, хөгжил хурдассаар байна.



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 ★ 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО
КАПИТАЛ ҮЦК

СЗХ
2021 .06. 2 3
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 1 8
БҮРТГЭЛ-03



## 2.2 БИЗНЕСИЙН ТҮҮХ, МӨН ЧАНАР, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

ЛэндМН ББСБ ХК нь 2015 онд Санхүүгийн зохицуулах хорооноос ББСБ-ын зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан бөгөөд 2016 оноос Лэнд МН ББСБ нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Анд Системс ЛэндМН ББСБ ХК-ийн толгой компани бөгөөд ЛэндМН ББСБ ХК нь зах зээлд технологийн дэвшлийг санхүүгийн үйлчилгээтэй хамтатгасан Финтек бизнес моделийг Лэнд Хэтэвч буюу LendMN аппликейшнээр дамжуулан амжилттай нэвтрүүлж буй барьцаагүй хямд өртөгтэй, хэрэглээний бичил цахим зээлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага юм. 2018 оны байдлаар харилцагчдын тоо 19 мянгад хүрсэн ба 2018 онд IPO гаргаж олон нийтэд 200,000,000 ширхэг хувьцаа гаргаж 5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татсан бөгөөд 2020 оны байдлаар Монголын хөрөнгийн биржийн 1-р ангиллын хувьцаат компаниудын тоонд багтсан төдийгүй, ТОП-20 -д багтсан.

### БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

ЛэндМН ББСБ ХК нь LendMN аппликейшнээр дамжуулан барьцаагүй хямд өртөгтэй, хэрэглээний бичил цахим зээлийн үйлчилгээг хамгийн хурдан шуурхай үзүүлдгээрээ онцлогтой.

### ЗАХ ЗЭЭЛИЙН БАГТААМЖ

**А. ЛэндМН ББСБ ХК-ийн хэрэглэгчдийн өнөөгийн байдал**

**ЛэндМН ББСБ ХК-ийн санал болгож буй бичил хэрэглээний зээлийн зах зээлийн зорилтот хэрэглэгчид нь дундаж орлоготой мобайл болон интернет банк ашигладаг,** технологийн дэвшилд идэвхитэй 20-39 насны интервалд хамаарах хэрэглэгчид байна. Эдгээр хэрэглэгчид нийт харилцагчдын 65%-ийг зээлдэг ба нийт харилцагчдын 60 гаруй хувь нь ямар нэгэн зээлтэй бол үлдсэн хэсэг зээлгүй байна.

Зээлийн гэрээ байгуулсан идэвхитэй харилцагч нар 2017 онд ойролцоогоор 19 мянга гаруй харилцагч байсан бол 2020 оны эцэс гэхэд 175,271 болж нийтдээ 9.2 дахин өссөн байна. ЛэндМН-ийн харилцагчдыг насны бүлгээр задалж харвал 39-өөс дээш насны харилцагч нар нийт зээлдэгч нарын 26%-ийг эзэлж байгаа нь анхны зорилтот насны түвшин болох 24-34 насны хэрэглэгчдээс тэлж байгаа нь зах зээлийн хэмжээ бизнесийн цар хүрээнд эерэгээр нөлөөлж байна.

Цаашид хугацаа өнгөрөх тусам карт ашиглан төлбөр тооцоо хийдэг үеэс интернет болон мобайл банк ашиглан үйлчилгээ авах сонирхолтой хэрэглэгч өсөх хандлагатай ба финтек шийдэл хүн амын дунд нас харгалзахгүйгээр тархаж эрэлт хэрэгцээ нэмэгдэхээр байна.

**ЛэндМН ББСБ ХК-ийн харилцагчийн хүрээ хэрэглээний зээлийн эрэлт өндөртэй дунд болон дундаас дээш орлоготой дундаж насныхнаар хүрээгээ тэлсэн байна.**



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267200

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРД КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031155 СТС2130

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



**Б. Нас, орлогын түвшинд суурилсан хэрэглэгчид**

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооны тооцоогоор 20-39 насны хүн амын тоо нийт хүн амын 30% болох 989,059 иргэн буюу ойролцоогоор 1 сая хүн уг насны интервалд хамаарч байна. Уг насны хүмүүсийн онцлог гэвэл бусад насны хүн амыг бодоход хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хэрэглээний түвшин харьцангуй өндөр бүлэг юм.

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

**Цалингийн бүлгийн задаргаа**




2020 оны эцсийн байдлаар ажил эрхэлж буй 500,000 төгрөгөөс 1,500,000 төгрөг хүртэл цалингийн орлоготой хүн амын тоо 442,709 болж байна. Энэ нь нийт ажил эрхлэгчдийн 72%-ийг эзлэх ба ЛэндМН ББСБ ХК-ийн хэрэглэгчдийн зээл олголтын тоон үзүүлэлтээс харахад 2020 оны 1-р улирлын байдлаар нэг хүнд олгосон сарын дундаж зээлийн хэмжээ 232,000 төгрөг байгаагаас үзэхэд зорилтот зах зээлд багтах хүн амын тоогоор харгалзуулан тооцсон зах зээлийн багтаамж сард дунджаар 102.7 тэрбум төгрөг буюу жилийн 1.2 их наяд төгрөг байхаар байна. Энэ нь ЛэндМН ББСБ ХК-ийн нийт хэрэглэгчдийн 65%-тай дүйцэж буйгаас харвал (2021 оны 1-р улирлын байдлаар) нийт зах зээлийн багтаамж ойролцоогоор 1.9 их наяд төгрөг байхаар таамаглагдаж байна.

**ЛэндМН ББСБ ХК-ийн 26% нь бусад буюу 20-39 насны ангилалд ороогүй зээлдэгчид байгаагаас харахад 39-с дээш насны тогтмол цалингийн орлоготой харилцагчид тус компанийн бүтээгдэхүүнийг хэрэглэж эхэлсэн нь сонирхол татаж байна. Энэ нь 40-өөд насныхан нь энэ салбарын нэмэлт сегмент болж буйг харуулах ба 15-19 насныхан нь санхүүгийн бүтээгдэхүүний ирээдүйн хэрэглэгчид байх болно.*



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ☎ 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
198

**В.Технологийн хэрэглээгээр тодорхойлсон хэрэглэгч**

2017 онд ЛэндМН ББСБ ХК-ийн олон нийтэд хувьцаагаа санал болгох үед смарт гар утас хэрэглэгчийн тоо 2.4 сая байсан бол 2020 онд 3.3 сая болж өссөн байна.

**Гар утасны апп ашиглан төлбөр тооцоо хийдэг Боломжит карт зээлийг 200-500 мянган хүн гэж үзвэл нийт зах зээлийн багтаамж багадаа 849 тэрбумаас 2.1 их наяд төгрөг байхаар таамаглагдаж байна.**

Түүнчлэн ЛэндМН аппликейшн татаж авсан тоо 2017 онд 100 мянга гаруй байсан бол 2020 оны байдлаар даруй 8 дахин өсч 890 мянга хол давсан байна. Үүнээс зээлийн гэрээ байгуулсан хэрэглэгчийн тоо 2020 оны байдлаар 175,271 болж өссөн байна. Банк санхүүгийн аппликейшн ашиглаж буй хэрэглэгчийн тоог хамгийн багадаа 200,000, нхдээ 500,000 гэж үзэх юм бол зах зээлийн багтаамж сард дунджаар 46-116 тэрбум буюу жилийн 0.5-1.3 их наяд төгрөг байхаар харагдаж байна. Энэ нь нийт ЛэндМН хэрэглэгчийн 65%-тай дүйцнэ гэж үзвэл нийт зах зээлийн багтаамж ойролцоогоор 0.8-2 их наяд хүртэл төгрөг байхаар таамаглагдаж байна.

**Г.Өрхийн орлого, хэрэглээний зөрүү, ДНБ-ийн өсөлтөд суурилсан судалгаа**

Монгол улсын хувьд өрхийн орлогын хэмжээ эдийн засгийн өсөлтийн хувь хэмжээнээс 95%, өрхийн хэрэглээ нь 79%-ийн хамааралтай байна. 2010 оны дүнтэй зэрэгцүүлэх үнээр тооцсон 2011-2020 оны өрхийн хэрэглээ, орлогын өсөлтийн хувь хэмжээг бодит ДНБ-ийн өсөлтийн хувь хэмжээтэй харьцуулахад дараах үр дүн гарч байна.

Зураг . Өрхийн орлого эдийн засгийн өсөлтийн хамаарал




*Эх сурвалж: ҮСХ*

Эндээс харахад эдийн засаг болон өрхийн орлого өсөхөд хэрэглээ давж өсдөг бол өрхийн орлого буурахад хэрэглээ дагаж буурдаг ч харьцангуй бага хэмжээгээр буурдаг байна. Мөн өрхийн орлогын өсөлтөөс шалтгаалж үүсэн хэрэглээний өсөлтийн тодорхой хэсэг тогтмол хэрэглээ болж үлддэг байна. 2010 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон өрхийн орлого хэрэглээний зөрүү 2021 онд 2.56 их наяд төгрөг байх тооцоо байгаа ч арилжааны банкны зээл гаргалтын бууралт ББСБ-ын зээлийн үлдэгдэл тогтвортой байх нэг үндэс болж байна. Нөгөө талаас финтек хэлбэрээр зээл олгож байгаа компаниудын зээлийн эрэлт тогтвортой байна гэж харж байна.

Бодит ДНБ, Өрхийн хэрэглээ, Өрхийн орлогыг цалин болон бусад орлогоор тооцож 2010 оны зэрэгцүүлэх үнэд шилжүүлэн харьцуулахад, өрхийн хэрэглээний хэмжээ, өрхийн цалин болон бусад орлогын зөрүүгээр тодорхойлсон дүн 2015 оны эдийн засгийн хүндрэлээс хойш нэмэгдсээр 2020 онд зөвхөн эрэлтээс шалтгаалан 1.56 их наяд төгрөгт хүрсэн байна.



2021/05/24

2021.06.23

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



**Зураг.Өрхийн хэрэглээ болон орлого, ДНБ-тай харьцуулсан судалгаа /Нэгж: их наяд төг/**




*Эх сурвалж: Монгол банк, судлаачийн тооцоолол*

Мөн 2020 оны хувьд Covid 19 цар тахал болон хөл хорионы улмаас МУ-ын эдийн засгийн өсөлт -5.3% болж буурсан байгаа. Ирээдүйн Өрхийн орлого хэрэглээний зөрүүгээр тодорхойлсон зах зээлийн хэмжээг 2010 оны зэрэгцүүлэх үнээр тооцон 2030 онд 5.29 их наяд төгрөг хүртэл өсөх хэмээн таамаглаж байна. Энэ нь дараагийн 10 жилд цаашид 2.4 дахин өсөх төсөөлөл юм. Энэхүү төсөөлөл дараагийн 5 жилийн Бодит ДНБ-ийн дундаж өсөлтийг 5% гэж тооцсон болно. 2020 онд энэ зөрөө 1.56 их наяд байсан ба банкны 1 жилийн хугацаатай иргэдийн зээлийн үлдэгдэл 1 их наяд, ББСБ-ын хэрэглээний зээл 1.2 их наяд төгрөг байсан байна.

Монгол банкны судалгаагаар иргэд орлогоос давсан санхүүгийн хэрэгцээгээ найз нөхөд, ах дүү, гэр бүл (28%), ломбард(16%), ББСБ(4%)-аас зээл авах хэлбэрээр санхүүжүүлдэг гэсэн байна. Энэ нь судалгаанд оролцсон иргэдийн 48% нь буюу дунджаар нийт 1.2 их наяд төгрөгийг бидний зорилтот нийлүүлэлтийн сувгаар дамжуулан зээлдэг гэж үзэж болохоор байна.

**Д. Банкны богино хугацаат зээл болон финтек хэлбэрээр олгосон зээлийн судалгаа**

Өрхийн орлого болон зардлын зөрөө санхүүжүүлж буй арга хэрэгслүүд нь тооцоход 48% нь найз нөхөд, гэр бүл, барьцаалан зээлдүүлэх газраас зээлж байгаа буюу 1.2 их наяд төгрөгийг ЛэндМН ББСБ ХК-ийн зорилтот нийлүүлэлтийн сувгаар дамжуулж авсан байх боломжтой юм.

Одоогийн финтек зах зээл нь богино хугацаатай 6 сая төгрөг хүртэлх зээлэнд төвлөрч байна. Финтекийн зах зээлийн боломжит хэмжээг арилжааны банкнуудын богино хугацаат зээлийн үлдэгдэл болон финтек хэлбэрээр олгосон зээлийн үлдэгдлийн дүнд үндэслэв. Ирээдүйн зах зээлийн хэмжээ 2020, 2021 оны эдийн засгийн төсөөлөл болон жилийн 5%-ийн CAGR-р тооцоход 2020 онд 1.2 их наяд төгрөг байх зах зээл 2030 онд 2.3 их наяд төгрөг хүртэл өсөх хэмээн таамаглаж байна. Энэхүү төсөөлөлд дараагийн 5 жилийн эдийн засгийн өсөлт болон арилжааны банкны зээл олголтын өсөлт нөлөөлнө. Богино хугацаат зээл болон финтек хэлбэрээр олгож буй зээлийн зах зээлд нөлөөлөгч үндсэн индикаторууд нь эдийн засгийн өсөлт, өрхийн хэрэглээ болон өрхийн орлогын зөрөө, чанаргүй зээлийн түвшин, Интернет банкны хэрэглээний түвшингээс хамаарна.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 рд 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК
ХХК
200

**Арилжааны банкуудын богино хугацаат зээлийн үлдэгдэл болон финтек хэлбэрээр олгосон зээлийн үлдэгдлийн дүнд үндэслэсэн зах зээлийн хэмжээ 1.2 их наяд төгрөг байхаар таамаглаж байна.**

**Е. Бизнесийн мөчлөг дээр үндэслэсэн зах зээлийн багтаамж**

Хятад улс финтек салбарын хөгжлөөр дэлхийд тэргүүлсээр байна. Тус улсын нийт иргэдийн 76% нь зээлийн картгүй ба финтек шийдлээр зээл олгох боломжтой асар том зах зээл хэвээр буйг Оливер Ваймэн Анализ тайланд 2019 онд дурдсан байна. Үүнд нөлөөлөх болсон гол хүчин зүйл нь Хятадын эрх зүйн орчин, смарт утас хэрэглэгчдийн тооноос гадна финтек бүтээгдэхүүнүүд банкны салбарын хүрч чадаагүй эрэлттэй зах зээл буюу жижиг дунд бизнес болон банкны шаардлага хангаагүй бизнесийнхэнд хүрч эхэлснээр маш том зах зээлийг бий болгож чадсан явдал юм.

**Зураг29. Хятадын интернет кредит зээлийн үлдэгдэл /их наяд юан/**




*Эх сурвалж: Ант Файнэншл Компанийн IPO проспектусаас*

Хятад улс нь дэлхийд финтек хэрэглэгчдийн тоогоор тэргүүлэгч буюу судалгаанд оролцсон иргэдийн 70% нь финтек хэрэглэдэг гэжээ.

## ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА:

ЛэндМН ББСБ ХК нь Монгол улсын хамгийн анхны хиймэл оюун ухаанд суурилан дэвшилтэт технологийг санхүүгийн үйлчилгээтэй хослуулсан финтек шийдэл бүхий бичил зээл олгох аппликейшн билээ. ЛэндМН нь тус аппликейшнээрээ дамжуулан Лэнд хэтэвч үйлчилгээг ашиглан төлбөр тооцоо, мөнгөн шилжүүлэг хийх болон барьцаагүй зээл авах боломжийг хэрэглэгчиддээ санал болгодог.Энэхүү аппликешнийг ашиглан хэрэглэгчид 2 сая хүртэлх төгрөгийн зээлийг 7, 14, 21 болон 30 хоногийн хугацаатайгаар авах боломжтой. ЛэндМН аппликейшн нь Google Play Store дээр 500,000+ хандалтыг авч, 3000 гаруй хэрэглэгчдийн сэтгэгдлийг цуглуулж, сэтгэгдлийн үнэлгээгээр 4.3 гэсэн үнэлгээг авсан байна.

2017 онд анх ЛэндМН аппликейшн олон нийтэд танилцуулснаас хойш энэхүү салбарт олон өрсөлдөгчид шинээр орж ирж байгаа нь хэр ирээдүйтэй салбарыг онилон харж зах зээлд түүчээлэн нэвтрүүлж чадсан байна вэ гэдгийг харуулж байна. Мөн түүнчлэн өрсөлдөгчдийн цар хүрээ нэмэгдэх нь хэрэглэгчдэд шаардлагатай өндөр өрсөлдөөн дундаас чанартай үйлчилгээг хүртэх, улам илүү давуу талуудыг олж авах таатай боломжуудыг нээж өгч байна. Энэхүү судалгаанд дараах 3 аппликейшнийг өрсөлдөгчдийг төлөөлүүлэн сонгосон бөгөөд товч танилцуулгуудыг хүргэж байна:



СЗХ 2021.06.23
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2021-06-18 БҮРТГЭВ
ЛЭНДМН ББСБ ХК УЛААНБААТАР ХОТ
2021/05/24
УЛААНБААТАР ХОТ ... КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ
№ 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



**1. Pocket аппликейшн /Инвескор Хэтэвч ББСБ ХХК/**

Pocket.mn апп нь “Инвескор Хэтэвч ББСБ” ХХК-иас гаргасан цахим зээл, цахим төлбөр тооцооны үйлчилгээ бүхий финтек болон хиймэл оюун ухааны технологид суурилсан апп бөгөөд харилцагч албан ёсны мэдээллүүдийг бөглөж бүртгүүлсний дараа харилцагчийн зээлжих эрхийг Монгол банкны зээлийн мэдээллийн сан болон системийн хиймэл оюун ухаанд тулгуурлан тогтоодог бичил зээл олгох апп юм. Харилцагчид нь 10 сая хүртэлх төгрөгийг 14 хоногоос 180 хүртэлх хоногийн хугацаатайгаар авах боломжтой бөгөөд Google Play Store дээр 100,000+ хандалтыг авч, 2000 гаруй хэрэглэгчдийн сэтгэгдлийг цуглуулж, сэтгэгдлийн үнэлгээгээр 4.5 гэсэн үнэлгээг авсан байна.

*Эх сурв: Play store, компанийн мэдээлэл, үйлчилгээний танилцуулга*

**2. Simple аппликейшн /Ашид Капитал ББСБ ХХК/**

Simple.mn апп нь сүүлийн үеийн ухаалаг технологийг ашиглан харицагчдынхаа цаг, энерги, мөнгийг хэмнэх зорилго бүхий дижитал зээлийн үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд биометрик мэдээлэлд тулгуурлан харилцагчаа таньж мэдэж, мөн зээлийг шийдвэр гаргалт, зээл олголтын үйл явцыг автоматжуулсан финтек апп юм. Харилцагчид нь 10 сая хүртэлх төгрөгийн зээлийг 1-12 сарын хугацаатайгаар авах боломжтой бөгөөд Google Play Store дээр 100,000+ хандалтыг авч, 339 хэрэглэгчдийн сэтгэгдлийг цуглуулж, сэтгэгдлийн үнэлгээгээр 3.5 гэсэн үнэлгээг авсан байна.

*Эх сурв: App store, Play store, компанийн мэдээлэл, үйлчилгээний танилцуулга*

**3. Ард аппликейшн /Ард Кредит ББСБ ХК/**

Энэхүү апп нь мөн технологийн шийдлийг ашиглан харилцагчидаа хаанаас ч, хэзээ ч өөрийн санхүүгийн санхүүгийн хөрөнгийг удирдах боломжийг олгож байгаа бөгөөд харилцагч апп-ийг татаж, гар утсандаа суулгаж бүртгүүлэн 5 сая төгрөг хүртэлх зээлийг 6 сарын хугацаатайгаар авах боломжтой юм. Мөн энэхүү апп нь Google Play Store дээр 500,000+ хандалтыг авч, 4000 гаруй хэрэглэгчдийн сэтгэгдлийг цуглуулж, сэтгэгдлийн үнэлгээгээр 4.2 гэсэн үнэлгээг авсан байна.

*Эх сурв: App store, Play store, компанийн мэдээлэл, үйлчилгээний танилцуулга*

**Өрсөлдөөний үнэлгээгээр ЛэндМН ББСБ ХК-ын өрсөлдөх чадварыг дурдвал:**

**Хувь хүнд тохирсон үйлчилгээ:** Хиймэл оюун ухаан (AI) нь хэрэглэгчдийн зээлийн үнэлгээг тооцоолж, зээлдэгчийн төлбөрийн чадварт таарсан зээлийг олгоно.

**Үнэнч хэрэглэгчид зориулсан урамшууллын систем:** Урамшууллын систем нь хэрэглэгчдэд илүү их зээлийг бага шимтгэлээр авах боломжийг олгодог. Тиймээс шимтгэл бууруулалт нь дахин зээл авахад хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг нэмж, зээлээ хугацаанд нь төлөх хандлагыг дэмжиж, санхүүгийн сахилга батад сургаж байна.

**Зардлын хэмнэлт:** Финтек компанийн хувьд нэг харилцагчид ногдох үйл ажиллагааны зардал нь банктай болон бусад банк бустай харьцуулахад бага байна. Толгой компани нь систем хөгжүүлэлтийг хийдэг ба ЛэндМН зөвхөн турших болон засварын зардал гаргадаг.

**Онцгой нөөц:** AI-ийн оновчтой стратегийн хүрээнд чанаргүй зээл нь бусад банкны хэрэглээний зээлийн чанаргүй зээлээс бага байна. Компани нь зах зээлд хүчтэй хоногшуулалт хийж байгаа ба өрсөлдөгч гарч ирэхээс өмнө үнэнч хэрэглэгчдийг татаж байна.



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ₯1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ЭЛИТ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5153505 СТС2420

СЭХ
2021.06.23 өдөр


МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭЭ-03



## БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТААМАГЛАЛ

ЛэндМН ББСБ ХК нь олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлж, барьцаагүй бичил зээлийг олгож эхлээд багагүй хугацаа өнгөрөөд байна. Тус компанийн зээлийн бүтээгдэхүүн нь техник технологийн шийдлийг ашиглан бичил зээл олгох процессыг бүрэн автоматжуулж олон мянган харилцагч зээлдэгчдийн цаг хугацаа болон бусад нөөцийг хэмнэсэн үйлчилгээ юм. Тухайн бүтээгдэхүүн үйлчилгээ олон нийтийн дунд дэлгэрч, хэрэглэгчид, хөрөнгө оруулагчдаас өндөр үнэлгээ авч санхүүгийн салбарт финтек технологи, бүтээгдэхүүний инновацийн шинэ жишгийг авчирсан нь ялангуяа салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлж байна.

Бүтээгдэхүүн үйлчилгээний онцлог нь барьцаагүй бичил зээлийг түргэн шуурхай байдлаар ухаалаг гар утсаар дамжуулан олгодог бөгөөд хөрөнгө оруулагч нарт итгэл төрүүлж өндөр өгөөжтэй санхүүгийн бүтээгдэхүүнийг эзэмших боломж олгож байна.

ЛэндМН ББСБ ХК /бонд гаргагч/-ийн үйл ажиллагаа явуулж буй зах зээл нь нийт орхийн орлого болон зардлын зөрүү болох -2.52 их наяд төгрөг (2021 оны прогноз) хүртэл тэлэх боломжтой төсөөлөлтэй байна.(2020 он нь Covid-19 цар тахалтай холбоотой хөл хорио, бизнесийн үйл ажиллагаа болон хэрэглэгчдийн худалдан авалт саатсан зэрэг нь богино хугацааны өрхийн орлого зардлын зөрөөг бүрэн илэрхийлж чадахгүй гэж үзэв). Энэхүү зах зээлд урт хугацаанд санхүүгийн сахилга баттай харилцагчдыг нэмэгдүүлж тэдний богино хугацаат санхүүгийн хэрэгцээг түргэн шуурхай хангаж, салбарын өрсөлдөөн, хөгжлийг түргэсгэж, нийгмийн нөөцийг үр ашигтай зарцуулахад хувь нэмрээ оруулан ажиллахаар зорьж байна.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ




Эх сурвалж: Компанийн бизнес төлөвлөгөө

ЛэндМН ББСБ ХК-ийн харилцагчдын тоо 2020 оны эцэст 175,271 болж өмнөх оны мөн үеэс даруй 5.3% өссөн байна. Харилцагчдын тоо хэдийгээр өссөн боловч хөл хорио, эдийн засгийн эргэлт удааширсан, өрхийн хэрэглээ буурсантай холбоотойгоор зээлийн дүн буурахад нөлөөлсөн гэж үзэж байна. Гэвч эдийн засаг хэвийн нөхцөлд шилжсэнээр хэрэглээний дүн огцом өсөх хандлагатай юм. Компанийн бизнес



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206
2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК
ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ



төлөвлөгөөний дагуу харилцагчдын өсөлтийн хувь тогтворжиж 2025 оны байдлаар 275,573 харилцагчтай болох төсөөлөлтэй байна. Иймд хүү болон шимтгэлийн орлогын гол үзүүлэлт болох харилцагчдын тооны төсөөллийг ЛэндМН ББСБ ХК-ийн үндсэн үйл ажиллагаатай уялдуулан, өрхийн хэрэглээ болон орлогын зөрөө болох өрхийн ахиу хэрэглээний (зөрөө) түвшинг ашиглан таамаглав.

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТААМАГЛАЛ

Хүснэгт . Санхүүгийн тайлангийн таамаглал /Сая ₮/

| | 2018 A | 2019 A | 2020 A | 2021 F | 2022 F | 2023 F | 2024 F | 2025 F |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Нийт хөрөнгө** | **24,323** | **58,100** | **39,681** | 45,797 | 61,491 | 82,939 | 92,401 | 102,424 |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 4,218 | 6,756 | 9,521 | 3,214 | 3,338 | 6,527 | 5,704 | 4,707 |
| Харилцагчдад олгосон нийт зээл | 19,210 | 50,007 | 28,115 | 41,231 | 56,809 | 75,089 | 85,402 | 97,355 |
| Хэвийн зээл | 18,075 | 47,055 | 25,036 | 37,719 | 52,636 | 70,430 | 80,368 | 91,302 |
| Хугацаа хэтэрсэн зээл | 792 | 1,218 | 514 | 678 | 925 | 1,236 | 1,616 | 2,082 |
| Чанаргүй зээл | 343 | 1,734 | 2,565 | 2,834 | 3,248 | 3,423 | 3,418 | 3,971 |
| Зээлийн эрсдэлийн сан | (444) | (1,552) | (3,343) | (4,190) | (4,710) | (5,057) | (5,269) | (6,070) |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | - | - | 2,500 | 2,500 | 2,500 | 2,500 | 2,500 | 2,500 |
| Бусад хөрөнгө | 693 | 1,385 | 1,647 | 1,886 | 2,252 | 2,625 | 2,807 | 3,021 |
| Үндсэн хөрөнгө | 258 | 1,162 | 1,063 | 1,011 | 1,188 | 1,173 | 1,203 | 889 |
| Биет бус хөрөнгө | 388 | 342 | 178 | 145 | 113 | 83 | 53 | 23 |

| | 2018 A | 2019 A | 2020 A | 2021 F | 2022 F | 2023 F | 2024 F | 2025 F |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Өр төлбөр** | 10,969 | 40,902 | 22,159 | 25,708 | 33,334 | 47,864 | 49,925 | 50,276 |
| Зээлийн эх үүсвэр | 9,849 | 37,985 | 20,489 | 23,934 | 31,334 | 45,434 | 47,434 | 47,834 |
| Бондын өр төлбөр | 6,329 | 3,523 | 7,266 | 9,636 | 8,636 | 14,436 | 14,436 | 15,336 |
| Итгэлцэл | - | 13,696 | 10,364 | 11,957 | 19,557 | 19,457 | 21,457 | 21,457 |
| Банкны зээл | 3,520 | 8,604 | 2,859 | 186 | 1,386 | 8,486 | 186 | 686 |
| Бусад зээл | - | 12,162 | - | 2,155 | 1,755 | 3,055 | 11,355 | 10,355 |
| Бусад өр төлбөр | 1,120 | 2,917 | 1,670 | 1,774 | 2,000 | 2,430 | 2,491 | 2,442 |

| | 2018 A | 2019 A | 2020 A | 2021 F | 2022 F | 2023 F | 2024 F | 2025 F |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Эздийн өмч** | 13,354 | 17,198 | 17,522 | 20,089 | 28,157 | 35,075 | 42,476 | 52,148 |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 10,814 | 10,814 | 10,814 | 10,814 | 10,814 | 10,814 | 10,814 | 10,814 |
| Халаасны хувьцаа | 0 | (266) | (989) | (1,493) | (1,493) | (1,493) | (1,493) | (1,493) |
| Тайлант үеийн ашиг (алдагдал) | 2,560 | 4,910 | 2,240 | 3,206 | 5,389 | 6,457 | 8,047 | 9,672 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | (20) | 1,740 | 5,457 | 7,249 | 10,134 | 14,984 | 20,795 | 28,842 |
| Бусад эздийн өмч | - | - | - | 313 | 3,313 | 4,313 | 4,313 | 4,313 |
| **Нийт өр төлбөр болон эздийн өмч** | 24,323 | 58,100 | 39,681 | 45,797 | 61,491 | 82,939 | 92,401 | 102,424 |

*'Хүлээгдэж буй төлөвлөгөө*



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК
ХХК
5183855
9021031196 СТС2420

**Дүрмийн сан өсөх төлөвтэй байна:** 2019 онд нийт хөрөнгийн 70 гаруй хувийг өр төлбөр эзлэн, түүний дийлэнх хэсгийг итгэлцэл болон банкны зээл эзэлж байсан бол 2020 оны эцэст өр төлбөрийн эзлэх хувь хэмжээ 55.8% болон буурсан байна. Компанийн үйл ажиллагаа тогтвортой нэмэгдсэнээр 2025 онд эздийн өмчийн дүн 2021 онтой харьцуулахад 2.6 дахин өсөх төлөвтэй байна. Компани финтект суурилсан бичил зээлийн зах зээлийн эрэлт хэрэгцээ болон зээл гаргалтын дүн, харилцагчдын тоо, зээл гаргах эх үүсвэрийн тогтвортой байдал зэрэг үзүүлэлт дээр үндэслэн өртөг бага санхүү эх үүсвэрээр зээлийн багцын дүнг нэмэгдүүлж ашигт ажиллагааг нэмэгдүүлэх стратеги баримтлан ажиллаж байна.

Зураг . Өр төлбөр ба эздийн өмч




Эх сурвалж: Компанийн дотоод мэдээлэл

**Нийт хөрөнгө өсөх төлөвтэй байна:** ЛэндМН ББСБ ХК-ийн нийт хөрөнгө 2020 оны эцэст 39.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үзүүлэлтээс 31.7%-р буурсан байна. Энэхүү бууралтыг задаргаа харвал өр төлбөр 44.7%-р буурч эздийн өмч 2%-иар өссөн байна. Компанийн эрсдлийн удирдлагын бодлого, цар тахалтай холбоотой иргэдийн зээлийн буурах хандлага, бизнесийн зогсонги байдал зэргийг урьдчилан тооцоолж эрсдэлтэй зээлийн багцыг бууруулах, өртөг өндөртэй эх үүсврийг хаах зэрэг бодлого авч хэрэгжүүлсэн нь оновчтой байсан гэж дүгнэж болохоор байна. Санхүүгийн зах зээл дээр зээлийн бизнесийн хувьд эх үүсвэр болон олгогдож буй зээлийн хугацааг зөв удирдах нь маш чухал байдаг. ЛэндМН ББСБ ХК-ийн хувьд бизнес загвар нь урт хугацаат эх үүсвэрээр богино хугацаат зээл гаргадаг тул эх үүсвэр болон зээл гаргалтын хугацааны удирдлагын эрсдэлд өртөх магадлал харьцангүй бага байдаг онцлогтой. Энэхүү бизнес загварын онцлог нь цар тахлын үеийг эрсдэл багатай даван туулснаар дахин нэг батлагдсан гэж үзэж болох юм. Компани нь цаашид зээлийн үйл ажиллагаагаа өөрийн болон бусад эх үүсвэрээр тогтвортой нэмэгдүүлснээр 2025 оны байдлаар 2020 онтой харьцуулахад нийт хөрөнгийн дүн 2.6 дахин өсч 102 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөлтэй байна.



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

2021/05/24

СЗХ 2021.06.23 БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



## ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ТААМАГЛАЛ

Хүснэгт . Орлогын тайлангийн таамаглал /сая төгрөг/

| | 2018 A | 2019 A | 2020 A | 2021 F | 2022 F | 2023 F | 2024 F | 2025 F |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хүү, шимтгэлийн орлого | 7,143 | 18,497 | 16,298 | 15,093 | 19,961 | 24,942 | 29,743 | 33,105 |
| Хүүгийн зардал | (512) | (4,487) | (5,229) | (3,567) | (5,076) | (7,226) | (8,545) | (8,692) |
| Цэвэр хүүгийн орлого | 6,631 | 14,010 | 11,069 | 11,526 | 14,885 | 17,716 | 21,198 | 24,413 |
| Эрсдэлийн сангийн зардал | (408) | (1,619) | (2,393) | (1,639) | (1,484) | (1,918) | (2,449) | (3,039) |
|---|---|---|---|
| 1. | **Очирсүрэнгийн Болдбаатар** (Гүйцэтгэх захирал ) | (Дээрхээс танилцана уу.) | (Дээрхээс танилцана уу.) |
| 2. | **Жаргалсайханы Мөнхзаяа (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга) (Хавсралт 2.21)** | 2002 онд Улсын багшийн их сургуульд байгууллагын менежерийн бакалавр; 2012 онд Австрали Улсын Флиндерсийн Их сургуулийг Хэрэглээний хүн ам судлал (Applied Population Studies)-ийн магистр. | 2002-2004 онд "МОНЦАМЭ Агентлаг"-т редактор; 2005-2019 онд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд мэргэжилтэн; 2019 оноос одоог хүртэл "Анд Глобал" ПиТиИ ЭкТиДи-д менежер. |
| 3. | **Бүлтэнгийн Увдал (Дэд захирал) (Хавсралт 2.22)** | 1996 онд Турк улсын Анкарагийн их сургуулийн ТОМЕР турк хэлний курс; 2000 онд Турк улсын Анкарагийн их сургуулийн эдийн засгийн институтэд эдийн засгийн бакалавр; 2003 онд Турк улсын Анкарагийн их сургуулийн нийгмийн ухааны институтэд эдийн засгийн магистр. | 2004-2006 онд "Анунгоо" ХХК-д ложистикийн менежер; 2006-2007 онд "Анунгоо" ХХК-д менежер (forecast manager); 2006-оноос хүртэл "Анунгоо" ХХК-д мэргэшсэн сургагч багш; 2007-2009 онд "Анунгоо" ХХК-д ложистикийн хэлтсийн захирал; 2009-2010 онд "Эм Си Эс менежмент" ХХК-д дотоод аудит; 2010-2012 онд "Грандхаан ЭфЭмСиЖи" групп компанид ложистик, хангамж нийлүүлэлтийн захирал; 2011 оноос одоог хүртэл төрийн худалдан авах ажиллагааны мэргэшсэн мэргэжилтэн; 2015-2018 онд "Анунгоо" ХХК-д бизнес хөгжил, хангамжийн сүлжээний захирал; 2016-2017 онд "Анунгоо" ХХК-д маркетингийн захирал; 2019-2020 онд "М" ХХК ("М" |



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
ХХК
5183556
9021031195 СТС2420

СЗХ
БҮ 2021 06 23
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



| | | | |
|---|---|---|---|
| | | | LLC)-д бизнес хөгжил, дата судалгааны багийн ахлагч;<br>2020-одоог хүртэл "Ашид капитал" ХХК-д дата шинжилгээний хэлтсийн захирал;<br>2020-одоог хүртэл "ЛэндМН ББСБ" ХК-д дэд захирал; |
| 4. | **Махбалын Түвшинжаргал** (Санхүү, үйл ажиллагааны газрын захирал) (Хавсралт 2.23) | 1999 онд Монгол Улсын Техникийн Их сургуульд усан барилгын бакалавр;<br>2005 онд Санхүү эдийн засгийн дээд сургуульд бизнесийн удирдлагын бакалавр;<br>2013 онд Удирдлагын академид бизнесийн удирдлагын магистр. | 2001-2005 онд "Ус инженер" ХХК-д инженер, эдийн засагч, менежер;<br>2005.05-2005.11 онд "Дэлхийн зөн" олон улсын байгууллагад хяналтын инженер;<br>2006-2016 онд "Ньюфонд ББСБ" ХХК-д зээлийн ахлах мэргэжилтэн;<br>2016 оноос ЛэндМН ББСБ гүйцэтгэх захирал, Санхүү, үйл ажиллагааны газрын захирал. |
| 5. | **Магмарцэрэнгийн Бямбасүрэн** (Эрсдэлийн удирдлагын газрын захирал) (Хавсралт 2.24) | 2009 онд Монгол Улсын Их сургуульд бакалавр;<br>2014 онд Санхүү эдийн засгийн дээд сургуульд бизнесийн удирдлагын магистр. | 2010-2014 онд "Хасбанк" ХХК-д теллер;<br>2014-2015 онд "Хасбанк" ХХК-д зээлийн хяналтын мэргэжилтэн;<br>2015-2015 онд "Хасбанк" ХХК-д ерөнхий захирлын туслах;<br>2015-2018 онд "Хасбанк" ХХК-д комплаенсийн мэргэжилтэн;<br>2018-2019 онд "Петровис Ойл" ХХК-д засаглал, комплаенсийн менежер;<br>2019-2020 онд "ЛэндМН ББСБ" ХК-д эрсдэл, хяналт шалгалтын газрын ахлах менежер;<br>2020-2021 онд "ЛэндМН ББСБ" ХК-д эрсдэл, хяналт шалгалтын газрын захирал. |
| 6. | **Сэргэлэнгийн Ажаргал** (Ерөнхий нягтлан) (Хавсралт 2.25) | 2001 онд Монгол Улсын Их сургуульд нягтлан бодох бүртгэлийн бакалавр. | 2002-2010 онд "Монгол Шуудан банк"-д ахлах нягтлан бодогч;<br>2014-2015 онд "Трансkапитал ББСБ" ХХК-д нягтлан бодогч;<br>2015-2019 онд "Капитал банк"-д нягтлан бодогч, бүртгэлийн хяналтын |



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
ХХК
5183855
9021031195 СТС2420

232

СЗХ
2021.06.23 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



| | | | |
|---|---|---|---|
| | | | мэргэжилтэн, салбарын захирал;<br>2019 оноос "Монголиан Эйрвейс Карго" ХХК-д нягтлан бодогч<br>2020 оны 3-р сараас "ЛэндМН ББСБ"ХК-д Ерөнхий нягтлан бодогч |

Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав:

| КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА | | | | | |
|---|---|---|---|---|---|
| № | Нэрс/Шаардлага | Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг эсэх | Ял шийтгэл эдэлж байгаа эсэх (КтХ-ийн 84.3.2)* | Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан эсэх (КтХ-ийн 75.8) | Хувь хүн байх (КтХ-ийн 77.3, 83.2, 83.3) |
| 1 | Ц.Одмаа (ТУЗ-ийн дарга) | Үгүй | Үгүй* | Тийм /2020.04.10-ны өдөр, Дугаар 0731121/ (Хавсралт 2.26) | Тийм |
| 2 | О.Болдбаатар (ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал) | Үгүй | Үгүй* | Тийм /2017.12.04-ний өдөр, Дугаар 0130848/ (Хавсралт 2.27) | Тийм |
| 3 | В.Баярсайхан (ТУЗ-ийн гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм /2019.02.24-ний өдөр, Дугаар 0520839/ (Хавсралт 2.28) | Тийм |
| 5 | Б.Дэлгэрмаргал (ТУЗ-ийн гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм /2014.09.13-ны өдөр, Дугаар 0130233/ (Хавсралт 2.29) | Тийм |



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 CTC2420

СЗХ
2021.06.23
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | Н.Цэцэгмаа (ТУЗ-ийн гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм /2019.02.24-ний өдөр. Дугаар 0520841/ (Хавсралт 2.30) | Тийм |
| 7 | С.Энх-Амгалан (ТУЗ-ийн гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм /2019.02.24-ний өдөр. Дугаар 0520840/ (Хавсралт 2.31) | Тийм |
| 8 | С.Боргил (ТУЗ-ийн хараат бус гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм /2018.08.31-ний өдөр. Дугаар 0130985/ (Хавсралт 2.32) | Тийм |
| 9 | Ж.Жаргалсүрэн (ТУЗ-ийн хараат бус гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм /2018.04.13-ны өдөр. Дугаар 0230323/ (Хавсралт 2.33) | Тийм |
| 10 | Б.Өлзийбаяр (ТУЗ-ийн хараат бус гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм /2013.03.16-ны өдөр. Дугаар 0420019/ (Хавсралт 2.34) | Тийм |
| 11 | Ж.Мөнхцэцэг (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга) | Үгүй | Үгүй* | Тийм /2019.04.26-ний өдөр. Дугаар 0731008/ (Хавсралт 2.35) | Тийм |
| 12 | Бүлтгэнгийн Удвал (Дэд захирал) | Үгүй | Үгүй* | Үгүй | Тийм |
| 13 | М.Түвшинжаргал (Санхүү, үйл ажиллагааны захирал) | Үгүй | Үгүй* | Үгүй | Тийм |
| 14 | Мягмарцэрэнгийн Бямбасүрэн (Эрсдэл, хяналт нийцүүлэлтийн газрын захирал) | Үгүй | Үгүй* | Үгүй | Тийм |
| 13 | С.Азжаргал (Ерөнхий нягтлан бодогч) | Үгүй | Үгүй* | Үгүй | Тийм |



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ЭЙБИАЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
234

*Монгол Улсын Хууль зүйн сайдын 2017 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн A/195 тоот тушаалын 6 дугаар зүйлд заасны дагуу Ял шийтгэлтэй эсэх лавлагааг өмгөөллийн нөхөрлөлд олгологгүй тул Компанийн тухай хуулийн 84.3.2-т заасан шийтгэл эдлээгүй байх шаардлагыг ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнууд хангаж байгаа эсэхийг бидэнд гаргаж өгсөн мэдүүлэг, баталгааг үндэслэж дүгнэв

Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүд нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавих нэмэлт шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав:

| ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах нэмэлт шаардлага | | | | |
|---|---|---|---|---|
| № | Шаардлага | ТУЗ-ийн хараат бус гишүүдийн нэрс | | |
| | | С.Бергин | Ж.Жаргалсүрэн | Б.Өлзийбаяр |
| 1. | Өөрөө эсхүл компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй байх (КтХ-ийн 79.1.1) | Тийм** | Тийм** | Тийм** |
| 2. | Өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанид болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, сүүлийн 3 жилийн хугацаанд аливаа ажил, албан тушаал эрхэлж байгаагүй байх (КтХ-ийн 79.1.2, КЗК-ийн 5.2.4) | Тийм** | Тийм** | Тийм** |
| 3. | Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй байх (КтХ-ийн 79.1.3) | Тийм** | Тийм** | Тийм** |
| 4. | Компанитай бизнесийн гэрээ хэлцэл байгуулаагүй байх, тийм холбоогүй байх (КтХ-ийн 79.1.4) | Тийм** | Тийм** | Тийм** |
| 5. | Сүүлийн 5 жилд компанид нэгдмэл сонирхолтой этгээд болж байгаагүй байх (КЗК-ийн 5.2.4) | Тийм** | Тийм** | Тийм** |
| 6. | Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй зөвлөх үйлчилгээ үзүүлдэггүй байх (КЗК-ийн 5.2.4) | Тийм** | Тийм** | Тийм** |
| 7. | Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдэд ханган нийлүүлэгч ба харилцагч биш байх (КЗК-ийн 5.2.4) | Тийм** | Тийм** | Тийм** |
| 8. | Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдэд үйлчилгээ | Тийм** | Тийм** | Тийм** |



2021/05/24

СЗХ
2021.06.23
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



| | | | | |
|---|---|---|---|---|
| | үзүүлэх гэрээ хийгээгүй байх (КЗК-ийн 5.2.4) | | | |
| 9. | Компанийн ТУЗ, гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, дотоод аудитын албаны нэгдмэл сонирхолтой этгээд биш байх (КЗК-ийн 5.2.4) | Тийм** | Тийм** | Тийм** |
| 10. | Хувьцаа эзэмшигч эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдийн ойрын хамаатан биш байх (КЗК-ийн 5.2.4) | Тийм** | Тийм** | Тийм** |

**Компанийн тухай хуулийн 79.1.1-79.1.4 зүйл, Компанийн засаглалын кодексийн 5.2.4-т заасан ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг тус компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүд хангаж байгаа эсэхийг тэдний гаргаж өгсөн мэдүүлэг, баталгааг үндэслэж дүгнэв.

Компанийн Гүйцэтгэх удирдлага, Эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангаж байгаа бөгөөд тэдгээр нь Компанийг удирдах чадвар, дадлага туршлагатай гэж дүгнэв.



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ☘ 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855 236
9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

2021.06.23



5. Компанийн дүрэм бусад холбогдох журмууд нь хууль тогтоомж, СЗХ-ноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-д нийцсэн эсэх

***ЛэндМН ББСБ ХК-ийн дүрэм.*** Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 01 тоот тогтоолоор баталж, хамгийн сүүлд 2020 оны 03 дугаар сарын 28-ны 03 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан "ЛэндМН ББСБ" ХК-ийн дүрэм (цаашид "Дүрэм" гэх)-ийг (Хавсралт 1.6) хүчин төгөлдөр мөрдөж байна. Дүрэм нь нийт 5 бүлэгтэй бөгөөд Компанийн оноосон нэр, оршин байгаа хаяг, Компанийн эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох, Компанийн хувь нийлүүлсэн болон өөрийн хөрөнгө, Компанийн удирдлага, хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, түүний дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод, тэдгээрийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан, тэдний эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлох, Компанийн дотоод болон хөндлөнгийн аудит, Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл, тайлан, их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийх хэлцэл хийх, үнэт цаас худалдах, эргүүлэн авах, ногдол ашиг хуваарилан олгох, Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Үнэт цаас гаргагчийн Дүрэм нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйл болон бусад холбогдох зохицуулалтад нийцсэн байна.

**Компанийн засаглалын журмууд**

***ТУЗ-ийн үйл ажиллагааны журам.*** Компанийн ТУЗ нь өөрийн үйл ажиллагаа Компанийн засаглалын кодекст нийцүүлэх зорилгоор нийт 15 бүлэгтэй "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг 2018 оны 06 дугаар сарын 04-ны өдрийн 18/13 тоот тогтоолын хавсралт 1-ээр батлан (Хавсралт 3.1) мөрдөж байна. Тус журмаар ТУЗ-ийн гишүүдэд тавигдах шаардлага, гишүүдийн үүрэг хариуцлага, ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргын бүрэн эрх, хариуцлага, ТУЗ-ийн хороодын чиг үүргийг тодорхойлох, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, шалгаруулах, гишүүдийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх, ТУЗ-ийн хурлыг зарлах, түүнд бэлтгэх, хуралдуулах, шийдвэр гаргах, шийдвэрийг мэдээлэх, биелэлтэд хяналт тавих, ТУЗ-ийн гишүүдийн идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхүйц цалин урамшуулал олгох, хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам нь Компанийн тухай хуулийн 76.1, 80.4, Компанийн засаглалын Кодексийн 5.1.4, 5.2.2-т заасан холбогдох шаардлагыг тус тус хангасан байна. Харин Компанийн хувьцаа МХБ-ийн I дүгээр ангилалд бүртгэгдсэнтэй холбоотойгоор Компанийн засаглалын кодексын шаардлагын дагуу зарим өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.

***Компанийн ногдол ашгийн бодлого.*** ТУЗ-өөс баримтлах ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах нөхцөл журмыг Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын Кодекст нийцүүлэн нийт 4 бүлэгтэй Ногдол ашгийн бодлогыг 2017 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 17/02 тоот тогтоолын Хавсралт 1-ээр батлан (Хавсралт 3.2) мөрдөж байна. Тус бодлогод ногдол ашгийг хуваарилах нөхцөл, ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр, ногдол ашиг хуваарилах, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулсан байна.

***Эрсдэлийн удирдлагын бодлого.*** Компанийн ТУЗ-ийн 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 19/55 тоот шийдвэрийн хавсралтаар Компанийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн цар хүрээ буюу төрөл, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ, эрсдэлийг хянах, үнэлэх, хариу арга хэмжээ авах, тайлагнах, удирдах бүтэц, чиг үүрэг, үйл явц болон тэдгээрийг зохицуулах бодлого, журам, аргачлалаас бүрдсэн Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх эрсдэлийн удирдлагын тогтолцоо, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зарчмыг тодорхойлох зорилгоор нийт 10 бүлгээс бүрдсэн бодлогыг (Хавсралт 3.3) батлан хэрэгжүүлж байна. Энэхүү бодлогын бичиг баримт нь Компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог тодорхойлж, эрсдэлийн удирдлагын засаглал, бүтэц, чиг үүрэг, эрсдэлийн төрөл, ангилал, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ, эрсдэлийн удирдлагын зарчим, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, эрсдэлийн загвар,



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ☎1118267206
2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ОЛБИЙ ЗЭЭЛ КО КАПИТАЛ ҮЦК ХХК
237
5183855
9021031195 СТС2520

СЗХ
он ... сар ... өдөр
2021.06.23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



эрсдэлийн хяналт, тайлагнал, дотоод аудит ба баталгаажуулалт, эрсдэлийн магадлалыг тодорхойлох шалгуур, эрсдэлийн үр дагаврыг үнэлэх шалгуур, эрсдэлийн тоон үнэлгээ, эрэмбэ тодорхойлох шалгуурыг зохицуулсан байна.

***Санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлого.*** Компанийн ТУЗ-ийн 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 19/13 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан уг бодлогын баримт бичиг (Хавсралт 3.4)-т хамрах хүрээ, нэр томьёоны тайлбар, санхүүгийн эрсдэлийг хариуцах албан тушаалтан, тэдгээрийн чиг үүрэг, эрсдэлийн хязгаарлалтыг тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний төрлөөр тодорхойлох, зохистой харьцаа, баримтлах зарчим, төлөвлөлт, Компанийн ТУЗ, гүйцэтгэх захирал, бусад эрх бүхий албан тушаалтнуудын эрх хэмжээ, тайлагналын талаар тусгасан нь СЗХ-оос баталсан зохистой харьцааны шалгуурт нийцэж байна.

***Дотоод хяналтын бодлого.*** Компанийн дэвшүүлсэн зорилтуудад хүрэхийн тулд үйл ажиллагааны зохистой, үр ашигтай байдал, санхүүгийн тайлагналын үнэн зөв, бодитой байдал, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангасан байдал зэрэгт хяналт тавих үйл явцыг зохицуулах, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Компанийн ТУЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 20/38 тоот тогтоолын Хавсралт 1-ээр баталсан нийт 6 бүлгээс бүрдэх Дотоод хяналтын бодлого (Хавсралт 3.5) болон ТУЗ-ийн 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн № 21/01 тоот тогтоолын Хавсралтаар баталсан Дотоод аудитын дүрэм (Хавсралт 3.6)-ийг батлан мөрдүүлж байна. Энэхүү дотоод хяналтын бодлого нь дотоод хяналтын тогтолцоо, оролцогч талуудын хүлээх үүрэг, хариуцлага, дотоод хяналтын зарчим, үүрэг хариуцлагын матриц зэргийг зохицуулсан. Дотоод аудитын дүрэм нь нийт 9 хэсгээс бүрдсэн бөгөөд Дотоод аудит/дотоод аудитын нэгж, эсхүл аудитор/-ын үүрэг, мэргэжлийн стандарт ба зарчим, үйл ажиллагааны зохион байгуулалт, хараат бус байдал бодитой хандлага, зөвшөөрөгдсөн эрх, хүлээх үүрэг, комплаенс болон эрсдэл хариуцсан нэгжүүд, хөндлөнгийн аудитортай харилцах, тайлагнах болон эргэн хянах мониторинг, чанарын баталгаажуулалт болон сайжруулах хөтөлбөр зэргийг зохицуулсан. Дээрх бодлого, дүрэм нь холбогдох хууль тогтоомж, 2011 оны Засгийн газрын 311 тоот тогтоолд нийцсэн байна.

***Хөдөлмөрийн дотоод журам.*** Компанийн гүйцэтгэх захирал нь 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 2020/46 тоот тушаалын Хавсралт 1-ээр Компанийн дотоод үйл ажиллагааг зохицуулах, ажилтнуудын хөдөлмөрийн оновчтой үр өгөөжтэй зохион байгуулах, хөдөлмөрийн бүтээмж, ажил үйлчилгээний чанар, үр дүнг дээшлүүлэхэд хяналт тавих, ажилтныг сонгон шалгаруулах, хөдөлмөрийн сахилга батыг бэхжүүлэх, шагнаж урамшуулах, тэтгэмж болон чөлөө олгох, сахилгын шийтгэл ногдуулахтай холбогдсон хөдөлмөрийн харилцааг зохицуулах зорилгоор нийт 10 бүлгээс бүрдсэн Хөдөлмөрийн дотоод журмыг (Хавсралт 3.7) батлан мөрдүүлж байна. Энэ журмаар компанийн засаглал, зохион байгуулалт, ажил олгогч ажилтны эрх үүрэг, хүний нөөцийн бүрдүүлэлт сонгон шалгаруулалт, ажилд авах ажлаас чөлөөлөх, хэд хэдэн ажил хэрэг гүйцэтгэх, шилжүүлэн ажиллуулах, ажил амралтын цаг, цалин хөлс урамшуулал, сахилгын шийтгэл, компанийн цахим харилцааны талаар зохицуулсан. Компанийн тухай хуулийн 83.1, Компанийн дүрмийн 15.1-д заасан бүрэн эрхийн дагуу Компанийн гүйцэтгэх захирал нь Хөдөлмөрийн дотоод журмыг баталсан байх ба энэхүү журам нь Хөдөлмөрийн тухай хуулийн 5.1, 80.2, 130.1-т заасан шаардлагад нийцсэн байна.

***Цахим зээлийн үйл ажиллагааны журам.*** Гүйцэтгэх захирлын 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 07 тоот тушаалын Хавсралтаар бага дүнтэй, богино хугацааны санхүүгийн хэрэгцээг дэвшилтэт технологи ашиглан агшин зуур санхүүжүүлэх зориулалтаар цахим зээл олгох үйлчилгээг үзүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор нийт 10 бүлгээс бүрдсэн "LENDMN" аппликэйшнээр олгох цахим зээлийн үйл ажиллагааны журмыг (Хавсралт 3.8) батлан мөрдүүлж байна. Энэхүү журмаар зээл олгох хэмжээ, төрөл, зээлдэгчийн оноо, харилцагч бүртгэх, зээл олгох, гэрээ байгуулах нөхцөл, зээлийн эргэн төлөлт, хяналт, зээлийн нягтлан бодох бүртгэл, хариуцлага зэрэг харилцааг зохицуулсан байна. Энэхүү журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн зарчим болон хууль тогтоомжид нийцэж байна.



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ₮.1118267206
2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ЭМ ЭЙ ЭС ЭНД КО КАПИТАЛ УЦК ХХК
238
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2021.06.23 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



***Мөнгөн хөрөнгө, төлбөр тооцооны журам.*** Гүйцэтгэх захирлын 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 2021/13 тоот тушаалын хавсралтаар Компанийн бэлэн болон бэлэн бус мөнгөн гүйлгээ, бэлэн мөнгөний хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хангах, төлбөр тооцооны үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэх, мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулахтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор нийт 8 бүлгээс бүрдсэн Мөнгөн хөрөнгө, төлбөр тооцооны журам (Хавсралт 3.9)-ыг батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь мөнгөн хөрөнгийн удирдлага, зохион байгуулалт, мөнгөн хөрөнгийн төлөвлөлт, хяналт, касс дахь бэлэн мөнгөний бүртгэл, харилцах дансны бүртгэл, мөнгөн хөрөнгийн тайлан, тооллого, хяналт, хоригдох зүйл, хариуцлагын талаар зохицуулсан байна. Энэхүү журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн зарчим болон хууль тогтоомжид нийцэж байна.

***Цахим төлбөр тооцооны үйлчилгээний журам, нөхцөл.*** (Хавсралт 3.10) Гүйцэтгэх захирлын 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 2018/153 дугаар тушаалын хавсралт 1-ээр батлагдсан бөгөөд цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн дагуу цахим төлбөр тооцооны үйлчилгээний нөхцөл, үйлчилгээний шимтгэл, хураамжийн нөхцөл, гэрээ байгуулах, дуусгавар болгох нөхцөл, нягтлан бодох бүртгэл, тайлан мэдээ хөтлөлт, тоног төхөөрөмж, програм хангамж, аюулгүй байдал, эрсдэлийн хяналт, түүнтэй холбоотой эрх, үүрэг, хяналт хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна. Компани нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн хүрээнд цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга хийх болон төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйл ажиллагаа эрхэлж байна. (Хавсралт 6.1) Дүгнэлт гаргах өдрийн байдлаар уг үйлчилгээг Лэнд хэтэвчээр дурдсан тусгай зөвшөөрлийн хүрээнд явуулахтай холбоотой энэхүү журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 (төлбөр тооцооны хэрэгсэл гаргах), 7.1.6 (цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ), тухайн үед хүчин төгөлдөр мөрдөж байсан СЗХ-ны 2011 оны Банк бус санхүүгийн цахим мөнгөний үйлчилгээний журамд[2] тус тус нийцсэн байгаагаас гадна уг тусгай зөвшөөрлүүдийг олгосон СЗХ-ны тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Компани нь Лэнд хэтэвчийн үйлчилгээгээ өөрийн 100 хувийн эзэмшлийн охин компани болох "Супер Ап Хэтэвч" ХХК-д шилжүүлсэн бөгөөд тус охин компани нь банк бус санхүүгийн байгууллага биш учраас Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн дагуу Монголбанкнаас холбогдох тусгай зөвшөөрөл авахаар хүсэлтээ өгч (Хавсралт 6.2, Хавсралт 6.3), 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Монголбанкнаас "Супер Ап Хэтэвч" ХХК-д "цахим мөнгө гаргах" төлбөрийн үйлчилгээ эрхлэх 06 дугаар зөвшөөрөл (Хавсралт 6.4) олгож шийдвэрлэсэн байна. " Супер Ап Хэтэвч" ХХК-ийн Монголбанкнаас авсан тус зөвшөөрөл нь дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр, түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл байдал үүсээгүй байна. (Хавсралт 11.!8)

***Итгэлцлийн үйлчилгээний журам.*** Гүйцэтгэх захирлын 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 2019/44а тоот тушаалын Хавсралт 1-ээр итгэмжлэгч талын бэлэн мөнгө, зээл болон бусад активыг үнэгүйдлээс хамгаалж, ашиг олж өгөх зорилгоор, түүнтэй байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу ирүүлсэн бэлэн мөнгө, тодорхой хугацаанд хянах, ашиглах, захиран зарцуулах, гэрээний хугацаа дуусахад өгөөжийн хамт эргүүлэн олгох талуудын хоорондын харилцааг зохицуулах, хяналт тавих, итгэлцлийн үйлчилгээ эрхлэхэд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, үйлчилгээг боловсронгуй болгох зорилгоор нийт 6 бүлгээс бүрдсэн журам (Хавсралт 3.11)-ыг батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь итгэлцлийн үйлчилгээний зарчим, итгэмжлэгч болон итгэмжлэгдэгчийн эрх, үүрэг, хяналт хариуцлагын талаар зохицуулсан байна. Итгэлцлийн үйлчилгээний журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон СЗХ-ны 2016 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 71 дугаар

[2] Үндэсний төлбөрийн системийн тухай хууль шинээр батлагдаж 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн хүчин төгөлдөр болсон. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А-45 дугаар тушаалаар "Цахим мөнгөний журам" батлагдсан зэрэгтэй холбогдуулан СЗХ-ны 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 376 тоот тогтоолоор "Банк бус санхүүгийн цахим мөнгөний үйлчилгээний журам"-ыг хүчингүй болгосон. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 (төлбөр тооцооны хэрэгсэл гаргах), 7.1.6 дахь заалт буюу "цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ" эрхлэх хуулийн заалт хүчин төгөлдөр хэвээр байх тул тус хуулийн заалт болон өөрийн баталсан журмын дагуу цахим төлбөр тооцооны үйлчилгээг Компани нь үргэлжлүүлж байгааг хууль бус гэж үзэх үндэслэлгүй болно. Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг шинээр батлахдаа хүчин төгөлдөр үйлчилж буй хуультай уялдуулах, шилжилтийн үеийн горимыг тогтоогоогүй нь эрх зүйн харилцаанд оролцогчийн үйл ажиллагааг хязгаарлах үндэслэл болохгүй гэж үзэж байна.



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
он сар өдөр
2021.06.23 В
№ 04

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭЛ-03



тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журамд заасан зарчимд нийцэж байна.

***Факторингийн үйлчилгээний журам.*** Компанийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 2018/184 тоот тушаалын Хавсралт 1-ээр факторингийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийн дагуу үзүүлэх факторингийн үйлчилгээтэй холбоотой журмыг (Хавсралт 3.12) батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь факторингийн үйлчилгээний нөхцөл, оролцогч талуудын эрх, үүрэг, гэрээ байгуулах, үйлчилгээ үзүүлэх, дуусгавар болгох нөхцөл, нягтлан бодох бүртгэл, тайлан мэдээ хөтлөх, тоног төхөөрөмж, програм хангамж, аюулгүй байдал, эрсдэлийн хяналтын талаар зохицуулсан байна.

***Гадаад валютын арилжааны тухай журам.*** Гүйцэтгэх захирлын 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 2019/60 тоот тушаалын Хавсралтаар гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн дагуу гадаад валютыг LendMN аппликейшнээр дамжуулан худалдах, худалдан авах, гадаад улс руу шилжүүлэх, хариуцлага, санхүүгийн тайлан мэдээ гаргахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор нийт 6 бүлгээс бүрдсэн Гадаад валютын арилжааны журмыг (Хавсралт 3.13) батлан мөрдүүлж байна. Энэхүү журмаар гадаад валютын арилжааны нөхцөл, үйлчилгээний оролцогч талууд, тэдгээрийн эрх, үүрэг, гадаад валютын арилжаанд хориглох зүйлс, тоног төхөөрөмж, програм хангамж, аюулгүй байдал, эрсдлийн хяналт, хариуцлага зэрэг зүйлсийг зохицуулсан байна. Энэхүү журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн зарчим болон холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

***Цалин тооцооллын үйлчилгээний журам.*** Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх үйл ажиллагааны хүрээнд Гүйцэтгэх захирлын 2020 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 2020/15 тоот тушаалын Хавсралт 1-ээр Компаниас Монгол Улсад хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд буюу гэрээт компанид хөдөлмөрийн гэрээ болон ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байгаа нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажилтнууд гэрээт компанитай байгуулсан "Цалингийн тооцооны үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний дагуу цалингийн тооцооны үйлчилгээ үзүүлэх, түүнтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор нийт 8 бүлгээс бүрдсэн Цалин тооцооллын үйлчилгээний журмыг (Хавсралт 3.14) батлан мөрдүүлж байна. Энэхүү журмаар Компаниас цалин тооцооллын үйлчилгээ авч байгаа гэрээт компанид ажиллаж буй нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажилтнуудын цалин хөлсийг мэргэжлийн өндөр түвшинд тооцолон олгох, нийгмийн даатгалын тайлан, ХХОАТ-ийн тайлан бэлтгэх, тайлагнах, ажилтнуудын мэдээллээр хангах, түүнтэй холбоотой бүхий л харилцааг зохицуулсан байна. Энэхүү журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн зарчим болон холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

***Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны журам.*** Гүйцэтгэх захирлын 2020 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн 2020/64 тоот тушаалаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй гүйлгээг илрүүлэх, сэжигтэй гүйлгээний болон бусад тайланг Монголбанкны санхүүгийн мэдээллийн албанд дамжуулахтай холбоотой Санхүүгийн зохицуулах хороонд харьяалагдах банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, харилцааг зохицуулах зорилгоор нийт 6 бүлгээс бүрдсэн журмыг (Хавсралт 3.15) батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нийцэж байна.

***Харилцагчийг таньж мэдэх, төлбөр тооцооны эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлд хяналт тавих үйл ажиллагааны журам.*** Гүйцэтгэх захирлын 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 2019/64 тоот тушаалын Хавсралт 1-ээр цахим төлбөр тооцооны үйлчилгээ, түүнтэй холбогдон үүсэх эрсдэлүүдийн үнэлгээг тодорхой мөчлөгтэйгээр стандартын дагуу хийх, харилцагчийг таньж мэдэх, эрсдэл бүхий үйл ажиллагааг зохицуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор нийт 7 бүлгээс бүрдсэн журмыг (Хавсралт 3.16) батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК
ХХК
240

СЗХ
2021.06.23 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



терроризмтой тэмцэх тухай хууль, Монголбанкнаас баталсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх үйл ажиллагааны журамд нийцсэн байна.

***Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр.*** Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай тухай хуулийн 14.1-д дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй байна гэсний дагуу Гүйцэтгэх захирлын 2021 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн 05/01А тоот тушаалын Хавсралт 1-ээр цахим төлбөр, тооцооны үйл ажиллагаанд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээлэхтэй холбоотой үйл ажиллагааг тодорхойлох, зохицуулах зорилгоор нийт 4 бүлгээс бүрдсэн хөтөлбөр (Хавсралт 3.17) батлан мөрдүүлж байна.

***Шүгэл үлээх журам.*** Компанийн гүйцэтгэх захирал нь 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 2021/04 тоот тушаалын Хавсралт 1-ээр Компанийн нэр төр, бүтээгдэхүүн үйлчилгээ, өмч хөрөнгө, үйл ажиллагаатай холбоотой МУ-ын хууль тогтоомж, компанийн дотоод бодлого, журмын талаар ёс зүйн дүрэм зөрчсөн ажилтан болон хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтнууд мэдээлэх буюу шүгэл үлээх, мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх, мэдээлэл өгсөн ажилтны нууцыг хадгалах, хамгаалахтай холбогдлон үүссэн харилцааг зохицуулах зорилгоор нийт 4 бүлэг, шүгэл үлээх журмын процесс зураглал бүхий 1 хавсралтаас бүрдсэн Шүгэл үлээх журам (Хавсралт 3.18)-ыг батлан мөрдүүлж байна. Энэ журмаар журмын зорилго, зохицуулах үйл ажиллагаа, хамрах хүрээ, мэдээллийг гаргах, түүний агуулга, мэдээллийг хүлээн авах, түүний мөрөөр ажиллах үйл явц, хариуцлагатай холбоотой харилцааны талаар зохицуулсан.

***Нууцлалын журам.*** Компанийн гүйцэтгэх захирал нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 2020/121 тоот тушаалын Хавсралт 1-ээр Компанийн нууцтай холбоотой өмч болох аливаа мэдээ мэдээллийг нууцын зэрэглэлээр ангилах, зэрэглэлийн дагуу хадгалах, хамгаалах, нууцад байх хугацааг тогтоох, устгах, алдагдахаас сэргийлэх, нууцад хамааралтай мэдээ мэдээлэлд нэвтрэх болон ашиглахтай холбоотой стандартыг тогтоосон нууцыг алдагдахаас урьдчилан сэргийлэх харилцааг зохицуулах зорилгоор нийт 7 бүлэг болон нууцлалын жагсаалт, нууц материал устгах акт, нууцлалын гэрээний загвар бүхий 3 хавсралтаас бүрдсэн Нууцлалын журам (Хавсралт 3.19)-ыг батлан мөрдүүлж байна. Энэ журмаар журмын зорилго, хамрах хүрээ, нэр томьёоны тайлбар, компанийн нууц, нууцын зэрэглэл, нууц материал танилцуулах, шилжүүлэх, хүлээлгэх, нууц материал хадгалах, устгах, архивт шилжүүлэх, хориглох зүйлс, компани нууц алдагдах, аюулаас урьдчилан сэргийлэх, алдагдсан тохиолдолд авах арга хэмжээ, хариуцлагатай холбоотой харилцааны талаар зохицуулсан бөгөөд энэ нь Байгууллагын нууцын тухай хууль болон Хувь хүний нууцын тухай хуульд нийцэж байна.

***Хувьцааг эргүүлэн худалдан авч, хадгалах журам.*** Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 20/37 тоот тогтоолын Хавсралт 2-оор Компанийн гаргасан нийт энгийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтээс эргүүлэн худалдан авч, хадгалах ажиллагааг зохицуулах зорилгоор нийт 6 зүйлтэй Хувьцааг эргүүлэн худалдан авч, хадгалах журам (Хавсралт 3.20)-ыг батлан мөрдүүлж байна. Энэ журмаар нийтлэг үндэслэл, холбогдох хууль тогтоомж, үйлчлэх хүрээ, хувьцааг эргүүлэн худалдан авах нөхцөл, хувьцааг эргүүлэн худалдан авах үйл ажиллагаанд оролцогчийн бүрэн эрхтэй холбоотой харилцааны талаар зохицуулсан бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2-д нийцэж байна.

Компанийн дүрэм бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, СЗХ-оос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцсэн байна.

Компани нь дээр дурдсан журмуудаас гадна хүний нөөц, нягтлан бодох бүртгэл, харилцагчид үйлчилгээ үзүүлэх зэрэг журам, бодлого зааврыг баталж мөрддөг байна.



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 ЦБ 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ЭРДЭНЭ ЗЭВЛЭЛ КАПИТАЛ ҮЦК
ХХК

СЭХ
2021.06.23
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



[illegible]

Бид тус Компаниас ирүүлсэн Компанийн үйл ажиллагаанд гоЛлох ач холбогдол бүхий дор дурдсан гэрээг хянасан болно.

***Хөдөлмөрийн контракт гэрээ*** (Хавсралт 4.1) Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээг 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдөр таван жилийн хугацаатай байгуулсан. Тус гэрээнд Гүйцэтгэх захирлын эрх үүрэг, түүний дотор ТУЗ-ийн зөвшөөрөлтэйгээр хэрэгжүүлэх эрх, үүрэг, Гүйцэтгэх захирлын хүлээх хариуцлага, үл өрсөлдөх, давхар ажил эрхлэхийг хязгаарлах, ажлын нөхцөл, цалин, урамшуулал, нэмэгдэл хөлс, хөнгөлөлт хангамж, олговор, тэтгэмж, эд хөрөнгийн хариуцлага, контрактыг цуцлах, дуусгавар болох нөхцөл, нууцлал зэргийг тодорхойлсон нь Хөдөлмөрийн тухай хуульд нийцэж байна.

***Лицензийн гэрээ.*** Компани нь 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 2017/19 тоот "*Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх (лиценз)-ийн гэрээ*" (Хавсралт 4.2) болон 2017 оны 01 дугаар сарын 02-ны өдрийн L_002 тоот гэрээ (Хавсралт 4.3)-г шинэчилсэн гэрээ болох 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 2017/20 тоот "*Үйлчилгээний гэрээ*" (Хавсралт 4.4)-г тус тус "Анд Системс" ХХК-тай байгуулж "LendMN" /application, core system/ бүтээлийг ашигладаг бөгөөд мөн "LendMN" аппликейшн, түүний системийг ашиглах, түүнтэй холбогдон гарах нэвтрүүлэлтийн ажил, хэрэглэгчид хүргэх, дагалдах засвар үйлчилгээг авах, мэдээллийн нууцлал, системийг төлбөр тооцоо хийх зэрэг үйлчилгээг авдаг.

"Анд системс" ХХК нь "Анд системс тех" ХХК-д "LendMN" /application, core system/ бүтээлийн өмчлөх эрхийг шилжүүлэн өгсөн. Улмаар "Анд системс" ХХК, "Анд системс тех" ХХК болон "ЛэндМН ББСБ" ХХК нар "*Үйлчилгээний гэрээний эрх үүрэг шилжүүлэх гэрээ*" (Хавсралт 4.5) болон "*Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх (лиценз)-ийн гэрээний эрх үүрэг шилжүүлэх гэрээ*" (Хавсралт 4.6)-г тус тус 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр байгуулсан.

Дээрх 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 2017/19 тоот "*Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх (лиценз)-ийн гэрээ*"-ний 12.1-т Бүтээл ашиглагч нь Бүтээл өмчлөгчийн бүтээсэн бусад бүтээлийг тэргүүн ээлжинд ашиглах эрхтэй гэж заасны дагуу Компани нь "Анд системс тех" ХХК-тай 2018 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн 2018/263 тоот "Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх (лиценз)-ийн нэмэлт гэрээ" (Хавсралт 4.7)-г байгуулсан. Мөн Шинэ коронавирус халдварт өвчний тархалттай холбогдуулан Засгийн газар болон холбогдох эрх бүхий байгууллагуудын шийдвэр мөн эдийн засгийн нөхцөл байдал зэргийг харгалзан 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр 2017/20/01 тоот "Нэмэлт гэрээ" (Хавсралт 4.8)-г "Анд системс тех" ХХК-тай харилцан тохиролцож байгуулсан байна. Эдгээр гэрээ хэлцлүүдийг талууд бичгээр байгуулан эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж баталгаажуулсан, Иргэний хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

***Зээлийн гэрээнүүд:***

***Худалдаа хөгжлийн банк болон "ЛэндМН ББСБ" ХК нарын хооронд 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр байгуулагдсан ОЭГ/CC181026004-1 тоот Овердрафтын эрх нээх гэрээ.*** (Хавсралт 4.9)

Гэрээний мэдээлэл:

- Зээлийн дүн: 800,000,000 (найман зуун сая) төгрөг
- Зээлийн зориулалт: гэрээний 1.2-д заасныас бусад зээлийн зориулалт
- Зээлийн хүү: жилийн XX хувь
- Нэмэгдүүлсэн хүү: төлөгдөөгүй овердрафтын хүүний 20 хувьтай тэнцүү
- Зээлийн хугацаа: 12 сар



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ₮1118267200

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗЭН ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855 242
9021031195 СТС2420

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



- Хариуцлага: гэрээний салшгүй хэсэг болох барьцаа, баталгааны гэрээнд заасны дагуу уг хөрөнгө, эх үүсвэрээс овердрафт, түүний хүү, нэмэгдүүлсэн хүүг үл маргах журмаар төлүүлж барагдуулна
- Эргэн төлөлт: овердрафтын эрхийг ашигласан өдрөөс эхлэн хуанлийн 30 хоногийн дотор төлнө.

Гэрээнд зээлийн дүн, үндсэн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ, зээлийн хугацаа, зориулалт, зээл төлөх хэлбэр, эргэн төлөлтийн хуваарь, зээлдэгч болон зээлдүүлэгчийн эрх, үүрэг, талуудын хүлээх хариуцлага, баталгаа ба зөвшөөрөл, эрх залгамжлуулах, шилжүүлэх, гэрээ дуусгавар болох цуцлах нөхцөл, журам, маргаан шийдвэрлэх заалтуудыг тусгасан байх ба эдгээр нөхцөлүүд нь Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

ОЭГ/СС181026004-1 тоот зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор Компани нь Худалдаа хөгжлийн банктай 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан ЗБ/СС1810026004-1-1 тоот (Хавсралт 4.10) хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээг байгуулсан. Худалдаа хөгжлийн банктай 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан ОЭГ/СС181026004-1-1 тоот (Хавсралт 4.11) Овердрафтын эрх нээх нэмэлт гэрээ байгуулж зээлийн хугацаа, хүү, дүнг өөрчилж байсан. Уг Зээлийн эрх нээх гэрээний нэмэлт өөрчлөлтийн дагуу Компани нь Худалдаа хөгжлийн банктай ЗБ/СС191008001-1-6 тоот (Хавсралт 4.12) хөдлөх эд хөрөнгийн болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ байгуулж, түүнд барьцааны зүйлийн үнэлгээ нь 1,200,000,000 төгрөг байхаар тохиролцсоныг ЗБ/СС191008001-1-6 тоот барьцааны гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдөр ЗБ/СС181026004-1-1-1 тоот (Хавсралт 4.13) хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны нэмэлт гэрээнд барьцааны зүйлийн үнэлгээ 1,450,000,000 төгрөг" гэж өөрчилсөн.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Худалдаа хөгжлийн банктай 2020 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан ОЭГ/СС181026004-1-2 тоот (Хавсралт 4.14) Овердрафтын эрх нээх нэмэлт гэрээгээр:

- Зээлийн хугацаа: 36 сар;
- Жилийн хүү: XX хувь;
- Зээлийн дүн: 1,400,000,000 (нэг тэрбум дөрвөн зуун сая) төгрөг.

Дээрх нэмэлт гэрээ нь ЗБ/СС191008001-1-6 тоот хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны салшгүй хэсэг ба тус барьцааны гэрээний 3.1 дэх хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулж 2020 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр ЗБ/СС191008001-1-6-1 тоот (Хавсралт 4.15) хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны нэмэлт гэрээнд барьцааны зүйлийн үнэлгээг " 1,400,000,000 төгрөг" гэж өөрчилсөн нь зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж дуусах хүртэл хугацаанд хэвээр үйлчлэхээр байна.

Одоогоор дээр дурдсан зээлийн гэрээнээс өөр хүчин төгөлдөр үйлчилж буй зээлийн гэрээ байхгүй, эдгээр гэрээний үүргийн гүйцэтгэл хэвийн хэрэгжиж буй бөгөөд сүүлийн 3 жилд байгуулсан бусад бүх зээлийн гэрээ зохих ёсоор хэрэгжиж дууссан болохыг Компанийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 05/776 тоот албан бичгээр нотлогдсон болно (Хавсралт 11.18). Эдгээр зээлийн ангилал "хэвийн" хэрэгжиж байна (Хавсралт 10.5, Хавсралт 10.6, Хавсралт 10.7, Хавсралт 10.8, Хавсралт 10.9, Хавсралт 10.10, Хавсралт 10.11).

***Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тэн болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ:***



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ☎ 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5103855
9021031195 CTC2420

243

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭСЭН



Бидэнд ирүүлсэн мэдээллээр Компани нь сүүлийн 3 жилийн хугацаанд Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн (Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 8,000,000,000 төгрөг бөгөөд үүний 5 хувь нь 400,000,000 төгрөг) бүхий үүрэг хүлээсэн нийт 47 гэрээ байгуулсан. Тэдгээрээс их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлээс гадна 2018 оны 1 гэрээ, 2019 оны 1 гэрээ болон 2020 оны 5 гэрээ тус тус хэвийн хэрэгжиж байна. Бусад гэрээ нь бүрэн хэрэгжиж дууссан. (Хавсралт 11.18) Эдгээр хэвийн хэрэгжиж буй тус 7 гэрээний жагсаалтыг доорх хүснэгтээр харуулж байна:

| № | Гэрээний нөгөө тал, нөхцөл | Хэрэгжиж буй эсэх |
|---|---|---|
| 1. | Худалдаа хөгжлийн банктай 2018.11.02-ны өдөр ОЭГ/CC181026004-1 тоот Овердрафтын гэрээ байгуулсан. (Дэлгэрэнгүйг дээрээс буюу зээлийн гэрээ хэсгээс харна уу.) | Хэрэгжиж байгаа |
| 2. | Гадаад улсын хуулийн этгээд XX-тэй түүний бэлэн мөнгө, бусад активыг үнэгүйдлээс хамгаалах, ашиг буюу үр шим олж өгөх зорилгоор тухайн хөрөнгийг хадгалах, хянах, өөрийн эрхлэх үйл ажиллагаанд ашиглах, захиран зарцуулахтай холбоотой харилцааг зохицуулсан хөрөнгө, баталгаа, талуудын эрх үүрэг, хариуцлага, зөрчлийн тохиолдол, мэдэгдэл хүргүүлэх, давагдашгүй хүчин зүйл, хэрэглэгдэх хууль болон маргаан шийдвэрлэх талаар тусгасан ХИУГ 20/14 тоот Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ 2020 оны 06 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан. (Хавсралт 4.16) (Гэрээний үнэ: 1,200,000.00 ам.доллар) | Хэрэгжиж байгаа |
| 3. | Гадаад улсын хуулийн этгээд XX-тэй түүний бэлэн мөнгө, бусад активыг үнэгүйдлээс хамгаалах, ашиг буюу үр шим олж өгөх зорилгоор тухайн хөрөнгийг хадгалах, хянах, өөрийн эрхлэх үйл ажиллагаанд ашиглах, захиран зарцуулахтай холбоотой харилцааг зохицуулсан хөрөнгө, баталгаа, талуудын эрх үүрэг, хариуцлага, зөрчлийн тохиолдол, мэдэгдэл хүргүүлэх, давагдашгүй хүчин зүйл, хэрэглэгдэх хууль болон маргаан шийдвэрлэх талаар тусгасан ХИУГ 20/15 тоот Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ 2020 оны 06 дугаар сарын 19-ний өдөр байгуулсан. (Хавсралт 4.17) (Гэрээний үнэ: 1,100,000,000.00 төгрөг) | Хэрэгжиж байгаа |
| 4. | Монгол улсын хуулийн этгээд XX-тэй XX хугацаанд санхүүжилт авахаар тохиролцож санхүүжилт, талуудын эрх үүрэг, хариуцлага, төлөөлөл ба баталгаа, гэрээ цуцлах, мэдэгдэл, давагдашгүй хүчин зүйл, маргаан шийдвэрлэх талаар тусгасан ХИУГ 20/16 тоот Financing agreement 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан. (Хавсралт 4.18) (Гэрээний үнэ: 200,000.00 ам.доллар) | Хэрэгжиж байгаа |
| 5. | Төрийн банктай валютын своп хэлцэл хийхээр тохиролцож арилжааны хэлбэр нөхцөл, эхний болон сүүлийн гүйлгээнүүдийн нөхцөл, талуудын хүлээх хариуцлага зэргийг зохицуулсан 2020.06.16-ны өдөр Sw-20/06/16/01 тоот Валютын своп арилжааны хэлцэл (Хавсралт 4.19)-ийг байгуулсан байна. (Гэрээний үнэ: 1,200, 000.00 ам.доллар) | Хэрэгжиж байгаа |
| 6. | Төрийн банктай валютын своп хэлцэл хийхээр тохиролцож арилжааны хэлбэр нөхцөл, эхний болон сүүлийн гүйлгээнүүдийн нөхцөл, талуудын хүлээх хариуцлага зэргийг зохицуулсан 2020.12.02-ны өдөр Sw-20/12/02/01 тоот Валютын своп арилжааны хэлцэл (Хавсралт 4.20)-ийг байгуулсан байна. (Гэрээний үнэ: 520,000.00 ам.доллар) | Хэрэгжиж байгаа |
| 7. | Гадаад улсын хуулийн этгээд XX-тэй тодорхой нөхцөлөөр бонд захиалахаар тохиролцож бонд, хүүгийн, урьдчилсан төлөлт, цуцлах, дефолт, төлөөлөл баталгаа, татвар, мэдэгдэл, ерөнхий нөхцөл зэргийг тусгасан 19/07 тоот Bond Subscription Agreement (Хавсралт 4.21) 2019 | Хэрэгжиж байгаа |



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ☎ 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
ХХК
5163655
9021031195 СТС2420

СЗХ
2021.06.23

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭЛ-03



| | | |
|---|---|---|
| | оны 12 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан байна. (Гэрээний үнэ: 400,000.00 ам доллар) | |

Дээр дурдсан гэрээнүүд нь Монгол Улсын хууль тогтоомж, СЗХ-оос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд байгуулагдсан гэж үзнэ.

***Даатгалын гэрээнүүд:***

***Эрүүл мэндийн даатгалын гэрээ*** (Хавсралт 4.22) Компани нь ажилтангуудынхаа эрүүл мэндийг даатгуулах зорилгоор хэвтэн эмчлүүлэх, архаг хууч өвчнийг эмчлүүлэх, амбулаторийн болон урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоонд хамрагдах хамгаалалт бүхий №21/00445861 тоот "Жаргалан эрүүл мэндийн даатгалын гэрээ"-г "Мандал даатгал" ХК-тай 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдөр 1 жилийн хугацаатайгаар байгуулсан байна. Энэхүү гэрээ нь одоогоор хүчин төгөлдөр бөгөөд Монгол Улсын Иргэний хууль, Даатгалын тухай хууль тогтоомжид нийцсэн байна.

***Тээврийн хэрэгслийн даатгалын гэрээ*** (Хавсралт 4.23) Компани нь өөрийн эзэмшил, өмчлөлийн 2039 УАВ улсын дугаар (Арлын дугаар: WVGZZZCRZKD030818) бүхий Volkswagen Touareg маркийн тээврийн хэрэгслийг Монгол Улсын нутаг дэвсгэрт гэрээнд заагдсан замын хөдөлгөөнд оролцох үеийн болон оролцоогүй байх үеийн эрсдэлүүд, хулгайн эрсдэлүүд, байгалийн эрсдэлүүд, галын тэсрэлт дэлбэрэх эрсдэлүүд зэрэг даатгалын эрсдэл үүсэн тохиолдол нөхөн төлбөрийг төлөх, даатгуулагч нь даатгагчид даатгалын хураамж төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор "Номин даатгал" ХХК-тай 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдөр "Тэгш 4 тээврийн хэрэгслийн даатгалын гэрээ"-г 1 жилийн хугацаатай байгуулсан байна. Энэхүү гэрээ нь одоогоор хүчин төгөлдөр бөгөөд Монгол Улсын Иргэний хууль, Даатгалын тухай хууль тогтоомжид нийцсэн байна.

Компани нь өөрийн эзэмшил, өмчлөлийн 0830 УБО улсын дугаар (Арлын дугаар: ZVW305057939) бүхий Приус маркийн тээврийн хэрэгслийг байгалийн эрсдэл, галын болон тэсрэлт, дэлбэрэлтийн, зам тээврийн хөдөлгөөнд оролцох үеийн, зогсоолд байрлуулах болон гаргах үеийн, дугуйнаас үүдэн гарсан, жолоо шилжүүлсэн үеийн, зогсоолд байх үеийн, тээврийн хэрэгслийн салхины шил, цонхонд дангаар учирсан хохирол, хулгайн хэрэг учран гарах хохирлын зэрэг учирч болох эрсдэлүүдээс сэргийлэн даатгуулах зорилгоор "Мандал Даатгал" ХК-тай 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдөр №21/00467921 тоот "Тээврийн хэрэгслийн даатгалын гэрээ" (Хавсралт 4.24)-г 2022 оны 05 сарын 17-ны өдөр дуусах хугацаатай байгуулсан байна. Энэхүү гэрээ нь одоогоор хүчин төгөлдөр бөгөөд Монгол Улсын Иргэний хууль, Даатгалын тухай хууль тогтоомжид нийцсэн байна.

Компани нь мөн жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдөр 1 жилийн хугацаатай даатгуулсан нь хүчин төгөлдөр бөгөөд (Хавсралт 4.25) 2020 оны 05 сарын 21-ний өдөр 1 жилийн хугацаатай (Хавсралт 4.26) даатгуулсан нь 2021 оны 05 сарын 21-ний өдөр хугацаа дуусгавар болох байгаа бөгөөд хугацаа дуусмагц нэн даруй сунгах арга хэмжээ авахыг Компанийн Гүйцэтгэх захирал баталгаа гаргасан болно (Хавсралт 11.18).

***Түрээсийн гэрээ.*** (Хавсралт 4.27) Компани нь Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж 34 хаягт байрлах барилгын 1, 6 давхрын нийт 449.9 мкв талбайг 5 жилийн хугацаатайгаар түрээслэх зорилгоор Монгол Улсын иргэн ХХ-тэй 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдөр №2018/150 тоот "Түрээсийн гэрээ"-г байгуулжээ. Энэхүү гэрээгээр талуудын эрх, үүрэг, хариуцлага, түрээсийн төлбөр, хугацаа,түрээсийн талбай хүлээлгэх, түрээсийн талбайн засвар тохижилт, сайжруулалт, эвдрэл гэмтэл, барьцаа, түрээсийн талбайг дахин түрээслүүлэх, шилжүүлэх, гэрээг өөрчлөх, цуцлах, дуусгавар болох, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, маргаан шийдвэрлэх журам зэргийг зохицуулсан байна. Энэхүү гэрээнд 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр, 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж түрээсийн талбай, түрээсийн төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулсан. Энэхүү гэрээ нь одоогоор хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд Монгол Улсын Иргэний хуульд нийцсэн байна.



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
245

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



***Үндсэн үйл ажиллагаатай холбоотой гэрээний загварууд:***

***Цахим зээлийн эрх нээх гэрээний загвар.*** (Хавсралт 4.28) Компанийн харилцагчтай байгуулдаг цахим зээлийн эрх нээх гэрээний загварын дагуу Компани нь харилцагчид зээлийн эрх, зээлийн дээд эрх нээж, нээсэн эрхийн дагуу зээл олгохтой холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү цахим зээлийн эрх нээх гэрээний загварыг хянаж үзэхэд зээлийн нөхцөл, талуудын эрх, үүрэг, хариуцлага, гэрээний хугацаа дуусгавар болох, түүнийг цуцлах, маргаан шийдвэрлэх зэргийг тусгасан зэрэг нь Иргэний хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байна.

***Хөдөлмөрийн гэрээний загвар.*** (Хавсралт 4.29) Компанийн ажилтнуудтайгаа байгуулдаг хөдөлмөрийн гэрээний загварт Хөдөлмөрийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан гэрээнд тусгах гол нөхцөлүүд болох ажлын байрны буюу албан тушаалын нэр, ажлын байрны тодорхойлтод заасан ажил, үүрэг, үндсэн цалин буюу албан тушаалын цалингийн хэмжээ, хөдөлмөрийн нөхцөлийг тусгасан бөгөөд Хөдөлмөрийн тухай хуульд нийцсэн байна.

***Нууцлалын гэрээний загвар.*** (Хавсралт 4.30) Компани нь Байгууллагын нууцын тухай хуулийн 4.2 дахь хэсэгт зааснаы дагуу ажилтантай байгуулах нууцлалын гэрээнд Компанийн нууцад хамаарах зүйлсийг тусгасан бөгөөд энэ нь Байгууллагын нууцын тухай хууль болон Хувь хүний нууцын тухай хуульд нийцэж байна.

***Цахим төлбөр тооцооны үйлчилгээний гэрээний загвар.*** 2018 оны 10 дугаар 19-ний өдрийн 2018/153 тоот Гүйцэтгэх захирлын тушаалын 4 дүгээр хавсралтаар нийт 10 бүлгээс бүрдсэн "Цахим төлбөр тооцооны үйлчилгээний гэрээ"-ний загвар (Хавсралт 4.31)-ийг баталсан нь Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Монголбанкнаас баталсан 2018 оны Цахим мөнгөний журамд нийцсэн байна.

***Хамтран ажиллах гэрээний загвар.*** (Хавсралт 4.32) Энэхүү гэрээний загварын дагуу Компани нь LendMN аппликейшнд байгууллагын үйлчилгээнд зориулан нэмэлт цэс байршуулж, аппликейшнээр дамжуулан хэрэглэгчдэд тус байгууллагын үйлчилгээг хүргэх, "Анд системс" ХХК нь тус нэмэлт цэсийг хөгжүүлэх, байгууллага нь LendMN аппликейшнээр дамжуулан төлбөр тооцоог хүлээн авахтай холбоотой харилцааг зохицуулж байна. Тус гэрээний загвар нь талуудын хамтын ажиллагааны нөхцөл, үйлчилгээний үнэ, төлбөр тооцоо, талуудын эрх, үүрэг, хариуцлага, системийн хэвийн ажиллагаа, үйлчилгээ, аюулгүй байдлыг хангах, өгөгдөл мэдээлэл, нууцлалын үүрэг, ажил хэргийн нэр хүнд, барааны тэмдэг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, гомдол, маргаан шийдвэрлэх, гэрээ дуусгавар болох, эрх шилжүүлэл, мэдэгдэл хүргүүлэх журам зэргийг тусгасан зэрэг нь Иргэний хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байна.

***Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний загвар.*** Итгэлцэл, хөрөнгө удирдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн үндсэн дээр Компани нь харилцагчидтай байгуулдаг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.33)-гээр итгэмжлэгчийн мөнгөн хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалж, ашиг буюу үр шим олж өгөх зорилгоор итгэмжлэгчийн хөрөнгийг хадгалах, өөрийн эрхлэх үйл ажиллагаанд ашиглах, захиран зарцуулах, үр шимийн хамт буцаан төлөх, шилжүүлэх болон түүнтэй холбоотой харилцааг зохицуулж байна. Энэхүү гэрээний загварыг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам болон Иргэний хуулийн 406-р зүйлд зааснаы дагуу боловсруулсан байна.

***Хөрөнгө оруулалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээний загвар.*** (Хавсралт 4.34) Энэхүү гэрээний загварын дагуу Компани нь хаалттай захиалгын үндсэн дээр өрийн бичиг гаргах, түүний үндсэн төлбөр болон хүүг төлөх, худалдан авагч нь бонд эзэмшихтэй холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулж байна. Тус гэрээний загвар нь нийтлэг үндэслэл, гэрээний хугацаа, бонд, түүний нөхцөл, бондын төлбөр, бонд гаргагчийн эрх, үүрэг, худалдан авагчийн эрх, үүрэг, гэрээ цуцлах, дуусгавар болгох үндэслэл, талуудын хариуцлага, талуудын мэдэгдэл баталгаа зэргийг тусгасан зэрэг нь Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байна.



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ➝ 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
246
5183855
9021031185 СТС2420

СЭХ
2021 оны 06 сарын 23 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



***Plus итгэлцлийн үйлчилгээний гэрээний загвар.*** (Хавсралт 4.35) Энэхүү загварын гэрээгээр итгэмжлэгч нь "PLUS" итгэлцлийн үйлчилгээгээр үйлчлүүлж харилцан тохиролцсон нөхцөлийн дагуу ашиг буюу үр шим хүртэх зорилгоор мөнгөн хөрөнгөө компанид итгэмжлэн шилжүүлэх, компани нь итгэмжлэгчид ашиг буюу үр шим олж өгөх зорилгоор мөнгөн хөрөнгийг итгэмжлэн удирдаж, өөрийн эрхлэх зээлийн үйл ажиллагаанд ашиглах, захиран зарцуулах, ашиг буюу үр шимийн хамт итгэмжлэгчид буцаан төлөхтэй холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулж байна. Тус гэрээний загвар нь ерөнхий үндэслэл, үйлчилгээний нөхцөл, үйлчилгээг ашиглах, хөрөнгө байршуулах, түүний хэмжээ, үйлчилгээний хугацаа, хөрөнгийн өгөөж, түүнийг тооцох, хөрөнгө буцаан татах, татвар суутгал хийх, үйлчилгээний хугацаа сунгах, хөрөнгийн зориулалт, төлбөрийн баталгаа, талуудын эрх үүрэг, хариуцлага, гэрээ цуцлах, дуусгавар болгох нөхцөл зэргийг тусгасан зэрэг нь Иргэний хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон СЗХ-ны 2016 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 71 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журамд заасан зарчимд нийцэж байна.

***Андеррайтер болон зөвлөх үйлчилгээний гэрээ.*** Үнэт цаас гаргагчийн Монголын Хөрөнгийн Биржид нээлттэй Бондыг гаргах ажлыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4.3-д заасан Хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах /Best Effort/ хэлбэрээр зохион байгуулах, андеррайтерийн үйлчилгээг үзүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, Бонд гаргагч нь үйлчилгээний төлбөрийг төлөхтэй холбогдуулан талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулсан 2021/13 тоот "Андеррайтер болон зөвлөх үйлчилгээний гэрээ" (Хавсралт 5.35)-г 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдөр андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний ТЗ 301/42 дугаар /http://www.frc.mn/o/6703/, 5183855 регистрийн дугаартай "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК, брокер, дилерийн, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, ТЗ 301/116 дугаар /http://www.frc.mn/o/198521/, 6481299 регистрийн дугаартай "Райнос инвестмент ҮЦК" ХХК нартай байгуулсан. "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК нь үнэт цаас гаргах үйл ажиллагаанд "Андеррайтер"-аар, "Райнос инвестмент ҮЦК" ХХК нь "Синдикат"-аар оролцож, хамтран ажиллахаар тохиролцсон. Энэхүү гэрээ нь Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 2.1-д заасан шаардлагад нийцсэн байна

***Аудитын үйлчилгээний гэрээ.*** "ЛэндМН ББСБ" ХК-ийн санхүүгийн байдлын тайлан, тайлант орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайлангуудыг багтаасан санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлангуудтай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд аудит хийж, тайланд дүгнэлт гаргахтай холбоотой харилцааг "Эрнст энд Янг монголия аудит" ГХОХХК-тай 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан "Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ" (Хавсралт 4.36)-ээр зохицуулсан байна. Уг гэрээнд талуудын харилцан хүлээх үүрэг, хариуцлага, ажлын хүрээ, гүйцэтгэх хугацаа, хөлс, үр дүнг хүлээлгэн өгөх, гэрээг дуусгавар болгох журмыг тусгасан нь Аудитын тухай хуулийн 13-т заасан шаардлагад нийцсэн байна.

***Бизнесийн үнэлгээний ажлын гэрээ.*** Компанийн бизнесийн үнэлгээг Монгол Улсын хууль болон Олон улсын үнэлгээний стандарт, Санхүүгийн зохицуулах хороо болон "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-аас баталсан дүрэм, журамд нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж, үр дүнг захиалагч талд хүлээлгэн өгөх, захиалагч нь ажлын үр дүнг актаар хүлээн авахтай холбоотой харилцааг "ЛэндМН ББСБ" ХК болон "Итгэлт-Эстимэйт" ХХК-тай 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан 2021/08 тоот Бизнесийн үнэлгээний ажлын гэрээ (Хавсралт 4.37)-ээр зохицуулсан байна. Уг гэрээнд бизнесийн үнэлгээний зориулалт, талуудын эрх үүрэг, бизнесийн үнэлгээний хөлс, бизнесийн үнэлгээний тайланг хүлээлгэн өгөх журмыг тусгасан.

***Хэрэглэгчийн гэрээ /домэйн нэр ашиглах цахим гэрээний загвар/.*** Компани нь www.lend.mn домэйн нэрийг ашиглах, төлбөр тооцоотой холбогдох харилцааг "Датаком" ХХК-ийн цахим



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ☎ 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
247
5183855

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



бүртгэлийн үндсэн дээр талууд цахим онлайн орчинд хүлээн зөвшөөрсөн үйлчилгээний журам (Хавсралт 4.38)-аар зохицуулдаг байна. Дээрх журмын дагуу Датаком ХХК-ийн үйлчилгээ болох домэйн нэрийн бүртгэл, сунгалт, төлбөр тооцоо болон талуудын хүлээх эрх, үүрэг хариуцлагатай холбоотой харилцаа зохицуулсан ба тус домэйн нэр нь 2022 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр хүртэл хүчинтэй байна.

Үнэт цаас гаргагчийн байгуулсан түүний үйл ажиллагаанд голлох ач холбогдолтой дээр дурдсан гэрээ, гэрээний загвар нь хууль тогтоомжид нийцсэн байна.



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

MDSKhanLex

Сүүлийн 3 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа бол хууль заасан журмын дагуу батлагдсан эсэх

Хуулийн дүгнэлт гаргах явцад бид тус компанид албан ёсоор хандсанаар сүүлийн 3 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй дор дурдсан хэлцлүүдийг ирүүлснийг хянав.

| № | Гэрээний нөгөө тал | Гэрээний нөхцөл | Их хэмжээний, сонирхлын зөрчилтэй аль нь болох | Хуулийн шаардлага хангасан эсэх | Хэрэгжсэн, хэрэгжиж буй эсэх |
|---|---|---|---|---|---|
| 1. | "Мирэ Эссэт Секьюритис Монгол ҮЦК" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 19/32 тоот тогтоолоор Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "ЛэндМН" ББСБ нь "Мирэ Эссэт Секьюритис Монгол" ҮЦК-тай өөрийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор гаргах буй өрийн бичгийг хаалттай хүрээнд санал болгох, санхүүжилт татан төвлөрүүлэхээр 2019 оны 02 дугаар сарын 01-ны өдөр 2019/95 тоот гэрээ (Хавсралт 5.1) байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжсэн |
| 2. | "Анд Систем" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2018 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 18/34 тоот тогтоолоор Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Анд системс" ХХК нь "ЛэндМН" ББСБ ХХК-д ХХ жилийн хугацаатай, жилийн ХХ хувийн хүүтэй зээл олгохоор харилцан тохиролцож 2019 оны 02 дугаар сарын 14-ны өдөр ЗГ19/01 тоот гэрээ (Хавсралт 5.2), 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдөр ЗГ19/02 тоот гэрээ (Хавсралт 5.3) тус тус байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжсэн |
| 3. | "Анд Систем" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2019 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 19/18 тоот тогтоолоор Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Анд системс" ХХК нь "ЛэндМН" ББСБ ХХК-д ХХ жилийн хугацаатай, жилийн ХХ хувийн хүүтэй зээл олгохоор харилцан тохиролцож 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдөр ЗГ19/03 тоот гэрээ (Хавсралт 5.4), 2019 оны 03 | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжсэн |



СЗХ 2021 он 06 сар 23 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2021-06-18 БҮРТГЭЛ-03

ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ 5039754 ₮ 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ БИЗНИЙ ЭНДКО КАПИТАЛ ҮЦК ХХК 249 5183855 9021031195 СТС2420

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | дугаар сарын 04-ний өдөр ЗГ19/04 тоот гэрээ (Хавсралт 5.5), 2019 оны 03 дугаар сарын 05-ны өдөр ЗГ19/05 тоот гэрээ (Хавсралт 5.6), 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдөр ЗГ19/08 (Хавсралт 5.7) болон ЗГ19/09 тоот гэрээ (Хавсралт 5.8), 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр ЗГ19/10 тоот гэрээ (Хавсралт 5.9), 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдөр ЗГ19/12 тоот гэрээ (Хавсралт 5.10) тус тус байгуулсан. | | | |
| 4. | "Анд Системс" ХХК болон "ХХ" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 19/39 тоот тогтоолоор Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "ЛэндМН" ББСБ нь LendMN аппликейшнаар үзүүлэх үйлчилгээний төрөл, цар хүрээг нэмэгдүүлэх зорилгоор "Анд Системс" ХХК нь өөрийн болон гуравдагч этгээдийн бүтээгдэхүүн үйлчилгээг LendMN аппликейшнаар дамжуулан хэрэглэгчдэд санал болгох, түүний төлбөр тооцоог "ЛэндМН" ББСБ ХК-иар гүйцэтгүүлэх тухай 2019/168 тоот гэрээ (Хавсралт 5.11) 2019 оны 03 дугаар сарын 19-ний өдөр байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжсэн |
| 5. | "Анд Системс" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 19/36 тоот тогтоолоор Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Анд системс" ХХК нь "ЛэндМН" ББСБ ХХК-д ХХ жилийн хугацаатай, жилийн ХХ хувийн хүүтэй зээл олгохоор харилцан тохиролцож 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр ЗГ19/13 тоот гэрээ (Хавсралт 5.12), 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр ЗГ19/14 тоот гэрээ (Хавсралт 5.13), 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдөр ЗГ19/16 тоот гэрээ (Хавсралт 5.14) тус тус байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжсэн |
| 6. | "Мирэ Эссэт Секьюритис Монгол ҮЦК" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 19/33 тоот тогтоолоор Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "ЛэндМН" ББСБ нь өөрийн бизнесийн үйл ажиллагааны өсөлтийг хангахад санхүүжилт авахад "Мирэ Эссэт Секьюритис Монгол" ҮЦК ХХК-иас мэргэжлийн зөвлөх үйлчилгээ авах 2019/274 тоот гэрээ (Хавсралт 5.15) 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжсэн |
| 7. | "Анд Системс | Компанийн ТУЗ-ийн 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 19/37 тоот тогтоолоор Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжсэн |



СЭХ 2021 .06. 23 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2021 -06- 18 БҮРТГЭВ-03
ЛЭНДМН ББСБ ХК УЛААНБААТАР ХОТ 5039754 ф.1118267206
2021/05/24
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183866 9021031156 СТС2420
250

СЭХ
2021 06 23 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18
БҮРТГЭВ-03



| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | " ХХК | "Анд системс" ХХК нь "ЛэндМН" ББСБ ХХК-д ХХ жилийн хугацаатай, жилийн ХХ хувийн хүүтэй зээл олгохоор харилцан тохиролцож 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдөр 19/17 тоот гэрээ (Хавсралт 5.16), 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдөр 19/18 тоот гэрээ (Хавсралт 5.17), 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдөр 19/19 тоот гэрээ (Хавсралт 5.18), 2019 оны 08 дугаар сарын 27-ны өдөр 19/21 тоот гэрээ (Хавсралт 5.19), 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдөр 19/22 тоот гэрээ (Хавсралт 5.20), 2019 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр 19/23 тоот гэрээ (Хавсралт 5.21), 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр 19/24 тоот гэрээ (Хавсралт 5.22), 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдөр 19/25 тоот гэрээ (Хавсралт 5.23), 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдөр 19/26 тоот гэрээ (Хавсралт 5.24), 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр 19/27 тоот гэрээ (Хавсралт 5.25) тус тус байгуулсан. | | | |
| 8. | "Анд Системс " ХХК | Компанийн ТУЗ-ийн 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 19/58 тоот тогтоолоор Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Анд системс" ХХК нь "ЛэндМН" ББСБ ХХК-д ХХ жилийн хугацаатай, жилийн ХХ хувийн хүүтэй зээл олгохоор харилцан тохиролцож 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдөр 19/28 тоот гэрээ (Хавсралт 5.26) байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжсэн |
| 9. | "Анд Системс Тех" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 19/59 тоот тогтоолоор Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Анд системс" ХХК нь "ЛэндМН" ББСБ ХХК-д ХХ хоногийн хугацаатай, жилийн ХХ хувийн хүүтэй зээл олгохоор харилцан тохиролцож 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр ЗГ19/29 тоот гэрээ (Хавсралт 5.27) байгуулсан. Энэхүү гэрээнд 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдөр зээлийн хэмжээ, хугацаа, хүүний хэмжээнд өөрчлөлт орсон ЗГ19/29-1 тоот Зээлийн гэрээний нэмэлт, өөрчлөлт гэрээ байгуулсан байна. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжсэн |
| 10. | "Анд Системс " ХХК | Компанийн ТУЗ-ийн 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 20/07 тоот тогтоолоор Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Анд системс" ХХК нь "ЛэндМН" ББСБ ХХК-ийн бизнесийн үйл ажиллагааны өсөлтийг хангах, үр ашигтай удирдан зохион байгуулах, шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилтийг шийдвэрлэхэд туслалцаа өгөх, бизнес санхүү, технологийн нарийн мэргэжлийн үйлчилгээгээр хангахаар харилцан тохиролцож 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдөр | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжсэн |



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ☎ 11 ... 8267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183856
9021031195 CTC2420

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2020/07 тоот Менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээ (Хавсралт 5.28) байгуулсан. | | | |
| 11. | "Анд Системс" ХХК, "Дижитал Молл" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 19/62 тоот тогтоолоор Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Анд Системс" ХХК, "Дижитал Молл" ХХК, ЛэндМН" ББСБ ХХК нар нь "XX" шоу нэвтрүүлгийн 2 дугаар улирлын дугаараар дамжуулан сурталчилгаа мэдээлэл нэвтрүүлэхэд шаардлагатай зардал сурталчилгаа хийлгэх хэмжээ, хувийг үндэслэн тохиролцсон дүнг хуваарилан төлөх, түүнтэй холбоотой эрсдлийг хуваарилан хариуцахаар тохиролцож 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 20/21а тоот Хамтран ажиллах гэрээ (Хавсралт 5.29) байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжсэн |
| 12. | Дижитал Молл" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2020 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 20/26-31 тоот ээлжит хурлын тэмдэглэлд ТУЗ-ийн гишүүдийн 88,88 хувь оролцсон буюу ирц бүрдсэн ба ТУЗ-ийн нэг гишүүн нь гадаадаас ирээд хол хоронд байсан тул хуралд оролцоогүйг дурдсан. Сонирхлын зөрчилтэй 4 ТУЗ-ийн гишүүд санал хураалтад оролцоогүй бөгөөд санал хураалтад оролцох эрхтэй үлдсэн 4 гишүүдийн 100 хувийн саналаар Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосон байна. Үүний дагуу 2020 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн 20/29 тоот тогтоолоор "Дижитал Молл" ХХК-тай байгууллагын бараа, ажил, үйлчилгээг SupPAY үйлчилгээгээр худалдан авах боломжийг аппликейшнээр дамжуулан харилцагчид болон байгууллагад олгох, харилцагчийн SupPAY-аар төлөх худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг Дижитал Молл ХХК-д шилжүүлэх, тус байгууллага нь компанид үйлчилгээний төлбөр төлөхөөр харилцан тохиролцож 2020 оны 07 сарын 31-ний өдрийн 2020/89 тоот дугаартай SupPAY үйлчилгээнд хамтран ажиллах гэрээ (Хавсралт 5.30) байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| 13. | "Супер Ап Хэтэвч" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2020 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 20/26-31 тоот ээлжит хурлын тэмдэглэлд ТУЗ-ийн гишүүдийн 88,88 хувь оролцсон буюу ирц бүрдсэн ба ТУЗ-ийн нэг гишүүн нь гадаадаас ирээд хол хоронд байсан тул хуралд оролцоогүйг дурдсан. ТУЗ-ийн сонирхол бүхий 4 гишүүн санал хураалтад оролцоогүй бөгөөд санал хураалтад оролцох эрхтэй гишүүд 100 хувийн саналаар Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосон | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |



СЗХ 2021.06.23 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2021-06-18 БҮРТГЭВ-03
ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ 5039754 1118267206
2021/05/24
УЛААНБААТАР ХОТ ... КАПИТАЛ ҮЦК ХХК 252 5183855 9021031195 СТС2420

| | | | | |
|---|---|---|---|---|
| | байна. Үүний дагуу 2020 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн 20/30 тоот тогтоолоор "Супер Ап Хэтэвч" ХХК-тай Компанийн Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ (зээл, факторинг, мөнгөн гуйвуулга, гадаад валютын арилжаа, итгэлцэл зэрэг)-г Супер Ап Хэтэвч ХХК-ийн хэрэглэгчдэд үзүүлэх, түүнтэй холбоотой гүйлгээ, хэрэглэгчдэд олгох урамшууллыг хэрэглэгчийн SuperUp цахим хэтэвчээр дамжуулан гүйцэтгэхээр харилцан тохиролцож 2020 оны 07 сарын 31-ний өдрийн 2020/85а тоот дугаартай Төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх гэрээ (Хавсралт 5.31) байгуулсан. | | | |
| 14. "Мирэ Эссет секьюритис Монгол ҮЦК" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2020 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 20/26-31 тоот ээлжит хурлын тэмдэглэлд ТУЗ-ийн гишүүдийн 88,88 хувь оролцсон буюу ирц бүрдсэн ба ТУЗ-ийн нэг гишүүн нь гадаадаас ирээд хөл хорионд байсан тул хуралд оролцоогүй дурдсан. ТУЗ-ийн сонирхол бүхий 4 гишүүн санал хураалтад оролцоогүй бөгөөд санал хураалтад оролцох эрхтэй гишүүдийн 100 хувийн саналаар Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосон байна. Үүний дагуу 2020 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн 20/31 тоот тогтоолоор "Мирэ Эссет секьюритис Монгол ҮЦК" ХХК-тай бизнесийн үйл ажиллагааны өсөлтийг хангахад санхүүжилт авахад мэргэжлийн зөвлөх үйлчилгээ авах, зөвлөхийн зүгээс тухайн үйлчилгээг компанид үзүүлэхээр харилцан тохиролцож 2020 оны 07 сарын 29-ний өдрийн 2020/52а тоот дугаартай Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ (Хавсралт 5.32) байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| 15. "Бүүминг трейд" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 21/09 тоот тогтоолоор Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Бүүминг трейд" ХХК-тай зээл болон барьцааны гэрээ байгуулах эрх олгосон бөгөөд 2021 оны 02 сарын 09-ний өдрийн ЗГ/202101 тоот зээлийн гэрээ, ЗБ202101 тоот барьцааны гэрээ (Хавсралт 5.33) байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| 16. "Мирэ Эссет секьюритис Монгол ҮЦК" | Компанийн ТУЗ-ийн 2020 оны 04 дугаар сарын 29-ны өдрийн 20/11 тоот тогтоолоор Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Мирэ Эссет секьюритис Монгол ҮЦК" ХХК-тай Андеррайтерын гэрээ байгуулах эрх олгосон бөгөөд 2020 оны 04 сарын 16-ний өдрийн 2020/27 тоот дугаартай Андеррайтерын гэрээ (Хавсралт 5.34) байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |



2021/05/24

| | | | | |
|---|---|---|---|---|
| | ХХК | | | |
| 17. | "Өлзий энд ко капитал ҮЦК" ХХК, "Райнос Инвестмент ҮЦК" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 21/20 тоот тогтоолоор Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Өлзий энд ко капитал ҮЦК" ХХК болон "Райнос Инвестмент ҮЦК" ХХК-тай анхан гүйцэтгэх гэрээ байгуулах эрх олгосон бөгөөд 2021 оны 05 сарын 20-ны өдрийн 2021/13 тоот дугаартай Андеррайтер болон зөвлөх үйлчилгээний гэрээ (Хавсралт 5.35) байгуулсан. (Дэлгэрэнгүйг дээрх буюу 4 дүгээр бүлгийн Андеррайтер болон зөвлөх үйлчилгээний гэрээ хэсгээс харна уу.) | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| 18. | "Райнос Инвестмент ҮЦК" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 21/21 тоот тогтоолоор Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Райнос Инвестмент ҮЦК" ХХК-тай анхан гүйцэтгэх гэрээ байгуулах эрх олгосон бөгөөд 2021 оны 05 сарын 20-ны өдрийн 2021/11 тоот дугаартай Анхан гүйцэтгэх гэрээ (Хавсралт 5.36) байгуулсан | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| 19. | "Райнос Инвестмент ҮЦК" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 21/22 тоот тогтоолоор Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Райнос Инвестмент ҮЦК" ХХК-тай зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах эрх олгосон бөгөөд 2021 оны 05 сарын 20-ны өдрийн 2021/12 тоот дугаартай Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ (Хавсралт 5.37) байгуулсан | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| 20. | "Ай Эн Мобайл Нэтворк" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 21/23 тоот тогтоолоор Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Ай Эн Мобайл Нэтворк" ХХК-тай ээлт болон зөвлөх үйлчилгээний чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулах эрх олгосон бөгөөд Дүгнэлт гаргах өдрийн байдлаар түс гэрээ байгуулаагүй, тэгүүд гэрээ байгуулахаар хэлэлцээр хийж байна. (Хавсралт 5.38) | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэлэлцээр хийж байгаа |
| 21. | "Диджитал Моал" | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 21/24 тоот тогтоолоор Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэлэлцээр хийж |



СЗХ 2021 .06. 23 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2021 -06- 18 БҮРТГЭВ-03
ЛЭНДМН ББСБ ХК УЛААНБААТАР ХОТ 5039754 1118267206
2021/05/24
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 254 5183855 9021031195 СТС2420

MDSKhanLex

| | | |
|---|---|---|
| ХХК | "Дижитал Молл" ХХК-тай хамтран зохиолах гэрээ байгуулах эрх олгосон боловч тус гэрээ байгуулагдаагүй, талууд гэрээ байгуулахаар хэлэлцээр хийж байна. (Хавсралт 5.39) | байгаа |

***Сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар:***

Бидэнд ирүүлсэн мэдээллээр Компани сүүлийн 3 жилд сонирхлын зөрчилтэй хэлцэл 37-г хийсэн бөгөөд 29 нь бүрэн хэрэгжсэн, Дуусгавар гаргах өдрийн байдлаар ямар нэгэн зөрчил маргаан гараагүй байна. Сүүлийн 3 жилийн дотор хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулахын өмнө Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан журмын дагуу ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж, зөвшөөрөл олгосон байна. Эдгээр 37 хэлцлээс Дуусгавар гаргах өдрийн байдлаар 8 хэлцэл нь хэвийн хэрэгжиж байгаа болохыг Компанийн Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно. (Хавсралт 11.18).

***Их хэмжээний хэлцлийн талаар:***

Компани сүүлийн 3 жилийн дотор их хэмжээний хэлцэл байгуулаагүй болохыг Компанийн Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно. (Хавсралт 11.18).



СЭХ он сар өдөр 2021.06.23 № 01

MONGOLIAN STOCK EXCHANGE 2021-06-18 БҮРТГЭЭ-03

ЛЭНДМН ББСБ ХК УЛААНБААТАР ХОТ 9039754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183655 9021031195 CTC2420

СЗХ
2021 .06. 23 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18
БҮРТГЭВ-03



"ЛэндМН ББСБ" ХК нь дүгнэлт гаргах өдрийн байдлаар Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 293 тоот тогтоолоор Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх Т3101/493 тоот тусгай зөвшөөрөл, 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 193 тоот тогтоолоор Банк бус санхүүгийн төлбөр тооцооны хэрэгсэл гаргах болон цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 45 тоот тогтоолоор Факторингийн үйл ажиллагаа, Итгэлцлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 128 тоот тогтоолоор Банк бус санхүүгийн гадаад валют арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл, мөн Санхүүгийн Зохицуулах Хорооны 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 107 тоот тогтоолоор Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг (Хавсралт 6.1) тус тус авсан бөгөөд эдгээр нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1 дэх заалт, 15.3.1 дэх заалт, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9.1 дэх хэсэгт заасан шаардлагад нийцэж байна.

"ЛэндМН ББСБ" ХК-ийн СЗХ-оос авсан дээр дурдсан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлүүд нь дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр, түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл байдал үүсээгүй байна.

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Компани нь өөрийн 100%-ийн хөрөнгө оруулалттай охин компани болох "Супер Ап Хэтэвч" ХХК-ийг 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр үүсгэн байгуулж, "Үндэсний төлбөрийн системийн тухай хууль"-ийн дагуу 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдөр Төлбөрийн үйлчилгээ, цахим мөнгөний тусгай зөвшөөрөл хүсэх тухай хүсэлт (Хавсралт 6.2), 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Төлбөрийн үйлчилгээ, цахим мөнгөний тусгай зөвшөөрлийн хүсэлттэй холбоотой нэмэлт материал хүргүүлэх тухай хүсэлт (Хавсралт 6.3)-ийг, холбогдох материалын хамт Монголбанкинд хүргүүлжээ. Ийнхүү хүргүүлсний дагуу 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Монголбанкнаас "Супер Ап Хэтэвч" ХХК-д "цахим мөнгө гаргах" төлбөрийн үйлчилгээ эрхлэх 06 дугаар зөвшөөрөл (Хавсралт 6.4) олгож шийдвэрлэсэн байна. " Супер Ап Хэтэвч" ХХК-ийн Монголбанкнаас авсан тус зөвшөөрөл нь дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр, түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл байдал үүсээгүй байна. (Хавсралт 11.18)

Компанийн нэр дээр 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн анхдагч огноотой, 40-0018383 тоот улсын бүртгэлийн дугаар, 201800613 тоот гэрчилгээний дугаартай 2027 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр хүртэл хүчинтэй барааны тэмдгийн гэрчилгээ (Хавсралт 6.5) авсан байна:

Ангилал 36: Санхүүгийн үйлчилгээ

lendmn

Оюуны өмчийн газрын аж үйлдвэрийн өмчийн мэдээллийн сан /https://publish.ipom.mn/wopublish-search/public/home?6/ (Хавсралт 11.7), зохиогчийн эрхийн хайлтын систем /http://copyright.ipom.mn/ (Хавсралт 11.8)-с тус тус хайлт хийхэд "ЛэндМН ББСБ" ХК-ийн нэр дээр эрхийн хамгаалалт хийгдсэн шинэ бүтээл, ашигтай загвар, зохиогчийн эрхийн аливаа бүтээл байхгүй, эрхийн хамгаалалт хийгдсэн хүчинтэй барааны тэмдэг 1 байгаа



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1111267206

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183655
9021031195 СТС2420

бөгөөд Компанийн нэр дээр байх дээрх барааны тэмдгийн өмчлөх, эзэмших эрх нь Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр бөгөөд хугацаа дуусах, цуцлагдах, барьцаалагдах зэргээр эрхээ хэрэгжүүлэхэд нь бодитой нөлөөлөх болон, эсхүл бусдын эрхээр хязгаарлагдсан нөхцөл харагдаагүй болно.

СЗХ
2021.06.23 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨК
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ №03



[illegible]

***Үнэт цаас:***

**Компани нь "Супер ап хэтэвч" ХХК (РД: 6517404)-ийн** 100 хувийн хувьцааг эзэмшдэг **ба өөр бусад байдлаар аливаа үнэт цаас** эзэмшдэггүй **болохыг** Компанийн Гүйцэтгэх захирал **албан бичгээр** **баталгаажуулсан** болно (Хавсралт 11.18).

**"Супер ап хэтэвч" ХХК (РД: 6517404)-ийн 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн өөрчлөлтийг тусгасан гэрчилгээ** (Хавсралт 7.1), **дүрэм** (Хавсралт 7.2)**-ийн дагуу хувьцаа эзэмшигч, гадаадын хувь, эзэмших хэмжээ байдлаар тодорхойлогдож байна. Үүнд:**

| № | Хувьцаа эзэмшигчдийн нэрс | Регистрийн дугаар | Эзэмших хувь | Эзэмших хувьцааны тоо /ширхэг/ | Оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/ | Зээлийн гэрээний дагуу барьцаалагдсан эсэх |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | "ЛэндМН ББСБ" ХК | 5039754 | 100 | 25,000,000 | 2,500,000,000.0 0 | - |
| **НИЙТ:** | | | **100%** | **25,000,000** | **2,500,000,000.00** | - |

**"Супер ап хэтэвч" ХХК нь мэдээллийн технологийн үйл ажиллагаа явуулдаг ба 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр үүсгэн байгуулагдсанаас хойш богино хугацаанд олон хэрэглэгчтэй болж үйл ажиллагаа нь тогтвортой өсөлттэй байна.**

***Үнэт цаас гаргагчийн барьцаанд байгаа хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө*** (Хавсралт 7.3)

| № | Хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийн нэр | Хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийн нэр төрөл, дугаар | Зээлийн Гэрээний дагуу Барьцаалагдсан эсэх |
|---|---|---|---|
| 1. | "ЛэндМН ББСБ" ХК-ийн данснаар болон борлуулалтаас орж ирэх мөнгөн хөрөнгө | Ирээдүйд болон дансаар болон борлуулалтаас орж ирэх мөнгөн хөрөнгө | Худалдаа хөгжлийн банктай байгуулсан ОЭГ/СС181026004-1 тоот зээлийн гэрээний дагуу ЗБ/СС20181026004-1-1, ОЭГ/СС20181026004-1-1-1 тоот хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ |
| 2. | Ирээдүйд орж ирэх мөнгөн хөрөнгө, түүний үр шим, | Хэлийн эзэмшлийн багцын үлдэгдэл | Худалдаа хөгжлийн банктай байгуулсан ОЭГ/СС181026004-1-2 тоот зээлийн гэрээний дагуу |



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18
БҮРТГЭВ-03

СЗХ
2021 .06. 23 өдөр
БҮРТГЭВ
№ 01



| | | | |
|---|---|---|---|
| | өлгөө түүний үр шим | | ЗБ/СС191008001-1-6, ЗБСС191008001-1-6-1 тоот хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ |

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар дээр дурдсан хөдлөх эд хөрөнгө, эргэлтийн хөрөнгө, ирээдүйд орж ирэх мөнгөн хөрөнгө нь дээрх гэрээний дагуу барьцаалагдсан байна.

*Тээврийн хэрэгсэл.* Компани нь 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар нийт 2 тээврийн хэрэгслийг өмчилдөг бөгөөд (Хавсралт 7.4, Хавсралт 7.5, Хавсралт 11.15, Хавсралт 11.18) эдгээр нь аливаа байдлаар барьцаалагдаагүй байна.

*Газар эзэмших эрх.* Компанийн гүйцэтгэх захирлын 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 05/776 тоот албан бичиг (Хавсралт 11.18) болон Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалтын албаны 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 03-09/3190 тоот албан бичиг (Хавсралт 11.13), Нийслэлийн Чингэлтэй дүүргийн газар зохион байгуулалтын албаны 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 15/364 тоот албан бичиг (Хавсралт 11.14)-ээс үзэхэд Компани нь нь аливаа газар эзэмших эрх эзэмшдэггүй болно.

*Үл хөдлөх эд хөрөнгө.* Компанийн гүйцэтгэх захирлын 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 05/776 тоот албан бичиг (Хавсралт 11.18) болон Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Эд Хөрөнгийн Бүртгэлийн Газрын 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 003337294 тоот лавлагаа (Хавсралт 11.16)-аа дурдсанаас үзэхэд Компани нь аливаа үл хөдлөх хөрөнгө өмчилдөггүй болно.



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267208

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5163655
9021031195 СТС2420

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ
№01

БҮРТГЭЭ-03



Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 21/18 тоот "Үнэт цаас нийтэд санал болгон гаргах тухай" тогтоол (Хавсралт 8.1)-оор "ЛэндМН ББСБ" ХК-ийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор дараах нөхцөлөөр өрийн бичиг гарган нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн.

| | | |
|---|---|---|
| 1 | Үнэт цаасны төрөл | Нээлттэй өрийн бичиг (бонд) |
| 2 | Олон нийтэд санал болгох нийт дүн | 5,000,000,000 (таван тэрбум) төгрөг |
| 3 | Бондын нэрлэсэн үнэ | 100,000 (нэг зуун мянга) төгрөг |
| 4 | Тоо ширхэг | 50,000 (тавин мянга) ширхэг |
| 5 | Хүү (жилийн буюу 365 хоног) | 14% (арван дөрвөн хувь) |
| 6 | Хугацаа | 2 (хоёр) жил |
| 7 | Хүү төлөх хугацаа, давтамж | 6 сар тутамд |
| 8 | Эргэн төлөх нөхцөл | Хугацааны эцэст |
| 9 | Баталгаа | "АНД Глобал" ПиТиИ ЭлТиДи компанийн 100%-ийн төлбөрийн баталгаа |
| 10 | Андеррайтерийн хөлс | Андеррайтертай байгуулах гэрээний үндсэн дээр Гүйцэтгэх захирал тодорхойлох |
| 11 | Нийтэд санал болгон гаргах хугацаа | 2021 оны II улирал (Зохицуулагч байгууллагаас шалтгаалан өөрчлөгдөх боломжтой) |

Уг тогтоолоор Компанийн өрийн бичгийг нийтэд санал болгон гаргах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, шаардлагатай зөвшөөрөл, баримт бичгийг бүрдүүлэх, бусад шаардлагатай арга хэмжээ авах, энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах бүрэн эрхийг Гүйцэтгэх захиралд олгосон ба тус ТУЗ-ийн тогтоол нь Компанийн тухай хуулийн 4.3 дахь хэсэг, 41.2, 41.3 дахь хэсэг, 42.1 дэх хэсэг, 55.9 дэх хэсэг, 76.1.5 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.1.2 дахь заалт, 6.1 дэх хэсэг, Компанийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрмийн 9.6.2 дахь заалтуудад тус нийцэж байна.

Компанийн гаргаж буй өрийн бичгийн эргэн төлөлтийн баталгааг "Анд Глобал" ПиТиИ ЭлТиДи[3] гаргасан байна. "Анд Глобал" ПиТиИ ЭлТиДи-ийн 2021 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн баталгааны бичиг гаргах тухай захирлуудын шийдвэрээр Компанийн өрийн бичгийн эргэн төлөлтийн баталгаа гаргах асуудлыг зөвшөөрч, тус шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбоотой шаардлагатай бүхий л арга хэмжээ авах эрхийг "Анд Глобал" ПиТиИ ЭлТиДи-ийн захирал тус бүрд олгожээ. (Хавсралт 8.2)

"Анд Глобал" ПиТиИ ЭлТиДи-ийн 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн баталгааны бичгээр охин компани болох ЛэндМН ББСБ ХК-ийн зүгээс олон нийтэд нээлттэй арилжаалах өрийн бичгийн эргэн төлөлт хийгдээгүй тохиолдолд нээлттэй өрийн бичгийн дүн 5,000,000,000 (таван тэрбум) төгрөг болон түүний хүүгээс хэтрэхгүй хэмжээгээр хариуцан, андеррайтерийн бичгэн шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор төлж барагдуулахаар 3 жилийн хугацаатай баталгааг Сингапур улсын хуулийн дагуу гаргасан байна (Хавсралт 8.3). Компанийн тухай Монгол Улсын хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-д "Компанийн балансад тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн дүнгээс компанийн нийт өр төлбөрийг хасаад үлдсэн хэсгийг компанийн өөрийн хөрөнгө гэнэ." гэж заасан. Бидэнд урьдчилан ирүүлсэн "Анд Глобал" ПиТиИ ЭлТиДи-ийн санхүүгийн тайлангаас үзвэл тус компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 9,138,484 (есөн сая нэг зуун гучин найман мянга дөрвөн зуун наян дөрөв) ам.доллар байна. (Хавсралт 8.4)[4] Энэхүү тайлан нь 2021 оны 06 дугаар 11-ний өдөр

[3] "Анд Глобал" ПиТиИ ЭлТиДи-ийн "ЛэндМН ББСБ" ХК-тай ямар холбоо хамааралтай талаар дүгнэлтийн 9-р бүлэг "Үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд нь хэн болох" хэсгээс дэлгэрэнгүй харна уу.

[4] Энэхүү тайлан нь 2021 оны 06 дугаар 11-ний өдөр аудитаар баталгаажих тухай компаниас бидэнд мэдэгдсэн бөгөөд дүгнэлт гаргах өдрийн байдлаар бидэнд шалгах шуудангаар урьдчилсан тайлан илгээснийг үндэслэсэн болно.



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 11 18267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2021.06.23
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2021-06-18
БҮРТГЭВ-03



аудитаар баталгаажих бөгөөд тус өөрийн хөрөнгийн хэмжээг үнэн зөв мэдүүлсэн талаар Компанийн гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно. (Хавсралт 11.18).

Нийтэд ил болсон мэдээлэл, төрийн болон бусад эрх бүхий байгууллагаас гаргуулсан, Компани, түүний холбогдох этгээд болон гуравдагч этгээдээс гаргуулсан мэдээллүүдийг шинжилсний үндсэн дээр Үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгасан мэдээлэл нь үнэн зөв, хууль зүйн хувьд хүчин төгөлдөр байна гэж дүгнэв.



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 11167267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2021.06.23 өдөр
БҮРТГЭВ
№01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

MDSKhanLex

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 07054 тоот Компанийн хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа (Хавсралт 11.17)-г гаргуулан судалсан. Түүнчлэн бид энэхүү дүгнэлтийг гаргахдаа өрийн бичиг гаргах тухай шийдвэр гаргасан тус Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр буюу 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн байдлаарх тархалтын судалгаа (Хавсралт 9.1)-г үндэслэв. Тархалтын судалгаанаас үзвэл Компанийн саналын эрхтэй энгийн хувьцааны 75 хувийг "Анд Системс" ГХО ХХК, үлдсэн хувьцааг Компанийн бусад хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна. (Үүнд "ЛэндМН ББСБ" ХК нь тус Компанийн нийт хувьцааны 4.688 хувь буюу 37,506,266 ширхэг хувьцааг халаасалсан байна.) (Хавсралт 9.1)

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Компанийн саналын эрхтэй энгийн хувьцааны 75 хувийг эзэмшиж байгаа Монгол Улсын хуулийн этгээд "Анд Системс" ГХО ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн ХЭ-21/01 тоот шийдвэрээр нэмэлт өөрчлөлт оруулсан дүрэм (Хавсралт 9.2, Хавсралт 9.3)-ийн 8.1-д зааснаар дээрх компанийн хувьцааг Сингапур улсын хуулийн этгээд "Анд Эф Эс Жи" ПиТиИ ЭлТиДи (Хавсралт 9.4, Хавсралт 9.5) 100 хувь эзэмшиж байна.

Сингапур улсын хуулийн этгээд "Анд Эф Эс Жи" ПиТиИ ЭлТиДи-ийн хувьцааг Сингапур улсын хуулийн этгээд "Анд Глобал" ПиТиИ ЭлТиДи (Хавсралт 9.6, Хавсралт 9.7) 100 хувь эзэмшиж байна. (Хавсралт 9.10)

"Анд Глобал" ПиТиИ ЭлТиДи-ийн хувьцааны хяналтын багц буюу 33.36 хувийг Сингапур улсын хуулийн этгээд "Иро Консалтинг Сингапур" ПиТиИ ЭлТиДи (Хавсралт 9.8, Хавсралт 9.9) эзэмшиж байна. (Хавсралт 9.10)

"Иро Консалтинг Сингапур" ПиТиИ ЭлТиДи-ийн хувьцааны 20 болон түүнээс дээш хувийг доор дурдсан хувьцаа эзэмшигчид /хувь хүмүүс/ эзэмшиж байна. (Хавсралт 9.10, Хавсралт 9.11) Үүнд:

| № | Овог, нэр/ Хуулийн этгээдийн нэр | Эзэмшиж буй хувь |
|---|---|---|
| 1 | Үүсэгийн Отгонбаяр | 20% |
| 2 | Чинбаатарын Анар | 20% |
| 3 | Очирсүрэнгийн Болдбаатар | 20% |
| 4 | Пүрэвсүрэнгийн Отгонбаяр | 20% |

Иргэний хуулийн 26.4-т: "Хуулийн этгээд удирдах байгууллагаараа дамжуулан иргэний эрх зүйн харилцаанд орно" гэж заасан тул бид эдгээр компаниудын хувьцаа эзэмшигч, ТУЗ, Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж, шийдвэр гаргахад хамгийн нөлөө бүхий хувь хүн (хүмүүс) Үнэт цаас гаргагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байна гэж үзэв. Ингэхдээ Компанийн тухай хуулийн компанийн нэгдлийн талаар зохицуулсан 6 дугаар зүйл, нэгдмэл сонирхолтой этгээдийг тодорхойлсон 99.1-д дурдсан зохицуулалтыг анхааралдаа авсан болно.

Дээрх бүх анализын үндсэн дээр Дүгнэлт гаргах өдрийн байдлаар "Иро Консалтинг Сингапур" ПиТиИ ЭлТиДи-ийн тус бүрдээ 20 хувийг эзэмшигч (Хавсралт 9.10, Хавсралт 9.11) Үүсэгийн Отгонбаяр, мөн тус компанийн 20 хувийг эзэмшигч бөгөөд "Анд Системс" ГХО ХХК-ийн ТУЗ-ийн гишүүд (Хавсралт 9.12) болох Чинбаатарын Анар, Очирсүрэнгийн Болдбаатар, Пүрэвсүрэнгийн Отгонбаяр нар нь хамтдаа "ЛэндМН ББСБ" ХК-ийн жинхэнэ хяналтыг хэрэгжүүлэгч гэж үзэв. Энэхүү Дүгнэлт нь бусад хүчин зүйлийн нөлөөгөөр өөрчлөгдөх боломжтойг дурдаж байна.



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -06- 18
БҮРТГЭВ-03

2021 .06. 23
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



### Тухайн Компанийн [illegible] бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх болон [illegible] судалгаа

Компани нь 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар Гаалийн байгууллагад татварын өргүй (Хавсралт 10.1), 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын тодорхойлолтоор нийгмийн даатгалын шимтгэлийн өглөггүй (Хавсралт 10.2) байна. 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн Монголын татварын албаны тодорхойлолтоор татварын байгууллагад 29,100,654.00 төгрөгийн дутуу төлөлттэй (Хавсралт 10.3) байна. МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 10.1.5-д "Үнэт цаас гаргагч, түүний хувьцааны хяналтын багцыг эзэмших этгээд, ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал нь татварын болон хугацаа хэтэрсэн их хэмжээний зээлийн өргүй байх" гэсэн шалгуурыг тодорхойлсон бөгөөд Компанийн түгээс дээр дурдсан дүн бүхий татварын үлдэгдлийг "их хэмжээний өр" гэж үзээгүй байна. (Хавсралт 11.18)

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Компанид нийгмийн даатгал, татварын дутуу төлөлттэй холбоотой нөхөн татвар, торгууль, алданги оногдуулаагүй байна.



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ш 1118267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ

MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03



Бид Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны болон МХБ-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын зохицуулалтаас гадна хөрөнгө оруулагчид шийдвэр гаргахад ач холбогдолтой гэж үзэн хөндлөнгийн мэдээлэл цуглуулж, тус Компанитай холбоотой дараах нөхцөл байдлуудыг тогтоосон болно. Үүнд:

- Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын олон улсын арбитрын 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 4/611 тоот Тодорхойлолт (Хавсралт 11.1)-д тусгаснаар тус арбитраар хянан шийдвэрлэгдсэн болон арбитрын ажиллагаа явагдаж байгаа хэрэгт "ЛэндМН ББСБ" ХК нь 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй байна;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албанаас 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдөр гаргасан 0011112 тоот Тодорхойлолт (Хавсралт 11.2)-д "ЛэндМН ББСБ" ХК нь шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр төлбөргүй байна;
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн төрөлжсөн архиваас 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдөр гаргасан Тодорхойлолт 1/8001 (Хавсралт 11.3)-д тусгаснаар "ЛэндМН ББСБ" ХК нь сүүлийн 3 жилийн байдлаар Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020.04.23-ны өдрийн 182/ШШ2020/00884 дугаар шүүхийн шийдвэртэй С-ийн нэхэмжлэлтэй "ЛэндМН ББСБ" ХК-иас ажилд эгүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалин хөлстэй тэнцэх олговор гаргуулах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын дэвтэрт нөхөн бичилт хийлгэх тухай, мөн Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020.08.25-ны өдрийн 181/ШШ2020/02151 дугаар шүүхийн шийдвэртэй иргэн А-ын нэхэмжлэлтэй "ЛэндМН ББСБ" ХК-д холбогдох гэрээний зарим зүйл заалтыг хүчин төгөлдөр бусад тооцуулах, 12,600 төгрөг гаргуулах тухай иргэний хэрэгт тус тус хариуцагчаар оролцож байсан. Гүйцэтгэх захирлын 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 05/776 тоот албан бичиг (Хавсралт 11.18)-т дурдсанаар "ЛэндМН ББСБ" ХК-д холбогдох дээр дурдсан ажилд эгүүлэн тогтоолгох тухай нэхэмжлэлийн шаардлага бүхий иргэний хэрэг Улсын дээд шүүхэд хянагдаж байгаа бөгөөд иргэн А-ын 12,600 төгрөг гаргуулах шаардлагыг шүүх хэрэгсэхгүй болгосон, уг шийдвэр хүчин төгөлдөр болсон байна. Түүнчлэн Компани нь сүүлийн 3 жилийн хугацаанд нийт 1327 хэрэгт нэхэмжлэгчээр оролцсон бөгөөд үүнээс шүүхийн шатанд хянан шийдвэрлэгдэж байгаа 238 иргэний хэрэг байна (Хавсралт 11.4);
- Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны Шүүхийн тамгын газраас 2021 оны 05 дугаар сарын 06-ний өдөр гаргасан 2993 тоот албан бичиг (Хавсралт 11.5)-т тусгаснаар "ЛэндМН ББСБ" ХК нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч болон гуравдагч этгээдээр сүүлийн 3 жилд оролцоогүй байна;
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдөр гаргасан 01/951 тоот албан бичиг (Хавсралт 11.6)-т тусгаснаар "ЛэндМН ББСБ" ХК нь Өрсөлдөөний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д заасны дагуу давамгай байдалтай аж ахуйн нэгжээр тогтоогдоогүй бөгөөд 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар Өрсөлдөөний тухай хуулийг зөрчсөн үндэслэлээр Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас шийтгэл оногдуулж байгаагүй байна;
- Оюуны өмчийн газрын аж үйлдвэрийн өмчийн мэдээллийн сан /https://publish.ipom.mn/wopublish-search/public/home?6/ (Хавсралт 11.7), зохиогчийн эрхийн хайлтын систем /http://copyright.ipom.mn/ (Хавсралт 11.8)-с тус тус хайлт хийхэд "ЛэндМН ББСБ" ХК-ийн нэр дээр эрхийн хамгаалалт хийгдсэн шинэ бүтээл, ашигтай загвар, зохиогчийн эрхийн аливаа бүтээл байхгүй, эрхийн хамгаалалт хийгдсэн хүчинтэй барааны тэмдэг 1 байна;
- **Санхүүгийн Зохицуулах Хорооноос МДСХ нь 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдөр Д-21/88 тоот "Лавлагаа хүсэх тухай" албан бичиг (Хавсралт 11.9)-ээр Үнэт цаас гаргагч нь тусгай зөвшөөрөл авсан эсэх, авсан бол ямар үйл ажиллагааны төрлөөр авсан, тусгай**



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
264

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-06-18
БҮРТГЭВ-03

СЗХ
2021.06.23
БҮРТГЭВ
№1

MDSKhanLex

зөвшөөрөл нь хүчинтэй эсэх, тусгай зөвшөөрлийн хугацаанд тус компани зөрчил гаргаж захиргааны хариуцлага хүлээж байсан эсэх талаарх лавлагаа авахаар хүсэлт гаргасан боловч Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хариу ирээгүй байна;

- "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-иас 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдөр гаргасан 01/207 тоот албан бичиг (Хавсралт 11.10)-т тусгаснаар "ЛэндМН ББСБ" ХК нь "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-д 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр бүртгэгдсэн бөгөөд ямар нэгэн өр төлбөргүй, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэн ажиллаж байна;
- "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХК-иас 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдөр гаргасан 01/616 тоот албан бичиг (Хавсралт 11.11)-т тусгаснаар "ЛэндМН ББСБ" ХК нь "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХК-тай Үнэт цаасны хадгаламжийн болон үнэт цаастай холбогдолтой төлбөр гүйцэтгэх гэрээ байгуулан ажилладаг ба гэрээний үүргийн хэрэгжилтийн зөрчилгүй, өр төлбөрийн тооцоогүй байна;
- Гаалийн ерөнхий газраас 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдөр гаргасан T214HU934 тоот тодорхойлолт (Хавсралт 10.1)-т тусгаснаар "ЛэндМН ББСБ" ХК нь гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн мэдээлэл гаалийн мэдүүлгийн санд бүртгэгдээгүй тул татварын өргүй байна;
- Цагдаагийн Ерөнхий Газар Мэдээлэл, Дүн Шинжилгээ, Шуурхай Удирдлагын Албаас 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 80/782 (Хавсралт 11.12)-д "ЛэндМН ББСБ" ХК болон гүйцэтгэх захирал О.Болдбаатар нарыг эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг цагдаагийн байгууллагын ял шийтгэлийн мэдээллийн сангаас шалгахад тэдэнд холбогдох мэдээлэл бүртгэгдээгүй байна;
- Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаас 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдөр гаргасан №03-09/3190 тоот албан бичиг (Хавсралт 11.13)-т тусгаснаар "ЛэндМН ББСБ" ХК-ийн нэрээр бүртгэлтэй Нийслэлийн засаг даргын захирамжтай газар эзэмших, ашиглах эрх болон газрын төлбөр төлөлтийн түүх газрын мэдээллийн санд бүртгэгдээгүй байна.
- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Газар зохион байгуулалтын албаас 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдөр гаргасан 15/364 тоот албан бичиг (Хавсралт 11.14)-т тусгаснаар "ЛэндМН ББСБ" ХК-ийн нэр дээр 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар тус дүүргийн газрын мэдээллийн сангийн "Ланд менежер" программд эзэмшил болон өмчлөлийн газар бүртгэлгүй байна.

**Гол дүгнэлт**

"ЛэндМН ББСБ" ХК-ийн Үнэт цаасны танилцуулгад дурдсан мэдээлэл үнэн зөв, хуульд нийцсэн байна. Энэ тухай Хавсралт 0.1-ээс үзнэ үү.

**ХҮНДЭТГЭСЭН,**

**"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН-ИЙН**

**ГИШҮҮН, ХУУЛЬЧ**

Д.ДҮГЭРЖАВ

УЛААНБААТАР ХОТ



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 11 18267206

2021/05/24

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183355
9021031155 СТС2420

| Үнэт цаасны материалтай холбоотой мэдээлэл өгөх хариуцлагатан | | | |
|---|---|---|---|
| **Байгууллагын нэр** | ЛЭНДМН ББСБ ХК | "ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК" ХХК | "РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК" ХХК |
| **Хариуцах ажилтан** | О.Болдбаатар | Б.Өлзийбаяр | Н.Цэвэгмид |
| **Албан тушаал** | Гүйцэтгэх захирал | Гүйцэтгэх захирал | Дэд захирал |
| **Утас** | 9400-2255 | 9910-3838 | 9999-9881 |
| **Цахим шуудан** | contact@lend.mn | info@ardcapital.mn | tsevegmid@rhinosinvest.mn |

*Хүснэгт 22: Үнэт цаасны материалтай холбоотой мэдээлэл өгөх хариуцлагатан*